

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО**

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**СЭДЭВ: “МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ
БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, ҮНЭЛЭХ”**

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**

*Та сонсголын тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR кодыг
уншуулан танилцах боломжтой*

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий хяналтын сонсголд оролцогч Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн сонсголд оролцохоор ирсэн Байнгын хорооны гишүүддээ талархал илэрхийлье. Ингээд ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар, Гомбын Ганбаатар, Сүрэнжавын Лүндэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Цэвэгдоржийн Туваан, Жадамбын Бат-Эрдэнэ, Мөнгөнцогийн Ганхүлэг, Мэндбаярын Мандхай, Тогтмолын Мөнхсайхан, Болдын Уянга, Буланы Бейсен, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Цагаанхүүгийн Мөнхбат, Нанзадын Наранбаатар, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын гишүүд ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос зохион байгуулж байгаа “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт ерөнхий хяналтын 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн сонсгол нээснийг мэдэгдье. Өнөөдрийн сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна иргэд, төрийн байгууллагын төлөөлөл нийт 72 хүн бүртгүүлсэн. Иргэдээс 38, төрийн байгууллагаас 17 хүн хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз, “Малчин” телевиз болон парламентын шууд дамжуулах сүлжээгээр энэхүү сонсголыг дамжуулж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.4-т “Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.” гэж заасны дагуу хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, сонсголд оролцох, ажиглах боломжийг хангах зорилгоор өнөөдрийн сонсголыг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизээр дохионы хэлмэрчтэй шууд дамжуулж байна.

Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа хяналтын сонсгол нь зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмаар явагддаг болохыг та бүхэнд мэдэгдье. Иймээс сонсголд оролцож байгаа Та бүхэн зөвхөн хуульд заасан дэг, журмыг сахин оролцохыг хүсэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй” гэж заасан бөгөөд мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан “Сонсголд оролцогчийн эрх, үүрэг”-ийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

124.1.Сонсголд оролцогч дараах эрх эдэлнэ: 124.1.1 Энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу асуултад хариулах тайлбар санал хэлэх; 24.1.2. Сонсголын тэмдэглэл гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал тайлбарыг хянах; 24.1.3 Сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцүүтэй хүндэтгэлтэй

хандахыг шаардах. 124.2.Сонсголд оролцогч дараах үүрэг хүлээнэ: 124.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх; 124.2.2.сонсголын дэг сахих; 124.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх; 124.2.4.сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх; 124.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх гэж тус тус заасан байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа өнөөдрийн сонсголын гол ач холбогдол бол мэдээлэл сонсох, цуглуулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн мэдэх эрхийг хангаж, саналыг сонсож, шийдвэр гаргах түвшиндээ нэгдсэн нэг ойлголттой болох, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах асуудлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл өгөхөд чиглэж байна.

Ингээд Та бүхэндээ сонсголын өнөөдрийн хөтөлбөр, дэгийг танилцуулъя. 10 цаг 10 минутаас 10 цаг 20 минутын хооронд одоо цаг хэд болж байгаа билээ 17 минут болж байна. “Малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж, зээл, санхүүжилтийн нөхцөл байдал, Малчны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой үр дүн” Монгол банкны дэд ерөнхийлөгч Г. Энхтайван, дараа нь сонсголд оролцогч иргэдээс санал, тайлбар, үг авах, УИХ-ын гишүүд асуулт асууж үг хэлэх, дараа нь “Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас учирсан хохирол, түүнийг даван туулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ”-ний талаар ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян илтгэнэ. Мөн дараа нь “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат, дараа нь “Малчны хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т. Аубакир, “Малчны хамтын санаачилга, хоршил-Шинэ хоршооны явц, үр дүнгийн талаар” Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил гэсэн хөтөлбөрийн дагуу явагдана. Үндсэндээ 5 илтгэлийг сонсох болно. Ингээд хяналтын сонсголын хөтөлбөр, дэг, дарааллыг та бүхэнд танилцуулж дууслаа. Ингээд сонсголынхоо үйл ажиллагаанд орцгооё.

“Малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж, зээл, санхүүжилтийн нөхцөл байдал, Малчны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой үр дүн” Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван танилцуулна. Г.Энхтайван таныг индэрт урьж байна.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Өнөөдөр энэ танхимд хүрэлцэн ирсэн нийт УИХ-ын гишүүд болон холбогдох төрийн байгууллагууд, мөн малчин, сонсголд оролцож байгаа нийт ард иргэд Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн сонсголоор Монгол Улсын эдийн засагт үзүүлж байгаа малчин өрхийн эдийн засгийн оролцоо, мөн малчдад үзүүлж байгаа санхүүгийн үйлчилгээ, түүний хүртээмж, цаг үеийн нөхцөл байдлын талаар товч танилцуулга хийе. Одоогийн байдлаар бол Монгол Улсын ХАА-н салбар, тэр дундаа МАА-н салбарт хэд хэдэн төрлийн зээл явж байгаа. Үүнд Малчны зээл болон ХАА-н салбарт олгогдож байгаа зээл мөн Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн талаар товч танилцуулга хийе. Монгол Улсын эдийн засгийн уламжлалт, тулгуур ХАА-н амьжиргааны үндэс нь бол малчин, МАА юм. Малчдын хөдөлмөрийг бодит баялаг болгон хувиргаж тэдгээрийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх нь банк, санхүүгийн салбарын чухал зорилтын нэг гэж Төв банк үзэж байгаа. Энэ хүрээнд арилжааны 10 банктай хамтраад Төв банк малчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа. Өнөөдрийн байдлаар 2025 оны байдлаар нийтдээ 122,838 зээл олгогдсон байгаа.

Энэ бол зээлийн тоо. Нийт зээлийн үлдэгдэл 2026 оны 4 сарын байдлаар 1.1 их наяд төгрөгийн зээл нийт малчдад олгогдсон байна. Энэ оны хувьд оны эхний 4 сарын байдлаар 412.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсон 2025 онд нийтдээ 867.1 тэрбум тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. Зээлийн дундаж хүүгийн хувьд малчны зээлийн дундаж хүү 22,2% байгаа. Энэ маань хэрэглээний зээлийн дундаж хүүгээс 4,4 хувиар өндөр, бизнесийн буюу том зээлээс 5,9 орчим хувиар өндөр байгаа. Тэгэхдээ энэ зээл маань өөрөө тухайн цаг үеийн нөхцөл байдал, Төв банкны бодлогын хүү болон бусад зээлийн үзүүлэлтүүдтэй харилцан уялдаж энэхүү зээлийн хүү тогтож явдаг. Зээлийн багцын хувьд малчны зээл дээр нийт зээлийн 96,3% нь хэвийн ангилалтай зээл, 1,9% нь анхаарал хандуулах зээл, 1,8% нь чанаргүй зээл гэсэн ангилалтай байгаа. Зээлийн хугацааны хувьд нийт зээлийн 90,8 буюу үндсэндээ 91% нь 1-5 жилийн хугацаатай зээл авдаг гэсэн үг. 5 жилээс дээш хугацаатай зээл нийтдээ 72 тэрбум төгрөг, нэг жил хүртэлх хугацаатай нь 31 тэрбум төгрөгийн зээл байна гэсэн үг.

Өнгөрсөн 2024, 2025 онуудад малчны зээлээс гадна хоршооны гишүүн малчдад олгож байгаа шинэ хоршоо хөтөлбөрийн зээл олгогдоод байгаа. Энэ дээр товч танилцуулга өгье. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 4 сарын 24-ний өдрийн 166 дугаар тогтоолоор “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” арга хэмжээ авсан тогтоол гарсан. Энэ хүрээнд “Хоршооны гишүүн малчныг дэмжих зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайд, Монголбанк, Зээлийн батлан даалтын сан болон банкууд хамтран гэрээ байгуулсны үндсэн дээр зээл олгогдоод явж байна. Энэхүү зээлийн хүрээнд 2024-2025 онд 1 их наяд төгрөгийн зээл олгохоор Засгийн газрын тогтоол гаргаад түүнд холбогдох төрийн байгууллагууд оролцоод зээл гарсан байгаа. Зээлийн нөхцөл үндсэндээ 18%-ийн хүүтэй боловч ЗГ нь үүнээс 12%-ийн хүүгийн татаас буюу хүүгийн төлбөрийг хариуцаж, малчин өөрөө 6%-ийн зээлийг төлж байгаа. Нэг зээлдэгчид 50 сая төгрөг хүртэл зээл олгож байгаа. Зээлийн хугацаа 5 жил, зээлийн хүүгийн 1/3-ыг зээлдэгч төлөөд, 2/3-ыг нь Засгийн газар төлж байгаа гэсэн үг. Зээл олголтын хувьд дийлэнх зээл 2024 онд 684 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бол 2025 онд 210 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. 2024 онд 26437 малчин өрх зээл авсан бол 2026 оны 5 сарын 01-ний өдрийн байдлаар нийтдээ 26270 малчин өрх зээл авчихаад байна. Нийт 894 тэрбум төгрөгийн зээл олгогдоод байна. Зээл олголтын хувьд бол орон нутагт үйл ажиллагаа явуулдаг салбар нэгжтэй банкуудаар явж байгаа. Үүнд хоршооны зээл үндсэндээ бараг 100% Хаан банк, Төрийн банкаар дамжиж олгогдсон байна. Нийт 894 тэрбум төгрөгийн зээлийн 500 тэрбум төгрөг нь Төрийн банкаар, 400 тэрбум орчим төгрөг нь Хаан банкаар явсан байгаа. Хас банкаар болон Богд банкаар маш бага ийм зээл гарсан. Нийтдээ 26437 малчин өрх энэхүү зээлд хамрагдаад байна. Зээлийн зориулалтыг ажиглах юм бол дийлэнх нь үржлийн мал худалдан авах зээл гарсан байгаа. Нийтдээ 513 тэрбум төгрөг буюу одоо нийт хоршооны зээлийн 57% нь үржлийн мал худалдан авах зээл байна. ХАА-н түүхий эд боловсруулах болон мах, сүү, цагаан идээ боловсруулах, тэжээлийн ургамал тарих, мал бордох аж ахуй, агуулах, зоорь, хөргүүр, мал үржүүлэг гэх мэт төрлүүдээр малчид ХАА-н шинэ хоршоо хөтөлбөрийн зээлийг авсан байгаа. Тэгэхээр эндээс ажиглахад дийлэнх нь мал худалдан авах, МАА-н бааз сууриа дээшлүүлэх, үржлийн мал худалдан авах зорилгоор энэ зээлийг ашиглаж байгааг энэ танилцуулга илтгэж байна. Нийт зээлийн үндсэндээ 75% нь зөвхөн эхний 3 төрлийн бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа гэсэн үг. Энэ нь зөвхөн шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээл. Малчны зээл дээр бол малчин өрх, аж ахуй өрх маань зээлийнхээ зориулалтыг өөрөө тухайн банкиндаа яаж мэдүүлсэн түүгээрээ гаргаад явж байгаа. Малчны зээл дээр дийлэнх нь, нийт зээлийн 90 орчим хувь нь хэрэглээний зээл буюу малчин өрх өөрийн өдөр тутмын

санхүүгийн хэрэгцээнд зориулсан зээлийг авч байгаа.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” мөн уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс хамгаалах тухай тогтоол гарсан. Энэ хүрээнд Засгийн газар шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлсэн тогтоолыг 2024 онд гаргасан. Банкны салбарт олгогдсон нийт малчны зээлтэй холбоотой товч танилцуулахад ийм байна. Өнөөдрийн сонсголд танилцуулсан танилцуулгаас хэд хэдэн зүйлийг Монгол банкны зүгээс онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Нэгдүгээрт, малчны зээлийн багц тасралтгүй өсөж байгаа. 2021 онтой харьцуулахад малчны зээлийн хэмжээ ойролцоогоор бараг 40 гаруй хувиар өсчихөөд байгаа. Нийт үлдэгдэл нь 1,1 их наяд төгрөгийн хэмжээнд хүрсэн. Хэдийгээр зээлийн багцын хэмжээ өсөж байгаа ч гэсэн зээлийн чанар харьцангуй сайн байгаад байгаа юм. Чанаргүй зээлийн хэмжээ 1,8%-тай байгаа нь малчид та бүгд маань төлбөрийн чадвар сайтай, зээлийн сахилга бат сайтай, гэрээний үүргээ маш ухамсартайгаар маш сайн сахилга баттай биелүүлдэг болохыг харуулж байгаа. Хоршооны гишүүн малчдыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 26000 гаруй малчин, 7000 гаруй хоршоог хамруулж 900 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан. Энэ нь эдийн засагт маш томоохон нөлөөг үзүүлж, тэр дундаа МАА-н үйлдвэрлэлийг дэмжсэн томоохон ЗГ-ын хөтөлбөр болж хэрэгжсэн. Зөвхөн нэг зээлийн хэмжээтэй тоо биш. Энэ бол нийт олон мянган малчин өрхийн амьжиргаа, ирээдүйд оруулж байгаа том хөрөнгө оруулалт. Малчны зээлийн жигнэсэн дундаж хүү бусад салбарын зээлээс үл ялих өндөр байгаа нь бидний анхаарах ёстой асуудал зайлшгүй мөн болохыг энэхүү статистик илэрхийлж байна. Тэгэхээр малчдын зээлийн чанар харьцангуй сайн байгаатай холбогдуулан малчны зээлийн хүү цаашид буурах боломжтой юм гэдгийг Төв банкны зүгээс арилжааны банкнуудтай харилцан ярилцаж бодлогын тохируулгуудыг хийж явах болно. Тэгээд цаашид санхүүжилтийн зардлыг бууруулаад, зээлийн зориулалтыг нэмэгдүүлж, малчдад олгож байгаа зээлийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь улсын үндэс хөгжлийн тулгуур болсон нийт ХАА-н салбар малчин түмнийг дэмжихэд чухал ач холбогдолтой гэж Төв банк үзэж байна. Ингээд өнөөдрийн сонсголд оролцож байгаа Та бүгдэд амжилт хүсье.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Танхимд хүрэлцэн ирсэн оролцогчдод санал хүсэлт, мэдээллээ хийх боломжийг олгож байгаа, оролцогчдоос авсан нэрс байна уу? Одоогоор 2 нэр ирсэн байна. Оролцогч Малчин телевиз Д.Шагдарсүрэн таныг 1 номерын микрофонд урья.

Малчин телевизийн сэтгүүлч Д.Шагдарсүрэн: Энэ цаг үеэ олсон гэдэг шиг энэ чухал сэдвээр малчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа удирдах хүмүүст малчдынхаа өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье. Миний ярих гол юм бол энэ зун ямар байх вэ гэдэг асуултад хариулах л гэж бодож байгаа. Надтай уулзсан хүн болгон хэдэн төгрөгийн зээл авсан, яаж өгнө дөө гэж ерөөсөө ярихгүй байна, манай нутагт зуншлага ямар байгаа бол, энэ зун яах бол л гэж асууж байна. Тэгэхлээр энэ асуултын хариу болгож би УЦУОШГ-ын ажилтан Бат-Оюун инженерийг авчирсан. Тэгээд Бат-Оюун мэдээллээ хийх байх.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Энэ мэдээллээ орхичихъё, хэдүүлээ хуулийнхаа дагуу л, сая тавьсан илтгэлтэй холбоотой мэдээлэл шүү дээ. Энэ талаар асуулт асууж, энэ талаар саналаа хэлэх юм. Д.Шагдарсүрэн гуайд баярлалаа. Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо Ш.Ариунаа, 5 номерын микрофон.

Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо ТББ Шагдарсүрэнгийн Ариунаа: Баярлалаа, илтгэлтэй холбоотойгоор нэг асуулт байна. Таатай санагдаж байгаа зүйл нь малчид маань санхүүгийн зээлээ хариуцлагатай төлдөг гэдэг бол маш сайхан мэдээ, үүнийг олон нийт мэдээсэй гэж хүсэж байна. Асуух гол зүйл маань эдгээр зээл авсан малчдын чинь дотор хэд нь эмэгтэй малчин байгааг надад хариулж өгөөч. Хэрвээ яг танд одоо тоо байгаа бол, байхгүй гэж би ер нь бодож байна. Тэгэхээр хэрвээ энэ тоо байхгүй бол яагаад зээл авч байгаа хүмүүсийнхээ эрэгтэй, эмэгтэй дор хаяж хүйсийг нь авдаг уу, авдаггүй бол яагаад вэ гэдэг асуулт. Яагаад үүнийг асууж байна вэ гэхээр би өөрөө жендерийн үндэсний шинжээч хүн. Монгол Улс дэлхийд, Азид анх удаа төрийн байгууллагаас жендерийн сийл медалийг Татварын ерөнхий газар авсан. Үүний цаана юу гэж хэлж байна гэхлээр санхүүгийн аливаа үйлчилгээ нь иргэд, эмэгтэйчүүд, малчид энэ өөр онцлогтой хүмүүстэй ижил хүмүүст ижил хүрч байгаа гэсэн санаа байгаад байгаа юм. Тэгэхээр энэ тоог асууж байна. 2 дахь миний тавих гэж байгаа санал нь та бүхэн энэ малчин эмэгтэйчүүдийн тусад нь зээлийн бүтээгдэхүүн гаргаж өгөх бодлогыг бариач ээ гэж Монгол банкинд санал өгч байна. Учир нь энэ эмэгтэйчүүд барьцаанд хөрөнгөө тавьчихъя гэхээр зэрэг данснаас нь эхлээд л өөрийн гэсэн өмч хөрөнгө байдаггүй. Малчин эмэгтэйчүүд эдийн засгийн оролцоонд бие дааж оролцож чаддаггүй. Энэ нь цаад утгаараа бид бүгдийн 2 өдрийн яриад байгаа яаж хөдөө нутагт эмэгтэйчүүдийг, залуу эмэгтэйчүүдийг тэнд очуулах вэ гэдэг учрах шалтгаануудын чинь нэг нь юм шүү. За баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа оролцогчдодоо нэг дэг танилцуулъя. УИХ-ын гишүүд, төрийн байгууллага болон удирдах албан тушаалтнуудаас энэ хуультай холбоотой асуултыг асууж, хариулт авах юм. УИХ-ын гишүүддээ санаа болгохоор та бүхний саналыг авчхаж байгаа юм шүү. Баярлалаа Ариунаа. Монголын барилгачдын нэгдсэн холбоо Б.Өлзийбат. 4 номерын микрофон. Та бүхэн саналаа хэлчих. Яг энэ саналыг энд сууж байгаа төрийн байгууллагынхан бас санаандаа аваад дараагийнхаа хариултаа үүнтэйгээ уялдуулаад хариулаад явчихна шүү. За Өлзийбат.

Монголын барилгачдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Б.Өлзийбат: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын барилгачдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Өлзийбат. Өнөөдөр УИХ үндсэн ажлаа хийж байгаад нь маш их талархаж байна. Үндсэн хуулиараа Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага бол парламент. Ард түмнээс эх үүсвэртэй парламентын үндсэн хийх ажил 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр парламент гаргасан хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьдаг онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн. Энэ бол маш сайн зүйл. Анх удаа тухайлан хуулийн хэрэгжилт, биелэлт дээр дүн шинжилгээ хийж үндсэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурлын гишүүддээ туйлын их талархаж байна.

Манай холбооны зүгээс ААН-үүдэд энэ хуулийн хэрэгжилт өөрөө удаашрахаараа, хуулийн хэрэгжилт хэрэгжихгүй дунд нь хаягдахаараа маш олон ААН-үүд хохирдог. Үүнтэй адилхан малчдын асуудал ч гэсэн энэ Малчдын тухай хууль дээр бас хаягдсан байгаа. Энэ хууль өмнөх парламентын үед хэлэлцэж байхад УИХ-ын ди парламент систем дээр хамгийн олон малчдын санал, хонин дээрээсээ, бэлчээр дээрээсээ өгч байсныг би санаж байна. Тэгэхлээр энэ хуулийн 4.2.4 дээр барилгын салбартай холбоотой, малчдын орон сууц, ипотектэй холбоотой асуудал байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 700 мянган өрх орон сууц зайлшгүй хэрэгтэй, орон нутагт бол 435 мянга хэрэгтэй байгаа юм. 2025 онд нийтдээ 21 аймаг гэж үзээд Дархан, Орхон аймгийг хасах юм бол үлдсэн 19

аймагт нь 5000 орон сууц орсон байгаа юм. Өнөөдөр малчдын амьдрал, малчдын орлого хэр байгаа билээ. Тэгэхлээр гол зүйл юу вэ гэхээр орон нутгууд өнөөдөр дулааны болоод цахилгааны гүн хямралд орчихсон байгаа. Тэгэхлээр малчдыг хямд үнэтэй орон сууцанд оруулах, малчдыг орон байраар хангах боломж дээр нь төрийн бодлого ямар түвшинд байгаа вэ гэдэгт илүү тодорхой мэдээллүүд хэлэх байх.

Бид асуулт асуухгүй болохоор зарчмын гол зүйлээ хэлье. Нэгдүгээрт, сонсголууд болдог, хуулиудыг хийдүүлдэг, яамны мэргэжилтэн хууль тайлбарлаад сууж байдаг. Энэ зүйлүүдийг ер нь хэзээ болиулах вэ? Сонсголын мөрөөр энэ хариуцлага алдсан зүйлүүд дээр хариуцлага тооцдог жишгийг тогтоомоор байна. Дараагийн нэг зүйл нь орон нутагт хуулийг Иргэдийн хурлын төлөөлөгч нар бас давхар хариуцдаг. Тэд маань хуулиа мэддэггүй, иргэдэд анхан шатны мэдээллүүдийг өгдөггүйгээс болж маш олон иргэд хуулийг шаардлагатай тэр шийднэ гэсэн асуудлын хуулийн процессыг хэрэгжүүлж чаддаггүй асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд гол зүйл бол орон нутагт Нийтийн сонсголын тухай хууль гэж байна л даа. Орон нутагт их хэрэглэдэг. Тэгээд улсын төсөв дээр сонсголын зардлыг улсын төсвөөс гаргана гэсэн боловч төсөвт тавьж өгдөггүй. Тэгэхлээр энэ иргэдийн мэдэх эрх, тухайн иргэд орон нутагтаа төрийн үйл ажиллагааны чиглэлээр өөрөө асуудлыг тавих, орон нутагтайгаа ярих, мэдээлэл авах энэ боломж дээр, энэ хуулийн хэрэгжилтийг хангах дээр нь санхүүжилт дээр нь анхаарах хэрэгтэй. Мөн энэ Нийтийн сонсголын хуулийг зайлшгүй сайжруулах шаардлагатай байгаа.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хүмүүсээсээ саналуудыг нь 3 минутдаа амжаад хэдүүлээ сонсчихъё. Энэ завсарлагааны үед төрийн байгууллагынхантайгаа уулзалдах асуудлууд нээлттэй шүү. Ц.Бээжин Өмнөговь аймаг, 4 номерын микрофон, 3 минутдаа багтааж саналаа хэлье.

Өмнөговь аймаг Ц.Бээжин: Өдрийн мэнд хүргэе. Малчны тухай хууль олон салбар хуульд хамааралтай учраас хууль тогтоогч эрхэм гишүүддээ Гурван тэс сумын малчдын санаа зовж байдаг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах товчхон хэдэн санааг хэлье.

Нэгдүгээрт, малчин гэдэг бол бэлчээртэйгээ шууд хамааралтай. Байгаль орчны үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, эцэст нь Газрын тухай хууль гэх мэт олон хуулиудын харилцан уялдаа, нэгдмэл ойлголтыг нэн даруй цэгцэлмээр байна гишүүд минь. Нэгдүгээрт, Ашигт малтмалын тухай хуульд малчин өрх уул уурхайн үйлдвэрлэлд шилжсэн хамаарал бүхий малчин өрхүүдийн нөхөн төлбөр гэдгийг төр нь зайлшгүй тэр уурхайн үйлдвэрлэл эрхлэх шаардлагатай бол 70 жилээр тооцож олгодог баймаар байна. Яагаад гэвэл лиценз 70 жилээр олгодог. Тэр хугацаанд малчдын орлогыг нөхөн төлбөрт тооцох;

Хоёрдугаарт, хайгуулын зөвшөөрөл өгөхдөө зөвхөн лицензийн талбайн малчдаар хязгаарлахгүй тухайн одоо талбайд хамаарал бүхий бүс нутгийн малчдын зөвшөөрлийг авч байж хайгуулын лицензийг олгодог заалтыг нэмүүлмээр байна.

Гуравдугаарт, Газрын тухай хуульд бэлчээрээс уул уурхайн ангилалд шилжүүлнэ гэсэн заалт байгаа. Энэ ангилалд шилжүүлэх шалгуур үзүүлэлтийг

чамбайруулмаар байна. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулаарай. Энд жишээ хэлье. Гурван мянган га талбайд 6 сая тонн нүүрсний нөөцтэй уурхай. Энэ бол эдийн засгийн хувьд ашигтай гэж. Гэтэл түүнээс 10 дахин том 30 мянган гад зургаахан сая тонны нөөцтэй орд гэж хэлэхэд хэцүү. Ийм лиценз олгогдсон, ийм хариуцлагагүй, бэлчээр сүйтгэсэн уурхай нэртэй ийм хариуцлагагүй үед бэлчээрийн ангиллаас Уурхайн ангилалд шилжүүлэх газрын тухай хуулийн шалгуур үзүүлэлтийг өндрөөр тавьж үнэхээр эдийн засгийн өндөр ашигтай талбайнуудыг бэлчээрээс уурхайд шилжүүлж баймаар байна. Эцэст нь Усны тухай хуульд зөвхөн уурхайн лицензийн талбай дахь олборлолтоос шалтгаалаад тухайн лицензийн талбайн эргэн тойронд 20-оос 30 метрт хамгийн багадаа хөрсний болоод гадаргын гүний усны ай савд асар их хомсдол үүсдэг юм. Энэ эрсдэлийг тооцоолж байж тэр уурхай нээх эрхийг өгөх, Усны тухай болоод Ашигт малтмалын тухай хуулиудад усны эрсдэлийг тооцож, эрсдэлтэй бүс нутагт уурхайн лицензийг зөвшөөрдөггүй байх, хайгуулынх нь ажлын зардлыг тэр хайгуул хийсэн компанид нь бас төрөөс нөхөн олговор өгч бэлчээрээ хамгаалж үлдэх ийм хуулийн зохицуулалтуудыг хийгээч ээ гишүүд минь. Боломж байвал нэг минутаа нэмээд ..

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Бэлчээртэй холбоотой санал хэллээ. Баярлалаа. Ц.Ундармаа Өмнөговь аймаг. Дараа нь Оюундэлгэр. Саналууд нь авчихъя. Уг нь болбол хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбоотой саналуудыг хэлэх нь зүйтэй юм. Ард иргэдийнхээ төлөөлөл болоод ирж байгаагийн хувьд саналуудаа хэлчих, сонсьё бид.

Өмнөговь аймаг Ц.Ундармаа: Нэг асуулт асууя. Хуулийн 12.2-т малчид нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл олгоно гэжээ. Энэ зээлд жил бүр улсын төсвөөс хэдэн төгрөг суулгаж, хэдэн малчин хамруулах тооцоо байгаа юу? эсвэл амлалт төдий юу? Малчны зээлийг болохоор малчид авсан зээлээ цаг хугацаанд нь маш сайн төлдөг гэж ярьж байна. Тэгэхээр малчны зээл маань 23% хувиар олдож байгаа, бусад зээлээс 4%-аар илүү байдаг. Тэгэхээр малчдын зээлийн энэ хүүг бас бууруулах боломжтой юу? Мөн өрх толгойлсон эмэгтэй, нэн ядуу, алслагдсан сумынх нь заавал хоршоонд орж байж энэ зээлд хамрагдах ёстой юу? Одоо нэн ядуу, өрх толгойлсон малчин эмэгтэй, алслагдсан суманд амьдарч байвал зээлийн өөр ямар боломж байгаа бэ? Малчид янз бүрийн уул уурхайн бүсэд алслагдсан, өрх толгойлсон, ядуу эмэгтэйг танай банк одоо санхүүгийн тал дээр ч гэсэн хөнгөлөлттэй, бас яг тусгайлан гаргасан тийм зээл байх боломжтой юм болов уу? Бусдаар бол малчин бид Хаан банкны малыг л маллаж байгаа шүү дээ яг үнэндээ бол. Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ундармаа танд баярлалаа. Маш сайхан асуултуудыг асуулаа. Энэ асуултуудыг төрийн байгууллагынхан маань хариулахдаа асуултуудыг бас бодолцож хариулна шүү. Оюундэлгэр байна уу?

В.Оюундэлгэр: Бүгдэд нь энэ өглөөний мэндийг хүргэе. Миний асуух 2 асуулт давхцаад гарчихлаа. Малын индексжүүлсэн даатгалын талаар асууж, санал хэлье. Малын индексжүүлсэн даатгал болохоор даатгалын компаниуд малчдаас малын индексжүүлсэн даатгалыг хийдэг, давхардаад банкнуудаас зээл авах болохоор банк дахиад малын даатгалын хураамжийг давхар давхар авдаг. Тэгэхээр энэ индексжүүлсэн даатгалуудыг хийгээд байгаа компаниуд ХХААХҮЯ-тай холбоотой байдаг уу гэсэн асуултыг асуумаар байна. 50 саяын малчдын зээл өндөр хүүтэй байна. 50 сая төгрөгийн зээл авсан хүн 17 сая төгрөгийг зээлийнх нь хүүд 2 жилийн хугацаанд малчид төлж байгаа. Малын хөл, малын тоо толгойгоороо

зээл олгодог. Тэгэхээр 200-аас доош толгой малтай айл, малчин өнөөдөр хүн биш гэдэг тоонд орчихсон. Зээл олгох боломжгүй гээд банкны аль ч салбарууд малчдыг маань буцааж байгаа. Тэгэхлээр яагаад вэ гэхээр малчид маань зээл авахын тулд малаа цөөн тоогоор нэмж тоолуулах тийм эрсдэлүүдийг бас үүрүүлээд байна. Ипотекийн зээлийн талаар манайхнаас санал ирээд байна. Аймагтаа сумаас Ипотекийн зээлд хамрагдаад байр авъя гэсэн малчдыг болохоор аймгийнхаа төв рүү явж аймаг дээрээ байгаа байрнаас авах боломжтой Улаанбаатараас байр авах боломжгүй гэсэн хариултыг өгөөд байна. Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Одоо холбогдох асуудалтай холбоотойгоор, Монгол банкнаас тавьсан илтгэлтэй холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт, үг хэлэхийг хамтдаа явуулъя. Баасанжаргал гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Зорьж ирсэн малчдадаа их баярлалаа. Бид хэд энэ малчны тухай хуультай холбогдолтой, ялангуяа Монгол банк, арилжааны банкнуудаас явуулж байгаа зээлтэй холбогдолтой асуудал руу илүү төвлөрөе гэж бодож байна. Малчны зээлийн хүүтэй холбогдолтой асуудал дээр, ер нь бусад бизнесийн зээлүүд, хэрэглээний зээлүүд, бүх зээлүүдээс хамгийн өндөр хүүтэй байгаа гол шалтгаанууд нь юу вэ? 24 хүртэлх хувийн хүүтэйгээр малчид зээл аваад байгаа. Үүнтэй холбогдолтой ер нь энэ хэлэлцүүлгээр бас гол бидний хөндөх ёстой асуудал бол зээлийн хүүг бууруулах чиглэл дээр цаашдаа бид бас тодорхой бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Нөгөө талаасаа нийт авсан зээлийнхээ 96,3% нь хэвийн төлж байгаа. Энэ оноожуулалтыг банк, санхүүгийн салбарт хийгээд явж байгаа. Үүнтэй холбогдолтойгоор малчдын зээлээ сайн төлж байгаа байдлыг үндсэндээ дэмжиж зээлийн хүү буурах боломжуудыг цаашдаа хайх гэсэн эхний нэг ийм санаа байж болох уу гэдэг асуулт байгаа. Хоёр дахь нь болохоор зээлийн хүүгийн энэ 22-24%-ийн 2-3% нь миний ойлгож байгаагаар эрсдэлийн хүү гэж тооцоолж аваад байх шиг байгаа юм. Эрсдэлийн хүү гэдэг энэ агуулга энгийн үедээ үндсэндээ тооцогддоггүй юм гэхэд 2023, 2024 оны яг зудын эрсдэлийн үед малчдаас өөрсдөөс нь хамаарахгүйгээр эрсдэлт нөхцөл байдалд орж байгааг энэ зээлийн хүүн дээр бас харгалзан үзмээр байна. Энэ үндсэндээ нийтээрээ, ОУ-ын байгууллага хүртэл хүлээн зөвшөөрөөд байгалийн онц ноцтой гамшигт үзэгдэл юм гэж ингэж тогтоож байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд үндсэндээ эрсдэлийн энэ 2-3% хүүг бууруулах арга хэмжээнүүдийг авах ийм зохицуулалтуудыг бид дотор нь ангилж, хэд хэдэн янзаар энэ зээлийн хүүг яаж бууруулах вэ гэдэг дээр гаргалгаануудыг гаргаж ажиллах хэрэгтэй байна гэдгийг эхний удаад тодруулъя.

Мөн Малчны тухай хуулиараа хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлийг олгох тухай тодорхой зохицуулалтыг оруулсан байгаа. Хөнгөлөлттэй нь ямар байх вэ, нэн хөнгөлөлттэй нь ямар байх вэ гэдэг дээр. Тэгэхээр ер нь шинэ хоршоо болон бусад төрлийн зээлүүдийг энэ хуулийн хэрэгжилт гэж үзэж байна уу? Цаашдаа тусгайлаад яг малчдад зориулсан нэн болон хөнгөлөлттэй зээл олгох чиглэл дээр бид ямар бодлогуудыг бас барьж болох вэ гэдэг рүү хэлэлцүүлэг чиглэх хэрэгтэй байна. 20 гаруй хувийн өндөр хүүтэй зээлээс илүүтэй хүүгийн тодорхой дэмжлэгтэй, МАА-н үйлдвэрлэл сайжруулах чиглэлийн зээлийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх нь ямар үр өгөөжтэй вэ гэдгийг зудын дараах 2, 3 жилийн хугацаанд бид бүхэн харлаа. ДНБ-д эзэлж байгаа хувь хэмжээ, МАА-н салбар үндсэндээ өндөр хувьтай байгаа нь үүнтэй холбоотой байгаа. Тэгэхээр ...

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк, 17 номерын микрофон.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Малчны зээлийн чанар түрүүн илтгэлд дурдагдсанаар чанаргүй зээлийн хэмжээ бол дөнгөж 1,8 орчим хувьтай байсан. Тэгэхээр малчид маань зээлээ цаг хугацаанд нь хариуцлагатайгаар төлдөг гэдгийг илтгэж байгаа. Малчны зээл ямар тохиолдолд хүү буух вэ гэхээр 1 дүгээрт, малчны зээлийн хүү яагаад бусдаас харьцангуй өндөр байгаад байгаа вэ гэхээр хамгийн гол нь арилжааны банкууд өөрсдийн үйл ажиллагааны зардалтай холбоотой байгаа юм. Яагаад гэхээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа малчны зээлийн дийлэнх нь цахимаар биш биетээр буюу банк биет салбар тухайн орон нутагт нээж үйл ажиллагаа явуулж банк, санхүүгийн үйлчилгээг орон нутагт хүргэж байгаатай холбоотой зардал гараад байгаа. Тэгэхээр тодорхой бага хэмжээний зардал зээлийн хүү дээр шингэж байгаа болов уу.

Хоёр дахь нь мэдээж эрсдэлтэй холбоотой асуудал. Түрүүн гишүүн хэлж байна. Тэр байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөлд ажиллаж байгаа малчдын болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр тогтолцооны арга хэмжээ авах нь зүйтэй. Энэ дээр хамгийн гол зүйлс бол малын индексжүүлсэн даатгалын асуудал байгаа юм. Малын индексжүүлсэн даатгалын хамрагдалт дөнгөж 18-22%-тай байгаа. Тэгэхээр тухайн малчин өрх өөрөө малын индексжүүлсэн даатгалд хамрагдчих юм бол, малаа бүрэн даатгуулчих юм бол тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкууд тухайн зээлийн хүү дээрээ хөнгөлөлт үзүүлэх боломжтой байгаа. Ер нь олон улсын жишгээрээ тухайн зээлийн барьцаанд байгаа эд зүйлс өөрөө даатгалтай байх юм бол үүн дээр 2-3%-ийн хөнгөлөлт зайлшгүй байна. Тэгэхээр малын индексжүүлсэн даатгал дээр дараагийн зээлийн эрсдэлд нөлөөлөөд байгаа нэг зүйл нь босго үзүүлэлт юм. Тухайн малын индексжүүлсэн даатгал маань өөрөө тухайн нэг малчны зээлийн эрсдэлийг хаадаггүй. Энэ бол системийн эрсдэлийг хаадаг. Тэгэхээр тухайн бүс нутгийн сумын малын хорогдлын босго үзүүлэлтээсээ хамаараад энэ эрсдэлийн хэмжээ нь бас өндөр байгаад байгаа юм. Тэгэхээр энэ босгыг тодорхой хэмжээнд бага зэрэг бууруулсан тохиолдолд малчны зээлийн хүү яг үүн дээр дагаад буурах боломжтой байгаа. Ипотекийн зээлтэй холбоотой, малчдын нийгмийн асуудалтай холбоотой зээлийн талаар гишүүн түрүүн хөндлөө. Энэ дээр Төв банкны зүгээс орон сууцын банкууд Санхүүжилтийн банкны тухай хуулийг Засгийн газартай хамтраад УИХ-аар өргөн бариад хэлэлцүүлээд явж байна. Энэ хүрээнд одоо явж байгаа энэ 6%-ийн хүүтэй зээл илүү орон нутагт ...

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг: Банкны хүүгийн эрсдэлийн 2-3%-ийг л би илүү тодруулж асуугаад байна л даа. Эрсдэлгүй үед яаж тооцож байгаа юм. Эрсдэлтэй үед өөрөөс хамаарсан эрсдэлт нөхцөл байдал үүссэн болон байгалийн онц ноцтой одоо эрсдэлт гээд ингээд энийг нь жоохон ялгамжтай харж яг энэ хүнд цаг үед нь үнэхээр одоо бид нар байнгын л 2-3%-ийн хүү аваад байгаа бол энэ дээр бас уян хатан байх зохицуулалтуудыг ер нь хийж болохгүй юу? Яагаад гэвэл малчдаас өөрсдөөс нь хамаарахгүйгээр байгалийн эрсдэлд орж байгаа, мал хуйгаа алдчихлаа, буцааж зээлээ төлөхөөсөө илүү бүр хүнд нөхцөл байдалд орчихсон ийм түүхийг бид нар хэдхэн жилийн өмнө харлаа шүү дээ. Нэг жил төлөлтийг нь хойшлуулах арга хэмжээнүүдийг авсан. Яах гэж бид нар 2-3%-ийн

зээлийн эрсдэлийн хүүг энгийн цаг үед хүртэл байнга аваад байгаа юм бэ, энэ нь яг хэзээ хэрэг болох юм бэ гэдэг дээр та хэд одоо ажиллаж болохгүй юу гэдэг санааг үндсэндээ хэлээд байгаа юм. Дахин 2 дахь санаа нь ер нь энэ Малчны тухай хууль дээр байгаа энэ хөнгөлөлттэй зээлд

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк хариулна, 17.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Хөнгөлөлттэй зээлтэй холбоотой асуудал дээр хүүгийн татаас болон бусад зээлийн батлан даалтын сан, малын индексжүүлсэн даатгалыг зохион байгуулж байгаа дэд бүтэц ч юм уу энэ чиглэлээрээ улсын төсөв дээр тодорхой хэмжээний төсвийн дэмжлэг суулгаад зээлийн хөнгөлөлтийг хийгээд явах зохицуулалттай. Энэ дээр арилжааны банк өөрийн эрх, үүргийн хүрээнд хадгаламж эзэмшигчдээс авч байгаа эх үүсвэрээ хэрвээ ЗГ энэ дээр нь тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх юм бол хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл гаргаад явах боломжтой байгаа. Эрсдэлийн хувь дээр мэдээж банк өөрийнхөө тавьж байгаа эрсдэлийнхээ үнэлгээгээр явж байгаа. Тэгэхээр эрсдэлийг нь яаж бууруулах вэ гэхээр хамгийн зөв тогтолцоо бол даатгал л байгаа юм. Түрүүн гишүүн хэллээ

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Ганхүлэг гишүүн үг хэлнэ.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг: Баярлалаа. Энэ банкны зээлтэй холбогдолтой асуудал чухал юм. Яагаад гэхээр малчдад бид ямар нэгэн халамж өгнө, тодорхой хэмжээний нэг удаагийн арга хэмжээ авна гэхээсээ илүүтэй суурь өөрсдийн аж ахуйгаа сайжруулахад нь зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хүүгийн дэмжлэгээр л үндсэндээ бусад улс орнууд ч тэр аж ахуйн салбараа босгож ирдэг. Тийм учраас зээлийн хүүг бууруулахтай холбогдолтой сая яриад байгаа асуудлыг бүрэн дүүрэн тодорхой хариулж чадахгүй байна. Одоо оруулах энэ боломжуудыг та хэд маань цаашдаа судлаач ээ. Хоршиж нэгдсэн малчдаа бас дэмжиж байгаа. Малчны тухай хуулиараа нэн болон хөнгөлөлттэй бусад төрлийн зээлийн хөтөлбөрүүдийг оруулж ирнэ гэдэг дээр санаачилгатай ажиллаач ээ гэдгийг хэлмээр байна. Үндсэндээ бол цаашдаа бид бүхэн халамжаас илүү ийм тодорхой боломжуудыг одоо бага хүүгийн дэмжлэгтэй ...

Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Малчдын зээлтэй холбоотой асуудал дээр асуулт асууж, хариулт авах гэж байна. Манай малчид ерөнхийдөө зээл аваад тэрийгээ харьцангуй төлөөд явдаг. Хэвийн зээлийн хувь хэмжээ харьцангуй өндөр байдаг нь хариуцлагатай бас ухамсартай байгаагийн шинж. Малчид маань талархалтай сайхан санагдаж байна. Хоёрдугаарт, шинэ хоршоо хөдөлгөөний талаар асууя. Шинэ хоршоо хөдөлгөөнийг 2024 оны эхээр ерөнхийдөө нэлээн идэвхтэй эрчимжүүлж, бүх төрийн албан хаагчдыг дайчлан орон нутагт ажиллуулаад шинэ хоршоо байгуулах, түүгээр дамжуулаад санхүүгийн үйлчилгээ авах боломжуудыг нээсэн. Энэ хөдөлгөөнд 1 их наяд төгрөг төлөвлөсөн байна. Үүнээс 894 буюу ойролцоогоор 900 орчим тэрбум төгрөг зарцуулагджээ. Цаана нь үлдсэн 100 орчим тэрбум төгрөг яасан бэ, Монгол банк хариулах боломж байна уу, хэвээрээ үлдээд байгаа юм уу, аль эсвэл өөр зүйлүүдэд зарцуулагдсан уу. Энэ талаар нэг хариулт авмаар байна.

Хоёрдугаарт, одоогоор зээлийн үлдэгдэл нь 758 тэрбум гэдэг чинь 150 орчим

тэрбум төгрөг төлөгдчихөөд байгаа юм шиг байна. Шинэ хоршоо хөдөлгөөний авсан зээлээс 150 тэрбум төгрөг одоо хаана байгаа вэ, үүнийг буцаагаад эргэлтэд оруулах уу? Одоо дахиад шинэ хоршоод байгуулагдаад төлөгдсөн байгаа 150 тэрбум төгрөгөөс зээл авч болох уу гэдэг талаар бас нэг хариулт өгнө үү. Ер нь Монгол банкнаас тавьж байгаа энэ мэдээлэл ХХААХҮЯ-ны мэдээлэлтэйгээ адилхан байгаа юу. Үүнийг ХХААХҮЯ-аас асуумаар байна. Бид 2025 онд шинэ хоршоо хөдөлгөөний талаар мэдээлэл авч байхад тухайн үеийн ХХААХҮ-ийн сайд, өнөөдрийн Тэргүүн шадар сайд Ж.Энхбаярын өгсөн мэдээлэлтэй арай л зөрөөтэй мэдээлэл яваад байх шиг санагдаад байх юм. Үүнд нэг ойлголт өгөөч ээ гэж хэлье. Гуравдугаарт, зээл олголтын зориулалт байна. Үржлийн мал худалдан авч бойжуулах дээр 57% байна. ХАА-н түүхий эд боловсруулах дээр 10 орчим хувь, мах сүү 7 гээд үндсэндээ дээд талын 3 төрлөөр 75% авсан байна. Үүнийг яаж шинжилж, бодитойгоор дүгнэж байгаа юм бэ. Энэ анх зээл авахдаа бичиж өгсөн тэр зээлийн мэдээллийн сангаас авч байна уу ...

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк хариулья, 17.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулья. Хоршооны зээлийн үлдэгдэл 100 орчим тэрбум төгрөгийг асууж байна. Шинэ хоршоо хөтөлбөр 2024, 2025 онд хэрэгжиж дууссан. 2025 оны 12 сарын 31-ний байдлаар банкинд хүсэлтээ ирүүлж зээл гарсан хэмжээ нь 900 тэрбум төгрөг. Энэ нь ЗГ-ын тогтоол дууссан, мөн тухайн жилийн 12 сарын 31-нээр тасалбар болоод, Төсвийн тухай хууль дуусгавар болсонтой холбоотой. Төсвийн дэмжлэг нь буюу татаастай хэмжээ нь дууссан. Тэгэхээр яг 2024, 2025 ондоо арилжааны банкинд дээр судлагдаад, амжаад материалаа ирүүлээд гарсан хэмжээ нь 900 тэрбум, нийт хөтөлбөр 90 орчим хувийн гүйцэтгэлтэй гарсан гэсэн үг. Түрүүний танилцуулга бол малчны зээлийн чанарын танилцуулга. Энэ бол хоршооны зээл биш. Хоршооны зээл 2024, 2025 онд олгогдоод эргэн төлөлтийн хөнгөлөлттэй нөхцөлтэй байсан учраас хамгийн анхны төлөлт нь 2026 оны 4 сард хийгдсэн. 2 сар гаруйн өмнөхөн анхны төлөлт нь хийгдсэн учраас энэ хоршооны зээлийн эргэн төлөлттэй холбоотой, зээлийн ангилалтай холбоотой, хэдэн хувь нь чанартай вэ гэдэг статистик гарах болоогүй. Энэ оны төгсгөл, дараа онд л гарна гэсэн үг. Малчны зээлийн хөнгөлөлттэй зээл дээр М.Ганхүлэг гишүүн бас асууж байсан юм. Энэ дээр бид бүхэн зээлийн хүү хамгийн өндөр боломж нь даатгал гэж үзэж байна. Даатгалын тогтолцоогоо боловсронгуй болгож малын индексжүүлсэн даатгалдаа 70, 80, 100% хамрагддаг болчихвол зээлийн хүү дор хаяж 3-4% буурч ердийн хэрэглээний зээлтэй ижил түвшинд очно. Засгийн газар 2024, 2025 онд дуусгавар болгосноор дахиж сунгаагүй, төсөв дээр хөрөнгө тавиагүй, Төсвийн тухай хууль дээр ...

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ХХААХҮЯ-аас Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулья.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Л.Чой-Иш: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуй, генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Чой-Иш Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулья. Малчдад олгосон хоршооны зээлийн мэдээллийг Монгол банк, манай яам 2 мэдээллээ нэгтгээд ижил мэдээлэлтэй байгаа. Тэгэхээр гүйцэтгэлийн асуудал арилжааны банкууд дээр байгаа, арилжааны банкуудаас болон Монгол банкнаас мэдээллийг харилцан солилцоод нэг мэдээлэлтэй байгаа гэж хэлмээр байна.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ц.Мөнхбат гишүүн тодруулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат: Хөтөлбөрийн зээл дууссан учраас өнгөрсөн. Үржлийн мал худалдан авах зээлийн зориулалт яг бодитой юу гэдэг дээр дахиад арай тодорхой хариулт өгнө үү. Анх зээл авахдаа ингэж бичээд авчихдаг, зээлээ авсан хойноо өөр зүйлд зарцуулсан юм биш байгаа гэдэг юм байдаг. Орон нутагт очоод уулзалт хийхээр малчны зээлийн асуудлууд, Малчны тухай хуулийн асуудлууд дандаа дурдагддаг. Манай малчид энэ зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй, машин тэрэг авсан, эсвэл хуучин том хүүтэй зээлүүдээ төлсөн гэж ярьдаг. Энэ бодитой байна уу худлаа яриад байна уу? Хоёрдугаарт, энэ нь өөрөө улс төрийн зорилготой том хөдөлгөөн байсан. Хөтөлбөр байсан, тэгээд үр дүндээ ч хүрсэн. Тэгэхээр энэний араас одоо ингээд асуулт асууж хариулт ...

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк тодорхой хариулаарай. Энэ зээл яг зориулалтаараа зарцуулагдсан уу? Энэ зээл арилжааны банкнаас гарч байгаа зээл тийм үү? Төслийн зээл биш. 17 номер.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Энэхүү шинэ хоршоо хөдөлгөөн маань өөрөө Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зээлийн батлан даалтын сан, арилжааны банкууд, Төв банк оролцоод явж байгаа. Төв банкны зүгээс зээлийн зориулалттай холбоотой хяналт шалгалтыг зөвхөн зээлийн гэрээнд оролцогч буюу зээлийн хүүгийн татаасыг өгч байгаа байгууллагын хүсэлтээр хяналт шалгалтыг хийдэг. Одоогийн байдлаар зээлийн зориулалттай холбоотой нэгдсэн хяналт шалгалтыг Төв банк хийгээгүй. Арилжааны банкууд өөрсдөө дотоод хяналтынхаа схемийн хүрээнд зээлийн зориулалттай холбоотой хяналт шалгалтыг хийгээд явж байна. Одоогийн байдлаар дүгнэлт нь бүрэн эцэслэж гараагүй байна. Яагаад гэвэл дөнгөж энэ оны 4 сард хамгийн анхны төлөлт гарч байна. Тэгэхээр энэ оны 9 сараас эхлээд ХХААЯ, манайх хамтраад зээлийн зориулалттай холбоотой шалгалтыг бол ...

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн: Өнөөдрийн сонсголд оролцож байгаа та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Монгол банкнаас өгсөн мэдээлэлтэй холбогдуулаад хэд хэдэн зүйлийг онцолж тодруулж асууж, хэлэхгүй бол болохгүй байна. Өнөөдөр энэ малчдад олгож байгаа, Мал аж ахуйн салбарт олгож байгаа зээлийн багцын чанар, хугацаагаар нь аваад үзэх юм бол үндсэндээ малчид хамгийн сайн хариуцлагатай зээлдэгчид байгаа юм. 96,3% нь хэвийн зээл буюу чанартай зээл байгаа юм. Гэтэл өнөөдөр бизнесийн хэвийн, ердийн зээлээс бараг 5, 6%-аар илүү өндөр хүү төлж байна. Хамгийн өндөр хүүтэй зээлийг төлж байна. 24, 25%-ийн зээлийн хүүг төлдөг хариуцлагатай зээлдэгч мөртлөө энэ салбарыг банкнаас хамгийн эрсдэлтэй салбар гэж үзээд байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болсон энэ салбарт энэ төрөөс, Монгол банкнаас зээлийн хүүг бууруулахтай холбоотой асуудлыг нэгд, хийхгүй байгаа юм бэ? Би даатгал руу чихэж байгаа ийм нөхцөл байдлаар хариулт авмааргүй байна.

Нэгдүгээрт, та бүхэн яагаад малчин хүний хөдөлмөрийг, хөрөнгийг зах зээлийнх нь хэмжээнд нь үнэлэхгүй байгаад байгаа юм бэ гэдэг асуудал. Бид Малчны тухай хуулийн 9.7 дээр мал болоод малын гаралтай түүхий эдийг чанар баталгаажуулж зах зээлийнх нь ханшид суурилсан хөрөнгийн үнэлгээг бий болго гэдэг асуудлыг тавьсан. Санхүүгийн энэ шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүл гэдэг

асуудлыг тавьсан. Өнөөдөр малыг бодитоор нь үнэлэх ёстой. Малчин хүний тэр хөдөлмөр, хөрөнгийг нь бид нар үнэгүйдүүлж болохгүй болчихоод байна, зах зээлийнх нь ханшид суурилж хөрөнгийн үнэлгээг нь бүрдүүлэх ёстой. Өнөөдөр Монгол Улс 60 сая малтай гэх юм болбол энэ 60 сая малын үнэлгээ нь хэд юм бэ? Та бүхэн зээлийн мэдээллийнхээ сан дээрээ барьцаа, баталгаанд тавихдаа малыг тэр малчин хүний өв хөрөнгийг яаж үнэлж байгаа юм бэ? Энэ дээр Монгол банк журам гаргаад зах зээлийнх нь бодит ханшаар нь тогтоох үнэлгээний аргачлалыг гаргаж өгөх ёстой. Дээрээс доошоо банкнууд энэ журмаа гаргаад хэрэгжүүлэх ёстой. Хөдөө аж ахуйн мэргэшсэн үнэлгээчдийг, хөрөнгийн үнэлгээчдийг бид нар бий болгох ёстой болчихоод байгаа юм. Үүнийг хэзээ хийх юм бэ? Энэ хууль хэрэгжээд 2 жил болсон байна. Өнөөдөр малыг бодитоор нь үнэлнэ гэх юм бол уламжлалт энэ тоонд суурилсан санхүүгийн тогтолцоогоо бид нар хэзээ өөрчлөх юм бэ. Уламжилсан санхүүгийн тогтолцоогоо, тоон дээр суурилсан, зөвхөн 200 малтай бол, 500 малтай бол хэдэн төгрөгийн зээл олгоно гэдэг хэдэн сая төгрөг өгнө гэдэг. Гэтэл энэ нь амьдын жингээс эхлээд үүлдэр, угсаа, ашиг шим, эрүүл баталгаатай мал гэдгээс хамаараад тусдаа өөр үнэлгээтэй, үнэ цэнтэй байх ёстой. Ингэж байж тооноос чанарт шилжих эдийн засгийн хөшүүрэг нь өөр болох юм. Үүнийг амар хялбар аргаар тоогоор, бүхлээр нь тоолоод байдаг, малчин хүний хөдөлмөр, өв хөрөнгийг нь үнэгүйдүүлж болохгүй байхгүй юу? Эсвэл ХАА-н салбарыг та нар номхон тэмээ ноолоход амархан гэдэг шиг хамгийн эрсдэлтэй салбар гэж авч үзээд хамгийн өндөр хүүг хамгийн хариуцлагатай зээлдэгчдэдээ өгч байгаа чинь болж байгаа юм уу?

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк хариулъя.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Малчдын зээлийн чанар өндөр байгаатай холбогдуулан зээлийн хүүг бууруулах боломжтой гэж таны үзэж байгаатай санал нэг байна. Гэхдээ энэ дээр арилжааны банкнууд өөрсдийн эх үүсвэрээр зээл олгодог, өөрсдийн гаргаж байгаа зардал болон бусад зүйлсээ тооцож зээлээ олгодог гэдгийг хэлэх гэсэн юм. Төв банкнаас малчдын зээлийн хүү тодорхой үе шаттайгаар буурах боломжтой болгоод бодлогын зохицуулалтуудыг хийгээд явах нь зүйтэй гэдэг дээр тантай санал нэг байна. Зээлийн хүү 2-3%-аар илүү өндөр байгаа нь дийлэнхдээ хөдөө орон нутагт бодит, биет салбар ажиллуулж байгаатай холбоотой зардал гарсантай холбоотой. Орон нутагт ажиллаж байгаа салбарууд маань малчид дээр биеэр очиж зээлийг судалж, малыг нь үзэж зээлийн бүрдүүлэлт хийж байж зээлийг олгож байгаа. Орон нутагт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын цалин, бусад зардлууд гарч байгаа учраас 2-3%-ийн зээлийн хүүгийн илүү байгаа гэдгийг арилжааны банкнуудаас Төв банкинд тайлбар ирүүлсэн. Ер нь илүү цахимжиж, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой болж байж зээлийн хүү буурах боломжтой нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь зээлийн эрсдэлтэй холбоотой асуудал дээр тухайн зээлийн барьцаанд байгаа МАА, мал маань өөрөө бас байгаль цаг уур, зуд, бусад асуудлаас болж эрсдэлтэй барьцаа хөрөнгө гэдэгт орж байгаа учраас арилжааны банкуудаас ийм асуудлыг тавьж байгаа. Төв банк ойрын хугацаанд хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудлыг холбогдох байгууллага, Сангийн яамтай харилцан ярилцаад мэргэшсэн ХАА-н салбарын хөрөнгийн үнэлгээчдийг бэлдэх, зээлийн барьцаа хөрөнгийг зүй зохистой үнэлэх чиглэл дээр холбогдох Сангийн яам болон хөрөнгийн үнэлгээний асуудал эрхэлж байгаа байгууллагууд, Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын асуудлуудтай танд дэлгэрэнгүй, тодорхой хариултыг

дараа нь албан бичгээр өгье.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн: Би Монгол банкнаас саналыг нь асуугаагүй. Би Монгол банкнаас хууль тогтоогчийн хувиар өөрөө хуулийн хэрэгжилтийг шаардаж байгаа. Энэ хууль дээр заасан 9.7 дахь заалтыг та бүхэн хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хуулийн заалт хэрэгжиж эхлээд 2 жил болж байна. Монгол банк үүний дагуу журам гаргах ёстой. Сангийн яамтайгаа хамтарч үнэлгээний аргачлалыг нь бий болгох ёстой. Монгол банк эрсдэлтэй салбар гэж үзээд байгаа бол энэ салбарыг яагаад та бүхэн эдийн засгийн салбар гэдгээс нь харахгүй байгаад байгаа юм. Энэ салбарт оролцогч мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч малчдыг яагаад эдийн засгийн оролцогч талаас нь харахгүй байгаад байгаа юм. Эдийн засгийн зөв хөшүүргийг бий болгохгүй байгаад байгаа юм. Энэ бол эдийн засгийн шинэ сэтгэлгээний шилжилт болох ёстой асуудал байгаа юм. Өнөөдөр мал аж ахуйн салбар дээр бид энэ шинэчлэлийг хийхийн тулд Монгол банк өөрөө санаачилгатай байх ёстой. Үүний үүднээс би бүр зах зээлийн ханшид суурилсан хөрөнгийн үнэлгээг бий болго гэдэг асуудлыг тавьсан. Малчин хүний хөдөлмөрийг зөвөөр үнэлдэг, зах зээлийнх нь зарчмаар бодитоор үнэлдэг байх аргачлалыг бий болго гэдэг асуудлыг тавьсан. Энэ асуудлыг л асууж байгаа. Өнөөдөр энэ бизнесийн салбар юм болбол энэ яагаад бусад бизнесийн салбар ...

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Хөрөнгийн үнэлгээний асуудлыг Засгийн газар буюу Сангийн яам хариуцдаг. Төв банк зээл олгож байгаа байгууллагуудын үйл ажиллагааг буюу арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулж байгаа. Тэдгээрийн үйл ажиллагаанд оролцож байгаа хөрөнгийн үнэлгээний асуудлыг Төв банк өөрөө хөрөнгийн үнэлгээгээр үнэлүүлээд энэ хөрөнгийн үнэлгээ чинь ийм байх ёстой, та хэд ийм нөхцөлөөр зээлээ олго гээд явах юм бол харилцан хяналтын тогтолцоо чинь байхгүй болчихно шүү дээ. Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал чинь хуулиараа, байгаа бүх хуулиараа энэ бол ЗГ-ын асуудал. Энэ дээр бол Төв банк хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал дээр хөндлөнгөөс оролцох хууль эрх зүйн хувьд ямар ч боломж байхгүй. Энэ чинь болохгүй шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Тэмүүлэн гишүүн

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн: Монгол банкныхаан би та бүхнийг Монгол Улсын банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа энэ салбарыг хариуцаж байгаа бол ажлаа хариуцлагатай хий гэдэг асуудлыг тавиад байгаа юм шүү. Хүссэн ч, хүсээгүй ч үүний чинь ард бүхэл бүтэн салбарын асуудал, эдийн засгийн асуудал байна. Үүний ард байгаа олон мянган малчдын асуудал байгаа. Тэр хүмүүсийн өв хөрөнгийн асуудлууд байгаа. Энэ дээр би хийх ёсгүй, энэ надад хамаагүй гэдэг байдлаар хандаж болохгүй шүү. Хүссэн ч, хүсээгүй ч банкнаас олгож байгаа зээлийн асуудлууд дээр Монгол банк хариуцлага хүлээх ёстой, энэ салбарыг эрүүл байх, зах зээлийнх нь зарчмаар явуулах, хөрөнгийг бодитоор үнэлэх асуудлууд дээр үнэлгээний аргачлалыг бий болгох асуудлууд дээр болбол та бүхэн хариуцлага хүлээнэ. Сангийн яам энэ дээр бас хариуцлага хүлээнэ. Сангийн яам бас байна уу? Өнөөдрийн энэ хуралд яг хариуцлагатай

албан тушаалтнуудыг нь оролцуул. Яахаараа дандаа төрийн нарийн бичгүүд ордог юм, яахаараа дандаа дэд дарга нар ордог юм бэ.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тэмүүлэн гишүүний хэлсэнчлэн Монгол банк УИХ-ын дэргэдэх байгууллага. Улсын Их Хурлын гишүүдээс болоод УИХ-аас гаргаж байгаа саналыг боловсруулахад, бодлого болгож гаргахад туслах, бодлого болгож гаргах үүрэгтэй шүү. Г.Энхтайван Ерөнхийлөгч өө үүнийг анхаарч бас хариултдаа анхаарч цаашид ажиллана шүү. Ингээд Гомбын Ганбаатар гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар: Өглөөний мэнд. Энэ сонсгол ч уг нь яах вэ дээ. Монгол Улсын Их Хурлаас гаргасан олон сайн хуулиудын нэг гэж би үздэг малчдын талаар. Харамсалтай нь хэрэгжүүлээгүй, бас зарим нэг албан тушаалтнууд хэрэгжүүлэх сонирхол байсангүй. Ялангуяа малчдын нийгмийн баталгаа, малчдын нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэх гээд олон асуудал дээр үндсэндээ хойрго хандсан. Түрүүн хэн нь хэлчихэв энэ малчдын сонсголын ар дээр тэр хууль хэрэгжүүлээгүй улсуудад заавал хариуцлага тооцдог байгаач гээд. Энэ саналыг би их зөв зүйтэй санал гэж үзэж байгаа. Ер нь УИХ одоо гаргасан хууль тогтоомжийнхоо араас хяналт тавьдаг системээ улам боловсронгуй болгох хэрэгтэй. Өнөөдөр 937 хууль Монгол Улсад үйлчилж байна. Яг нийгмийн харилцааг зохицуулж байгаа нь 300, 400 орчим хууль л байна. Эдгээр хуулиудын хэрэгжилт дээр нь хяналт тавих асуудал зайлшгүй байгаа. Сонсголын гол ач холбогдол энэ юм. Бид өнөөдрийн сонсголоороо малчдын Хөдөө аж ахуйн салбарын санхүүгийн хүртээмжийн асуудал, санхүүгийн үйлчилгээний асуудлын тухай ярьж байна. Монгол банкнаас 2 асуулт байна. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсын санхүүгийн нийт зээлийн үлдэгдэл 43,8 их наяд байгаа юм байна. Гэтэл Хөдөө аж ахуй ялангуяа энэ малчдад олгосон зээл чинь, малчдад олгосон 1,1 их наяд 22%-ийн хүүтэй олгосон зээл чинь. Шинэ хоршоогоор олгосон зээл чинь 894 тэрбум байна. Ингээд 2 их наяд орчим байна л даа. Өөрөөр хэлбэл нийт санхүүгийн зах зээлийн 5 орчим хүрэхгүй хувь байна. Малчны тухай хуулийн 13 дугаар зүйлд малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах нэг гол заалт байгаа юм. Тэгээд энэ сумдууд ч ажлаа хийхгүй байна. Дээрээс нь тэр хуулийн 13.2.6 дээр “хуулиар хориглоогүй бусад санхүүжилтийн эх үүсвэр” гэдэг үүнийг та бүхэн ер нь энэ хуулийг үзэж байгаа юу Монгол банкаа? Та бүхэн энэ чиглэлээр малчдыг дэмжих чиглэлээр заалтыг ашиглаад ямарваа нэгэн юм хийж байна уу?

Хоёрдугаарт, Монгол банкны Г.Энхтайваны хийсэн мэдээлэлд малчдын зээл 1,8 % нь чанаргүй гэж ярьсан. 1,8 % чинь ингээд нийтдээ гаргасан зээлийнхээ 19,8 тэрбум нь л юм байна. Бодвол 1,8 гэдэг чинь 2023, 2024 он дамнасан их зуд, зуд гэхээсээ илүү гамшиг болсон шүү дээ үүнтэй холбоотой тэр чанаргүй зээл 1,8 хувьд хүрсэн юм болов уу гэж би хувьдаа бодож байна. Тэгэхлээр энэ нь 2023, 2024 он дамнасан зуднаас улбаатай болов уу. Ер нь аливаа гэрээнд банк ч бай ямар ч гэрээнд нэг форсе мажорын тухай ойлголт байдаг. Давагдашгүй хүчин зүйлийн тухай ойлголт. Та бүхэн энэ давагдашгүй хүчин зүйлийг малчдын эрх зүйн мэдлэг бас дутмагийг ашиглаад энэ гэрээний заалтыг ерөөсөө биелүүлэхгүй харагдаад байдаг. Үүнтэй холбоотой 2023, 2024 оны зудыг хэрвээ байгалийн гамшиг форсе мажор гэж, байгалийн гамшигт үзэгдэл гэж үзэх юм бол та бүхэн энэ 1,8%-ийн чанаргүй зээлээ бараг хүчингүй болгох боломжтой. Яагаад вэ гэхлээр энэ чинь гэрээнийхээ малчин, банк 2 гэрээ яаж хийдгийг би мэдэхгүй байна л даа тэгэхлээр энэ байдлаар 1,8 хувийнхаа чанаргүй зээлийнхээ дансыг цэвэрлэх, цаашдаа бас энэ малчдад санхүүгийн зээлийн хүртээмжийг нь илүү олгох талаар боломж бий юу гэсэн 2 асуулт байна даа. Дараа нь тодруулга авъя Монгол банкнаас.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монгол банк хариулъя, 17 номерын микрофон.

Монгол банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Г.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2023, 2024 онд дамнаад гарсан энэ байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал, зудын хүрээнд бол Төв банк өөрийн хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хүрээнд малчны зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан байгаа. Эргэн төлөлтийг хойшлуулна гэдэг нь тухайн арилжааны банкнаас зээл авсан малчин өрх яг тухайн зээлийнхээ эргэн төлөлтийг ойролцоогоор 2 жил орчмын хугацаанд, жил хагасын хугацаанд ямар нэгэн зээлийн ангилал хийгдэхгүйгээр банкиндаа зээлээ төлөхгүй байж болно гэсэн зохицуулалтыг хийж өгсөн байгаа. Төв банк хуулиараа яг ийм зохицуулалтыг зээлийн эргэн төлөлтийг хойшлох, актив ангилахгүй байх тийм хуулийн эрхтэй байгаа. Түүнээс биш яг малчин өрх маань өөрөө арилжааны банктай хоорондоо Иргэний хуулийн дагуу гэрээ байгуулаад зээл аваад явж байгаа. Тэгэхээр 2 хүний хоорондоо байгуулсан гэрээнд гуравдагч этгээд хөндлөнгөөс оролцох тийм эрх байхгүй буюу зээлийг төлөхгүй, зээлийг тэглэх тийм зохицуулалт бид бүхэнд байхгүй. Тэгэхээр үүнийг одоо тэтгэврийн зээл тэглэж байсантай ижлээр УИХ хууль гаргаж л шийдэх эрх зүйн зохицуулалттай байгаа. Ер нь Төв банк малчны зээлийн хүү тодорхой хэмжээнд бууруулах талаар, бүх л талаар дан ганц малчны зээл ч гэхгүй бүх л зээлийн хүүгээ ер нь бууруулах талаар бүхий л зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч байгаа. Гэхдээ бид бүхэн бас тодорхой хэмжээний мэдээж энэ бол арилжааны банкны өөрийн эх үүсвэрээр олгогдож байгаа зээл учраас зээлийн өртөг ийм байгаа гэдгийг сайн ойлгох хэрэгтэй.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүн тодруулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар: Та бүхэн анзаарсан бол нийт Монгол банкнаас санхүүгийн салбараас олгосон зээлийн чинь 57% нь, тэр 513,1 тэрбум төгрөг чинь дандаа малчид мал үржлийн мал худалдан авсан гэсэн мэдээлэл байдаг юм шүү дээ. Хэрвээ энэ санхүүгийнх нь хүртээмж сайн байгаад, зээлийнх нь хүү бага байх юм бол ер нь явж явж малчид чинь энэ хотод үнэтэй байгаа махны чинь асуудлыг шийднэ шүү. Санхүүгийн хүртээмж нь ийм өндөр 22%-ийн хүүтэй зээл аваад байгаа малчид, энэ байгаль цаг уурын эрсдэлд үйл ажиллагаа явуулж байгаа малчид цаашдаа бол махны үнэ буурах боломж байхгүй. Аль аль талаа бодолцоод нөгөө талдаа тэр 19,8 тэрбум төгрөгийг яаж ч шийдэх боломжтой байгаа шүү дээ. Тэгээд активаа цэвэрлээд авчих боломж байхгүй юм уу? Хуулийн хэрэгжилтэд сонсголын үр дүнгээ үндэслэн Улсын Их Хурлаас ажлын хэсэг гаргаад анхаарах хэрэгтэй гэж бодож байна. Мөн холбогдох яамдууд хууль хэрэгжүүлэхгүй байгаад хариуцлага тооцох асуудлыг ерөнхий хяналтын сонсгол дээр зориуд оруулж байгааг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сонсголоор төрийн байгууллагуудаас асуулт асууж, тодруулснаар хаана, ямар алдаа дутагдал гарч, хариуцлага алдаж байгаа талаар бид бас мэдээлэл өгөх үүрэгтэй. Энэ мэдээллийн дагуу Засгийн газарт чиглэл өгнө. Тэгэхээр хариуцлагатай холбоотой асуудлуудыг хэдүүлээ тодорхой бодлогоор Засгийн газар луу явуулна.

Би Г.Энхтайван Дэд ерөнхийлөгчөөс нэг зүйл асууя. Танай Ерөнхийлөгч С.Наранцогт байгаа юу? Ирээгүй шалтгаан юу вэ? Монгол Улс даяар харж байгаа

шүү. Сая гишүүд хэлсэн, баталсан хууль дээр Улсын Их Хурал өөрөө хяналт тавьдаг ийм процессыг бид эхлүүлж байгаа. Энэ бол ард иргэдэд хүрч байгаа хуулийг чанартай болгох асуудалд асар том алхмыг хийж байгаа. Тийм болохоор ард иргэдийн өмнө хүндэтгэн хүрэлцэн ирж, ажлаа тайлагнаж, асуултад хариулах үүрэгтэй учраас би танаас ямар учир шалтгаантай ирээгүйг асууя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: 6 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Төв банкны Мөнгөний бодлогын хорооны ээлжит хуралтай байгаа. Өнөөдрийн хурлаар зах зээл дээр үүссэн нөхцөл байдал болон олон улсын хориг арга хэмжээтэй холбоотой танилцуулгуудыг сонсож байгаа. Улирал бүрийн сүүлийн 7 хоногийн 3, 4 дэх өдрүүдэд манай Мөнгөний бодлогын хороо хуралдаж бодлогын хүүг шинэчлэн тогтоодог. Яг одоо Улсын Их Хурлаас томилогдсон хараат бус гишүүдтэйгээ бүгдээрээ хуралдаж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монголбанк бол Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага. Улсын Их Хурлыг хүндэтгэж ирэх ёстой. Үүнийг дамжуулаарай. Одоо О.Алтангэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

УИХ-ын гишүүн О.Алтангэрэл: Малчдын асуудал болохоор яаж хандаж байгаа байдал нь харагдаж байна шүү дээ. Монголын олон зуун мянган малчдын асуудал яригдаж байхад хорооны хурлаа Дэд ерөнхийлөгч та нар удирдаад явуулж болдоггүй юм уу? Яах гэж та нар байгаа юм. Улсын Их Хурал дээр хуулийн хэрэгжилтээ ярихаас илүү хорооны хуралтай гээд тайлбарлаад сууж байдаг, ийм Монголбанктай байх юм уу. Сая баахан статистик ярьж байна. Би бүр тодорхой асууя. Өмнөх хамтарсан Засгийн газрын үед ноолуурын салбарыг дэмжиж зээл олгосон, хүүг нь төрөөс төлсөн. Ноолуурын салбар харьцангуй боссон. Монголын ноолуурын салбарын үйлдвэрлэгчид нэлээн тэнхээтэй болсон гэж ойлгож байгаа. Тэгэхээр зүгээр нэг зээл өгдөг, өөрөөр хэлбэл малчид гэж төрөөс юм нэхсэн хүмүүс юм шиг худлаа ойлголт олон нийтийн дунд өгдөг. Энэ тийм биш ш дээ. Бүгд адилхан, малчид чинь бас татвараа төлөөд амьдарч байгаа.

Тэгэхээр Монголбанк эдийн засгаа тооцохдоо малчдын эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөө, ач тусыг тооцох тооцоолол байна уу? Ямар хэмжээний баялаг бүтээж улс орны хөгжил дэвшилд оролцож байгааг мөнгөн дүнгээр илэрхийлж, ноолуур, мах, түүхий эд нь эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг тооцдог шалгуур үзүүлэлт байна уу?. Би маш тодорхой асууж байна шүү.

2 дугаарт, ипотекийн зээл гээд ярьж байна. Өнөөдөр сум орноосоо ипотекийн зээл авчихсан малчид тун цөөхөн, малчдад байтугай залуучуудад олдохгүй байгаа. Үүнийг хэрэгжүүлж чадах уу, өнөөдрийн байдлаар хэдэн малчин ипотекийн зээл авсан юм бэ? Хамруулж чадахгүй байгаа шалтгаан, цаашид хамруулах уу, ипотекийн зээлийн байдал ямар байна гэсэн тодорхой 2 асуултыг Монголбанкаас асууя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монголбанк хариулъя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Манай улсын ДНБ өнгөрсөн оны төгсгөлөөр 92 их наяд байгаа. Үүний 27 хувийг ХАА-н салбар дангаар бий болгож байгаа гэсэн үг. ХАА-н салбарынхаа 68 орчим хувийг МАА-н салбар эзэлж байна. ХАА-н салбар тэр дундаа МАА-н салбараас экспортын орлогоор 297 орчим сая ам.долларын мах, 330 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ноолууран бүтээгдэхүүн экспортод гарсан. Нийт статистикийн хувьд ХАА-н болон МАА-н

салбарт ажиллаж байгаа малчдын эдийн засагт оруулж байгаа хувь хэмжээг 21 орчим хувь гэж Төв банк болон Үндэсний статистикийн хорооноос гаргасан.

Ипотекийн зээлтэй холбоотой асуудал хүндрэлтэй байгаа. Нийт олгогдож байгаа ипотекийн зээлийн 27 орчим хувь нь орон нутагт, үүний 25 орчим хувь нь аймгийн төвүүд болон дагуул хот болох Дархан-Уул, Эрдэнэтэд олгогдсон. Арилжааны банкаар дамжаад сумын төв дээр ипотекийн зээл авах асуудал барилгын хүрэлцээ, баригдаж байгаа барилгын тоо хэмжээнээс хамаараад харьцангуй бага байна. Одоо Орон сууцны санхүүжилтийн банкны тухай хуулийг өргөн барьсантай холбогдуулан 6 хувийн зээлийг зөвхөн орон нутагт олгох зохицуулалттай болж байгаа буюу Улаанбаатар хотод 6 хувийн энэ зээлийг дахин олгохгүй байх чиглэлийг Төв банкнаас барьж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ хууль хэрэгжихээр орон нутагт хэрэгжүүлж байгаа ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэмжээ нэмэгдэнэ. Ипотекийн зээлийг яг хэдэн малчин өрх авсан талаарх тоон мэдээллийг мэдэхгүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: О.Алтангэрэл гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн О.Алтангэрэл: Ийм л хариулт өгч байна л даа. Нэг зүйлийг Монголбанканд зориуд хэлмээр байна. Ж.Бат-Эрдэнэ дарга энэ сонсголын дараа чиглэл өгөхдөө бодно биз. Ганцхан Малчны тухай хууль гэлтгүй бусад олон хуулиар Монголбанканд хүлээчихсэн үүрэг байгаа. Хууль тогтоох дээд байгууллагаас сонсгол хийж, асуудал тавьж байгаа бол тоо баримтуудаа нягталж, бэлдэж ирмээр байна. Хэн нэгэн төлөөний хүн явуулдаг, тэр нь ирээд хэдэн статистик тоо хэлээд ам тагладаг.

ХАА-н салбар дээр 25 хувь гэх, тийм өндөр болчихсон юм уу, үүнийг тодруулъя даа. Дараа ийм байдалтай баймааргүй байна, цаашдаа Монголбанкныхан үйл ажиллагаандаа анхаарах ёстой гэдгийг хэлье. Өөр санал, асуулт байхгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Одоо Д.Батбаяр гишүүн алга байна. Х.Баасанжаргал гишүүн.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Би малчдын зээлтэй холбоотойгоор малчны зээлийн хүүг бууруулах ямар арга замууд байж болох вэ? Ямар бодлого байна гэдгийг тодорхой асууя. Түрүүн М.Ганхүлэг, Г.Тэмүүлэн гишүүд асуулаа. Энэ зээлийн хүүг бууруулах ямар боломж байгаа талаар. Гэвч зөвхөн даатгалтай холбоотой байдлаар эрсдэл өндөр гэдэг утгаар, эсвэл хөдөө орон нутагт банкнууд үйл ажиллагаа явуулахад зардал өндөр байдаг гэдэг утгаар нь тайлбарлаад хаацайлаад өнгөрч болохгүй гэж бодож байна. Олон хувилбарыг бид бодож олж, бодлогын хувилбарууд дээрээ бид мэтгэлцмээр байна гэсэн үг.

1 дүгээрт, хоёр мянган хоньтой малчин, 300 үхэртэй тогтмол сүүгээ нийлүүлдэг 2 малчин зээл авах өнөөдөр яг адилхан байна. Хоёулаа яг адилхан зээлийн хүү төлж байгаа. Гэтэл энэ хоёрын хоёулангийнх нь нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөө, бүтээмж гээд асар олон зүйл дээр маш их ялгаатай байгаа энэ ялгааг бид жишээ нь, зээлийн хүү дээр тооцож болохгүй юу гэсэн үг.

1 дүгээрт, хэрвээ малчин даатгалд даатгуулсан бол зээлийн хүү 1-2 хувь буурах боломжтой юу? Тэгвэл нөгөө талдаа даатгалд даатгуулах сэдэл нь өөрөө

нэмэгдэнэ, тийм үү?

2 дугаарт, сүүлийн 3 жил, 5 жилд зээлээ тасралтгүй сайн төлсөн бол зээлийн хүү дахиад 2 хувиар буурна. Тэгэхээр тэртээ тэргүй өндөр чадамжтай зээлийн төлөлт эргэн төлөлт сайтай байгаа учраас үүнийг нь үнэлсэн үнэлгээ гаргаж ирээч ээ гэсэн үг.

3 дугаарт, тогтмол худалдан авагчтай бол зээлийн хүү дахиад 2 хувь буурна. Ийм байж болно биз дээ. Тэгэхээр эрсдэлийг нь зөвхөн малаар тооцох биш орлогыг нь тооцож үзээд тогтмол орлоготой байх хөшүүргээ бид зээлийн хүүгээрээ дамжуулж гаргаж ирмээр байна. Тэгэхээр зээлийн хүүгийн яг энэ хувилбарууд дээр ямар боломжууд, уялдаанууд, бодлогын хувилбарууд байгааг түрүүнээс хойш гишүүд асуугаад байна гэж бодоод байна. Энд бүтээлч байдлаар, гэхдээ энэ огт байхгүй зүйл биш, дэлхийн олон улс орнууд янз бүрийн байдлаар зээлийн хүүг бууруулах олон арга нэвтрүүлээд байгаа. Бид л хамгийн залхуу аргыг сонгоод зөвхөн малыг нь тоолоод, өвөл зуд болох вий гэдэг 2 хүчин зүйл дээр зээлийн хүү яваад байна. Тэгэхээр энэ залхуу аргаасаа татгалзаад, бүтээлч байдал руу шилжих бодлогын боломжийн талаар Монголбанк юу бодож, юу төлөвлөж байна вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монголбанк хариулъя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: О.Алтангэрэл гишүүний асуусан тоог хэлье. Улаанбаатар хотод болон аймаг, орон нутгийн төв суурин газруудад 11,115 малчин өрх ипотекийн зээлд хамрагдсан. Тэдний дийлэнх нь өөрийн үр хүүхэд, ах дүү, хамаатан садантайгаа хамтран зээлд хамрагдсан.

Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Түрүүн таны хэлдгээр хэрэв сүүгээ зарж байгаа бол энэ дээр илүү хөнгөлөлттэй нөхцөлтэй байх ёстой гэдэг дээр арилжааны банкнууд мэдээж ажиллаад явдаг. Жишээлбэл, Хаан банк зөвхөн орон нутгийн фермерийн үйл ажиллагааг дэмжсэн зээлийг олгоод явж байгаа. Энэ нь малчны зээлийн ангилалд орохгүй, ХАА-н зээлийн ангилал гэдэгт хамаарна. Жишээ нь, махны чиглэлийн фермерийн үйл ажиллагаа явуулаад худалдан авагч нь бэлэн байвал энэ дээр хөнгөлөлттэй нөхцөл байгаа.

Даатгалд бүрэн хамрагдаад явахад 3-4 хувиар зээлийн хүү буурах боломжтой гэдэг судалгаа байгаа. Орон нутагт Малчны тухай хуульд заасны дагуу хөнгөлөлттэй нөхцөлтэй төрийн санхүүгийн үйлчилгээ гэдэг дотор банкны үйл ажиллагаанаас гадна даатгалын үйл ажиллагаа явагдаж байгаа. Тэгэхээр даатгалынхаа үйл ажиллагааг сайжруулбал эрсдэлийн үйл ажиллагаа нэг талаасаа буурах боломж, нөгөө талдаа энэ бол хүртээмжийн асуудал буюу зээлийн багцын хэмжээ буюу тухайн ХАА-н салбарт оногдож байгаа зээлийн мөнгөн хөрөнгийн хүрэлцээний асуудал байгаа. Тиймээс нийт арилжааны банканд байгаа хадгаламжийн хэмжээ нэмэгдэж байж тодорхой хэмжээний хүү буурч, хүртээмж нэмэгдэнэ гэсэн үг. Төв банк өөрийн бодлогын зохицуулалтаа тодорхой хэмжээнд, зээлийн багцын хооронд шилжүүлэлт хийсний үндсэн дээр, шилжүүлэлт хийх боломжийг арилжааны банкнуудтай ярилцаж байгаа. Зээлийн хүү гэдэг эрсдэлээсээ хамаарч байгаа учраас арилжааны банкиг тэдэн хувийн хүүтэй тийм зээл олго гэдгийг Төв банкнаас тулгалт хийх нь зохистой арга хэмжээ биш гэж үзэж байгаа. Бид малчны зээл дээр байж болох хөнгөлөлт буюу малчдыг илүү санхүүгийн үйлчилгээнд хамруулахад нь боломжтой үйлчилгээнүүдийг нээж өгөх зорилготой байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Х.Баасанжаргал гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Даатгалд даатгуулбал зээлийн хүү 3-4 хувь буурах боломжтой бол үүнийг хэзээнээс хэрэгжүүлж эхлэх вэ? ХХААХҮЯ энэ дээр ямар байр суурьтай байна, бэлэн юм уу гэдгийг даруйхан хариулаад өгөөрэй.

2 дугаарт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Монголбанк 2 хоорондоо малчны зээлийн асуудал дээр хамтарч ажилладаг уу? Үүний цаана ямар асуулт байна гэвэл өнөөдөр ганц бие малчин эрэгтэйчүүд олон боллоо гээд байна. Гэтэл зээлийнхээ хүртээмжийг, зээлийн бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүд хөдөө бизнес эрхлэх боломжийг нь бий болгох боломжтой байхгүй юу. Сүү цагаан идээ боловсруулах. Түүнийг ганцхан фермер гэж битгий хар гэх гээд байгаа юм. Малчдад олгож байгаа зээлээ эхнэр, нөхөр, гэр бүлээрээ хамтдаа, өрх айл цагаан идээнийхээ бизнесийг өргөжүүлж байгаа бол тэр чинь нөгөө талдаа эмэгтэйчүүд тэнд ажиллах, амьдрах нөхцөл нь бүрдэж эхэлнэ гэсэн үг. Жендерийн бодлогоо бид эдийн засгийн бодлоготойгоо яаж уялдуулаад байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монголбанк, дараа нь ХХААХҮЯ хариулъя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Даатгалтай холбоотой асуудал яг одоо хэрэгжээд явж байна. Малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан тохиолдолд малчны зээлд Төрийн банк, Хаан банк хөнгөлөлт үзүүлж байгаа. 2,5 хувь гэж би ойлгож байна. Дээр үед тийм байсан.

Эмэгтэйчүүдийн жендертэй холбоотой асуудал дээр орон нутагт байгаа малчин эмэгтэйчүүдийг дэмжих “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр (WiB)” хөтөлбөрийг Хаан банкнаас ЕСБХБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа. Энэ дээр Төв банк эх үүсвэр оруулж ирэхэд нь дэмжлэг үзүүлээд Хаан банкнаас дээр миний санаж байгаагаар 4 орчим сая еврогийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зөвхөн орон нутгийн малчин эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөр хэрэгжиж байгаа.

ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлаас Малчны тухай анхдагч хуулийг батлаад, хуулийн хэрэгжилтийн асуудлаар сонсгол хийж байгаа нь цаг үеэ олсон гэж үзэж байна. Энэ сонсголд сайд нарын оролцох хуваарь тус тусдаа байгаа. Миний хувьд өнөөдрийн буюу 24-ний өдрийн 13 цаг 50 минутаас мэдээлэл хийх үүрэгтэй байсан. Өнөөдөр Засгийн газрын хуралдаантай байгаа ч гэсэн банкны хүүтэй холбоотой чухал асуудлууд яригдаж байгаа учраас Засгийн газрын хуралдаанаас чөлөө аваад ирснээ хэлэх нь зүйтэй байх. Манай яамны танилцуулга хийгдээд, би холбогдох асуултуудад хариулаад явна. Тухайлсан малчны хүүтэй холбоотой асуудалд Г.Энхтайван Дэд ерөнхийлөгч бодитой ярих хэрэгтэй шүү. Та биднийг олон хүн сонсож байгаа. Нэгнийгээ асуултад аргалах маягтай байхаа болимоор байна. Байгаа юмыг бодитоор нь яриад, болохгүйгээ шулуухан хэлчихдэг байхгүй бол та бидний үгийг монголын мянга мянган малчид сонсоод сууж байгаа. Хүү буулгах асуудал дээр малчдын зээлийн хүү битгий хэл төрөөс мөнгийг нь тогтмол өгч байгаа ахмадын тэтгэврийн зээлийн хүүг буулгаж чадахгүй байгаа шүү дээ. Тийм учраас хэдүүлээ бодитой юм ярихгүй бол болохгүй.

Малчдын талаарх дараагийн хууль бол Малын индексжүүлсэн даатгалын

хууль. Энэ дэлхийд байхгүй, ганцхан манайд байдаг хууль. Энэ хууль 2014 онд батлагдаад бараг арван хэдэн жил өөрчлөгдөөгүй. Миний бие ажлын хэсгийг ахлаад ямар ч байсан өөрчлөлт оруулаад, малчдын хүсдэг 6 хувийг 4 дээр нэмж хасах 1 болгох, аймгаар биш сумаар нь болгох зэргээр өөрчилсөн. Гэхдээ энэ хууль амьдрал дээр малчдад хэрэг болоод байгаа юм төдийлөн байхгүй, энэ хуулийг бариад учиргүй хөнгөлөлт үзүүлээд байгаа арилжааны банк байхгүй. Бодит байдал дээр та манай банканд даатгуулбал таны юуг жаахан хөнгөлж өгье гэдэг л харилцан ойлголцол явж байгаа. Малчдыг даатгахыг хүсдэг газар гэж бас байхгүй. Гадаа нь байгаа машины даатгал гэж хөөцөлдөөд байгаа болохоос малчны хотонд байгаа малыг нь даатгадаг компани байхгүй байгаа шүү дээ. Малчдыг даатгуулчихвал 3-4 хувиар бууруулна гэдэг мэдэхгүй дээ. Өнөө маргаашдаа хэрэгжинэ гэж бодохгүй л байна. Харин энэ хуулийг хэрэгжүүлэх тал дээр, ялангуяа Малчны тухай хуулийн 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх тал дээр арилжааны банкнуудтай хамтраад зээлийн багц гаргавал гэсэн тиймэрхүү юм яригдвал арай илүү бодитой болно доо. Тулгамдаад байгаа олон асуудлууд байна шүү дээ. Дулаан хашаа хороо, гар утасны сүлжээгээ яах юм гэдэг асуудлууд.

Ер нь малчин хүн ая тухтай амьдрахад ийм юмнууд хэрэгцээтэй байна. Үүнийг багцлахад төдий хэмжээний мөнгө орохоор байна. Энд нь зориулсан уян хатан зээлийг бодлогоор олгоод, заавал дөрөв, тавуулаа биш, тухайн нэг малчин өрхөд зориулаад олгох зээлийн багц гаргаад, түүнийх нь бодлогын хүүг нааш нь цааш нь болговол яадаг юм гэхээс.../минут дуусав./

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Юуны өмнө малчдынхаа, оролцогчдынхоо болон Улсын Их Хурлын гишүүддээ хүндэтгэл үзүүлж, Улсын Их Хурлын ерөнхий хяналтын сонсголд хүрэлцэн ирсэн Ц.Идэрбат сайдад талархал илэрхийлье. Өчигдөр 4 сайд ирэх ёстой байсан, бүгд төлөөллөө явуулсан. Малчны тухай хуулийн хариуцлагатай сонсголд хүрэлцэн ирсэнд талархалтай байгааг илэрхийлье. Илтгэлээ тавиад, асуултад хариулаад явна. ГБХНХЯ нэмэлт хариулт өгье.

ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул: Одоогоор малчны зээлтэй холбоотой асуудлаар Монголбанкт хамтарч ажилласан асуудал байхгүй. Харин манай яамнаас Улсын Их Хуралд өргөн барьсан Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд гэр бүлийн төсөв санхүүг дэмжих, үүгээрээ алслагдмал малчин өрхүүд, ганц бие буюу жендертэй холбоотой асуудлууд дээр хэрхэн дэмжих талаар тусгасан. Энэ талаар Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсаны дараа бас ажиллах болно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Х.Баасанжаргал гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Бид нар Баянгол дүүргээс Говь-Алтай руу эмэгтэйчүүдээ аваачаад, гэр бүл болгоод энэ асуудлыг шийдэхгүй л дээ. Монголбанк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ, ХХААХҮЯ салбарынхаа бодлого шийдвэрээрээ, Боловсролын яам хүүхэд хамгааллынхаа бодлого, дотуур байраараа дамжуулаад л гэр бүл элэг бүтэн, хөдөө орон нутагтаа ажиллаж амьдрах залуучууд малчдын залгамж халааг үргэлжлүүлээд явах тэр нөхцөл нь энэ бүх бодлогоос чинь хамаарах байхгүй юу. Ганцхан бодлогоос биш. ГБХНХЯ-ыг энэ дээр хариуцлагатай ажиллаач ээ гэж хэлмээр байна. Эмэгтэйчүүд хөдөө байхгүй гэх асуудлыг ганцхан Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулиар шийдэхгүй. Энэ бүх бодлого хоорондоо уялдаж байж шийдэгдэнэ. Тэгэхээр энэ

асуудалд дорвитойхон шиг, яамнаас гадна Монголбанк санхүүгийн бүтээгдэхүүн.../минут дуусав./

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дахиад хариулт өгөх үү? Бид Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж өөрчилсөн шүү дээ. Бодлогодоо нэлээд том өөрчлөлт оруулсан байх ёстой гэж бодож байгаа. 15 дугаар микрофон дээр Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар: Сайн байцгаана уу? Х.Баасанжаргал гишүүний ярьж байгаа бол зөв. ГБХНХЯ-ны зүгээс 4 том судалгааг явуулсан. Монгол гэр бүлийн хэв шинжийн судалгаа болон залуучуудын хөгжил оролцоо, малчдын нөхцөл байдал, залуу гэр бүлд тулгамдаж байгаа асуудлаар судалгаа явуулсан. Энд “төрөлтийг дэмжих, гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх үйлчилгээг сайжруулах, мөн хамгийн гол нь сэтгэл зүйн үйлчилгээ орон нутагт хэрэгтэй” гэсэн судалгаанууд гарсан байгаа. Хүн ам, гэр бүл хүүхдийн чиглэл дээр цогц бодлого хэрэгтэй, орон сууц, татвараас хөнгөлөх, зээл болон бусад чиглэлээр үйлчилгээг өргөжүүлэх бодлого хэрэгтэй. Мөн орчны бохирдлын асуудал, хүүхдүүдийн асрамж халамжийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх хэрэгтэй байна гэсэн асуудлууд энэ судалгааны 50-иас дээш хувийг эзэлсэн.

ГБХНХЯ-ны зүгээс Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд эдгээр зорилтуудын ихэнхийг нь Сангийн яамтай зөвшилцөж оруулсан. Тухайлбал, орон сууцаар дэмжих, гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээг орон нутагт явуулах, хүүхэд харах үйлчилгээ, СӨБ-ыг дээшлүүлэх зэрэг эдгээр зорилтуудыг оруулсан. Эдгээр цогц арга хэмжээ нь салбаруудын уялдаа холбоотойгоор төлөвлөгдөж, хэрэгжих арга хэмжээ байгаа юм. Тиймээс энэ асуудалд ГБХНХЯ эрхлэх асуудлынхаа хүрээнд энэ хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, дараа 7 хоногт хэлэлцэх тов гарсан байгаа. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Малчдын гэр бүлийн асуудал нэлээн хүндхэн байгаа шүү. Тиймээс ГБХНХЯ тодорхой бодлого гаргах хэрэгтэй байх. Наад судалгааг чинь Х.Баасанжаргал гишүүн, бусад гишүүд ч авъя гэж байна. Өөрсдөө хийсэн үү, хаанаас хийсэн судалгаа юм. 15 дугаар микрофонд хариулт өгье.

/1:41:28/ ГБХНХЯ: Төрөлтийн шинжилгээ судалгааг МУИС-ийн профессорууд, Гэр бүлийн хэв шинжийн судалгааг манай яамны харьяа судалгааны институт хийсэн. Бусад өрсөлдөх чадварын судалгааг МУИС-ийн докторууд хийсэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

УИХ-ын гишүүн Ц.Туваан: Энэ их чухал асуудал. Малчны зээлийн тухайд манай малчид маш найдвартай зээлээ төлдөг шүү. Өрөөс айдаг, өртэй хүн өөдөлдөггүй ээ гэдэг ийм философитой хүмүүс юм. Монголбанкны гаргаж өгсөн тоонууд дээр 98,2 хувьтай гээд харагдаж байна л даа. Хэдхэн жилийн өмнө малчны зээлийн эргэн төлөлт 99,8 хувь буюу бараг 100 хувьтай байсан. Манай малчдад ган, зуднаас холбоотой асуудлууд үүсэж, жижигхээн багассан байна. Тиймээс банкнууд маань малчдадаа найдвартай харилцагч, итгэлтэй харилцагч гэсэн цол хэргэм хэрвээ байдаг өгмөөр байгаа юм. Ийм өндөр эргэн төлөлттэй салбар байна

уу?

Тэгэхээр бусад салбарын чанаргүй зээлийн хэмжээ хэдэн хувь байна вэ? Монголбанк тоогоор хэлээч.

2 дугаарт, нэг малчны дундаж зээлийн хэмжээ хоршооны асуудал оруулахгүйгээр хэд байгааг тодорхой хариулж өгөөч. За хүү бол өндөр байгаа, үүнийг хүүгийн мөлжлөг гэж хэлье. Яагаад гэвэл бусад хэрэглээний зээлээс 4,4 хувь яагаад малчдад өндөр өгдөг юм, бизнесийн зээл яагаад 5,9 хувь өндөр өгдөг юм. Малчин хүн мянган мэргэжлийн эзэн. Малчин хүн өөрсдөө ЖДҮ эрхлэгч. Энэ хүмүүс дор бүрнээ тугалыг хэдэн сар, жилийн дотор яаж 100-150 кг, хургыг гарснаас нь хойш 10 сарын дотор яаж 15-18 кг гулуузтай болгох ажлыг эрхэлж байгаа хуулийн этгээдүүд. Тэгэхээр энэ хүмүүс яагаад 4,4-5,9 хувийн өндөр хүү төлөөд байгаа юм. Энэ бол мөлжлөг шүү гэдгийг хэлье. Харин үүний логик нь хамгийн найдвартай буюу 98 хувиас дээш найдвартай төлөлттэй хүмүүст хүү нь бага байх ёстой биз дээ. Эрхэлж байгаа аж ахуй нь эрсдэлтэй гэдэг. Тэгвэл тийм эрсдэлтэй юм бол энэ олон жилийн хугацаанд яагаад зээлийн эргэн төлөлт нь буурахгүй байгаа юм. Энд логик нь хаана байгаа юм бэ? гэдэгт хариулт авъя. Банк чинь өөрсдөө найдвартай төлдөг хүмүүстээ итгэлцэл дээр үндэслэдэг гээд барьцаа энэ тэрээ буулгаад зээл өгдөг биз дээ. Иймэрхүү логикууд манай малчид дээр хэрэгжихгүй байна.

3 дугаарт, Монголбанк өөрөө Монгол Улсын эдийн засгийг, мөнгөний бодлогыг, тэр дундаа инфляцыг хариуцаж байгаа. Инфляц ямар байхыг махны үнэ шийддэг юм аа. Нэг номерын хүчин зүйл нь махны үнийн савлагаа ямар байхаас инфляц хамаардаг. Монгол Улсад энэ бол бодитой үнэн шүү. Тэгэхээр инфляц бага байлгахыг хариуцдаг байгууллагуудын нэгэнд Монголбанк орно. Махны үнэ, гурилын үнээс шалтгаална. Тиймээс инфляцыг бага байлгахын тулд энэ салбар луу чиглэсэн ямар хөтөлбөр бодлого хэрэгжүүлэх гэж байна вэ? Хэрвээ хэрэгжүүлэе гэх хүсэл сонирхол нь байвал Монголбанканд үүнийг хэрэгжүүлэх бүрэн боломж, мөнгө нь байгаа. Ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, ялангуяа малчид руу чиглэсэн, ХАА-н салбарт чиглэсэн хөтөлбөр, бодлого юу байна вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монголбанк хариулъя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Малчны зээлээс гадна нийт салбарын зээлийн статистик дээр 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 5,2 хувь нь чанаргүй зээл байгаа. 5,2 хувийн чанаргүй зээл нь малчны зээлтэй харьцуулбал харьцангуй өндөр. Энд нийт хэрэглээний зээлийн буюу цалингийн зээлийн чанаргүй зээлийн өсөлт харьцангуй өндөр болсноос 5,2 хувь гэсэн статистик гарсан.

Нэг малчны зээлийн үлдэгдэл хэд байгаа тухайд одоогийн байдлаар нийт салбарынхаа хэмжээнд 1,1 их наяд, 122 мянган малчин өрх зээлтэй байна. Малчин өрхийн дундаж зээлийн хэмжээ 8,9 сая орчим төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гэсэн үг.

Малчны зээлийн хүүг бууруулахтай холбоотой асуудал дээр Малчны тухай хуульд төрөөс зээлийн хөнгөлөлт үзүүлэх, ипотекийн зээлд хамруулах зэргээр малчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хэд хэдэн бодлогын заалтууд

орсон. Энэ дээр мэдээж малчны зээлийг бууруулах хэд хэдэн боломж бололцооны нэг нь 1 дүгээрт, төрөөс хэрэгжүүлж байгаа хөнгөлөлттэй нөхцөлтэй татаастай зээлийг хэрвээ малчны зээл дээр оруулбал энэ дээр хөнгөлөөд явна. Яг одоогийн байдлаар нэлээн хэд хэдэн салбарт хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр хэрэгжээд явж байгаа. Тухайлбал, аялал жуулчлалын зээл, орон нутагт хэрэгжүүлж байгаа хүнсний хувьсгалын зээл гэх мэт энэ схемээр явбал Монголбанк малчны зээлийн хүү дээр төрийн татаастай хөтөлбөрийг ХХААХҮЯ-наас зохион байгуулаад явбал зээлийн хүү буурах боломжтой гэж үзэж байна.

Малчны зээл яагаад өндөр хүүтэй байгаа гэдэг дээр хамгийн том нь тухайн арилжааны банкнаас гарч байгаа зардлын хэмжээ л байгаа. Орон нутагт салбар ажиллуулж, ажилтан албан хаагчдадаа цалин өгч байна. Тухайн орон нутагт ажиллаж байгаа банкны салбарын үйл ажиллагааны зардлаас хамаараад орон нутагт олгогдож байгаа малчны гэлтгүй ер нь зээл харьцангуй өндөр байгаад байгаа юм. Тэгэхээр үүнийг бууруулах хамгийн гол зүйл нь зээлийн эрсдэлтэй холбоотой санхүүгийн бусад үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх, цахимжилтыг буюу цахимаар малчдад зээл олгодог энэхүү боломжийг нээх нь зээлийн хүүг тодорхой хэмжээгээр бууруулах илүү боломжтой гэж үзэж байна.

Мэдээж МАА-н салбар, тэр дундаа мах бол инфляцад хамгийн гол нөлөө үзүүлж байгаа бүтээгдэхүүн. Тэгэхээр энэ малын.../минут дуусав./

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ц.Туваан гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Ц.Туваан: Чанаргүй зээлийн хувь нь статистикаар 3 дахин бусад салбар нь үнэтэй байгаад байдаг, зээлийн хүү нь 4,4-5,9 хувийн бага байна. Энд ямар ч логик алга байна шүү. Үүнийгээ бодлогодоо оруулж шийдвэрээ гаргаарай. МАА-н салбар эрсдэлтэй л гээд байна, эрсдэлтэй байгаа юм бол зээл нь яагаад төлөгдөөд байгаа юм. Энэ чинь малчдын ухамсартай, хариуцлагатай холбоотой асуудал байхгүй юу. Тэгэхээр эрсдэлтэй салбар гэдэг энэ худлаа зүйлээ хэдүүлээ болимоор байна.

Малчин өрхийн дундаж зээлийг хоршоог оруулахгүйгээр та хэлээд өгөөч. Хоршооны зээл гээд нэг өрхөд 50 сая гээд байгаа, үүнийг оруулахгүйгээр зээлийн хэмжээ нь хэд байна. Энд өчүүхэн бага байгаа. Тэр нь юутай холбоотой гэхээр малыг ерөөсөө А данс аваад л, тэнд банкны зардалсаад байх юм байхгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Монголбанк хариулъя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван: Хоршооны зээлийг оролцуулахгүйгээр зээлийн үлдэгдэл 1,1 их наяд. Нийт зээлийн хэмжээ 122 мянган малчин өрх байгаа, дундаж хэмжээ нь 8,9 сая төгрөг байгаа. Нэг малчин өрхийн авч байгаа дундаж зээлийн хэмжээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дараагийнхаа илтгэлд оръё.

“Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас учирсан хохирол, түүнийг даван туулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ” сэдвээр ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян танилцуулна. Г.Ариунбуян генералыг индэрт урьж байна.

ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд, сонголд оролцож байгаа оролцогчид Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас учирсан хохирол, түүнийг даван туулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг товчлон танилцуулъя.

Монгол Улс бол уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн өртөж байгаа. 1940 оноос хойш агаарын хэм 2,5 градусаар нэмэгдсэн нь дэлхийн дундажтай харьцуулбал нэг градусаар илүү байна. Энэ нь гамшигт, аюулт үзэгдлийн давтамж, эрчимжил, гамшгийн тохиолдлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Жилийн дундаж нийлбэр хур тунадас, ялангуяа өвлийн улиралд хур тунадас нэмэгдэх хандлагатай болсон. Монгол орны нутаг дэвсгэрийн 77 орчим хувь нь цөлжсөн, 690 орчим нуур ширгэж, мөстлөгийн талбай 50 хувиар багассан гэсэн судалгааны мэдээлэл байдаг. Монгол Улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол, эрчим нэмэгдсэн. Статистик мэдээллээс авч үзвэл 2016-2025 онд буюу сүүлийн 10 жилд тохиолдож байгаа гамшигт, аюулт үзэгдэл, ослын тохиолдол өмнөх 10 жилтэй харьцуулбал улсын хэмжээнд 25 орчим хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Үүнийг гамшгийн ангиллаар нь авч үзвэл сүүлийн 10 жилд объектын түймрийн тохиолдол 11,6 хувь, биологийн гаралтай аюулт үзэгдэл 77 хувь, хүний үйл ажиллагаатай холбоотой осол 4 хувь, геологийн гаралтай аюулт үзэгдэл 3,2 хувь, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл өмнөх онтой харьцуулбал 2,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин ой хээрийн түймэр сүүлийн 10 жилд түүний өмнөх 10 жилтэй харьцуулбал 27,7 хувь буурсан үзүүлэлттэй боловч учирсан хохирол нь 1,9 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2015-2025 онд тохиолдсон ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн улмаас 110 хүн амь насаа алдсан. Мөн 11,4 сая толгой мал хорогдсон нь нийгэм, эдийн засагт 1,4 их наяд төгрөгийн хохирол учирсан гэж үзэж байгаа. Ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн улмаас сүүлийн 5 жилийн хугацаанд 44 малчин амь насаа алдсан. Үүний 84 хувь нь аадар бороо, цасан шуурга, хүчтэй салхи шуурганд төөрч, сураггүй болсноос амь насаа алдсан харамсалтай тохиолдол эзэлж байна. Зудын гамшгийн давтамж, мөчлөг урьд нь 10 жил, 12 жилийн хугацаанд давтамжтай байсан бол сүүлийн жилүүдэд 2-3 жилийн хугацаанд болж мөчлөг ойртож байна. Үүнийг дагаад хохирлууд нэмэгдэж байна. Монгол Улсын эдийн засгийн гол салбар болох ХАА, ялангуяа МАА-н салбарт ган, зудын эрсдэл ихээхэн хохирол учруулдаг. Тухайлбал, 2010 онд 10,3 сая толгой мал хорогдож байсан нь нийт малын 23 хувийг эзэлж байсан, өнгөрсөн 2023, 2024 оныг дамнасан зудын үеэр 8,1 сая толгой мал буюу нийт малын 12,5 хувь нь хорогдсон гэсэн мэдээлэл байна.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр цагаан зудын болон харын зудад Монгол Улсын газар нутгийн өртөх байдлыг дэлгэцэд харуулж байна. Цаашид уур амьсгалын өөрчлөлтийн үүдэлтэй зудын эрсдэл бүхий л нутаг дэвсгэрийг хамрах, нэмэгдэх хандлагатай байгаа. Гамшгийн төлөв байдлыг ган, зудын дараалсан гамшгийг хамтад нь тооцож үзвэл зудын эрсдэл 2020-2022 он, 2030 он, 2050 оноор тооцож гаргасан судалгаагаар 2030 онд зудын эрсдэл “их эрсдэлтэй” зэрэглэлд байх нутаг дэвсгэрийн хэмжээ 2020-2022 онтой харьцуулбал 14,4 хувь, “нэн их эрсдэлтэй” байх нутаг 3,4 хувиар нэмэгдэх төлөвтэй гэсэн үр дүн гарч байгаа.

Харин 2050 онд манай улсын ихэнх нутгаар зудын эрсдэл их буюу “нэн их

эрсдэлтэй” зэрэглэлд байх газар нутгийн хэмжээ 27 орчим хувиар нэмэгдэх төлөвтэй байна. 2023-2024 онд сүүлийн 50 жилд болоогүй цасан бүрхүүл тогтож төмөр зуд нүүрлэсэн. Үүний улмаас нийт нутаг дэвсгэрийг хамарсан хүйтрэлийн хугацаа маш урт байсан. Үүнд Монгол Улсын Засгийн газар, холбогдох яам, байгууллагууд хариу арга хэмжээг оновчтой, шуурхай авч хэрэгжүүлж ажилласан. Улсын хэмжээнд 138км даваа, гүвээ, замыг нээж, замд боогдсон алслагдсан малчин айл өрхөд хоол хүнс, өвс тэжээл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх, малчдад дотоодын болон олон улсын тусламж, хүмүүнлэгийн тусламжийг хүргэх үйл ажиллагааг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажилласан. Үүнд 9400 гаруй малчин айл өрхөд хүнсний тусламж, 202,0 мянга гаруй малчин өрхөд 87 мянга орчим тонн өвс тэжээл, зам, даваанд боогдсон айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, цасанд дарагдсан айл өрхийн гэр, хашааг цэвэрлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулсан. 178 мянган малчин айл өрхөд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, 20,400 гаруй малчин айл өрхөд эрүүл мэндийн багцыг хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд 9800 гаруй албан хаагч, 2300 гаруй техник хэрэгсэлтэйгээр ажилласан.

Малчны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11-д заасны хүрээнд гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас ажил үүргээ гүйцэтгэж яваад амиа алдсан малчны ар гэрт буцалтгүй тусламж олгох журам, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, мөрдөж ажиллаж байна. Одоо аймаг, сумын түвшинд энэхүү төлөвлөгөөг дахин шинэчлэхээр ажиллаж байна.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг онцолбол, гамшгийн эрсдэлийн үнэлгээний хувьд зуд, ган, хүчтэй салхи шуурга, шороон шуурга, үер, ой, хээрийн түймрийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний зураглалыг гаргасан байдаг. Салбар дундын чадавхын үнэлгээний хувьд НҮБ-ын суурин зохицуулагчийн газар, Монгол дахь төрөлжсөн агентлагууд хамтраад “Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл” буюу КАДРИ (CADRI)-ын үнэлгээний багийг Монголд урьж, Монгол Улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөөс дасан зохицох гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхын үнэлгээг хийсэн. Мөн малчид руу чиглэсэн малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх хүрээнд сургалт мэдээллийн ажлыг малчин, багийн дарга нар, бүх шатны Засаг дарга нарт зориулсан сургалтыг Онцгой байдлын байгууллага, ХХААХҮЯ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн газар ОУБ-тай үе шаттайгаар зохион байгуулж ажиллаж байна.

Цаг агаарын аюулт, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүх төрлийн цахим болон пэйж хуудсаар олон нийтэд сурталчлах, багц мессеж хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан. Эрт зарлан мэдээллийн хувьд малчдад төрөл бүрийн сувгаар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дохионы хэлтэйгээр энэ мэдээллийг тогтмол хүргүүлж ажиллаж байна.

Судалгаа шинжилгээний ажлын хувьд ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс судалгаа шинжилгээний ажлыг боловсруулж, иргэд, малчдад чиглэсэн, ялангуяа шинжлэх ухаанд суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна. Үүний дотор МУЗН жил бүр “Уур амьсгалын өөрчлөлт ба гамшгийг даван туулах чадавх” сэдэвт онол практикийн бага хурлыг хийж, шинжлэх ухаанд, нотолгоонд суурилсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр ажиллаж байна. Товч мэдээллийг танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За баярлалаа. Дараагийнхаа илтгэлийг хамтад нь сонсьё. “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат танилцуулна. Ц.Идэрбат сайдыг урьж байна.

ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сард баталсан Малчны тухай хууль. Энэ нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл, монголчуудын хоолтой ундтай байх зэрэг олон асуудлыг шийддэг малчдад зориулж тэдний нийгмийн баталгаа, ажлын байр, мөн бэлчээрийн МАА-г цаашид тогтвортой хөгжүүлэхэд малчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар нэлээдгүй тодорхой зүйл, заалттай хуулийг тухайн үед УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн нарын гишүүд өргөн барьсан байгаа. Тухайн үед миний хувьд энэ хуулийг дэмжиж өргөн барьсан гишүүдийнх нь нэг. Тийм учраас энэ хуулийн хэрэгжилт дээр салбарын сайдын албыг авч ажиллаж байгаа энэ хугацаандаа анхаарал хандуулж, шийдвэрлэгдээгүй зарим асуудлыг шийдүүлэхийн төлөө судалгаа юмнууд хийж, холбогдох төрийн байгууллагуудтай санал хүсэлтээ солилцоод явж байгаа гэдгээ би хэлье гэж бодож байна.

Энэ хууль анх өргөн баригдахдаа ер нь ХАА-н салбар, тэр дундаа МАА-н салбарын хөгжлийг өнөөгийн түвшнээс нь яаж ахиулах вэ гэдэг дээр гол анхаарлаа хандуулж, малчин бол мянган мэргэжлийн эзэн гэдэг тэр тодорхойлолтод нь дүйцүүлэхүйцээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох ийм зорилгоор анх хийсэн. Одоо нийгэмд буруу ойлголт өгөөд байгаа нь малчид л баахан юм гуйгаад, тэрийг нь төр өгнө гээд өгч чадахгүй байгаа юм шиг ийм байдлаар биш, малчин хүн өөрөө өөрийгөө санхүүжүүлээд аваад явчихдаг, ар гэрээ, хажуугаар нь олон хүмүүсийн ажил, амьдралыг нь тэтгээд аваад явчихдаг, “халамжийн” биш “хөгжлийн” хууль байх ёстой гэсэн нь энэ хуулийн гол үзэл баримтлал байсан юм. Дараа нь өрхийн хөгжлийг үнэлэх шинэ тогтолцоотой больё. Малчин хүний өрхийн хөгжлийг зөвхөн малын тоогоор буюу мянгат уу, 2-3 мянгат уу гэдгээр биш, ер нь өрхийн хөгжил нь цаашаа яаж явж байна вэ гэдэг дээр суурилъя гэсэн.

Дараагийнх нь, ер нь малчин хүний асуудал гэдэг бол зөвхөн хөдөө байгаа хэдэн малчин хүний асуудал биш ээ. Энэ бол Монгол Улсын тусгаар тогтнолтой, үндэсний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал гээд олон зүйлүүдтэй энэ хууль холбогдох ёстой.

Дараагийн асуудал бол Монгол Улсын хөдөлмөрийн салбарын 30 гаруй хувийг бүрдүүлж байгаа энэ салбарыг бид эрсдэлээс яаж авч гарах юм. Зуд болохоор малаа үрэгдүүлдэг, зудын ард зулагтай гэж хэдэн жил өөрөөсөө харамлаж байгаад л өсгөдөг, дахиад л зуд болдог, алддаг. Ийм эрсдэлтэй нөхцөл байдлаас ер нь малчдыг яаж гаргах вэ гэдэг бас нэг гол үзэл баримтлал байсан юм.

Хамгийн сүүлд, ер нь малын тооноос биш, чанарт шилжье. 1990-ээд оны сүүлээр мал өсөөд, “мянгат малчин” болохоор сумын удирдлагууд, бид бүхэн баяр ёслолын байдалтай батламж юм гардуулж өгдөг байсан. Тухайн үеийн мянгат малчны эдийн засгийн өсөлт, орлого, амьдралын чанар өнөөдрийн мянгат малчин 2-ын хооронд эдийн засгийн чадавхын хувьд арай л өөр дүр зураг харагдаад байгаа учраас малчин хүний бүтээмжийн асуудал руу онцгой анхаарал хандуулъя гэсэн ийм дарааллаар, ийм ач холбогдлоор энэ хууль анх батлагдсан юм гэдгийг тодотгож хэлье.

Энэ хуульд төрийн байгууллага хоорондын уялдаа холбоотой 9 төрлийн дүрэм, журмууд дагалдаж гаргах шаардлагатай байгаа.

1 дүгээрт, миний хэлдэг Малчны хөгжлийн индексийн асуудлууд, 2 дугаарт малчдын мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөрүүд, Улсын аварга шалгаруулах журмын асуудлууд, малчны хүүхдийг их, дээд сургуульд тэтгэлэгтэй сургах асуудал, гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас амь насаа алдсан малчны ар гэрт нөхөн олговор олгох асуудал, Малчин өрхийг малжуулах арга хэмжээ, малчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах асуудал, малчны хөгжлийн сангийн журмын асуудал, НДШ-ийг нэг удаа нөхөн төлүүлэх гэсэн 9 төрлийн журам гарах ёстой юм.

Эндээс ХХААХҮЯ-ны зүгээс малчин өрхийн хөгжлийг цогцоор үнэлэх асуудлаар 2025 оны 6 дугаар сарын 09-нд Үндэсний статистикийн хороо руу саналаа боловсруулаад хүргүүлсэн. Малчны хөгжлийн индексийг боловсрол, эрүүл мэнд, амьдралын чанар, эдийн засгийн чадавх, нийгмийн хамгаалал талаас нь ер нь яаж үнэлж байх юм гэдэг талаар хүргүүлсэн. Үүнээс хойш ажил хийгдээгүй байна. Журам нь боловсруулагдах саналаа холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

Дараагийнх нь малчдын мэдлэгийг дээшлүүлэх чадавхжуулах сургалтын хөтөлбөрүүд байна. Энэ бол ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/515 дугаар тушаалаар чадамжид суурилсан залуу малчдын сургалтын хөтөлбөрийг 9 чиглэлээр явуулах хөтөлбөр батлагдсан. Бидний хувьд улсын төсөв дээр 2026 онд малчдын сургалт хийх төсөв санхүүгийн асуудал хараахан шийдэгдээгүй. Гэхдээ манай яамны хувьд ХАА-н салбар дээр хэрэгжиж байгаа, ялангуяа манай яаман дээр зохион байгуулалтыг нь хийх 3 төсөл байна. Энэ төсөл, хөтөлбөрүүдийг бид хэрэгтэй хэрэггүй оффисын зардал, кофены гэх мэт зүйлд зарцуулахгүйгээр малчдад хэрэгтэй, Монгол Улсад үлдэх, ХАА-н салбарт өгөөжөө өгчих юм руу чиглүүлэх талаар Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банкттай ярилцаад яг хэрэгжээд явж байгаа зарим төслийн хөрөнгийнх нь асуудал дээр тодорхой хэмжээнд ойлголцолд хүрээд явж байна. Тэгэхээр энэ зунаас бидний ажлын төлөвлөгөөнд малчдын сургалтын асуудлыг давхар явуулъя. Энэ хүрээндээ бид малчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх олон асуудлууд, шаардлага бидний өмнө байна.

1 дүгээрт, мал үржүүлгийн асуудал дээрээ бид онцгой анхаарал хандуулахгүй бол болохгүй байна. 2 дугаарт, малын өвчинтэй холбоотой асуудал дээр малчнаасаа эхлээд төрийн яам нь хүртэл нэг бодлоготой, нэг чиглэлтэй байхгүй бол болохгүй. Үүнээс болоод олон асуудлууд малчдын өмнө тулгамдаж байна. Ялангуяа арьс шир үнэгүйдэж байгаагийн шалтгаан бол малын паразитдах өвчний асуудлууд байна. Жишээ нь, хонины арьсан дээр хэрэв үүнийгээ арилгачихвал доод тал нь 3,0 мянгаас эхлээд дээшээ үнэ хүрэх бололцоотой. Гэтэл бодит амьдрал дээр сая надад сумаас ирсэн мессежэнд малаа угаалгах гэсэн хэн угаах нь мэдэгдэхгүй байна, малын эмчтэйгээ ярь гэсэн, малын эмч нь ямар ч тоног төхөөрөмжгүй гэсэн юм яриад суугаад байна. Би яаж угаалгах вэ? гэж Энхтулга гэдэг хүн явуулж байна. Тэгэхээр энэ мэт бодит амьдрал дээр хэрэгтэй байгаа, бидний өмнө тулгамдаад байгаа олон асуудлуудыг энэ сургалтаар зохион байгуулъя. Гэхдээ энэ 300 гаруй мянган малчдыг бид нэг дор цуглуулах, хамруулах бололцоо байхгүй учраас танхимаар зарим нэг юмаа хийе. Малчин сэтгүүл, энд Д.Шагдарсүрэн гуай сууж байна. Уламжлалт цаг агаарыг шинждэг аргыг бид жишээ нь Хумбагарын Батмэнд гээд дуучин байдаг, тэр хүнтэй сургалт юмнуудыг хийлгэх талаар бид судлаад, хөрөнгийнх нь асуудлыг би шийдвэрлэж байгаа гэдгийг энд

байгаа малчдадаа хэлье. Харин та хэд маань идэвхтэй оролцож байгаарай гэж хүсье.

Дараагийн асуудал бол Улсын аварга шалгаруулах журам байгаа. Тэгэхээр энэ 300 мянган малчнаас жилдээ нэг аймгаас 10-аад аварга малчин төрөхөд болохгүй зүйлгүй гэж бодож байна. Энэ дээр гар татаад л, тэд байх ёстой гэсэн хатуу зүйлээр яах юм. Харин Улсын аварга болсон малчид маань малын чанараа сайжруулах, малын эрүүл мэнд рүүгээ анхаарах, арьс ширээ анхан шатны боловсруулалт хийх зэргээр бусад малчдадаа сайн үлгэр дуурайлал үзүүлдэг байгаасай гэж бодож байгаа юм. Сая Ховд аймагт ажиллаж байхад нэг улсын аварга малчин хөл хорио тогтоосон байхад шөнө оройн цагаар үхэр малаа нууж зөөж байна гэсэн мэдээллүүд ирж байгаа юм. Ийм байдалтай байж болохгүй.

Малчны хүүхдийг их, дээд сургуульд тэтгэлэгтэй сургах асуудал байгаа. Энэ бол Малчны тухай хуулийн бас нэг гол цөм юм. Энэ дээр журам гарсан байна. Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 215 дугаар тогтоол гарчээ. ХААИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилд МАА-н чиглэлээр 34, тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр 16, нийт 50 оюутан энэ хуулийн хэрэгжилтийн дагуу суралцаж байна. Сая би амралтын өдрүүдэд зүүн бүсэд ажиллаж “Энэ нутагтаа эзэн 100” хөтөлбөр, дээрээс нь арьс ширийг анхан шатны боловсруулалт хийж үнэд хүргэх ажлыг эхлүүлэх ажлаар явлаа. Тэр үед уулзаж байхад Дорнод аймгийн Булган суманд иргэд, малчидтай уулзахад заавал ХАА-н чиглэлээр гэх хэрэг байна уу? Энэ чинь малчдын хүүхдүүдийг ялгаварлан гадуурхаж байна гэдэг зүйлийг малчин эмэгтэй надад хэлсэн. Тиймээс үүнийг бид цаашдаа байхаар бол ямар ёстой, ямар бодлогоор ХАА-н чиглэлээр, бэлчээр гэсэн чиглэлээр сурга гэдэг шаардлага тавиад байгаагаа ойлгомжтой болгох шаардлага байна гэж бодож байна. ХААИС бол Боловсролын яамны харьяа, тэгэхээр ХААИС-тай бид цаашдаа энэ талаар ярилцах шаардлага гарч байна. Суралцагчдад тэтгэлэг олгох энэ журмыг бас эргэж харъя.

Сая Г.Ариунбуян генерал танилцууллаа. Монгол Улсад байгалийн гамшгийн давтамж маш их байгаа. Гэтэл нөгөө талдаа манай ХАА-н салбар, МАА-н салбарт гамшгийн асуудал дээр зохицуулалт хийсэн ганцхан хууль байгаа нь Малын индексжүүлсэн даатгалын хууль л байгаа. Энэ үнэндээ гамшгийн дараах нөхөн төлбөр гэхээсээ илүүтэйгээр шагналд тодорхойлох, зээл авахад зориулаад л индексжүүлсэн даатгалыг малчид хийлгэж байгаа юм. Тэгэхээр үүнийг арай зорилтот түвшин рүү нь хүргэхийн тулд бид тухайн сумын нийт малынх нь 6 хувь хорогдсоны дараа зээл олгодог энэ процессыг уул нь 4 хувь болгож өмнөх парламентаар би ажлын хэсгийг ахалж батлуулсан. Гэхдээ энэ нэг их айхтар гамшгийн бүх асуудлуудыг шийдэх ийм зүйл байхгүй. Энэ даатгалын хуулийн ажлын хэсгийг ахлаад ажиллаж байхад миний өмнө хэлсэн гэрийнх нь гадаа байгаа машиныг даатгая л гэж уралдаад байхаас хотон дахь малыг нь даатгая гэж ер нь нэг их явдаггүй. Яагаад гэвэл их эрсдэлтэй салбар. Өнөөдөр мянган хоньтой байна, 4 дүгээр сарын зуднаар нэг ч малгүй болчих эрсдэлтэй гэдэг утгаар даатгалын компаниуд нэг их сонирхож өгдөггүй зовлонтой юм байна лээ.

Үүнийг бид сайжруулах ёстой, Малчны тухай хууль дээр гамшигт ослын үед малынхаа араас явж байгаад олон малчид амь насаа эрсдүүлдэг. Тэр хүмүүст нөхөн төлбөрийн асуудлыг анх удаа энэ хууль дээр оруулж өгсөн. Гэхдээ энэ нь бас шат дамжлагатай. Эхлээд сум, дараа нь аймаг, улс гэсэн дамжлагатай байгаа. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилт хаанаасаа эхлэх вэ гэхээр анхан болон дунд шатаасаа эхлэх юм. Гэхдээ би ХХААХҮ-ийн сайдын хувьд энэ гамшигт ослын үед

нэг ч малчин битгий амь үрэгдээсэй билээ гэж л бодож байгаа юм. Тэгэхийн тулд бид бэлтгэлтэй, бэлэн байдалд байх ёстой. Амьдрал дээр зөндөө юм болдог. Нүдгүй шуурганаар малдаа явах нь битгий хэл хотныхоо хашааг эргэх гэж яваад эргээд гэрээ олоогүй зэрэг асуудал гардаг. Гамшгаас өмнө амжаад хонио эргүүлчихье гээд дан дээлтэй давхисан хүн эргээд хүнд байдалд ордог, амь нас нь эрсэддэг ийм олон зүйлүүд байгаа юм. Тэгэхээр ер нь монголын МАА-д чиглэсэн, энэ онцлогийг нь тусгасан, гамшгийн үед бэлтгэл, бэлэн байдлаа хангахаас гадна хувь хүний амь насыг хамгаалах тал дээр бид бас бодлого гаргаж өгвөл яасан юм. Адуундаа чип зүүхийн хажуугаар гамшгийн үед, шуургатай үед малдаа явж байгаа хүн бас чиптэй явчихдаг ийм байдал руу орохгүй бол малаа хайрладаг шигээ амиа бас хайрладаг, түүнд нь бид дэмжлэг үзүүлдэг байдал руу явмаар байна. Би олон малчны араас, шуурганы араас явж байсан. Амь аврагдсан олон малчин ярьдаг, нүдгүй шуурганаар сумын Тамгын газрын машин арваадхан метрийн цаана миний урдуур гэрэл нь гялалзаад л явчихсан, би цаана нь мянга бархираад намайг харж чадаагүй өнгөрсөн гэдэг.

Малчны орон сууцны ипотекийн зээлийн асуудал байна. Энд харамсалтай нь улсын хэмжээнд ердөө 2-3-хан хүн хамрагджээ. Тийм учраас ипотекийн зээлийн асуудал дээр Малчны тухай хуулийг судлаад үзэхээр нэг зүйл гарч ирж байна. Яагаад 2 хүн хамрагдчихсан юм бэ гэдэг дээр ипотекийн зээлийг малчдад олгож болно. Гэхдээ ипотекийн зээлийн журмыг мөрдөж ажиллана гэсэн нэг өгүүлбэр орчиход тэр журмыг хангах малчин монголын 160 мянган малчин дунд ховор, 20 жилийн хугацаатай тийм зээлийг авчих малчин ховор оо. Тиймээс арилжааны банкнууд ипотекийн зээлд хамруулж өгөхгүй зовлон бас байгаа юм билээ гэж бодож байна. Үнэхээр ипотекийн зээл олгоё гэж байгаа бол ипотекийн зээлийн ерөнхий тэр журамд биш, ипотекийн зээлийн хажуугаар яг одоо адилхан малчин хүнд 20 жилийн хугацаатай зээл олгох ямар бололцоо байх юм, тэрийг нь тусгаж өгөхгүй бол одоо байгаа ипотекийн зээлээр малчин битгий хэл өдөр тутам, сар тутам цалингаа авч байгаа төрийн албан хаагч нар ч хамрагдаж чадахгүй, материалыг нь бүрдүүлж чадахгүй л байгаа. Энэ хуулийг амь оруулъя, ипотека олгоё гэвэл саяын асуудлыг цогцоор нь харах ёстой гэдгийг шулуухан хэлэх нь зөв болов уу гэж бодож байна. Энд миний сая танилцуулсан асуудлуудыг үзүүлсэн хэсгүүд харагдаж байна. Засгийн газраас гаргасан шийдвэрүүд, бэлчээрийн чиглэлээрх 50 оюутан сурч байгаа, гамшиг ослын үед нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, малжуулах хөтөлбөрүүд харагдаж байна.

Малжуулах хөтөлбөр дээр бас олон хүндрэлүүд байгаа. Өнөөдрийн сонсголд орсон малчид бас ярьсан байна лээ. Заавал хонин толгойд шилжүүлснээр 250 байх ёстой, 35 нас хүрсэн байх ёстой гээд. Түүнийг нь сумын Тамгын газрын мэргэжилтэн тэрэнд нь нийцүүлээд өгье гэхээр авах хүн олддоггүй нэг ийм зовлон байдаг. Тэгэхээр ГБХНХЯ амьдралд нь ойртуулаад, үнэхээр 7-8 сая төгрөгийн малын дэмжлэг хэрэгтэй байгаа хүн бол 2 хонин толгойд шилжүүлснээр гэсэн ийм юмаа больчихвол хүндээ хүрэх юм аа.

Цаашдаа монголын малчид яах ёстой, нарны эрчим хүчийг хуучин бол гэрэл л асаадаг байсан. Одоо бол угаалгын машин, хөргөгч гээд. Сая Сүхбаатар аймагт ажиллаж байхад гэрээсээ худгийн насосыг ажиллуулаад, дээрээс нь сүлжээтэй газар байвал мал нь худаг дээр очиход камераараа хараад гэрээсээ шууд усалчих хэмжээний тийм төхөөрөмжүүд гарчихсан гээд. Тэгэхээр бид технологийн ийм шинэчлэлийг МАА, ХАА-д нэмэгдүүлэх юм хийе гэсэн ийм бодолтой. Ер нь МАА-д тулгамдсан олон асуудлууд байгаа. Өнөөдрийн бидний ярьж байгаа энэ олон асуудлууд эцсийн дүндээ малчин хүний орлогын асуудал дээр очиж зангидагдах

юм. Энэ зовлонг бид зөв шийдэл гаргаж байж өнөөдрийн ипотека, зээлийн хүү, арилжааны банкууд эрсдэлтэй гэж өндөр өгөөд байгаа тэр зээлийн хүү буурах гээд олон бололцоонууд малчдын өмнө гарч ирнэ. Би ХХААХҮ-ийн сайдын ажлыг аваад 2 сар гаруй болж байна. Энэ хугацаанд нутагтаа эзэн 100 мянга хөтөлбөрийг хийж байгаа юм. Үнэхээр монголын малчид нутаг нутагтаа эзэн болоод, яригдаад байгаа байгалийн гамшиг, ялангуяа зудын өмнө бэлтгэл, бэлэн байдлаа хангахгүй бол өнөөдөр мянга гаруй малтай хүн зуд болоход дөрөвхөн сарын дараа хашаагаа хураагаад, төв суурин бараадаж гачгаар хийе гээд явж байгаа зовлонг зүүн аймагт 2023 онд үзлээ шүү дээ. Тэгэхээр дараагийн зудад бид яаж бэлтгэл, бэлэн байдлаа хангах юм бэ гэдэг дээр 17 аймгийн 25 суманд бид туршиж үзэж байна. Сая гүйцэтгэлтэй танилцахаар Баян-Өлгий аймгийн Толбо суманд өнгөрсөн амралтын өдрүүдэд явсан, сая зүүн аймгуудаар явлаа. Ирэх 7 хоногт Төв аймгаар явна. Ингээд үзэхээр малчид 40, 50-иулаа нэгдээд ногоон тэжээл тарих ажил руу идэвхтэй орж байна. Яагаад гэвэл дараагийн зудад бэлэн байя, зуд болохгүй ч гэсэн бэлчээрээр бид малаа дөнгөж онд оруулдаг биш, намар хамаг малаа заазалж зардаг биш, ногоон тэжээлээ тариад намартаа ч хавартаа тарган малтай байх юм бол бидний эдийн засгийн эргэлт сайжирна гэдгийг малчид ойлгоод байна. Тэгэхээр энэ сэдчихсэн юм биш амьдрал дээр туршигдчихсан ийм төслийг олон улс даяараа хэрэгжүүлэхийн төлөө үүнийг хийгээд явж байгаа. Үүнээс олон зүйлийн үр дүн гаргана гэдэгт би итгэлтэй байгаа.

Дараагийн асуудал нь малчдын гол хүсдэг юм. Ер нь салбарын сайдын хувьд малчдын үнэтэй байгаа ноолуурыг яриад байхаас илүүтэй үнэгүй байгаа юм руу нь гол анхаарлаа хандуулъя гэж бодож малын яснаас нь авахуулаад мөнгө болгочих ямар бололцоо байна вэ гэдгийг судалж байгаа. Малын ясаар бордоо хийж байна. Энэ бордоог бид монголын газар тариаланд нэвтрүүлбэл монгол малын яс хаягдахгүй юм байна лээ. Түүнээс гарч байгаа тос нь гадагшаа экспортод гарчих юм байна. Үүнийг монголын ААН-үүд хийгээд эхэлчихсэн байна. Харин газар тариалантай уях асуудал л бидний өмнө байгаа.

УИХ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат: Тэгэхээр бордоог бид газар тариалангийн 3 газар дээр туршаад тарилтыг эхлүүлчихсэн. Тэндээс хөрсний үр дүнг гаргаад хөрсөө хамгаалж, малын ясаар хийсэн бордоог газар тариаланд нэвтрүүлээд ургацаа нэмэгдүүлж бид ясаа хаяхаа болино.

2 дахь асуудал бол бид түүхий эдээ 10 жил хаялаа. 2022 оны 3 сард тухайн үеийн ХХАА-н сайдаас Монгол ер нь жилд хэдэн арьс гаргадаг, хэдийг нь ашигладаг, хэдийг нь хаяад байгаа юм бэ? Би орон нутгаас ирлээ. Арьс булж байгаад ирлээ. Үнэхээр тэрийг булаад зогсож байгаа хүнд нүд халтирмаар байдаг учраас энэ дээр анхаарлаа хандуулж явсан.

Улсын хэмжээнд 5 газар дээр арьс ширийг мөнгө болгох ажлыг Арьс ширний үндэсний холбоо эхлүүлэе. Үхэр талдаа зүүн аймгууд сайн байдаг учраас зүүн аймгаас үхрийн арьсыг 10 мянгаар эхлүүлэе гэдэг юм.

Нэг дэх өдөр Архангай аймагт хонины арьсыг үхрийн арьстай авах ажлыг эхлүүлэе. Дараа нь Хөвсгөл аймагт хонины арьс, үхрийн арьс авах ажлыг эхлүүлмээр байна. Түүнээс гаднаас нь шүршдэг ийм хэн хэнийгээ хуурсан зүйл явахгүй байна. Тэгэхээр энийг хийж Монгол малын арьс үнэд хүрэх юм байна. Үүнийг хийж малчин хүний орлого нэмэгдэнэ. Залуу малчин ховордлоо биш. Сая хөдөө явахад малын мах өндөр байгаа үеийг олон залуучууд хэрэв махны үнэ ийм

өндөр байвал ер нь хөдөө рүүгээ явмаар байна шүү гэдэг зүйлийг ярьж эхэлж байна. Олон малчидтай уулзахад тэрийг ярьж байна шүү дээ.

Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг малчны орлого, малаас гарч байгаа ашиг шимийг амьсгаанаас бусдыг нь хаядаггүй байсан тэр тогтолцоонд оруулж ипотек, нийгмийн даатгал ямар ч асуудал биш болно гэж боддог. Тийм учраас манай яамны бодлого тийшээ чиглэж, малаас гарч байгаа ашиг шим болгоныг мөнгө болгохын төлөө зүтгэнэ гэдгийг хэлье. баярлалаа Та бүхэнд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Өчигдөр сонсголыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын илтгэлээр эхлүүлэе гэж бодож байсан. Таныг ажилтай байсан тул илтгэлийг өнөөдөр шилжүүлсэн. Одоо оролцогчдоос авсан саналын дагуу оролцогчдын үгийг сонсьё.

Түүний дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд оролцогчдоос асууж байгаа саналуудыг үндэслээд хариултдаа анхаараад явна байх гэж бодож байна. Булган аймгийн Ц.Бийбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын илтгэлтэй холбоотой саналаа хэлнэ үү.

Оролцогч Ц.Бийбат: Оролцогчдодоо өдрийн мэнд хүргэе. Сайдын мэдээллийг сонслоо. Их аятайхан салбарт нэг өөрчлөлт хийчих юм байна гэсэн итгэл төрлөө.

Хэлэлцэж байгаа асуудлын дагуу Г.Ариунбуян генералаас асуух асуулт байна. Онцгой байдал авран хамгаалах урьдчилан сэргийлэх гэдэг дээр зудын эрсдэлийг хамгийн бага хохиролтой давах шийдэл гарц бол сум, орон нутагт байгаа өвс тэжээлийн агуулахууд дүүрэн байхаас л эхэлнэ шүү дээ.

Зуд болоход агуулах нь хоосон байж байгаад гэнэт баахан самбартай тэрний тусламж, тэрний хандив гэж ирээд 1, 2 өвс, нэг тэжээлээр ингээд л өнгөрдөг. Ерөөсөө байдал ингэдэг шүү дээ. Энэ бол хариуцлагагүй төр засаг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам урьдчилан сэргийлэлт огт хийгдэхгүй байгаа. Энэ дээр нэг хариулт авмаар байна. Би өчигдөр асуудлаа ярьсан, түүн дээр протокол тэмдэглэл үйлдсэн байх.

Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтнууд холбогдсон гэмт хэргийн шинжтэй асуудал байгаа. Энэ дээр эрх бүхий УИХ-ын гишүүд, шинэ сонгогдсон идэвхтэй маш олон УИХ-ын гишүүд гарч ирсэнд хөдөөгийн малчид баяртай байдаг. Энэ хүмүүсийн асуудлыг нэг ажил болгоод өгөөрэй.

Тэгээд Г.Ариунбуян даргаас асуухад дахин давтагдашгүй гамшигт малаа алдсан тохиолдолд орон нутгийн ойролцоох 2, 3 сумын хүмүүсийг дуудаад хөдөө аж ахуйн байцаагч халдваргүйжүүлэлтийг нь хийгээд, дарга нар нь байлцаад зураг хөрөг аваад баталгаажуулаад, нөхөн төлбөр олгогдох мэдээллийг танд явуулдаг. Төлбөр ерөөсөө олгогддоггүй. Ингээд 5 жил, 10 гаран жил болчихсон малчдад энэ төлбөрийг олгох уу?

Одоо малчдын тулгамдсан асуудал бол нийгмийн даатгал гэж сая Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ярилаа.

Одоо ажилласан жил нь болчихсон боловч нөгөө хуульд заасан төрийн

бүтэц л ажлаа хийхгүй байгаатай холбоотой шүү дээ. Төр нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай, хөдөө аж ахуйн газартай, сумандаа мэргэжилтэнтэй, асар том бүтэцтэй боловч ажлаа хийдэггүйгээс хууль малчдад хүрч очоогүйгээс болоод малчид даатгалаа ойлгоогүй байж байгаад нийгмийн даатгалаа төлөөгүй өнгөрөөчихсөн. Үүнийг нөхөн төлүүлэхийг анхаармаар байна.

Малчдын хамгийн гол тулгамдаж байгаа асуудал юу вэ гэхээр бэлчээрийн тухай зохицуулалт байхгүй гэдгийг малчид хэлдэг. Өнөөдөр бид зах зээлийн нийгэмд амьдарч байгаа хэр нь бусдын үйлчилгээний газар дээр хэн дуртай хүн ирж буугаад, дээр нь зөрчил үүсээд, бараг буугаа барих нь шахуу байна. Уул уурхайчид ирэхэд захын 60 настай малчид бол буудна гэдэг болчихоод байна. Яагаад вэ гэхээр малчин хүнд бэлчээрийн газраас нь үнэтэй юм алга байгаа учраас энийгээ булаалгаад дээрэмдүүлээд байхаар асуудал үүсэж байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: баярлалаа. Оролцогч Д.Шагдарсүрэн малчин үгээ хэлнэ.

Оролцогч Д.Шагдарсүрэн малчин: Юуны өмнө хэлэлцүүлгийг санаачилж зохион байгуулж байгаа УИХ-ын байнгын хороонд талархал дэвшүүлье. Өнөөдөр малчдын амьдралд тулгарч байгаа олон чухал асуудлуудыг хэлэлцэж байна.

Малчны тухай хуультай холбогдуулаад тавих 1 санал бол Бэлчээрийн тухай хууль гээд тусдаа нэг хууль байгаа шүү дээ. Малчны тухай хууль болон Бэлчээрийн тухай хууль 2-ын хоорондын уялдааг хангасан ямар зүйл заалтууд байна вэ? Энэ дээр ямар өөрчлөлт оруулах юм бэ? гэдэг дээр анхаараасай гэсэн бодол байна.

Өнөөдөр бэлчээрийн талбайд малчид хоорондоо бэлчээрээ булаацалдаад байдаг. Газар бол сунахгүй. Мал бол өснө. Мал өсөхөөр малчдын тоо өснө. Ингээд буурь, бууцны асуудал, хашаа саравчны асуудал гараад ирнэ. Үүнийг төрийн зүгээс хуульд ямар байдлаар тусгах вэ? Цаашид бид хэчнээн тооны малтай, хэчнээн тооны малчинтай байх ёстой юм бэ? Ийм багтаамж гэдэг юм уу, үнэлгээ, үзүүлэлт байдаг болов уу? Байдаггүй бол энэ тоон үзүүлэлтийг тооцдог болгох талаар бодмоор байна. Ийм л нэг санал байна даа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. О.Отгонцэрэн, Архангай аймаг.

Оролцогч О.Отгонцэрэн: Та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе. Бэлчээр, гамшиг, малчдын эрүүл мэндийн баталгаа, эрсдэл, хөдөө орон нутагт болж байгаа бодит амьдралтай холбоотой санал асуулга ярья гэж бодож байна.

Монгол Улс эрс тэс амьсгалтай. Нэг л өглөө босдог, цас буудаг, зам гүвээ хаагддаг, асуудал үүсдэг, эрсдэл бий болдог. Хөдөө орон нутагт энэ мэт эрсдэлээс малчдаа гаргах болоход тухайн сумаас трактор байтугай 31 байдаггүй, харин мотоциклтой байж байдаг .

Мал төрийн хамгаалалтад байдаг. Малчин хүн бодит амьдрал дээр ийм эрсдэлтэй байгаа. Үүнээс гарахын тулд яах вэ гэхээр малчид нэг л зүйл хүсэж байгаа. Онцгой байдлын нэгж байхгүй суманд хүчин чадал сайтай трактор яагаад бий болгож болдоггүй юм бэ? Трактор байснаар олон мянган малчид цаг алдахгүйгээр сумаасаа эрүүл мэндийн асуудалтай өрхөд зам гаргаснаар нутгийн олон иргэд тэр замаараа үйлчилгээ авах бүрэн боломжтой юм. нэгд ийм байгаа.

Энэ асуудлаа ярихгүй орон нутагт яадаг вэ гэхээр нэг л их тусламж ирдэг. Малчид энэ завсарт хүндэрлээ, ингэлээ, тэглээ гээд л ярьдаг байхгүй юу.

Малчид хэзээ ч төсвийн ажилчдын нэг өдрийн цалинг авъя гэж хүсдэггүй. Сургуулийн сурагчдаас хүртэл нэг лаа авах нь гарц биш. Онцгой байдлаас хэдэн мянган тонн өвч ийшээ явлаа, тийшээ явлаа гээд цуваа гаргадаг. Тэр нь амьдрал дээр, малчдын хотон дээр очоод нэг, 2 ширхэг өвс болдог байхгүй юу. Энэ бол гарц биш.

Ерөөсөө гарц гээд юу асуугаад байгаа вэ? гэхээр өнөөдөр малчид өөрсдийн бэлтгэлээ хангах нь малчин хүний өөрийнх нь үүрэг байхгүй. Хууль, тогтоомж хэрэгжих ёстой. Хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжийг шийдэх ёстой гэдэг нь төрийн асуудал.

Өнөөдөр малчид татвар төлдөггүй биш. Малчид орон нутагтаа, улс орондоо хамгийн бодитой хувь нэмэр оруулаад явж байгаа. Жишээ нь, сум орныхоо хөгжлийн санд малын хөлийн татварыг бүрдүүлж байна. Бусад татвар тэтгэмж мэдээж улсын төсвийг бүрдүүлж байна. Мал, мах, хүнсний асуудлыг шийдэж байна, тийм үү? Малчид өнөөдөр төрдөө татвар төлж байгаа учраас төрийнхөө үйлчилгээг авахын тулд онцгой байдлын нэгжгүй сумд тракторын асуудлыг шийдээд өгөөч гэдгийг л бид өнөөдөр хүсэж байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ц.Бат-Оюун, Ус цаг уурын хүрээлэн.

Оролцогч Ц.Бат-Оюун: Сайн байцгаана уу? Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. УЦУОСМХ-ийн Ц.Бат-Оюун гэдэг хүн байна.

Манайх малчдад чиглэсэн хөдөө аж ахуйн олон төрлийн бүтээгдэхүүнийг гаргадаг. Уур амьсгалын эрчимтэй өөрчлөлт, малын тооны хэтрэлттэй холбоотойгоор малчдад уламжлалт мэдлэг дээр нэмээд шинжлэх ухаанд суурилсан мэдлэгийг хослуулан авч ашиглах зайлшгүй шаардлагатай болоод байна. Энэ дээр манай цаг уурын байгууллагаас ган зуд, гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх мэдээллийг цаг алдалгүй хүргэж явдаг.

Бэлчээрийн даац багтаамж бол менежмент юм. Бэлчээрийн оновчтой менежментийг авч хэрэгжүүлэх бэлчээрийн өнөөгийн төлөв байдал нь ямар байгаа вэ? Чанарт нь ямар өөрчлөлт гараад байгаа вэ? гэх мэтчилэн малчдыг мэдлэг, мэдээллээр хангах чиглэлээр илүү түлхүү хамтарч ажиллах боломжтой.

2025 оны байдлаар Монгол орны бэлчээрийн даац 37.7 сая хонин толгойгоор хэтэрсэн байна. Энэ мэтчилэн малчдад тухайн газар нутгийнх нь бэлчээрийн даац нь хэдэн хувиар хэтрээд байгаа вэ? Бэлчээрийн ургамлын төлөв байдал нь ямар байгаа вэ? Цаашид хэрэв бэлчээр хэтэрхий их доройтвол эргээд сэргээхэд асар их хэмжээний хөрөнгө, мөнгө шаардана.

Энэ чиглэлээр мэдлэг, мэдээллээр хангах, малчдын өөрсдийнх нь хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой. Үйл ажиллагаагаа улам дэлгэрүүлж ажиллах шаардлагатай байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: баярлалаа. Н.Баярсайхан, Хил хязгааргүй алхам.

Оролцогч Н.Баярсайхан: Баярлалаа, өдрийн мэнд. Өчигдөр өглөө хууль санаачлагч УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Малчны тухай хуулийн сурталчилгаа энд явагдаж байна гэж хэлсэн. Үнэхээр л орон нутгаас маш олон иргэд холбогдож байна. Ийм хууль байдаг юм уу, ийм чухал хууль байдаг юм байна гээд олон иргэд холбогдож байна. Тийм учраас хуулийн сурталчилгаа болж байна гэж таны хэлсэнтэй санал нэгдэж байна. Энэ чухал арга хэмжээ болж байна.

Олон малчид асууж байна. Би саналаа хэлсэн байгаа гэхдээ олон малчдынхаа саналыг дамжуулж хэлье. Ингэж асууж өгөөч гэж байна.

Монгол Улсад малчид юм уу, уурхай юм уу гэдгийгээ л сонгох цаг нь болсон байна. Аль нь төрийн тэргүүлэх ашиг сонирхол юм бэ? Аль нь төрийн бодлогын цөм байх юм бэ? гэдгийг асууж өгөөч.

Уур амьсгалын өөрчлөлт, ган зудын улмаас бэлчээр багасаж байгаа энэ үед төр үлдсэн бэлчээрээ малчдад үлдээх юм уу, эсвэл уурхайд өгөх юм уу, яах юм бэ? Хамтарсан ямар салбар дундын бодлого байх юм бэ? гэдэг асуултыг асууж өгөөч гэж байна.

Сүүлийн 10 жилд уул уурхайн нөлөөллийн бүсэд хэдэн өрх айл бэлчээрийн хомсдолоос болж мал аж ахуйгаа орхисон талаар тоон мэдээлэл байна уу?

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас өчигдөр мэдээлэл өгсөн. Ашиглалтын лицензийн талбайд 1300 гаруй өвөлжөө, хаваржаа байна. Хайгуулын лицензэд 3 мянга гаруй нийт 4800 шахам өвөлжөө, хаваржаа уул уурхайн лицензэд өртсөн байгаа юм байна. Тэгэхээр Монгол Улсад нийт хэдэн өвөлжөө, хаваржаа байгаа юм? Үүнээс хэд нь уул уурхайн бүсэд өртчихөөд байгаа юм бэ гэдгийг тоо баримтаар гаргаж өгөх хэрэгтэй байна.

Ган зудтай холбоотой, Онцгой байдлын ерөнхий газартай холбоотойгоор асуулт ирүүллээ. Ган зудын эрсдэлийн зураглалд уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй бэлчээрийн доройтлыг тусгаж байгаа юу? гэдгийг Онцгой байдлын ерөнхий газрын даргаас асууж өгөөч.

Шороон шуурганы давтамж нэмэгдэхэд уул уурхайн ил задгай эвдрэл ямар хувь нэмэр оруулж байгааг үнэлж судалсан судалгаа байдаг уу? Энэ судалгааг хийх үү? Уул уурхайн бүсийн малчдад зориулсан эрт сэрэмжлүүлэх тогтолцоо бодитоор хэр үр дүнтэй ажиллаж байна вэ?

Уул уурхайгаас болж нүүдлийн маршрут тасалдсан, отор нүүдлийн зай тасалдсан тохиолдолд малчдын эрхийг төр хамгаалах уу, ямар механизм байна вэ? Энийг Г.Тэмүүлэн гишүүн өөрөөс нь асууж өгөөч гэснийг уламжилж байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ш.Ариунаа, эмэгтэйчүүдийн хөдөлмөр дэмжих холбоо.

Оролцогч Ш.Ариунаа: Баярлалаа. Эрэмбэлсэн байгаа саналаа шууд хэлье.

1 дүгээр санал нь өнөөдрийн Ерөнхий хяналтын сонсголын хүрээнд Монгол Улс нүүдэлчин ахуй соёлоо авч үлдэх гэж төрийн бодлогоор Малчны тухай хууль гарсанд таатай байгаа. Сонсголд их талархалтай хандаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа. Энэ хууль дээр уур амьсгалын өөрчлөлтөө олон улсын түвшинд тодорхой тодорхойлоогүй мөртөө дахиад хүлэмжийн хийг олон улсад худалдаалах худалдаа арилжааны заалтыг давхар оруулаад ирчихсэн. Малчид бараг карбонаа зараад мөнгө авах юм шигээр хуульд оруулаад ирчихсэн байгаа нь нэлээн эрсдэлтэй шүү. Та бүхэн минь энийг анхаараач гэсэн санал байна.

2 дахь санал нь хөдөө аж ахуй ялангуяа малчны бодлого бол нийт монголчуудынхаа аж амьдралыг сайжруулах гэж тогтоол шийдвэрүүд гараад байгаа. Энэ тогтоол, та бүхний бодлого хүний амьдралыг өөрчлөхийн тулд тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсөв, нөөц, бусад нөөц болоод хүний нөөцийн бодлого нь хангалттай байж хүндээ хүрнэ.

Гэтэл анхан шатанд, сум багийн түвшинд бүх хуулиудаар үүрэг өгчихдөг. Энийгээ та бүхэн минь анзаараач. Анхан шатдаа хүнийг нь сайн томилж өгөөч, төсвийг нь хангалттай өгөөч, баг, сумын түвшинд хэлж байна.

Би өөрөө нэлээн олон судалгаан дээр ажилладаг хүн байгаа юм. УИХ болон Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд дараах саналыг тавьж байна.

Та бүхний цуглуулаад байгаа захиргааны тоо, статистик мэдээллүүд бодит амьдралаа илэрхийлэхгүй байна. Нэг жишээ хэлэхэд, сум, баг дээр очоод тоо авахаар албан тушаалтан бүхэн өөр, өөр тоо өгдөг. Статистикийн мэдээнд тэр тоо нь өөр тоо байдаг. Ингээд эдгээр тоо нь бодит амьдралаа онохгүй байгаа учраас та хэд маань бодлогоо боловсруулахад хүндрэл учраад байгаа юм. Энийг анхаараад өгөөч. Дараагийн нэг гол чухал саналаа хэлье.

Сонсголоор авсан мэдээллээр Малчны тухай хуулийг дагаж гарах маш олон журмууд батлагдаагүй байгаа. Тэгэхээр 1 гуйх, хүсэх зүйл нь малчдын аж амьдралтай холбоотой журмуудыг батлахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа малчидтайгаа сайн зөвлөлдөөд өгөөч. Анхан шатдаа малчидтайгаа очоод уулзаад саналуудыг нь аваад 2 тал хүлээн зөвшөөрсний дараа бодлогоо батлаач.

Үүнтэй холбоотойгоор Монгол банкны бодлогууд нь яагаад хөрсөн дээр хэрэгжихгүй байна гэвэл хүмүүс Монгол ахуй юу болоод байгааг огт мэдэхгүй байгаад байна. Тэгэхээр энэ сонсголын үеэр арилжааны банкны асуудлыг яриад байна шүү дээ. Тэгэхээр энийг болимоор байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. М.Бямбаахүү, Дорноговь аймаг.

Оролцогч М.Бямбаахүү: Баярлалаа. Шууд асуудлаа ярья гэж бодлоо. Хязгаар нутгийн хамгаалагчид, манаачид буюу үүрэг хүлээж нутгаа хамгаалж байгаа манаачид бол малчид байгаад байдаг.

Тэгээд газар, бэлчээртэй холбоотой эрх мэдлийг төр тухайн орон нутгаас нь булааж авч байгаад ямар ч судалгаагүйгээр лицензийг гаднын хөрөнгө

оруулалттай компаниудад олгодог. Тэгээд үүнээс үүдэлтэй бий болсон асуудлуудыг малчин орон нутагт үүрдэг.

Тэгээд уул уурхайн лицензүүдээс үүдсэн асуудлаа төр өөрөө бүрэн хянаач. Буцаад ашиглалт хайгуулын лицензүүдийг хэн олгоод байдаг юм бэ? Тэгээд тухайн орон нутгийн газрын эзэн хэн юм бэ?

Одоо бид нарыг биш болгочихлоо. Малчин бидэнд бэлчээр, ус, газар нутаг хамгийн чухал байдаг. Хуулиас хамгийн чухал байгаад байдаг. Малчдыг газар нутагт нь эзэн биш болгочхоод цаашид малчид яаж оршин тогтнох юм бэ? Үүнийг тодорхой хариулаад өгөөч.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам өөрөө хариулаач. Шууд амаар болон бичгээр хариултаа авмаар байна.

Залуу малчин бэлтгэх гээд байгаа. Энийг малчин суурьтай Монгол түмэн маань бүгдээрээ суурьшмал бүсэд шилжин нүүгээд, Монголоо тэжээж чадахгүй хэмжээнд хүрээд, махаа үнэтэй болгочхоод түүнийгээ малчдын буруу гээд яриад байдаг. Тэгвэл малчин суурийг энэ төвлөрсөн суурь бүсээс хөдөө татах механизмыг ажиллуулаад явуулаач.

Энэ дээр 16-40 нас гэж зааж, түүний 50-аас илүү хувийг алдсан малчдыг хөдөө дэмжинэ гэхийн оронд сууриар нь хөдөө татах нөхцөл байдлыг нь бүрэн хангаж өгөх хэрэгтэй байна. Сургуулийн хүүхдүүд яагаад цөөрөөд байгаа вэ? Малчдын хүүхдүүд тэдний үргэлжлэл, залгамж халаа шүү дээ. Тэгэхэд малчдын хүүхдүүдийг шууд оюутан болгоод явуулж байна. Сурч боловсроод мэргэжил эзэмшээд ирэхээр хөдөө буцаж очихгүй байгаа асуудал нийгэмд өрнөөд байдаг.

Тэгвэл малчныхаа хотноос оюутан насныхыг нь сурах нөхцөл боломжийг нь цахимаар хангаад өгөөч. Тэгвэл бага ангийн 1, 2, 3 дугаар ангиас илүү оюутан насны хүүхэд өөрөө сурах боломжтой учраас энэ хуулийг ингээд хэрэгжүүлж болохоор харагдаад байна.

Тэгэхээр суурь түвшнээс малчдын амьдрал ахуй цаашдаа зөв болох чиг хандлагад очоод байгаа юм. Тэгж байж хязгаар нутгийнхаа газар нутгийг үнэгүйдүүлэх биш зөв зохистой ашиглах, малаараа дамжуулж шимт хөрсөө бүрэн ашиглах хэмжээнд эргэлтэд оруулах хэмжээнд Монгол Улс анхаараач.

Уул уурхайгаар газраа 10, 20, 30 жил ухаад усгүй, бэлчээргүй, газаргүй болгож хаягчаад явбал дараа нь малчин яаж оршин тогтнох юм бэ? Энэ тал дээр улс бүх асуудлаа аваад явмаар байна. Энэ дээр бүгдээрээ анхаараач гэдгийг хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Б.Өлзийбат, Монголын барилгачдын холбоо.

Оролцогч Б.Өлзийбат: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын Барилгачдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Б.Өлзийбат байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2 дээр төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим бол хууль дээдлэх. Өнөөдөр энэ хуулийн хэрэгжилтийн биелэлт маш муу байгаа. Тэгэхээр барилгын салбартай холбоотой гол асуудал нь хуулийн 4.2.4-т

малчдын амьдралыг сайжруулах, амьдрах нөхцөлийг сайжруулах, малчдын ипотекийн зээл, орон сууцад оруулах гээд бодлогын алдаа гарсан зүйл нь үндсэндээ Засгийн газрын хэмжээнд Үндэсний орон сууцын хөтөлбөрийг зайлшгүй зарлах хэрэгтэй байгаад байна. 150 мянган айлын, 100 мянган айлын гэдэг шиг хөтөлбөр. Бидний зүгээс бодит асуудал юу вэ?

Эрчим хүчний хэмнэлттэй ногоон пассив 100 мянган айлын үндэсний орон сууцын хөтөлбөрийг зарлаж, үүн дээр үнийн бодлого, татварын асуудал. Гол нь масс үйлдвэрлэл болоод ирэхээр малчин өрхүүд орон нутагт байгаа 400 мянган орон сууцад орох хэрэгцээтэй байгаа хүмүүсийн худалдан авах чадвар нэмэгдэнэ шүү дээ. Үүн дээр төрийн зүгээс бодлогоор дэмжиж цаашид авах арга хэмжээг тодорхой болгох хэрэгтэй.

Яагаад гэхлээр орон нутаг дулааны болон эрчим хүчний маш том асуудалд орсон байгаа. Үүнийг гол шалтгаан нь олон хүмүүс нарны болон ногоон эрчим хүч чухал гээд байгаа боловч Монгол Улсад, барилгын салбарт ногоон барилгын стандарт албан ёсоор байхгүй.

2025 оны 03 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа ногоон барилгын загвар аргачлалыг зөвлөмжийн байдлаар хэрэгжинэ гэж байгаа. Үүнээс шалтгаалаад Монголын арилжааны банкнууд дээр нийт 4,8 их наяд төгрөг ногоон зээл гарч чадахгүй байгаа. Тэгэхлээр энэ бодлогын алдаанууд дээр анхаарах хэрэгтэй.

Хууль өөрөө яваад хэрэгжихгүй л дээ. Сайн хууль гарах нэг хэрэг, үр дүн гаргах нь хамгийн чухал учраас хуулийг баталж байгаа нь эхний үе шат. Үүний дараах маш олон үе шатууд дээр иргэд, олон нийт, аж ахуйн нэгжүүдийн бодит байдлыг сонсох хэрэгтэй. Гол асуудал нь орон нутагт юу гардаг вэ гэхлээр уул уурхайн асуудал байдаг. Уул уурхай салбар маш олон баялгийг улсын төсөвт авчигдаг.

Одоо амнатын хууль явж байна. Орон нутагт үлдэх боломжийг нь нэмэх хэрэгтэй. Дээр нь энэ хуулийн 13.1-д заасан сум бүрд малчны сан байна гэсэн. Энийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Цаашид Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулаад хууль дагаж гардаг олон журмыг багасгах хэрэгтэй.

Хэрвээ журам гарахаар бол хууль хэрэгжих өдрөөс өмнө журам нь цуг батлагддаг байдлаар байх. Тэгэхгүй бол хууль нь гараад 2 жил болж байхад журам нь гараагүй байдаг. Үүнээс болоод маш олон иргэдийн хуулийн үндсэн үзэл баримтлалын хүрээнд шийдүүлэх асуудал нь тодорхойгүй болж эхэлдэг.

Дараагийн нэг зүйл бол Үндэсний баялгийн сан байгаа. Одоогийн байдлаар 8.2 их наяд төгрөг байгаа. Бидний хуримтлал буюу нэрийн дансанд хүүхдийн мөнгө буюу 1.4 их наяд, 6.8 их наяд нь хуримтлалын санд үүсэж байгаа. Үүгээр 2030 оноос хойш орон сууц болон боловсролд хэрэгжиж эхэлнэ.

Тэгэхлээр 8 айлын хүүхдийн нэг нь малчин айлын хүүхэд. Хөдөөд малчдын нуруун дээр, адуучин залуучуудын нуруун дээр амьдрал үргэлжилж байгаа.

Хуулийн биелэлтийг парламент цаашдаа улам төгөлдөржүүлж хяналт шалгалтыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Хариуцлага тооцдог байх ёстой.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ц.Ундрам,

Өмнөговь аймаг.

Оролцогч Ц.Ундрам: Монгол орон даяар энэ сонсголыг, Малчны тухай хуулийг малчид чих тавин сонсоод сууж байна. Маш олон үүрэг даалгаврыг төлөөлөн оролцож байгаа малчдадаа хэлсэн байна.

Тухайлбал, энэ хуулиар малчдад үүрэг нэмээд эрхийн баталгаа нь хангалтгүй байна гэж дамжуулсан. Төсөлд малчдыг дагаж мөрдөх олон үүрэг, шалгуур, шаардлага тулгасан боловч малчдын эрх зөрчигдвөл хамгаалах, гомдол гаргах, нөхөн төлбөр авах механизм байхгүй байна. Эрхийн хууль мөн үү? гэж асуумаар байна.

Дараа нь уул уурхайн нөлөөлөлд өртсөн малчдын асуудал яагаад тусгагдаагүй вэ? Монголын олон аймагт малчид уул уурхайн дэд бүтцийн төслийн нөлөөгөөр бэлчээр, ус, нүүдлийн маршрутаа алдсаар байгаа. Гэтэл энэ хуульд ийм нөхцөл тусгагдаагүй, малчдын эрхийг хамгаалах заалт ч алга байна.

Малчны тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Газрын тухай хууль хооронд уялдаа холбоотой байх ёстой. Хэдэн тийшээ харсан хууль байвал цаашид аль аль нь зөрчил, маргаан үүсгэхээр байх болно. Хуулийн хэрэгжилт бол хангалтгүй байна.

Малчид маш хэрсүү болсон шүү. Малчдад 20 гаруй үүрэг оноож байгаа атлаа уул уурхай, уур амьсгалын өөрчлөлтөөс болж амьжиргаагаа алдсан үед нь хамгаалах ганц баталгаа энэ хуульд хаана нь байна вэ?

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас малчдынхаа бэлчээрт газрыг уул уурхайгаас хамгаалах лиценз олгохгүй байх, эрүүл газар нутаг авч үлдэх талаар ямар оролцоотой байдаг вэ? Энэ хоёр чухал асуудал мөртөө байнга зөрчигдөж байдаг 2 салбараа хэрхэн хөгжүүлэх вэ? гэж асууя. Баярлалаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Д.Гомбо-Очир, Төв аймаг.

Оролцогч Д.Гомбо-Очир: Малчны тухай хууль өөр оронд дэлхий дээр бараг байхгүй байх. Энэ хуулийг бусад хууль шиг гадаадын хуулиас жишиг аваад, хуулаад, орчуулаад хийчих ямар ч арга байхгүй. Тэгэхээр ийм сайхан хууль хийсэн нь Монголын мал аж ахуй нэг алхам урагшаа явлаа гэж бодож байна.

Энэ хуулийн зорилго гэж байна. Уг зорилгод хүн төрөлхтний өмнө бидний хүлээсэн нэг том үүрэг бол нүүдлийн соёл иргэншлийг авч үлдэх явдал юм. Энэ зорилгод нүүдлийн соёл иргэншлийг авч үлдэх тухай нэг өгүүлбэрийг оруулаарай. Энэ бол 1 дүгээрт.

2 дугаарт нь бэлчээр бол улсын үндэс. Хөрс бол улсын оршин тогтнох үндэс. Тэгэхээр бид бэлчээрээ хамгаалах хэрэгтэй, хөрсөө хамгаалах хэрэгтэй, Үүний дараагаар хөрс, бэлчээртэй байж мал тогтоно. Тийм учраас хуульд бэлчээрийг сэлгэх, бүүр заавал сэлгэх сумуудад энийг хуульчилж оруулж өгмөөр байна.

Тэгэхгүй бол сум суурин аймгийн төвийг тойроод айлууд буучихсан. Ингээд улаан зүлэг, улаан элс болгочихдог. Миний багад Монгол Улс өвсөн далай байсан бол шороон далай болсон. Баруун аймгийг цөлжүүлээд дуусгачихсан, зүүн тийшээ

нүүж байгаа. Зүүн талд 5 жилийн дараа цөл болно. Тэгэхээр энийг хуульд хатуу суулгаж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол бидний өнөөдрийн ярьдаг тэр жижиг сажиг заалт, мал байхгүй бол энэ хуулийн заалт гээд яриад ямар ч хэрэггүй болно. Ердөө ийм л юм хэлэх гэж энд сууж байна.

Гэхдээ малчид 5 Буудлаас ирээгүй 500км-ээс ирсэн, 7 буудлаас ирээгүй 700км-ээс ирсэн. Иймд энд оролцож байгаа малчин хүний хэлэх гэж байгаа санааг нь гүйцээгээд хэлүүлчихгүй бол болохгүй байна шүү. товчхондоо ийм байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Д.Гомбо-Очир малчин гавьяат малчин. Энэ сонсголд хүрэлцэн ирсэнд танд талархлаа илэрхийлье. Үнэтэй санаанууд хэллээ.

Үнэхээр бэлчээргүй бол малын тухай асуудал яригдахгүй шүү дээ. Тийм болохоор Бэлчээрийн тухай хуулийг зайлшгүй оруулах шаардлагатай байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ дээр анхаарна биз. Бэлчээр, малын тэжээл тариалах, газартай холбоотой асуудлууд гээд маш олон асуудлууд байна.

Нөгөөтээгүүр, Та сая малчид 7 буудлаас ирээгүй 700км-ээс ирлээ гэж хэллээ. Бид өөрчлөлт хийх хэрэгтэй байх. Малчны тухай хуульд Ерөнхий хяналтын сонсгол хийж байгаа нь хуульд хийж байгаа хамгийн анхны сонсгол.

Цаашлаад олон хуулиудад сонсгол хийгдэх байх. Олон алдаа, дутагдал, олж хараагүй, хийхгүй байгаа, хариуцлагагүй алдсан зүйлүүдээ бид засах ийм боломж бололцоо олдох байх. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих боломж, бололцоо бидэнд гарч ирж байгаа юм. Цаашид улам төгөлдөржөөд явна. Магадгүй Малчны тухай хуульд та бүхний оруулж ирж байгаа саналуудыг тусгаад, нарийвчилсан заалтуудыг хуульд оруулах шаардлага ч гарна.

Мөн хэрэгжихгүй байгаа гэсэн заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газарт бид тодорхой чиглэлүүдийг өгнө. Эндээс УИХ-ын гишүүдээс гарч байгаа саналууд, төрийн байгууллагуудын хариулж байгаа хариулт дундаас гарсан саналуудыг бүгдийг нь нягтлаад Засгийн газарт тодорхой чиглэл өгөх юм.

2 дугаарт нь, та бүхнийг энд үг хэлэх эрхийг нь нээж өгч байгаа. Түүнээс биш Ерөнхий хяналтын сонсголд зөвхөн УИХ-ын гишүүн, төрийн байгууллагынхан нэг нь асууж нөгөөдөх нь хариулах ийм дэгтэй юм байгаа. Магадгүй бид энэ дэгтээ ч өөрчлөлт оруулъя. Өнөөдрийн хувьд та бүхний үгийг сонсож байгаа нь үндсэндээ дэгээсээ жоохон гажаад явж байгаа гэдгийг та бүхэн ойлгоосой гэж хүсэж байна. Баярлалаа.

Дараагийн үг хэлэх оролцогч С.Мааманхүү, Өмнөговь аймаг.

Оролцогч С.Мааманхүү: Та бүгдийн энэ өдрийн сайхан мэндийг хүргэе. Малчны тухай хуулийн төслийг ингээд хэлэлцэж байгаа нь бидний хувьд нэг алхам урагш явах маш том сайхан боломж байгаа юм.

Бид дээрээс биш доороос иргэдийнхээ үгийг сонсож, сонсгол хийж байгаа нь Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын 17 дугаар бага хурал (КОП17)-ын өмнө хийж байгаа сайхан амжилт гэж бодож байна.

Үг хэлсэн өмнөх хүмүүсийн хэлээд байгаагаас арай өөр өнцгөөс нь

давхардуулахгүйгээр ярья гэж бодлоо. Монголын говьд уул уурхай түрээд ороод ирчихсэн байдаг. Засгийн газар хөрөнгө оруулалтыг нэлээн хийдэг боловч малчдад нь ямар ч хөрөнгө оруулалт байдаггүй. Жишээлбэл, саяхан 1 хуралд ороход Монголын говьд ямар ч төсөл хөтөлбөр хэрэгждэггүй. Манай Өмнөговь аймагт 30 жил бараг төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

Одоо Коп17-ын бага хуралд малчдын хурлууд олон болно. Энэ дээр Монголын говьд илүү анхаараарай гэж та бүгдээс хүсэх байна гэдгийг дамжуулж хэллээ.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та бүхэн ард иргэдийн, малчдын төлөөлөл. Тэгээд мэдээж ард иргэдийнхээ төлөөллийг УИХ-ын гишүүд, төрийн байгууллагууд сонсох ёстой. Тэгээд та бүхний хэлсэн саналыг төрийн байгууллагынхан хариулт дээрээ бодолцож давхар хариулна гэж итгэж байгаа. Ер нь ийм удирдамжийг өгч байна. Та бүхнээс саналыг их сонслоо.

Завсарлагын цаг болсон байна. Завсарлаж орж ирээд гишүүдийн нэрсийг авъя. Завсарлага 13 цаг 30 минут хүртэл.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Үдээс хойших хуралдаанаа эхлүүлье. Үдээс өмнө хэлэлцүүлэгдсэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Хошууч генерал Г.Ариунбуяны илтгэлтэй холбоотойгоор асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Одоо УИХ-ын гишүүн Б.Бейсен асуулт асууж, үг хэлнэ.

УИХ-ын гишүүн Б.Бейсен: Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд, өнөөдрийн сонсгол хэлэлцүүлэгт оролцож байгаа албан байгууллага, хоршоодын эзэд, малчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдөр чухал хэлэлцүүлэг болж байна. Малчны тухай хуулийг Г.Тэмүүлэн гишүүн болон бусад олон гишүүд санаачилсан. Би ч энэ хуулийг дэмжээд сонсгол явуулах шийдвэрийг манай Байнгын хорооноос гаргаж, хууль яагаад хэрэгжихгүй байна гэдэг асуудал дээр ингээд сонсгол хийж байгаа.

Би өөрөө малчин айлын хүүхэд. Одоо ч мал малладаг. Зун хөдөө очихдоо хэдэн үхэртэйгээ л байж байдаг. Малчдын амьдралыг үнэхээр сайн мэддэг. Өглөөний 5:06 цагаас шөнийн 22:23 цаг хүртэл тасралтгүй ажилдаг. Малчдын амьдрал бол жилийн 365 хоног тасралтгүй явдаг. Төрийн албан хаагчид ч юм уу, төрийн үйлчилгээний албан хаагчид шиг 1, 2 сар амраад явчихгүй, байнга тасралтгүй үйл ажиллагаатай салбар байгаа юм. Жишээлбэл, 1, 2 цаг цасан шуургад зогсоход жирийн иргэд тэсэхгүй шүү дээ. Малчид бол өдрийн 12-15 цаг цасан шуурганд малаа хариулаад явж л байдаг. Ийм хүнд нөхцөлтэй. Тийм учраас Малчны тухай хуулийн хэрэгжилт дээр малчдын нийгмийн асуудал, хөдөлмөр хамгааллын асуудлаа яаж шийдэх вэ, малчдын эрүүл мэнд болон тэдний хүүхдийн боловсролын асуудлыг яаж шийдэх вэ, малчдын уур амьсгалын өөрчлөлтөд яаж дасан зохицож, яаж тэсвэрлэж чадах вэ гэдэг асуудлууд байна. Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, УОК-оос анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудал байгаа юу?

Өнгөрсөн 2 жилийн Сүхбаатар, Дорнод аймгуудад болсон зудаар тэнд байгаа ихэнх малчдын мал үрэгдээд хүнд байдалд орж зарим малчдын хот нь харлачихсан тохиолдол гарсан. Гэтэл сараалж хашаатай, заримыг нь эсгийгээр, алаг цаасаар хашаа хийчихсэн боловч үнэхээр байгалийн хүчин зүйлийг давашгүй байгаа юм.

Өндөр хөгжилтэй зарим орнууд дээр сэндвичин хашаа, байшин барилгыг нь бариад өгчихдөг асуудал байж байна. Энийг шийдэх асуудал. Жилийн жилд УОК-оос өчнөөн тэрбум төгрөгийн зардал гардаг. Тийм учраас ядахдаа нэг сум, нэг аймагт ч гэсэн энэ малчдын нийгмийн асуудлыг шийдэх асуудал байж байгаа.

Нөгөө талаар уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бэлчээр, хадлангийн асуудал гэх мэт чухал асуудлууд байна. Энэ дээр салбарын яамнууд онцгой анхаарах хэрэгтэй байна. Гол нь эрүүл мэндийн асуудал байгаа. Нярай хүүхдийн эндэгдлийн ихэнх нь малчдын хүүхэд гээд байна сүүлийн үед дүгнэлт судалгаа гараад байна. Хөдөө өвдсөн хүнийг аймгийн төв рүү, сум руу авч явахад хүндрэл учирдаг тул энэ асуудал ийм чухал. Одоо юун дээр салбарын яамнууд, шийдвэр гаргагч түвшний улсууд анхаарахыг өнөөдрийн сонсголд тусгасан нь зөв байх гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Ганхүлэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Шууд тодорхой асуултууд асууя. Эхлээд Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян генералаас асууя.

Малчны тухай хуулийн 4.2.7 дахь заалтын хэрэгжилтийг та тодорхой хэлж өгөөч?

Гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгоно гэсэн заалт байгаа. Энэ заалтын хэрэгжилт ямар түвшинд байна вэ? Хэчнээн хүн хүсэлтээ өгөөд хэчнээн хүний асуудлыг хэдэн төгрөгөөр шийдсэн бэ? гэдгийг эхлээд асууя.

2 дахь нь энэ хуулийн 11 дүгээр зүйл гэж уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах гэсэн үндсэн бүлэг байгаа. Энэ хүрээнд 5 асуудлыг үндсэндээ дурдсан. Гол санаа нь дундын эрсдэлийн сан байгуулж болно гэсэн заалт байгаа. Тэгээд энэ сан байгуулах ажил хаана яаж явж байгаа вэ? Сан байгуулагдсан уу? Эрсдэлийн санд үүсэх, зарцуулах, хяналт тавих журмыг харилцан тохиролцож гэрээгээр баталгаажуулна гэж заасан. Тэгэхээр энэ журам батлагдсан уу? Хэрвээ байнгын эрсдэлийн сантай тодорхой асуудлуудаа бид эрэмбэлээд шийдлүүдээ гаргаад явж болно гэдэг агуулгыг хууль дээр заасан байгаа. Тэгэхээр ийм 2 асуултыг Г.Ариунбуян даргаас асууя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатад хандаад хэлэхэд сүүлийн хугацаанд Таны хийж байгаа 1100 хөтөлбөр, арьс ширний тордолтын цэг байгуулах гээд олон ажлуудыг дэмжиж байгаа. Их үр бүтээлтэй, бодитой ажлууд явж байгаа. Тэгээд энэ дээр талархалтай байгаагаа юуны түрүүнд хэлье.

Малчны тухай хууль болон өнөөдрийн сонсгол явагдаж байгаатай холбогдолтой ерөнхий бодлогыг танаас асууя аа.

Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо зарчим гэж энэ хуулийн 6 дугаар зүйлд дурдсан. Тэгээд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачилга гаргаад МСҮТ, их дээд сургуулиуд дээр хөдөө аж ахуйн чиглэлээр малчдыг сургах богино болон урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ гэдэг тодорхой заалт орчихсон байгаа.

Гол асуудал бол малчдын боловсролын асуудал. Одоо эхэлж байгаа цахимаар болон янз бүрийн хэлбэрээр насан туршийн боловсрол олгохтой холбогдолтой заалтууд яаж хэрэгжиж байгаа вэ? Боловсролын яамтай яаж уялдаж ажиллаж байгаа вэ?

Түүнчлэн тэжээл бэлтгэл болон мал аж ахуйн чиглэлээр суралцаж байгаа 50 оюутныг цаашид мал эмнэлгийн чиглэлийн малын эмч, зоо техникийн чиглэлийн мэргэжлүүдээр сургахад хэдүүлээ яаж ажиллаж болох вэ гэдэг бодлогын асуултыг танаас асууя.

Малчдын хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүд дээр таны саяын хэрэгжүүлж байгаа заалтууд хуулийн төсөлтэй уялдаж ажиллах уу? Малчдын нийгмийн асуудал дээр цаашдаа эрүүл мэнд, бусад төрийн үйлчилгээ авах чиглэлд ямар бодлогыг барьж ажиллах вэ? Хамгийн чухал нэг зүйл бол цахим шилжилт юм.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Онцгой байдлын ерөнхий газар хариулъя.

Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга Ц.Ганзориг: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга Ц.Ганзориг байна.

Малчны тухай хуулийн 4.2 дахь заалтад заасан Гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан малчны ар гэрт буцалтгүй тусламж олгох журмыг Засгийн газрын 2026 оны 03 сарын 11-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор баталсан. Энэ тогтоол батлагдсанаас хойш ямар нэгэн аюулт үзэгдэл, гамшигт амь насаа эрсэдсэн малчин өрхөд тэтгэмж олгоогүй байна. Нэг л хүсэлт УОК дээр ирсэн. Энэ хүсэлт Дорнод аймгаас ирсэн. Энэ оны 2 сард болсон цасан шуурганы улмаас 2 иргэн нас барсан гэдэг. Энэ тэтгэмж олгох хүсэлтийг аймгийн Засаг даргаас ирүүлсэн. Засаг даргад УОК-ын ажлын албанаас хүргүүлсэн хариу нь энэ тогтоол 3 сарын 11-нд баталсан учраас 2 сард болсон асуудал дээр нөхөн үйлчлэх боломжгүй байна. Тийм учраас аймгийн Засаг дарга аймгийн Онцгой комиссын эрх мэдлийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд та бүхэн энийгээ шийдвэрлэх нь зүйтэй гэсэн хариуг өгсөн байгаа.

Эрсдэлийн сан гэж энэ хуулийн 11.2 дээр байгаа. Энэ нь малчид өөрсдийн санаачилгаар хоршин нэгдэж болзошгүй гэнэтийн аюул эрсдэлээс хамгаалах өөрөөр хэлбэл өөрсдийн үйл ажиллагааны борлуулалтын орлогоос хуримтлал үүсгэж дундын эрсдэлийн сан байгуулж болно гэсэн заалт байдаг. Тэгэхээр малчид өөрсдөө эвлэлдэн нэгдэж бүлэг хоршоо үүсгэж дундын эрсдэлийн сан байгуулах нь малчдын асуудал.

2017 онд шинэчлэн найруулсан Гамшгаас хамгаалах тухай хуульд аймгийн

Засаг дарга болон иргэдийн хүлээх үүрэг дээр аливаа иргэн эвлэлдэн нэгдэж бүлэг нөхөрлөл байгуулан гамшгаас хамгаалах эрсдэлийн сан байгуулна гэсэн байдаг.

Энэ хүрээнд олон улсын төсөл, хөтөлбөр олон аймаг сумуудад малчдын сайн дурын бүлэг байгуулж төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Гэсэн хэдий боловч төсөл дуусаад түүнийг тасралтгүй авч хэрэгжүүлэх үүрэгтэй Засаг дарга, баг хорооны дарга энэ асуудлыг орхидог. Өөрөөр хэлбэл төсөл яваад нэг жилийн дараа гэхэд төслийн үр дүн зогсонги байдалд ордог.

Сайн бүлэг нөхөрлөл, хоршоолол үүсээд үйл ажиллагаагаа явуулж байгаа цөөхөн сайн жишээнүүд байгаа. Тэгэхээр энэ дээр анхаарч ажиллаж байгаа.

УИХ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат сайд: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Малчны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд одоогоор 50 хүүхэд сурч байгаа гэсэн тоон мэдээлэлтэй байгаа. Яг малчдад энийг сургах гэж байгаа бол заавал мэргэжлийн хичээл заахгүйгээр сургах хүсэлтүүдийг илэрхийлж байгаа.

Цаашид хөдөө аж ахуйн салбарт жишээ нь малчин хүн юу хэлж байна гэхээр малчны хүүхэд гээд заавал хөдөө аж ахуйтай холбоотой, малтай холбоотой мэргэжлээр сурах албагүй гэдэг зүйлийг ярьж байгаа. Тэгэхээр үүнийг цаашид яаж шийдэх вэ? гэдгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Боловсролын яамтай эргэж харж ярихгүй бол болохгүй юм байна.

Малчдын хөгжлийн сургалтын асуудал дээр 2026 онд нэг ч төгрөг байхгүй байгаа. Гэхдээ Малчны тухай хуулийг санаачилсан гишүүдийн нэг учраас малчдын цаашдын нийгмийн асуудал болон олон зүйлүүдийг шийдвэрлэхэд мэдлэг боловсрол олгох тал дээр онцгой анхаарал хандуулъя. Яаман дээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрөөс малчдад хандсан сургалтыг үр дүнтэй, амьдралтай, хөрсөн дээрээ буусан, амьдрал дээр тулгуурласан сургалт хийе гэсэн бодолтой байгаа.

Нөгөө талдаа малчдыг мэдээллээр хангах зайлшгүй шаардлага байна. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайтыг зөвхөн сайд гараад байдаг биш, салбарын бүхий л үйл ажиллагааг ялангуяа ямар зүйл төлөвлөж байгаа юм, ямар юм хийж байгаа юм гээд олон зүйлийг ил тод, нээлттэй болгож сурталчилдаг сайт болгон өөрчилж байгаа. Үүний үр дүн ч гарч байгаа гэж хэлье.

Малчдын нийгмийн асуудлыг яах вэ? гэж байна. Хэдүүлээ нэг зүйлийг бодох хэрэгтэй байх. Амьдрал дээр малчид төрөөс ганц л зүйлийг хүсдэг. Энэ нь малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулаад өгөөч л гэдэг. Өөр та нараас юу ч хүсэхгүй гэдэг зүйлийг олон малчид хэлдэг.

Нэг жилийн 12 сарын хугацаанд 1, 2 сар махны үнэ жоохон өндийгөөд ирэхээр экспортоо ч хаа гэж нэг хэсэг нь уурлаад, нөгөө хэсэг нь тарган хонины гуя барьж Төрийн ордноор гүйлдээд л. Иймэрхүү байдлаар хандаад бол болохгүй л дээ.

Тэгэхээр малчдын нийгмийн асуудлыг шийднэ гэхээсээ илүүтэйгээр малчдын өсгөн үржүүлж буй малын түүхий эдийг үнэтэй болгох асуудлыг бид шийдээд өгвөл эсвэл эдийн засгийн эргэлтэд оруулбал олон асуудлууд ул

сууриараа шийдэгдэнэ гэж харж байгаа. Энэ хуульд олон зохицуулалт тусгагдсан байгаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн хувьд Ц.Идэрбат сайд аа, нэг зүйл дээр бид ойлголцлоо нэг болгох ёстой шүү.

Анх хуулийг санаачилж байхад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхантай бид ярьж байгаад ямар мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна. Ямар мэргэжлээр, өөрөөр хэлбэл ямар хөдөө аж ахуйн мэргэжлээр хүмүүс сурахгүй байна гэсэн асуудлууд яригдаж байсан. Тэр тусмаа сүүлийн үед малын эмч, зоотехникч мэргэжлээр хүүхдүүд сурахгүй байгаа энэ тохиолдолд малчдын хүүхдүүд амьдрал дээр арай илүү ойрхон болохоор хэрвээ энэ чиглэлээр суралцъя гэсэн тохиолдолд дэмжиж мэргэжлийнхээ боловсон хүчнийг бий болгоё гэдэг өнцгөөр малчдаас хүүхдүүдээ сургая гэсэн ийм логик явсан. Одоо бүүр хавтгайраад хэн хүссэн нь ямар ч хамаагүй мэргэжилд шилжүүлэх зүйлд ингээд гулсаад орчих шиг боллоо. Анхны зорилго бол тийм байсан шүү.

М.Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Энэ хуулиас хэрэгжсэн заалт байгаа юм уу?

Хуулийн 4.2.7-д “гамшигт нэрвэгдсэн бол улсын нөөцөөс тодорхой арга хэмжээ авна” гэж заасны дагуу 2024 оны 6 сарын 5-ны өдөр журам батлагдсан гэж ойлгож байгаа. Журам гараагүй хэдэн жил болсныг харгалзан үзэх асуудал гэж бодохгүй байна.

Бидний яриад байдаг хууль давсан журам гэдэг чинь эндээс гарч ирэх гээд байна. 2024 оны 6 сараас хойших тохиолдлууд дээр бид бүхэн энэ асуудлыг авч хэлэлцэх хэрэгтэй. Тэгээд яагаад ингэж үзэж байгаа гэдгээ дахиад тодруулъя.

Дорнодоос ирсэн тэр хүсэлтийг би санаж байна. Түймэртэй холбогдолтой нэлээн олон тохиолдлууд сүүлийн 2 жилийн хугацаанд гарсан. Тэгэхээр энэ зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой асуудал дээр ингэж хандмааргүй байна. Журам батлагдсанаас хойш буюу 3 сард дөнгөж баталсан гэсэн тайлбарт харамсалтай байна.

Эрсдэлийн сан байгуулахад нээлттэй байгаа гээд орхиж болохгүй. Уур амьсгалын өөрчлөлт онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хувьд энэ асуудалд компани ажлыг өрнүүлж хуульд тусгагдсан бололцоог ашиглаж сум орон нутгийн удирдлагууд, малчидтайгаа хамтран ажиллах, эдгээр санаачилгуудыг өрнүүлэх бололцоог нь хуулиар олгоод өгсөн байгаа. Тэгэхээр үүнтэй холбогдолтой ажил дээр та хэд санаачилга гаргаад ажиллах нь зөв. Хэрвээ ажилласан сайн туршлага байгаа бол тэрийгээ хэлээч гэдэг асуултыг асууж байгаа юм. Тодорхойгүй хариулт өгч байгаа тул нэмэлт тайлбар авъя.

Боловсролын яамнаас бүх мэргэжлээ больё гэж байгаа юм. Малын эмч болон хөдөө аж ахуйн гол мэргэжлүүдийг мал аж ахуй гэдэг үндсэн томьёолол дунд оруулж хуулийн төсөл батлагдсан байгаа. Гэхдээ эрхээ олгохдоо зөвхөн тэжээл бэлтгэл, мал аж ахуй гэдэг 2 мэргэжлээр сургахаар хамрагдалт нь бага байгаад байна.

УИХ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат сайд: Миний илтгэлийг урагшлуулаад 13.50-аас биш, урьдчилаад тавиулсан учраас энэ талаар илтгэлд юу ч ороогүй байна. Та бүхэнд мэдээлэл очоогүй байна.

Малчны хууль батлагдсантай холбогдуулаад 9 төрлийн журам боловсруулагдах ёстой юм байна. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон бусад салбарын яамнууд хоорондоо үйл ажиллагааны уялдаа холбоогоо сайжруулах ёстой юм байна. Эдгээр журмаас үлдээд байгаа нь НДШ-ийн асуудал мөн малчны зөвлөлийн асуудал байна. Энэ журмыг Сангийн яам болон бусад холбогдох яамнууд нь оруулж ирэх ёстой. Энэ дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам өмнө дурдсан 2 яамтайгаа хамтраад саналаа боловсруулах ажил дээр анхаарлаа хандуулъя. Хуулийг дагаж гарах нийт 9 журмаас 7 нь батлагдсан гэж ойлгосон. Үүнээс 2 нь батлагдаагүй байгаа гэдэг нь үнэн юм билээ.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ХААИС-аас хариулъя.

ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг: ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг.

Боловсролын сайдын баталсан дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл хөтөлбөрийн индекс байдаг. Энэ индексийг үзвэл Малчны тухай хууль дээр ч, Боловсролын яамнаас батлагдсан журам дээр ч адил мал аж ахуй болон тэжээл, бэлчээрийн чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрүүдэд төлбөрийг нь даана гэсэн заалт байгаа.

Тэгвэл мэргэжлийн индекс батлагдсан тушаал дээр нарийвчилсан чиглэл буюу мал аж ахуй, газар тариалан гэдэг чиглэл дотор бакалаврын 11 хөтөлбөр байгаа. Энэ 11 хөтөлбөрийн 5 нь мал аж ахуйн чиглэлийнх, 6 нь газар тариалангийн чиглэлийн хөтөлбөр. Энэ 5 мал аж ахуйн чиглэлийн хөтөлбөрт тэжээл, бэлчээр судлал гэсэн нэг хөтөлбөр нь орсон. Бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлт гэсэн нэг хөтөлбөр 07 индекс дээр байгаа. Тэгэхээр бид хууль, журам хоёроо баривал Боловсролын зээлийн сангаас мал аж ахуй болон тэжээл бэлчээр чиглэлийн 5 хөтөлбөр дээр тэтгэлэг олгох бүрэн боломжтой гэж бид харж байгаа. Тэгээд асуудлыг нэгэнт журам тусгасан учраас Зээлийн сан журмаа мөрдвөл бас боломжтой асуудал. Одоо бол зөвхөн 2 мэргэжил дээр тэтгэлэг өгөөд явж байгаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Зээлийн сангаас мал эмнэлгийн асуудал орох уу?

ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг: Мал эмнэлэг орохгүй. Энэ чиглэлийн хувьд 084 буюу мал эмнэлэг гэдэг чиглэлд ороод яамнаас баталсан байгаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Бид хуульд өөрчлөлт оруулна гэсэн үг үү?

ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг: Тийм. Энэ хуульд мал эмнэлэг гэсэн чиглэл оруулж байж өөрчлөлт орно.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Танайх аргачлалаа өөрчилнө гэж байна. Энэ дээр тайлбар нэмэлт хийе.

ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг: Тийм. Боловсролын яаман дээр дээд боловсролын мэргэжлийн чиглэлд тэтгэлэг олгох 2 журам дээр нэмж чиглэлээ зааж өгч байж энэ хууль хэрэгжинэ.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Мал аж ахуй гэдэг дотор мал эмнэлэг орохгүй юу? Мал аж ахуй гэдэгт мал эмнэлэг орохгүй гэдгийг гишүүд ойлгоорой. Хэрвээ тэтгэлгийн мөнгийг өөр мэргэжлээр сурч байгаа оюутнуудад зарцуулсан бол нөгөө албан тушаалтан хэрэгт орно. Тэгэхээр тэр журамд өөрчлөлт оруулах юм уу? Эсвэл хуульд өөрчлөлт орж байж энэ журамд өөрчлөлт орох уу? Би бол тэгж ойлгож байна зөв үү?

ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг: Тийм.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Энэ дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан хариулах уу?

Анх хууль санаачилж байхад танай дээр салбар дээр боловсон хүчин дутагдаж байгаа болохоор малчдын хүүхдүүд нь очвол арай амьдралд ойрхон болохоор сурах боломж бололцоог нь дэмжчихвэл нэг талаасаа малчдаа дэмжих, нөгөө талаасаа боловсон хүчнийхээ асуудлуудыг хангах бодлого гарах юм гэж бид хуульд оруулсан. Энэ дээр нэг саналаа хэлээдэх үү.

УИХ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат сайд: Энэ хуулийг анх боловсруулахад хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжлээр хүүхдүүд сурахгүй байна. Таны хэлж байгаа малчны хүүхэд арай илүү суралцах болов уу гэж хуульд оруулсан. Түүний хүрээнд ч 50 хүүхэд сурч байна.

Хөдөө аж ахуйн салбарт боловсон хүчний дутагдалтай байгаа ч мал эмнэлгийн чиглэлээр оюутнууд сураад байгаа. Жилдээ 100 гаруй хүүхэд мал эмнэлгийн чиглэлээр сурч төгсөөд байна. Зоотехникч гээд мэргэжил нь нарийвчлаад ирэхээр хүүхдүүд сурахгүй байгаад байна. Тэгээд тэрийг нь оруулаад өгье гэхээр нэг журам болохгүй байна, хууль нь болохгүй байгаа гэдэг зүйл яриад байгаа юм.

Дорнод аймгийн Булган сум дээр өнгөрсөн 7 хоногт амралтын өдөр малчидтай уулзлаа. Тэгэхэд нэг малчин эмэгтэй асуудлыг сөхөж тавьсан. Малчны хүүхэд гэхээрээ яахлаараа заавал мал аж ахуйтай холбогдох ёстой юм гэж ярьж байна. Одоо манай хүүхэд дургүйцээд байгаа юм чинь энэ ялгаварлан гадуурхалт биш үү гэдэг зүйлийг яриад байна.

Эндээс юу гэж ойлгосон гэхээр бид хуулийнхаа агуулгыг хууль батлагдсан цагаас хойш зөв тайлбарлаагүй, ойлгуулаагүй, зүгээр л малчны хүүхдийг сургана гэсэн нэг ийм зүйл явсан болохоос биш, ингээд дутагдаж байгаа мэргэжлээр сурвал тэтгэлэг олгоно гэдэг мэдээллийг хүргээгүйгээс ойлголтын зөрөөнүүд гарсан байна гэж ойлгож байгаа.

Гэтэл Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга болон мэргэжилтэн хоёр нь 2 өөр юм яриад байна гэж сая Л.Мөнхбаясгалан гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Тэгэхээр энийг нэг мөр тодорхой болгохгүй бол болохгүй.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тийм, үүний учрыг нь олоорой. Хуульд заагаагүй зүйлийг журамд тусгаад, уг журмыг нь баталсан сайд мөнгөний асуудалд орно шүү. 2 дугаарт журмын дагуу төрийн сангаас мөнгө олгоод тэтгэлэг өгөөд явбал зориулалтын бус буюу хуульд заагаагүй тэтгэлэг өгсөн гэдгээрээ хэрэгт орно шүү. Тийм болохоор төрийн албан хаагчид сайн бодож байх ёстой.

Бодлогын асуудлуудыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргаж ирээд ямар мэргэжил тухайлбал, зоотехникч байдаг юм уу, ямар мэргэжлүүд бидэнд дутагдалтай байгаа юм. Энийг тооцож гаргаад, энэ мэргэжлээр сурах эрх зүйн орчныг бүрдүүлье гээд. Эсвэл шаардлагатай бол журамд зохицуулалтын заалтыг нь тусгах хэрэгтэй.

М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Боловсролын яам саяын журамтай холбогдолтой Ерөнхий хяналтын сонсголын дүгнэлтэд тодорхой санал оруулах нь зөв байх гэж бодож байна. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр явах юм уу, журмаар явах юм уу гэдгээ шийдэх ёстой асуудлын нэг нь энэ байна. Бусад мэргэжлээр буюу малын эмч, мал зүйчийн мэргэжлүүдийг оруулаад ирэх нь зөв гэсэн байр суурьтай байгаа гэдгээ илэрхийлье .

Г.Ариунбуян генерал дахиад тодруулах уу?

Тэгэхээр байгалийн онц ноцтой нөхцөл байдалд орсон малчдадаа бид улсын нөөцөөс тодорхой хэмжээний арга хэмжээ авна гэж байгаа. Гэтэл л журам нь 3 сард батлагдсан учраас өмнөх хугацаанд нь хамаарахгүй гэдэг ийм ойлголтод орж эхэлж байна л даа. Тэгвэл яагаад журмаа 3 сард баталж байгаа юм бэ? Яагаад 2 жилийн дараа баталж байгаа юм бэ? Нэгэнт хууль баталсан байхад журмаа батлаагүйгээс болоод иргэд хохирч болохгүй шүү дээ. Тэгээд энийг хагалуулмаар байна.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян: Гамшигт аюулт үзэгдлийн улмаас малчин үүргээ гүйцэтгэж байгаад амиа алдсантай холбоотой гаргасан журмыг Сангийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам боловсруулж батлуулсан. Энэ хуульд журам батлах харилцааг энэ хуулийн 4.8-д Засгийн газрын журмаар зохицуулна гэж заасан учраас журам батлагдсаны дараа хуулийн үйлчлэл нь явж байгаа. Тэгэхлээр 2026 оны 3 дугаар сараас өмнөх ямар нэгэн асуудалд орсон малчдад нөхөн олговор олгох боломжгүй болчихоод байгаа юм.

2 дугаарт, өвс тэжээлийн нөөцтэй холбоотой асуудалд аймаг орон нутаг Засгийн газрын тогтоолоор гаргасан аюулгүй нөөцийг бүрдүүлэх үүрэгтэй байдаг. Түүний дагуу тухайн шатны Засаг даргын нөөц хөрөнгөөс давсан тохиолдолд хүсэлтээ УОК-т ирүүлж түүний дагуу УОК материалыг хууль тогтоомжид нийцүүлж

хянаад Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлдэг ийм журамтай байгаа.

УИХ-ын дарга, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлье.

УИХ-ын гишүүн Ц.Туваан: 2 асуултаа цувруулаад асууя.

Юуны өмнө онцгойгийнхондоо баяр хүргэе гэж бодож байна. Гал усны, ган зудын гамшиг тулахад онцгойгийнхон тэр дундаа хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа эрэн хайх аврах бүлгийнхэн гээд хэдэн хүмүүс л зүтгэдэг. Тийм учраас энэ хүмүүст бид талархах ёстой.

Бид улсын төсөв батлахад жишээлбэл, сая Заамарын хүүхдийн асуудал ч тэр. Бүх юман дээр тулж ирээд харахаар нөгөө техник, тоног төхөөрөмж, төсөв мөнгөтэй холбоотой асуудлууд тулгардаг. УИХ-д төсөв батлахдаа энэ байдлуудыг нэлээн харж үзэж батлах ёстой гэж боддог.

Зудын нөхцөл байдал үүсэхээр Засгийн газрын шийдвэр гаргаад, УОК-ын нөөцүүдээс жоохон тэжээл, өвс хуваарилдаг. Яг газар дээрээ очихоор нэг малчинд нэг боодол өвс, нэг шуудай хивэг л хүрэхтэй үгүйтэй оногддог. Тэгэхээр асуудлыг бид углуургаар нь шийдмээр байгаа юм. Үүнийг нэг тодорхой асуудал буюу махны үнэтэй холбоотой асуудлыг шууд холбовол яасан юм бэ гэж боддог хүн. Махны үнэ ер нь маш олон юм шийднэ шүү.

Үүгээр залуу малчингүйдлийг шийднэ, ядуурлыг шийднэ, зудын асуудлыг шийднэ, цөлжилтийг хүртэл шийднэ гэж хэлбэл зарим хүн гайхах байх.

Яагаад ядуурлыг, яагаад залуу малчингүйдлийг шийдэж байгаа гэхлээр хэрвээ мал, мах үнэтэй болоод нэг эр хонь 500, 600 мянгаар борлогдоод, үхэр 3, 4 саяар борлогдоод ирвэл манай залуучууд дээр сонголт ирнэ. Хөдөө гараад бизнес хийж ашиг олох боломж байгаа юм байна гэдэг сонголттой болж ирнэ. Тэгэхээр хөдөөг чиглэх цуваа эхэлнэ. Ядуурал бол мэдээж орлоготой болоод ирэхээр асуудал шийдэгдэнэ.

Зудыг яаж шийдэх юм бэ? Өнгөрсөн өвөл Сэлэнгэ, Дархан, Төв аймгийн сумуудаар цагаан зудтай өвөлжсөн. Зарим малчин айл өрх малынхаа 70%-ийг төхөөрч борлуулсан. Махны үнэ өндөр байсан учраас малаа төхөөрч борлуулаад үлдсэн малдаа таарах хэмжээний тэжээл өвсөө нөөцлөөд өвлийг давчихсан.

Зүй ёсны 2%-аар тооцдог хорогдолд ч хүрээгүй. Хорогдлын хэмжээгээ нэг хувьд хүрээд зогсож байх жишээтэй. Тэгэхээр юу хэлж байна гэхлээр экспортод мах гарч байсан учраас малын махны үнэ дажгүй байсан учраа малаа төхөөрч борлуулж байгаа юм.

Цөлжилт дээр хүн гайхаж магадгүй. Яагаад гэхлээр малчид тэнэг биш. Бид өнөөдөр аливаа асуудлыг нэгхэн талаас нь бодож байхад энд сууж байгаа малчдын төлөөлөл Д.Гомбо-Очир гавьяат шиг хүмүүс 10-н талаас нь боддог юм. Малаа маллаад явж байхдаа нэг асуудлыг 10 талаас нь бодоод хамгийн мэргэн шийдвэрийг гаргадаг байхгүй юу. Тэгэхээр хүмүүс яах вэ гэхээр мах үнэтэй бол олон мал маллаж, махаа идэж, өөрсдийгөө зовоохыг бодохгүй байхгүй юу.

Хургаа 15-18 кг жинд хүргээд борлуулчих хэмжээний ухаан манай малчдад байгаа. Тэгэхээр цөөн малтай болж махны үнийн асуудлыг шийднэ гэж хэлээд байгаа юм.

Энэ дээр тодорхой 2 асуулт байна. Онцгойгоос гамшгийн үед малчдадаа нөгөө жи пи эстэй гар утсанд нь суулгах программ хангамжийн асуудал ямар нэгэн хямдхан тоноглолын асуудлыг та хэд судалж шийдсэн үү?

Төв аймгийн Эрдэнэсант, Лүн дээр болсон. Уржнангийн цаад жилийн гамшгаар хүмүүс ойрхон машинуудыг нь хараад байдаг. Энд байсан гээд мэдээд байдаг олж авч чадахгүй олон хүн нас барсан шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан: Хоёрдугаарт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдаас энэ махны үнэ дээр та ямар бодолтой байх вэ? Махны үнэ үнэтэй байх нь зөв үү хямд байх ёстой юу? Энэ дээр нэг салбарын сайдын хувьд хариултаа өгөөдхөөч. Одоо бас маш олон малчид харж байгаа. Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамныхнаас хөдөө малчидтай уулзаад явахаар нэг л юм ярьж байгаа нөгөө олон асуудлуудыг чинь хамгийн чухал нь юу гээч? Малчны НДШ-ийг нөхөн төлүүлэх гэдэг асуудал чинь яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ? Энэ сонгуулийн шоу байсан юм уу эс үгүй бол бид нарыг хошхируулаад өнгөрчихсэн юм уу? Энэ хууль чинь яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ гэж ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар хэмжээний зардал гарах гээд байгаа юм бэ? Нийгмийн даатгалын санд ямар асуудал үүсэх гээд байгаа гэдгийг нь нэг тодорхой тоо хэлээд өгөөч. Хэдий хэмжээний асуудал байгаа юм малчдын НДШ төлүүлчихвэл болох гээд байгаа гэдэг тоог нэг сонсодохъё ийм асуултуудад хариулт авъя.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Онцгой байдлын ерөнхий газар.

Онцгой байдлын Ерөнхий газрын орлогч дарга Ц.Ганзориг: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, онцгой байдлын байгууллагаас 2019, 2020 оноос эхлээд бид нар нөгөө 3 хэсэгт байршил тогтоох аппликэйшнийг улс орон даяар ашиглаж байгаа бүх иргэн ашиглаж байгаа энийг хэрхэн ашиглах гэдэг компани ажлыг бол тогтмол явуулж байгаа. Тэгэхээр одоо ер нь Монголын нийт иргэдийн 60-70 хувьд нь энэ аппликэйшн байгаа энэ ямар ч офлайн ажиллана дуудлагаа өгөөд зөвхөн 3 үсгийг л бид нарт хэлнэ.

Зүгээр асаагаад тийм гэдэг бол бид нар байрлалыг нь шууд тогтоочих онцгой байдлын бүх 21 аймгийн дуудлага хүлээн авагч дээр. Хоёрдугаарт нь бид нар АХБ-ны 30 сая долларын гамшгаас хамгаалах зарлан мэдээллийн системийн тогтолцоог боловсронгуй болгон төслийг энэ оноос эхлүүлээд хэрэгжүүлж эхэлж байгаа. Энэ хүрээнд 21 аймаг 330 сум дээр дуу дохиолол, мессеж систем, өргөн нэвтрүүлэг, үүрийн телефоны утсаар бүх мэдээллийг урьдчилан сэргийлэх ажлыг явуулдаг. Дээрээс нь 112 гээд нэгдсэн дуудлагын тогтолцоонд шилжүүлэх гэж байна. Энэ нь холбогдуулаад бүх иргэний дуудлагыг өгөхөд байршилтай нь гаргаж ирдэг энэ системийн тогтолцоо руу явж байгаа.

Засгийн газраас Цахим, инновац харилцаа холбооны яам, Онцгой байдлын ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр үүрэг өгөгдөөд нэгдсэн системийг боловсруулах ажлууд хийгдэж байгаа. Тэгэхээр энэ ажлууд хийгдэнэ. Мөн Эмерженси Сос гээд аппликэйшн системийг нийт Монголын аппликэйшнийг иргэдэд бол хэрэглээнд гаргах гэж байгаа. Энэ нь бас аюултай нөхцөл байдлын

мэдээллийг өгдөг бас байршлыг нь илрүүлдэг ийм платформыг ашиглаж байгаа. Тийм учраас бид бүхэн энэ асуудал дээр нэлээн идэвхтэй ажиллаж байгаа гэдгийг хэлье. М.Ганхүлэг гишүүний асуултад бас нэмж хариулахад энэ журмаараа аймгийн Засаг дарга энэ нөхөн олговрыг олгох үүрэгтэй. Засаг даргын нөөц хөрөнгө нь хүрэлцэхгүй болсон тохиолдолд УОК-т хандаж Засгийн газраар шийдвэрлүүлэхээр журмын зохицуулалттай гэдгийг би бас нэмж хэлье ээ.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ХХААХҮЯ 11 За.

ХХААХҮЯ-ны сайд Ц.Идэрбат: Махны үнийн асуудал байна. Сая таны хэлж байгаа яг экспортыг хэрвээ бид нар ингээд гэнэт зогсоовол яг нөгөө цаг хүндрээд өвөл хүндрэх нь тодорхой үед махаа борлуулж чадахгүй болчиход тэр эрсдэлүүд байдаг учраас экспортыг ингэж гэнэт зогсоож тийм арга хэмжээ авахгүй ээ гэсэн үг. Махны үнийн асуудал гэдэг бол жилийн 12 сарын л асуудал байгаа юм. Үнийн асуудал энэ хавар ингээд харагдаж байна шүү дээ. Ялангуяа төв суурин газрын үнийн асуудал байгаа юм. Тэгэхээр аймаг, орон нутгийн төв бол аймгийн Засаг дарга нь төвийнхийг бол НЗД нь тэр арга хэмжээгээ аваад сая хэлж байгаа намар ингээд мах бэлтгэлийн үйл ажиллагаа явагдахад энэ төв суурин газрынхан ч бас ингээд л цуг яваад л бэлтгэдэг ийм юм руугаа л явах нь зүйтэй болов уу.

Тэрнээс одоо хавар махны үнэ өслөө гэж бид нар ярьж бол болохгүй. Таны хэлж байгаа тэр үгэн дээр бас нэг зөв юм гарч гарч ирж байгаа нь мах ингээд нэг жоохон өсөөд ирэхэд сая яг орон нутгаар яваад малчидтай уулзаад ирэхэд ер нь бас ч гэж энэ махны үнэ аятайхан болоод байгаа дээр өр ширээ дарлаа олон залуучууд бас эргээд нэг хөдөө рүүгээ гаръя гэдэг ийм зүйлүүд яригдаж байна гэж байгаа юм. Тэгэхээр ХХААХҮЯ-ны хувьд бол энэ ганц мах гэхгүйгээр малаас гарч байгаа түүхий эдийг бүгдийг нь үнэтэй болгох хаядаггүй болох ажлыг л эхний ээлжид туршилтын маягаар 5 аймагт эхлүүлээд явж байна. Энэ амжилттай бол бусад бүх аймгууд дээрээ хийчихвэл бололцоо байна гэж ингэж бас харж байгаа.

Дараагийнх нь энэ малчидтай холбоотой. Энэ зудын асуудал дээр зудын бэлтгэл бэлэн байдал руу бид одоо бас анхаарлаа хандуулж байгаа. Нутагтаа эзэн 100 мянга гэдэг энэ хөтөлбөр бол өөрсдөө ногоон тэжээлээ тариад зуд бол малаа аваад гараг, өнтэй сайхан өвөл болох юм бол малаа тэжээгээд заавал одоо намар малаа заазалдаг биш өгдөг биш бүрхэг цаг үед мал нь тарга тэвээрэгтэй ийм байх л бололцоог бүрдүүлж ажиллая.

Ингээд ирэх юм бол дагаад цөлжилтийн асуудал дагаад энэ арьс ширний чанарын асуудал гээд олон асуудлууд шийдэгдэх юм байна. Малчдын өмнө тулгамдсан олон асуудлуудыг шийдэх гарц бол энэ байна аа гэж. Ингэж үзээд 17 аймгийн 25 баг дээр туршиж байна. Энэ ингээд 10 сараас үр дүн нь гараад туршилт амжилттай боллоо гэж ингэж үзвэл бид 2027 оны хавраас өшөө энийгээ тэлж малчид зудад малаа алддаг биш зудын бэлтгэл дээрээс нь малынхаа чанар луу анхаарах бололцоог нь газар олголтоор нь авхуулаад ингээд дэмжээд явъя. Өчигдөр энэ сонсгол дээр бол малчдад газар өгдөггүй мөнгөтэй компаниуд ганц комбайнгүй байж л өчнөөн газрыг нь авчихдаг гэж байгаа. Тэгэхээр манай явуулж байгаа энэ 100 мянга хөтөлбөр нутагтаа эзэн хөтөлбөр малчдад нийлээд хоршоод энэ газар дээрээ ногоон тэжээлээ тариад ирээдүйд үүсэх эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах бүрэн бололцоог нь олгож байгаа гэдгээрээ бас онцлогтой гэж ингэж бас би хэлье.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нийгмийн даатгалынхан 15 за.

Гэр бүл ХНХХ-ын яамны ТНБД А.Даваажаргал: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя аа. Гэр бүл ХНХХ-ын яамны ТНБД А.Даваажаргал байна. Малчны тухай хуулийн 4.2-ын есөд өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчин нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газар батлахаар хуульчилсан. Энэ журмыг боловсруулж Гэр бүл, ХНХ-ын яам нийтдээ 3 удаа Засгийн газар, яамдуудаас санал авсан. Харамсалтай нь Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам болон бусад ХЗДХЯ зэрэг яамдуудаас бол энэ журмыг дэмжээгүй. Мөн Улсын Их Хурлаас 2025, 2026 оны төсвийг баталж өгөхдөө энэ нөхөн төлүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсөв дээр сууд суулгаж өгөөгүй.

Тэгээд энэнтэй холбоотойгоор энэ журам бол батлагдаж гараагүй байгаа. Хоёрдугаарт нь бол таны асуусан журам батлагдсантай холбоотой. Хэрвээ энэ хууль хэрэгжсэн бол 5 жилийн хугацаанд нийтдээ 375.5 тэрбум төгрөгийн зардал улсын төсөв дээр хэрвээ журам батлагдаад нөхөн төлөвлөлттэй холбоотой асуудал үүссэн бол 375.5 тэрбум төгрөгийн зарцуулалтын тооцооллыг бол манай яамны зүгээс гарсан энэ нөхөн төлөвлөлтөд 38,2 мянган малчин хамрагдах. Боломжтой байсан гэж ингэж үзэж байгаа. Одоо харамсалтай нь хуулийнх нь хэрэгжилтийн хугацаа 2026 оны 1 сарын 1-нээр дуусгавар болчихсон. Хэдийгээр бид нар нөхөн журам гаргалаа ч хууль хэрэгжилтийн хугацаа нь дуусчихсан учраас энэ журам бол хэрэгжих боломжгүй болчихсон байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан: Энэ 2 өдрийн сонсголын юуг Монголчууд юу мэдэж авав аа гэвэл малчны мал нь үнэгүй, хөрөнгө нь үнэгүй, малаас гардаг түүхий эд нь үнэгүй, ашиг шим нь үнэгүй, малчин хүний ирээдүй нь баталгаагүй, үр хүүхдийнх нь ирээдүй баталгаагүй, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чаддаггүй. Арай хийж нэг малчны тухай хуультай болсон чинь 20% нь огт хэрэгждэггүй 33% нь сул хэрэгжилттэй нийтдээ 53% нь хэрэгждэггүй. Малчин хүн хотод ипотекийн байр авах эрх нь хаагдмал. Малчин хүн хамгийн өндөр хүүтэй зээл авдаг тэгсэн хэрнээ тэрийгээ малчид маш үнэнчээр төлдөг. Тэгэхэд Монгол банк нь орж ирээд хамгийн эрсдэлтэй зээлийн ангилалд шууд оруулдаг өвөлжөө хаваржаагаа эзэмшиж байтал лицензийн талбайд ороод хөөгддөг бага балчир хүүхдүүд нь сургуульд орохоор гэр бүл нь салахаар болдог.

Иймэрхүү малчны маань ирээдүй байхгүй эцэстээ малчид малаа маллаад өсөж төрсөн нутагтаа амьдрах эрхгүй хөөгддөг, нүүлгэн шилжүүлэлтэд өртдөг, энийг нь сонсдоггүй, энийг нь ярихаар одоо ад үздэг энэ төр ийм болжээ тэгээд ийм байхад өнөөдөр бид нар энд энэ юуг хийж байгаа юм? Сонсголыг хийж байгаа юм тэгээд бид нар энд юу ч шийдэж өгч чадахгүй байгаа нь маш их харамсалтай байна л даа. Тэгсэн хэрнээ Монгол Улсын дангааршил Монгол Улсын өв соёл, Монгол Улсын хэл, Монгол Улсын тусгаар тогтнол энэ бүх энэ малчдын нуруун дээр байдаг гэж байгаа юм. Малын мах нь арайхийж үнэтэй болсон чинь одоо малчид нь гэмт хэрэгтэн болох гэж байна. Махны үнэ нэмсэн гээд ийм нөхцөл байдалд байгаа юм аа. Тэгээд би ХХААХҮ-н сайдаас ийм асуулт асуух гэсэн юм. Малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгоё оо, аль болох малчдыг орлоготой болгоё оо, гээд Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг харсан байхгүй юу. Арьс ширний үйлдвэрийн салбарт 35 тэрбум төгрөгийн зээл олгосон байна л даа. Гэтэл 1,2 сая ширхэг, 2 сая бог, 488,5 ширхэг бодын шир бэлтгэх нөхцөл бүрдсэн гэж байгаа юм. Гэтэл арьс ширний үйлдвэрлэл нийт дүнгээрээ 2023 онд 12,7 сая байсан бол, 24 онд 16,4 сая болоод буурчхаж байгаа байхгүй юу. Үгүй ээ яагаад вэ? Хөрөнгө мөнгө хийгээд байхад сүүний урамшуулал чинь мөн адилхан эсрэг 12,1 тэрбум төгрөг олгочихсон байгаа байхгүй юу. Тэгсэн чинь үнээний сүүний үйлдвэрлэл нь буурчихсан байгаа байхгүй юу. Үгүй ээ яагаад вэ? Эсвэл энэ мөнгө эзэндээ очихгүй

байгаа юм уу. Тодруулъя.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ХХААХҮЯ 11 за.

ХХААХҮЯ-ны сайд Ц.Идэрбат: Малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгох хамгийн эхний алхам бол арьс ширээс эхэлнэ ээ. Арьс, ширэн дээр ажлууд явагдаад байна вэ гэхээр арьс, ширний урамшуулал гэж зүйл явагдаж байгаа. Дээрээс нь арьс, ширний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийг эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлүүд олгож байгаа. Үүнийхээ хүрээнд Монгол Улсад одоогоор том жижиг нийлсэн 20 гаруй ААН байна. Энэ жил одоо бид нар 4 сарын хорьдоор энэ сайд болоод энэ холбоодуудтай уулзсан. Арьс ширний салбар бол бас үйл ажиллагаагаа сэргээчих бүрэн дүүрэн бололцоо бол байна аа гэж.

Ингэж хараад 2 сарын хугацаанд бас нэлээдгүй олон зүйлийг боловсруулж байгаад нэр бүхий 5 аймаг дээр үхэр, хонины арьс хаягдаад байгааг нь одоо 10 мянга 3 мянгаас эхлүүлээд ингээд явуулъя гэдэг зүйл рүүгээ ороод эхлүүлээд туршаад үзэж байгаа. Энэ жил дахиад тэд нарын зүгээс ямар хүсэлт тавьж байна вэ гэвэл арьс шир авдаг энэ үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн зээл хэрэгтэй байна аа гээд бид 35 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр шийдэж өгсөн. Тэгэхээр энэ дээр нэг ийм зөрөө гараад байгаа юм. Шууд арьс ширнийхэнд 35 тэрбум төгрөг өгчихсөн юм бол байхгүй. Энэ хүүгийн татаасанд 3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бид гаргаж өгөөд арилжааны банкнууд бусад эрсдэлээ үүрээд. Одоо арьс ширний компаниудад 35 тэрбум төгрөгийн одоо зээлийг олгож байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө банкны хөрөнгөөр арьс ширээ худалдаж авах дээр төр ингээд нэг үзүүлэлтүүд юу? Тодорхой хэмжээнд 10 хувийнх нь хүүгийн хөнгөлөлт юмнуудыг өгөөд ингээд явж байгаа гэдэг.

Цаашдаа бол ер нь 2027 оны төсөв хөтөлбөр дээр мөнгө тавихгүй байх ийм зүйл яригдаж байгаа. Гэхдээ бидний хувьд энэ ХАА-н салбар дээр хэрэгжиж байгаа олон улсын зээл тусламжийг ялангуяа энэ олон улсын зээлийг ХАА-н салбар арьс шир, ноос ноолуур, хүнсний хувьсгал руугаа чиглүүлнэ. Заавал 2027 оны улсын төсвийг харахгүйгээр шийдэх бололцоо бүрэн дүүрэн байна. Ингэж хараад ингээд явчих сүүний урамшууллын хувьд энэ хэрэгжиж эхлээд бас жоохон амжилттай явж байгаа ийм төсөл ингэж үзэж байгаа юм байна. Гэхдээ энэ дээр бас нэг сүүний урамшуулал дээр энэ чинь 10 сараас 3 сар хүртэл байгаа.

Яг орон нутагт ингээд ажиллаад ирэхээр сүү үйлдвэрлэгчдийн хувьд 10 сараа 9 сар болгочооч ээ 3 сараа 4 сар 5 сар болгоод өгөөч ээ гэдэг ийм хүсэлтүүдийг тавиад бид 2027 оны төсөв дээр бол 5 орчим тэрбум төгрөгийн сүүний хөнгөлөлтүүд үзүүлэхэд шаардлагатай байгаа санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэе ээ гэсэн ийм саналууд өгөөд явж байгаа гэдгийг хэлье минут дуусаж байгаа учраас дахиад тодруулъя.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Л.Мөнхбаясгалан гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан: Арьс, ширний үйлдвэрийн салбарт байна шүү дээ. Эргэлтийн хөрөнгө 23,7 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байгаа байхгүй юу 22,7 сая ширхгийг арьс шир боловсруулдаг байсан бол 2024 онд 16,4 сая ширхэг болоод буурчихсан байгаа. Сүү чинь бас адилхан 12,1 тэрбумыг олгочихсон байхад дахиад үйлдвэрлэл нь буураад байгаа байхгүй юу.

Эдийн засгийн хөгжлийн сайд Ж.Энхбаяр ХХААХҮ-н сайд байхдаа 2026 оны нэг сар гэхэд Эмээлтэд нөгөө арьс ширний үйлдвэр ашиглалтад орно гэж Байнгын хорооны хурал дээр хэлж байсан. Одоо тэр үйлдвэр юу болсон. Дарханд арьс ширний үйлдвэр барьж байхад барьсан эзнийг нь барьж аваад шоронд хийгээд татан буулгаж байсан. Төр өөрөө барина гээд хувийн хөрөнгөөр барих гэж байсан чинь тэгээд тэр үйлдвэр яг хэзээ ашиглалтад орох гэж байгаа юм тэгээд энэ ингээд мөнгө оруулаад байхад сайд аа би гайхаад байгаа байхгүй юу. Үйлдвэрлэл нь буураад байгаа болохоор наад мөнгө чинь байгаа онохгүй байгаад байгаа юм биш үү?

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ХХААХҮЯ 11.

ХХААХҮЯ-ны сайд Ц.Идэрбат: Арьс ширний үйлдвэрийн асуудал дээр Эмээлтэд би бас очиж танилцсан төсөл энийг цааш нь үргэлжлүүлээд явуулахад хуулийн хүсэл байгаа. Арьс ширний 23 ААН бол Эмээлтээ явуулчихвал бид одоо очиход бэлэн байна аа гэдэг зүйлээ ярьж байгаа. Үүнийг явуулахад шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрүүдийг бид нар 2027 оны улсын төсвийн төсөлд өгчихсөн байгаа.

Дээрээс нь энэ арьс ширний үйлдвэрүүдэд шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрүүдийг нь бид нар энэ олон улсын хөнгөлөлт тэй зээлүүдээс хамруулъя гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Тэгэхээр Арьс ширний үндэсний холбоо болон арьс ширний холбоодуудтай бид заавал тэр үйлдвэрийг хүлээхгүйгээр эхнээс нь авч эхэлье ээ гэдэг ийм зүйл. Яагаад? Тэгэхээр энэ арьс ширнийхэн дээр нэг зовлон байгаад байдаг юм байна. Авъя гэхээр шаардлага хангах арьс ховор болчихоод байна хонины арьс нь гэхэд ийм байна үхрийн арьс нь ийм байна гээд би одоо 3 өдөр ярьж байгаад л ирсэн ийм зүйл байгаа. Дарханы үйлдвэрийг бол би ашиглалтад орохгүй болсон гэдгийг энэ танхимд бараг анх удаа хэлсэн байх аа.

Учир шалтгааны хувьд бол олон л хүчин зүйл байгаа байх. Гэхдээ энэ чинь Хөгжлийн банкнаас бас нэг зээл хүү авсан тэр нь одоо зориулалтын мөн бус эд нар гээд тийм юу асуудалтай л юм билээ. Тэгэхдээ би тэрийг нь бол сөхөж үзээгүй ер нь бол бодит байдал нь явахгүй болчихсон юм байна. Монгол улсад энэ арьс ширний үйлдвэрлэлтэй холбоотой асуудал яривал Ховд дээр нэг аж үйлдвэрийн парк байна. Өвөрхангай дээр байгаа тэр арьс ирээдүй, ноос ирээдүй гэдэг тэр 2 дээр шаардлагатай байгаа тэр цэвэрлэх байгууламжийн асуудлыг нь шийдчихвэл төвийн бүс шийдэгдэх юм байна хангайн бүс хотод бол нийслэлийн Эмээлтийг явуулчихвал нэлээн асуудлууд бас шийдэгдээд явчих юм байна гэсэн ерөнхий ийм л одоо дүр зурагтай байгаа. Тэгэхээр арьсны үйлдвэрүүд Дархан дээр бас жилатины үйлдвэр барьчихсан, Дархан Нэхий компани, Дархан Минж компани нь бол одоо жилатины үйлдвэр. Дээрээс нь Хөвсгөл дээр Архангай дээр хонины арьсуудаа авч эхэлье гээд. Ингээд яам болон үйлдвэр малчидтайгаа хамтраад л шийдэхийн төлөө ажиллаж байгаа дахин тодруулъя.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан: 2023 оноос хойш татаас өгч байгаа энэ хөтөлбөрүүдийг уншаад өгчихье гэж бодлоо. Хүнсний хангамж аюулгүй байдал ЗГ-ын 23 оны 63 дугаар тогтоол 47,6 тэрбум, Шинэ хоршоо чинээлэг малчин ЗГ-ын 24 оны 166 дугаар тогтоол 75,9 тэрбум, Цагаан алт ЗГ-ын 24 оны 63 дугаар тогтоол 86,9 тэрбум, Атар 4 25 оны 47 дугаар тогтоол 60,3 тэрбум, малчин фермерүүдийг дэмжихэд чиглэсэн урамшуулал, УИХ-аас баталсан 6 тэрбум энэ ноосон дээр арьс ширэн дээр 5,4, Сүүний урамшуулал 12,1, бусад арга хэмжээ 0,5 тэрбум, гоц халдварт өвчин дээр 55 тэрбум, малчинд үзүүлсэн эрүүл мэндийн

тусламж гэдэг дээр 2024 онд 36 тэрбум, 2025 онд 26,9 тэрбум.

ХХААХҮЯ-ны сайд Ц.Идэрбат: Таны хэлж байгаа саяын төслүүд бол зөв өө. Энэ төслүүд хэрэгжээд ийм мөнгөн дүнтэй дэмжлэг юмнууд үзүүлсэн нь зөв. Үүний хүрээнд одоо ганцхан манайх түүхий эд бэлтгэдэг тэрийг гаргадаг улс байгаа. Тэдэн үйлдвэрүүд нь эргэлтийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэггүй байсан энэ үйлдвэрүүд жоохон амь ороод одоо ингээд явж байгаа юм.

Жишээ нь одоо л ирэх хүчин чадал одоо 400 тонноор нэмэгдээд сүлжих хүчин чадал нь өшөө нэмэгдээд. Тэгэхээр энэ болгон чинь түүхий эд бэлтгэхэд биш түүхий эдийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгоход зориулагдсан ийм зээлүүд бас гарсан. Энэ бол гадагшаа гараагүй Монголын үйлдвэр эрхлэгч нарт очсон үйлдвэр эрхлэгч нар бол маш сэтгэл хангалуун байдаг энэ талаарх танилцуулгыг одоо хүргүүлэх нь зүйтэй болов уу гэж ингэж бас бодож байна бидний хувьд хүнс дээр бол 53 үйлдвэр чинь шинээр ашиглалтад орсон мянга гаруй нэр төрлийн.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн гишүүн Оюунсайханы Алтангэрэл гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл: Энэ гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас амь насаа алдсан малчинд өгөх тэтгэмжтэй холбоотой журмыг энэ оны 3 дугаар сарын 15-ны өдөр ЗГ баталсан байгаа юм. Хууль 2024 оны 6 дугаар сард батлагдсан гамшигт амь насаа алдчихсан малчинтай холбоотой журмыг дөнгөж энэ оны 3 дугаар сарын 15-нд баталж байгаа байхгүй юу. Монгол Улсын төр Монгол Улсын Засгийн газар малчиндаа малчны бодлогоор яаж хандаж байгаагийн. Ганц жишээ. Нүүр царай нь л энэ. Тэгээд одоо яах юм 2024 оны 6 дугаар сараас 2026 оны 3 дугаар сарын 15 хүртэл нас барчихсан гамшигт үзэгдлийн улмаас ажил үүргээ гүйцэтгэж яваад нас барчихсан малчид тэтгэмж авахгүй нь л дээ. Одоо үндсэндээ тэгж л ойлгогдож байгаа.

Энэ хариуцсан байгууллага бол одоо өөр яах вэ журам батлагдсан учраас ингэнэ. Гол нь энэ эс үйлдэл хаана байна гэвэл Монгол Улсын ЗГ-т байна өнөөдөр ингээд өглөөнөөс хойш хүлээж байна. Жишээлбэл яг тэр нийгмийн даатгалтай холбоотой асуудал дээр Т.Аубакир сайд бас нэг хариулт хэлчих болов уу гээд хүлээгээд сууж байна. Одоо хэзээ ирэх юм байгаа юм хариултыг нь авмаар байна аа. Ер нь одоо сая манай энэ Ц.Идэрбат сайд бол ажлаа аваад удаагүй хүн. Таныг бол одоо энэ малчдын төлөө хэлсэн ярьснаасаа ухарсан буцсан гэж ерөөсөө бодохгүй байна.

Энэ танхимынхаа асуудал дээр наад бусад сайд нараа наад танхимаа жоохон шахаж ажиллаарай одоо ер нь Монгол Улсын ЗГ энэ Монгол төрийн хуулийг хэрэгжүүлээгүйдээ нэг. Уучлал гуйчихгүй юм уу? Малчдынхаа өмнө чадсангүй ээ бид нар удаан ажиллалаа чадахгүй байна аа манай зарим сайд нар шалтаг шалтгаан тоочоод ажил хийхгүй байна гээд нэг уучлал гуйчхаач. Энд ингээд нэг болсон болоогүй тоо баримт худлаа үнэн юм яриад ингээд цаг аргалаад суугаад байгаа байхгүй юу. Эс үйлдэл гэж нэг том юм байна шүү цаана чинь. Одоо тэр саяын тэр нэр дурдагдсан гамшигт ослын үед ажил үүргээ гүйцэтгэж яваад нас барсан малчдын ар гэр байвал би орон дээр уриалах гэж байгаа нэхэмжлэл гаргах хэрэгтэй.

Эс үйлдлийнх нь төлөө нэхэмжлэл гаргаж шийдүүлэх ёстой нийгмийн

даатгалтай холбоотой асуудал дээр манай малчид эрх ашгаа хамгаалж шүүхэд бас хандах хэрэгтэй. Тэгээд худалч хажуугаар нь энэ оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлээд амлаад эхэлсэн шүү дээ. Өө удахгүй журам нь батлагдана. Ярьж байгаа Сангийн яамнаас хүлээж байгаа, тэндээс хүлээж байгаа, одоо болно гээд. Ингээд олон нийтэд байнга тийм мэдээлэл өгсөн. Хариуцсан ажил хариуцсан сайд нар нь тэр Т.Аубакир сайд яг ингэж олон нийтэд мэдээлэл өгсөн УИХ-ын гишүүд орон нутгаар явахдаа яг энэ асуудлыг нь яриад явсан.

Удахгүй батлагдах юм байна лээ. Манайхан малчид аа засаг ингэсэн гээд ингэж ярьж явсан гишүүн болгон худалч болсон хүний өмнөөс худалч болсон. Монгол төрийн хууль биелдэг байх ёстой заавал биелдэг байх ёстой биелэхгүй байгаа бол бид нар гүйцэтгэх засаглалаасаа хариуцлага шаарддаг хариуцлага тооцож чаддаг байх ёстой энэ сонсголд оролцож байгаа гишүүдэд ер нь нийт УИХ-ын гишүүддээ өнөөдөр яригдаж байгаа энэ хуулийн хэрэгжилтээр одоо манай Ж.Бат-Эрдэнэ дарга тэргүүтэй сонсголынхон маань Засгийн газарт чиглэл өгөх байх.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Энэ удаагийн ерөнхий сонсгол маань бол анх удаа хуулийн хэрэгжилт дээр хийж байгаа ерөнхий сонсгол тийм ээ тэгэхээр маш их зүйлийн хаалгыг нээх ёстой гэж ойлгож байгаа. Хаана хариуцлага байна хаана хариуцлага алдаж байна гэдэг дээр бол хариуцлага тооцдог байх том алхам юм аа л гэж харж байгаа шүү. За үг хэлчихлээ Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан: Сонсгол маань 2 дахь өдрөө болж байна. Өчигдөр бол бид нар ингээд л баахан л тайлан бүр хийж байгаа ажил ч биш хийх гэж байгаа ажил гэж ярьсан бүр хийсэн ажил ерөөсөө байхгүй. Тэгээд та бол одоо хаалт дээр бол маргааш сайд нар ороод ирнэ ээ л гэсэн. Нөгөө сайд нар чинь хаана байна? Ингээд Улсын Их Хурлын дэргэдэх Монгол банкны нөгөө ерөнхийлөгч маань хаа байна тэ? дуудаад ирдэггүй ер нь одоо хэнийг доромжилж байгаа юм? Малчдыг доромжилж байгаа юм уу монголын ард түмнийг доромжилж байгаа юм уу? Үнэхээр Монгол улсын эдийн засаг энэ юмнуудыг ингээд харахаар бол энэ малчин энэ малаас гарч байгаа түүхий эд Монгол Улсын эдийн засгийг аваад яваад байдаг.

Энэ жилийн одоо эдийн засгийн өсөлт гэдэг 33%-ийн өсөлтийг нь бол МАА-н салбар эзэлж байна шүү дээ. Тэгээд мах үнэтэй болохоор ингээд л Монголын ард түмэн сандраад л унадаг. Тэгээд өчигдрийн сонсгол дээр бол ийм яриа боллоо шүү дээ. Яагаад энэ малын өвчнүүд гарсан бэ яагаад хавтгайрчхав аа гээд. Монголд малын өвчин гарахаар гадагшаа мах гарахгүй болж байгаа юм. Гадагшаа мах гарахгүй болохоор махны үнэ унаж байгаа юм. Махны үнэ унахаар малчны амьдрал доройтож байгаа юм. Тэгээд одоо юу хэлж байгаа юм юу болж байгаа юм тэ яг энэнээс хамгаалах 55 тэрбум төгрөг нь гараад явчихсан байна гүйцэтгэлээрээ гарчихсан байна.

Гэтэл яагаад энэ өвчин буурахгүй байгаа юм яагаад ажлаа хийхгүй байгаа юм яагаад энэ эрүүл мэндийн салбар нь одоо тусламж үйлчилгээгээ малчдадаа хүргэж өгөхгүй байгаа юм. Яагаад квоттой болчхов, тоотой болчхов яагаад энэ сургалтаа энэ малчид руугаа хүргэж хийж чадахгүй байгаа юм? Ер нь малчдыг одоо доромжилж байгаа юм биш үү? Тийм учраас энэ сонсгол бол үндсэндээ би бол цаашаа явах боломжгүй боллоо гэж хэлмээр байна. Энэ сайд нараа дууд энэ Монгол банкныхаа ерөнхийлөгчийг дууд тэгж байж хэдүүлээ асуудлаа ярья.

Тэрнээс ингэж 1 нь асуусан болж нэг нь хариулсан болж одоо 2 өдөр суулаа. Тэгээд ийм сонсголыг хурал даргалагч бол зохион байгуулах шаардлагагүй ээ.

Та тийм учраас энэ хүмүүсээ дуудаж энэ сонсголоо үргэлжлүүлье. Монгол банкныхаа Ерөнхийлөгчийг дуудаач ээ, энэ сайдуудаа дуудаач ээ энэ хэдэн малчдынхаа асуудлыг шийдээч энэ хуулиа биелүүлээч худлаа ярьж явсаар байтал энэ бид нар чинь хүртэл энэ нүүргүй боллоо. Нээрээ яг үнэндээ тэгээд энэ дээр арга хэмжээ аваач хурал даргалагч хэнийг доромжлоод байгаа юм энэ нээрээ арай хэтэрч байна шүү дээ. Та ч гэсэн хэлсэн үгэндээ хүр л дээ энэ хүмүүсээ дуудаж оролцуул л даа энэ сайд нараа дууд л даа тэгээд ингээд л цааш нь явуулаад л байдаг энэ чинь болохгүй шүү дээ энэ чинь. Бид нар ч гэсэн бас ярих юм бол байна шүү дээ. Тэр сайд нараас чинь амлалт авмаар байна шүү дээ. Энэ хурлыг үр дүнтэй болгомоор байна шүү.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Малчны тухай хууль гээд малчдынхаа төлөө 1 хууль санаачлаад одоо энд байгаа Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар энэ парламентууд бол бид 3 л байна л даа. Ц.Туваан гишүүн уучлаарай тэгээд энийгээ хэрэгжилт нь хэр байна гээд хяналт тавья гээд сонсгол зохион байгуулаад явж байгаа. Одоо сүүлдээ би ч өөрөө буруу болчхов уу яах вэ? За тэгвэл сайд нарыг иртэл хурал хаалаа.

Сайдаа уг нь хүндлээд ирсэн сайд чинь хариулт өгөөд сууж байна. Т.Аубакирын асуудал яригдаагүй байгаа шүү дээ. Та нар энэ хуралд хоцорч ирчхээд ямар асуудал хэлэлцэж байна гэдгээ мэдэхгүй ингэж одоо попорч байж бас болохгүй шүү дээ. Өглөөнөөс хойш Ц.Идэрбат гишүүн хүрч ирээд өөрсдийнхөө танилцуулгыг хийгээд, илтгэлээ тавиад хариулаад, өнөөдөржингөө сууж үдээс хойшоос эхлээд сууж байгаа шүү дээ. Т.Аубакирын асуудал үдээс хойш энэний ар дээр байгаа. Наад хуралдаа идэвхтэй оролц л доо. Ямар асуудал ярьж байгаагаа бас ойлго л доо. Тэгээд орж ирээд хурал даргалж байгаа гээд над руу дайраад байх юм. Хурлыг цааш нь үргэлжлүүлье. Энэ чинь юу гэсэн үг юм бэ энэ чинь Далай Батбаяр гишүүн эхлээд л энэ хүнээсээ хариултаа аваад дуусчихъя. Хэдүүлээ малчдаа доромжлоод байна гэсэн асуудал юу юм? Харин ч малчдаа хүндлээд малчдынхаа төлөө бүгдээрээ сууж байгаа шүү дээ. Далайн Батбаяр гишүүн сая гараад явчих шиг боллоо. Хүрээд ирэхээр нь тэгээд дахиад үг өгөх боломжийг нь хангая. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн за.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал: Гишүүдийн тавиад байгаа нэг шаардлага нь бол зайлшгүй л дээ. Яагаад гэвэл хөдөө орон нутгаар очоод ажиллахаар хамгийн түрүүнд яг малчдаас энэ малчны тухай хуулийг асуудаг та нарыг энэ сүрхий хууль баталчхаад тэгээд хэрэгжиж байгаа юм байхгүй байна аа л гэж асуудаг. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ ганцхан Улсын Их хурлын гишүүд гэлтгүй ЗГ-ын гишүүд ч гэсэндээ бас энэ дээр нүүртэй байхын тулд нэг хаа хаанаа бодох байлгүй дээ гэж бодож байна. Тавьсан 2 илтгэлтэй холбоотой асуулт асууя. Энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зуд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой энэ дээр авч байгаа арга хэмжээнүүдийн үр дүнд гарч байгаа үр дүнгүүдээ танилцуулга мэдээлэл гэж байна уу? Нэг, Хоёрдугаарт тухайлбал одоо зудны гамшигтай холбоотой зудын хор уршигтай холбоотой арга хэмжээ авчээ. За зудад малаа алдсан Сүхбаатар аймгийн ч гэдэг юм уу маш олон малчид төв суурин газар бараадсан аймаг, сум руу орсон ч гэдэг юм уу эдгээр иргэд ер нь одоо хаана явна вэ тэдний амьжиргаа ер нь ямар түвшиндээ явж байна вэ гэдгийг үргэлжлүүлээд судалдаг уу? Үргэлжлүүлж судалдаг тийм судалгаа ер нь манай төр дээр аль яам нь хаанах нь хариуцаад судалдаг юм.

Яг энэ гамшигт өртсөн малчдын нөхцөл байдал эргээд яаж сэргэдэг, ямар хугацаа ордог, ямар тусламж дэмжлэг шаардлагатай байдаг гээд. Ингээд нэг наад зах нь бид нарын хамгийн түгээмэл мэддэг яг зудтай холбоотой үүсэж байгаа энэ арга хэмжээн дээр бүтэн яг циклээр нь судалсан судалгаа байдаг болов уу. Нэг өрх одоо юу гэдэг юм. Айл 500 малтай, өрх айл мянган малтай өрх айл зудад нэрвэгдээд малынхаа 80%-ийг алдлаа гэхэд эргэж 2-оос 3 жилийн дараа ингэдэг ийм тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай байдаг. Төрөөс ийм тусламж дэмжлэгийг нь үзүүлж чаддаг энийг нь үзүүлж чаддаггүй тэгэх юм бол энэ өрх айл хэрвээ үзүүлж чадах юм бол өрх айл 2-оос 3 жилийн дараа эргээд хэвийн амьдралын горим нь эхлээд эргээд, үргэлжлээд явах боломжтой ч гэдэг юм уу яг ийм төрлийн судалгаанууд байна уу гэдгийг онцгой байдлынхан, бас одоо хүнс ХХААХҮЯ 2 л одоо хариулах байх даа ийм судалгаа байна уу гэж асуух гээд байгаа юм.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За ХХААХҮЯ 11.

Ц.Идэрбат сайд: Зудтай холбоотой асуудал дээр. Одоо тэгээд л яг үнэндээ за зуд боллоо. Нийгмийн нөгөө хамгааллын чиглэлээр малжуулах хөтөлбөр гэж нэг юм яригдана. Миг даатгал гэж нэг юм яригдана. Өөр гадна дотнын төсөл хөтөлбөрүүд бас энэ рүү нэг жоохон анхаарлаа хандуулна. Бусдаар бол ер нь бараг байхгүй. Ер нь бол тийм учраас энэ зудын гамшиг гэдэг энэ зүйл өөрөө Монголын эдийн засагт тэр Монгол Улсын энэ МАА-д ч тэр ямар айхтар нөлөө үзүүлдэг вэ гэдгийг 2023 оны зуд бол харуулж байгаа л даа. Ер нь манай яаман дээр бол хийсэн судалгаагаар зудын гамшиг өртсөн тэр жилүүдэд төв суурин газар луу шилжиж байгаа хүмүүс маш их байдаг.

Намайг орон нутагт ажиллаж байхад ч гэсэн дөрөвхөн сарын өмнө би 1500 малтай байсан одоо ингээд хашаагаа хураагаад сумын төв орохоор жоохон санаа зовоод байна. Аймгийн төв оръё доо гэж байгаа. Залуу малчинтай таарч л явсан. Тийм учраас бид нар энэ зудыг дараа нь тэгээд яах вэ гэхээр зуд зулагтай одоо ингээд сайхан боллоо гэдэг нэг ийм үгтэй. Тэгэхээр энийгээ болиод зуд болохоос өмнө бэлтгэлээ хангадаг ийм байдал руу оръё оо гэж байгаа. Тэгэхээр энэ дээр ганцхан ХХААХҮЯ биш аймгийн удирдлагууд, сумын удирдлагууд, багийн Засаг дарга хүртэл их рольтой. Тэгэхээр энэ төрийн байгууллага бол одоо яамнаасаа авхуулаад багийн дарга хүртэл ийшээгээ анхаарлаа хандуулж дараа болох зудын гамшгийн эсрэг ямар бэлтгэл бэлэн байдалтай байх вэ гэдэг л ийм юм руугаа бид орохгүй бол болохгүй болчихсон учраас ХХААХҮЯ-наас энэ 17 аймгийн 25 баг дээр энэ 1000, 100 гээд хөтөлбөрийг туршиж үзээд байгаа юм аа.

Өнгөрсөн 7 хоногт би Баян-Өлгий аймгийн Толбо сум дээр яг энэ төслийг хэрэгжүүлж байгаа хүмүүстэй уулзсан 50 өрх нийлчихсэн ногоон тэжээлээ тариалаад хамтын хөдөлмөр эрхлээд яг амьдаараа хоршоо болж эхэлж байгаа. Сая амралтын өдрүүдээр зүүн аймгуудаар ажиллалаа. Энэ асуудлууд бас сайн явж байгаа. Одоо ингээд ирэх 7 хоногоос бид Архангай аймагт бас очиж хэрэгжилттэй нь танилцана гээд ингээд яваад байгаа юм. Тэгэхээр яагаад би ингээд яваад байна вэ гэхээр нэг бодлого ярьчихдаг яг хөрсөн дээрээ байна уу үгүй юү гэдгийг очиж үзэж шалгаж ингэж л яваад байгаа юм. Ингэж байж бид нар зудын эсрэг одоо гарна аа л гэсэн ийм бэлтгэлтэй.

Тэрнээс одоо зудын дараа нэг ийм байна тийм байна гэсэн судалгаа яг үнэндээ хаана хаана л байхгүй байна. Зудаас гарч байгаа хор уршиг нь аюултай

2023 оны зуд нийтдээ энэ чинь арваад сая мал тэгээд одоо мөнгөн дүнгээр тооцох юм бол энэ чинь 3,4 их наяд төгрөгийг дөрөвхөн сар, тавхан сарын зудын хугацаанд Монголын малчид ингээд алдчихаж байгаа байхгүй юу 3,4 их наяд төгрөг гэдэг чинь Монголын хүүхдүүдэд өгч байгаа мөнгийг бараг 3 жил өгчих хэмжээний мөнгийг бид нар 4, тавхан сард алдаад байгаа юм. Тэгэхээр ХХААХҮЯ бол энэ зуд болоход бэлтгэлтэй байх тал дээр анхаарлаа хандуулж энэ төслийг эхлүүлж байгаа. Амжилттай болбол 2027 онд өшөө дэлгэрүүлнэ.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэг мэдээлэл өгөөдөхье өө өчигдөр Л.Энх-амгалан Боловсролын сайд ирэх ёстой байсан, Сангийн сайд З.Мэндсайхан ирэх ёстой байсан, Цахим хөгжил инновац харилцаа холбооны сайд Ч.Номин сайд ирэх ёстой байсан, Эрүүл мэндийн сайд Н.Батшугар сайд ирэх ёстой байсан энэ 4 сайд ирээгүй шүү. Монгол улсын Ерөнхий сайд Н.Учрал сайд бол энэ мэдээлэл аваад сууж байгаа юм байна лээ. Одоо тэгээд ажлын албаныхан бас дахиад мэдээлэл хүргээрэй. Шаардлагатай бол Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхбаярыг дуудъя гишүүдээ юу сайд нараа наашаа явуул гэж одоо мэдээлэл хүргэе. Түүнээс биш би цэцэрлэгийн хүүхэд шиг гүйж очоод хөтөлж ирнэ гэж юу байх вэ? Хэдүүлээ ер нь зарчимтай байх ёстой шүү дээ. Нэгэнт Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал чинь мэдээлэл сонсгол хийж байгаа бол тэнд зайлшгүй хүрч ирж мэдээлэл өгөх ёстой сайд, дарга нар бүгдээрээ хүрэлцэн ирэх үүрэгтэй. Түүнээс биш гуйх ёсгүй хөтөлж авчрах ёсгүй энэний ар дээр Гэр бүл, НХХ-ын сайд Т.Аубакир мэдээлэл өгнө. Т.Аубакир сайдыг урьж байна тэгэх үү. Дуудъя тэрний ар дээр нь Монгол Улсын шадар сайд Номтойбаяр мэдээлэл хийх ёстой, 2 сайдыг авчруулахад тэр ажлын хэсгийнхэн ажиллаарай тодруул онцгой байдал уу? За онцгой байдал хариулъя.

ОБЕГ-ын тэргүүн дэд дарга Ц.Ганзориг: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. ОБЕГ-ын тэргүүн дэд дарга Ганзориг гамшигт өртөөд өртсөн иргэд цаашдаа ямар нийгмийн алба нийгмийн одоо үйлчилгээ тусламж авч байна үзүүлж байна төр засгаас одоо хаана очсон ямаршуу аж амьдралтай байна гэдэг судалгаа бол онцгой байдлын байгууллага дээр бол хийгддэггүй. Гэр Бүл хөгжлийн энэ нийгмийн хамгааллын яамнаас нөгөө сум, орон нутгийн энэ нийгмийн хамгааллын байгууллагууд энийг хариуцаж хийдэг НҮБ-ын хүүхдийн сан, гэр бүлийн сан гээд олон төслүүд бол энэ байгууллага дээр хэрэгжүүлэх судалгаа юмнууд бол хийгддэг. Төслийн хүрээнд.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэг Хөдөлмөр, нийгэм хамгаалал, хамгаалал хэд вэ? 15.

Гэр бүл, НХХ-ын яам ТНБД А.Даваажаргал: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл НХХ-ын яам А.Даваажаргал яг малчин өрх буюу малчид руу чиглэсэн сектор луу чиглэсэн нарийвчилсан судалгаа бол манай яаман дээр хийгддэггүй. Ер нь бол мал бүхий иргэдэд санхүүгийн туслалцаа гэж 8 хүртэл сая төгрөгийн дэмжлэг өгдөг. За энэ дэмжлэгийг авсан иргэд эргээд малжчихсан байгаа. Энэ тоон мэдээллийг бол бид нар танд гаргаж өгч болно. Хоёрдугаарт нь бол мал бүхий иргэдээс халамж авч байгаад халамжаасаа одоо хөдөлмөрт шилжсэн иргэдийн тоон мэдээллийг бас гаргаж өгч болно. Тэрнээс биш бол яг одоо байгалийн гамшигт нэрвэгдээд за эргээд амьдрал нь сэргэсэн боссон тийм өрхийн тоо судалгаа бол одоогоор манайд байхгүй байна аа.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Х.Баасанжаргал гишүүн тодруулъя.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал: Би яагаад энэ асуултыг асуугаад байгаа юм гэхээр нөгөө байгалийн гамшигт өртөөд өртөнө гэдэг чинь өөрөө шууд ядуурлын шугам руу орж байгаа байхгүй юу. Ядуурал, ядуу өрхийн тоо байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой шууд нэмэгдэнэ гэсэн үг. Ийм л зүйл дээр л төрийн бодлого чинь байж байх ёстой шүү дээ тийм биз дээ. Яг энэ үед төр өөрөө ажлаа хийдэг төр өөрөө тэр хүмүүсээ хамгаалдаг хаана явж байна, явал энэ өрхийг эргэж ядуурлын шугамаас яаж аврах вэ эргэж яаж хэвийн үйл ажиллагаа хэвийн амьдралын хэв маягт нь эргэж яаж шилжүүлэх вэ гэдэг чинь л одоо бид нарын байгаа гол учир шалтгаан энэ.

Олон яамдуудын байгаа гол зорилгын чинь бодлогын нэг гол зорилго чинь энэ биш юм уу? Тэгэхээр энэ судалгааг цаашид тэгвэл хэн хийдэг байх юм? Яг чиг үүргээрээ аль нь хийх юм хамтрах юм уу яах юм энэ эсвэл салбар дундын асуудал гээд ингээд орхигдоод явах юм уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсье. Хоёрдугаар тодруулга зуд тийм байна. Энэ дээр яг тодорхой хариулт өгөөрэй Хоёрдугаарт цөлжилттэй холбоотой малын хөлийн татвар болон цөлжилтийн эсрэг бодлого 2 хоорондоо яаж уялдаж байна. Энийг бас хэн хариулах вэ? Малын хөлийн татвартай болсноороо цөлжилтийн эсрэг авч байгаа арга хэмжээнд яаж нөлөөлж байна ямар үр дүн гарч байна шууд хамааралтай юу хамааралгүй юу бодлогын хооронд нь уялдаа хэн хангадаг юм ямар хэмжилт хийдэг юм 76%-ийн өсөлттэй байгаа ийм цөлжилтийн эсрэг яг энэ малчдын бас авч байгаа энэ татвар хураамж чинь яаж чиглэх юм гэдэг дээр бас хариулт хэлээч.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ОБЕГ Эхлээд хариулъя. Ядууралтай холбоотой асуудал гамшгаас болоод ядуурал руу орох ард иргэдээ хэрхэн хамгаалах талаар

ОБЕГ-ын тэргүүн дэд дарга Ц.Ганзориг: ОБЕГ-ын тэргүүн дэд дарга Ц.Ганзориг энэ асуудал дээр одоо би Гэр бүл НХХ-ын яам энийг хийх байх аа. Энэ нөгөө ядууралтай холбоотой бас нийгмийн халамжтай орлоготой болох амьжиргаатай болох хөдөө ХХААХҮЯ 2 бас хамтраад хариулт өгөх болов уу гэж бодож байна. Ер нь өнгөрсөн зүгээр 2023-аас 2024 оны зуд дээр Монгол Улс 190 мянган малчин өрхтэй байсан гэж явж байгаад Та бүхэн бас харвал зудаар маш олон иргэд одоо малгүй болоод хот суурин газар шилжсэн 170 мянган шахуу өрхтэй боллоо гэж явж байсан 2024 онд тэгээд өнөөдөр бас статистик мэдээ харахаар 240 хэдэн мянган малчин өрхтэй болчихсон явж байгаа.

Тэгээд ингээд бас статистикийн тоог харахаар малчин өрхийн тоо ихэсчихсэн юм шиг харагдаад байна. Тэгэхээр. Энэ бас асуудлууд дээр бол онцгой байдлын байгууллага бид нарын зүгээс яг хариуцаад одоо даалгах ажил байвал хийхэд бэлэн байна.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За уг нь гүйцээж хариулмаар л байгаа юм даа. Одоо та бүхэн л саналууд гаргах ёстой шүү дээ онцгой байдлын хүрээнд энэ гамшигтай холбоотой асуудлаар яаж хүмүүс амь амьжиргаагаа алдаж байна бид нар яаж тэмцэх юм уг нь та бүхэн л саналаа гаргаж л дээшээгээ зохих байгууллага руу гаргах ёстой хүмүүс шүү дээ. ХХААХҮЯ 2 асуулт байна.

Ц.Идэрбат сайд: Нэг нь төсөвтэй холбоотой мал малчид татвар төлдөггүй биш төлдөг өө малын хөлийн татварыг малчид одоо төлөөд ингээд явж байгаа түрээгээр 2 хуулиар зохицуулагдаад байгаа юм. Нэг нь бол одоо малын хөлийн татвар нойлоос 2 мянга байна гээд заачихсан.

Тэгэхээр зарим сумдынхан бол иргэдийн хурлаараа оруулаад манайх татвар авахгүй ээ гээд зарим нь болохоор ингээд татвар оноогоод тэрүүгээрээ малчдынхаа өмнө асуудлуудаа шийдээд ингээд явдаг. Тэгэхээр ийм ялгамжтай нэг нь авч болдог нэг нь авч болдоггүй биш бүгд ингээд жигд авдаг ийм хуулийн төслийг бид өргөн бариад байгаа юм. Нөгөө талдаа энэ малын хөлийн татвараар орж ирсэн мөнгийг хааш нь яаж зохицуулах вэ гэдэг нь төсвийн хуулиар зохицуулагдаад байгаа юм. Тэгэхээр төсвийн хууль дээрээс бид нар одоогоор энэ чинь нэг 10-аад төрлийн зардлыг малын хөлийн татвараас санхүүжүүлээд байгаа байхгүй юу. Сумын иргэдийн хурал нь өөрсдөө тогтоогоод хурааж аваад эргүүлээд зарж байгаа ганц татвар бараг энэ байгаа.

Тэгэхээр энэ малын хөлийн татвараас орж ирсэн зардлыг бид энэ арваад төрөлд биш тодорхой 2,3 зүйл дээр зарцуулдаг больё нэгдүгээрт энэ малын өвчний асуудал байна. Хоёрдугаарт бол энэ малын чанарын асуудлууд байна гээд. Ингээд бэлчээрийн асуудал байна. Ингээд ийм 3 юм руу л эхний ээлжид зардаг болгох ийм саналыг бас боловсруулаад өргөн барихад бол ер нь бэлдэж байгаа нөгөө талдаа сая бол энэ баахан бүсийн зөвлөгөөнүүдийг хийлээ. Энэ асуудлаар бол сумын Иргэдийн хурлын дарга нар багийн Засаг дарга нар бол бас нэлээдгүй саналаа хэлж байсан учраас энэ малын хөлийн татвартай холбоотой асуудал дээр нэг ийм өөрчлөлт оруулна. Дээрээс нь отроор явсан нөхдүүд очсон газраа татвар төлдөггүй сумдаа төлчихсөн эд нар гэдэг гээд. Ингээд нэг ойлгомжгүй байдал хаана хаанаа үүсгэдэг ийм зохицуулалтуудыг нэг хийгээд өгчихье өө гэсэн ийм бодолтой байгаа. Тоон мэдээллүүдийн асуудал дээр миний бие ч гэсэн бас олон юман дээр эргэлздэг ээ. Ялангуяа манайх энэ малын тооноосоо авхуулаад ер нь яг бас за

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн: ХХААҮ-н сайдын хийсэн мэдээллийг сонслоо. Ц.Идэрбат сайд аа та бас нэг ийм зүйлийг ойлгоорой гэх гээд байгаа юм Засгийн газрын гишүүний хувиар энэ малчны тухай хуулийг хэрэгжүүлдэггүй. Энэ байдал бол үндсэндээ хариуцлагагүй төрийн нэг жишээ л байгаад байгаа юм. Хариуцлагагүй төрийн нэг жишээ өнөөдөр Монгол Улсад маш олон хууль яг ийм байдлаар хэрэгжихгүй байгаа. Сайд нарын үзэмжээр Засгийн газрын магадгүй одоо юу гэдэг юм харалган бодлогоор орхигддог байдал энэ бодит жишээ нь энэ байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ хэрэгждэггүй заалтыг шаардах сонсголыг бол хийж байгаа.

Өнөөдөр цаашид Монголын төр байгаа хууль засагладаг нийгмийг бид нар бий болгохын тулд хувь хүн биш хууль засагладаг нийгмийг болгохын тулд бид нар өнөөдөр сонсголыг зохион байгуулж байгаа юм. Хуулиа мэддэггүй эрх мэдэлтэнд энэ мэдрүүлэх хяналтын сонсгол болж байна гэж харж байгаа юм. Тэгэхээр ХХААХҮ-ийн сайд та яг энэ малчны хуулийн манаач нь байх ёстой байгаад байгаа юм. ХХААХҮЯ тэр дундаа би харин хаа очиж таны мэдээлэл дээрээс очиж харахад бас ядаж нэг МАА-гаа ярьдаг малчны хуулиа судалдаг бас нэг сайдтай болсонд талархаж байна. Өнөөдөр үндсэндээ мартагдсан МАА-гаа бид нар эргээд одоо нэг анхаарахгүй бол болохгүй ийм цаг мөч болчихсон байна.

Хоёрдугаарт, гишүүдийн хэлж байгаа асуудлууд дээр энэ хэлж байгаа, ярьж байгаа, анхаарах, хэлэх, ярих асуудлууд үндсэндээ бүгд л хүний эрхтэй холбоотой асуудлууд байгаа шүү дээ. Үндсэн хуулиар бид нар энэ тэр хүний амьдрах, ажиллах тэр эрхийг нь хангах үндсэн үүрэгтэй. Дээрээс нь Монгол Улсын энэ

хамгийн чухал салбар болсон стратегийн салбар болсон энэ салбарын хөгжлийн асуудлаар ороход учиргүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр бид нар хүнээсээ хөрөнгө мөнгө харамладаг тийм харалган төр байж болохгүй болчихоод байна. Бид нар энэ хуулийн Ерөнхий хяналтын сонсголыг анх удаагаа хийж байгаа. Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд та бүхнээс энэ хууль дээдлэх зарчмыг нэхээд байгаа юм хууль дээдлээч ээ. Хуулийн өмнө бүгд захирагдах ёстой хэн ч хуулиас дээгүүр эрх мэдэл албан тушаалтан байх ёсгүй хууль дээдлэх зарчмыг бид нар мөрдөхгүй ширэнгийн хууль одоо үүснэ шүү.

Бид нар үндсэн энэ зарчмыг шаардаж байна аа. Энэ ч үүднээсээ сая энэ сонсгол дээр бид нар энэ сайд нарыг нэхээд байгаа асуудал байгаа. Өчигдрийн хуралдаан дээр оролцох байсан 4, 5 сайд бүгдээрээ ирж оролцсонгүй. Өнөөдөр ганцхан одоо юу гэдэг юм Ц.Идэрбат сайд орж ирж байна. Өнөөдөр сонсголоос сайд нар бүгдээрээ жийрхээд байгаа. Одоо орж ирж бодит үнэтэйгээ нүүр тулах ёстой хийж чадаагүй ажлаа бодитоор нь үнэлэх ёстой хэлэх ёстой асуудлаа тайлбарлах ёстой гарц шийдлээ хамтдаа олох ёстой байгаад байгаа юм. Тэгээд бид нар ядаж энэ хяналтын сонсгол хийдэг ажлыг эхлүүлнэ ээ. Малчин түмнээс сонсдог байх ажлыг хийх зайлшгүй шаардлагатай байна аа.

Хэрэгжүүлдэггүй ажлуудаа Засгийн газраас хийгээгүй хууль, журам дүрэм журмуудыг бүгдээрэнг нь бас ингээд хэлээд ярьчихлаа энэ дотроос чинь ингээд хуулиас давсан журмуудыг танай Засгийн газрын сайд нар чинь хэрэгжүүлсэн журам гаргахдаа нугалаа гаргаж үүсгээд байна аа. Хамгийн энгийн жишээ чинь одоо юу гэдэг юм? Малчдын залгамж халаа болсон залуучуудыг нэг МАА-н чиглэлээр сургая гээд аваад үзэхээр нугалаа гаргаад өнөөдөр дөнгөж тавьхан хүүхэд сурч байна. МАА-н мэргэжлийг нь мэргэжлээс нь малын эмчийг нь хасаад хаячхаж байна. Сургууль нь дээрээс нь босго шалгуур оноог нь тавихаар 500 оноо гээд тавьчихаж байна. Ингэхээр чинь бид нар хэн энэ МАА дээр чинь үлдэх юм бэ? Мал дагавал ам тосодно гээд байдаг энэ малыг чинь дагах хүнгүй боллоо шүү МАА чинь цаашид орших уу эс орших уу дээр очлоо шүү. Тэгэхээр энэ мэт одоо юу гэдэг юм? Саяын тэр дээд боловсролтой мэдлэг боловсролыг нь олгохтой насан туршийн боловсролыг аймаг сум болгон дээр бүрд тогтолцоог нь бүрдүүлэхтэй холбоотой ипотектэй холбоотой саяын тэр нийгмийн баталгаатай холбоотой асуудал болгон ч гэсэн яг сайд болгоны үзэмжээр чинь та бүхний нугалаагаар чинь хууль завхраад байна.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. Ямар ч байсан ХХААҮ-н сайд Ц.Идэрбаттай нэлээн зүйлүүдийг ярьчихлаа. Малчид маань ч саналуудаа хэлчихлээ. Малчныхаа одоо төлөөлөл болсон оролцогчдоос та бас бүх саналуудыг нь ингээд сонсчихлоо. Гишүүд хүрч ирж бас ууртай уцаартай ч гэсэн нэлээд зүйлүүдийг ярьчих шиг боллоо. Ядаж ямар ч л байсан энэ малчны тухай хуулийн манаач болсон ХХААҮЯ маань бүтэн сонсож байгаад бас газрын дарга нар бусад одоо холбогдох хүмүүстэйгээ бүтэн сонсож байгаад бас таатай байна аа. Энийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Ингээд дараагийнхаа илтгэл рүү оръё одоо бидний хүлээсэн. НХХ-ын асуудал гэр бүл НХХ-ын сайд Т. Аубакир танилцуулна аа. Аубакир сайдыг индэр дээр урьж байна. Сайдыг урьж байна, индэрт урьж байна индрийн микрофоныг нээе.

Гэр бүл, НХХ-ын яамны ТНБД А.Даваажаргал: Та бүгдийн өдрийн амгаланг айлтгая аа. Би Гэр бүл НХХ-ын яамны ТНБД А.Даваажаргал байна. Яг энэ цаг үед манай салбарын сайд Үндсэн Хуулийн Цэц дээр хурал давхацсан байна. Тэгээд би салбарынхаа мэдээллийг та бүхэнд хүргээд тэгээд асуулт

хариултын үед сайд маань амжаад ороод ирчих байх гэж бодож байна. Тэгээд цагийг хэмнээд надад мэдээлэл хийх боломж өгнө үү.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Мэдээлэл хийх боломж олгож өгнө үү. Яах юм айн? Танилцуулгаа сонсчих уу сайдаа сонсох уу? сайдаа сонсьё гэж байна. Дараагийнхаа асуудлыг сонсож байх уу тэгвэл дараагийн асуудал малчин малчдын малчны хамтын санаачилга, шинэ хоршооны явц, үр дүнгийн талаар? Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны дарга Б.Мөнх-оргил гэсэн байна. Н.Номтойбаяр сайд гадаадад томилолттой явж байгаа юм байна. Б.Мөнх-оргицыг дуудаарай.

Мэдээллээ сонсож байх уу хэдүүлээ тэгэхээр ойлгож байгаа та бүхний бас нөхцөл байдлыг ойлгож байгаа. Энэ холоос хүрч ирээд энэ Сонсголын ерөнхий сонсгол руу ороод бүх асуудлуудыг хараад би нэг асуудал дээр баяртай байгаа шүү дээ. Тэр холоос та нар хүрч ирчхээд энд сайд нар нь оролцдоггүй юм байна. Сайд нар нь зугтчихдаг юм байна. Аливаа асуудлаас айгаад зутаад явчихдаг юм байна. Ажлаа хийгээгүй хүн л айна шүү дээ.

Одоо өнөөдөр энэ Ц.Идэрбат сайд хүрч ирээд сууж байна. Алдаа дутагдал байсан ч гэсэн улаан нүүрээрээ тэрийгээ сонсоод сууж байх шиг. Ийм хариуцлага гэж хаана байх вэ дээ. Тэгэхээр энэ чинь хамгийн том ашиг энэ чинь хамгийн том үр дүн байхгүй юу даа. Бас бид нар энэнийхээ дагуу бол цаашаа албан ёсоор Ерөнхий сайдад бас чиглэл өгнө шүү дээ. Энэ сайд нар чинь ийм ажил хийх ёстой байсан, хийгээгүй байна, алдаа дутагдал гаргасан байна бүтэн 2 жил болж байхад ийм үр дүнтэй байна гэдгийг бид нар цаашаа мэдээлж чиглэл өгөх юм байгаа юм. Хоёрдахь илтгэлээ хэдүүлээ сонсож байаа? Малчны хамтын санаачилга, хоршил, шинэ хоршооны явц, үр дүнгийн талаар Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-оргил Шадар сайд гадаадад яваа юм байна энэ талаар танилцуулна биз өөрийгөө танилцуулаад тэгээд мэдээллээ хийнэ үү.

Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-оргил: Монгол Улсын бүтэц зүйн хөгжил онцгой байдал хариуцсан Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-оргил. Монгол Улсын Шадар сайд ажлын айлчлалын хүрээнд гадаад улсад томилолтоор энэ цаг үед ажиллаж байна.

Энэ хүрээнд би малчны хамтын санаачилга, хоршил, шинэ хоршооны явц, үр дүнгийн талаарх мэдээллийг өгье өө. Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Монгол Улсын Үндсэн хууль болон уламжлалт МАА тулгамдаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу уламжлалт МАА-н тогтвортой хөгжлийг дэмжих, малчдын орлого, амьжиргааг сайжруулах зорилгоор малчдын хоршоог төрөөс дэмжих хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай ЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолыг баталж шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлсэн. Мөн Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон 5 жилийн үндсэн чиглэлд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгүүдэд шинэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, дундын хоршоог байгуулах ХАА-н салбарыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж байна.

Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах зохион байгуулалтын нэгжийг ЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолоор анх шинэ сэргэлтийн бодлого хурдасгуур төв УТҮГ-т улмаар, ЗГ-ын 2024 оны 39 дүгээр тогтоолоор ЖДҮ-

ийн газарт ЗГ-ын 2025 оны 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд шилжүүлэн ажиллаж байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд МАА-н салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, түүний сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах, малчин өрхийн амьжиргааг дэмжих орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Шинэ хоршоо хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш улсын хэмжээнд 10578 хоршоо байгуулагдаж 103.340 малчин шинээр хоршооны гишүүнээр элсээд байна. Үүнээс 7700 хоршооны 26.437 гишүүн малчдад 894,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкнуудаар олгоод байна. Зээл олголтын мэдээг аймаг тус бүрээр харьцуулан үзвэл хамгийн өндөр дүнтэй зээлд хамрагдсан аймгуудыг дурдвал Булган 84,5 тэрбум, Ховд 76 тэрбум, Архангай аймаг 73,7 тэрбум Говь-Алтай аймаг 64,2 тэрбум, Баянхонгор аймаг 64,2 тэрбум төгрөгийн өндөр дүнтэй зээлд хамрагдсан байна. Харин Дархан-Уул 5,1 тэрбум, Орхон аймаг 6,7 тэрбум тус тус зээлийг хамгийн бага хувьтайгаар авсан байна. Төрийн банкаар дамжуулан 14225 малчид нийт 496,8 тэрбум төгрөгийн зээл Хаан банкаар дамжуулан 12166 малчинд нийт 396,6 тэрбум төгрөгийн зээл Хас банкаар дамжуулан 45 малчинд 1,3 тэрбум төгрөгийн зээл Богд банкаар дамжуулан нэг малчинд 50 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон дүн мэдээтэй байна.

Зээлийн эргэн төлөлтийн хувьд 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 136,4 тэрбум төгрөгийн зээлийн төлөлт хийгдээд байна. Шинэ хоршооны гишүүд 14 зориулалтаар хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа. Үүнд Нэг. Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах, 2.ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах машин тоног төхөөрөмжийг худалдан авах, 3.Мах, сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрт цех байгуулах, 4.Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, 5.Бэлчээрт худаг, уст нэг цэг гаргах усан хангамж байгуулах, 6. Мал төхөөрөх цех, үйлдвэр байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, 7.Мал, малын гаралтай түүхий эдийг эдийн агуулах, зоорь, хөргүүр байгуулах зэрэг 14 зориулалтаар зээлийг олгож байгаа.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд ХАА-н салбарт байгуулагдсан хоршоодын чадавхыг бэхжүүлэх, тэдгээрийг дотоод, гадаадын байнгын худалдан авагчтай холбох үйлдвэрлэл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх, санхүүжилт, зээлийн эх үүсвэрийг тогтвортой байдал, хүртээмжийг сайжруулах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд ЗГ-ын 2025 оны 166 дугаар тогтоолоор 5 аймгийн нутаг дэвсгэрт 71,235 га атар газрыг. Тариалангийн газрын ангилалд шилжүүлсэн бөгөөд ингэснээр шинэ хоршоо хөдөлгөөний гишүүдэд газар тариалан эрхлэх боломжийг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн.

Малын ашиг шимийг богино хугацаанд нэмэгдүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор стратегийн хүнс болох махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал бордох, хонь хяргах болон арьс, шир боловсруулах тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх түүнчлэн малын ашиг шимийг сайжруулах, уураг, эрдэс бодисын нэмэлт агууламжтай тэжээлийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хоршоологчдыг улсын бүртгэлд бүртгүүлэх үйл явцыг хялбаршуулах зээл авахад шаардагдах судалгаа тооцоо болон төслийн баримт бичгийг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж шинээр байгуулагдсан хоршоодыг

чадавхжуулах, тогтмол сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд улсын хэмжээнд шинэ хоршоо хөдөлгөөнөөр дамжуулан нийт 1109 шинэ ажлын байрыг өнөөдөр бий болгоод байна.

Түүнчлэн хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага эм эн эс 68 91 2020 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн Төв аймагт нэг, Ховд аймагт 2, Булган аймагт нэг буюу нийт 4 хоршоо өнөөдөр энэ стандартыг нэвтрүүлэн нэвтрүүлсэн байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчдын хоршоолох санаачилгыг дэмжих зорилгоор хоршооны гишүүн малчдад арилжааны банкаар дамжуулан жилийн 6%-ийн хүүтэй 50 хүртэлх сая төгрөгийн хэмжээтэй 5 хүртэлх жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгож байна. Түүнчлэн барьцаа хөрөнгийн хүрэлцээ муутай малчин хоршоологчдод зориулан Зээлийн батлан даалтын сангийн зээлийн сангаас зээлийн дүнгийн 80-аас 100 хувьд батлан даалт гаргаж байгаа нь төрөөс малчдад үзүүлж буй бодит дэмжлэгийн нэг илэрхийлэл юм. Зээлийн батлан даалтын сангийн мэдээллээр улсын хэмжээнд нийт 13769 гишүүн малчны 329,5 тэрбум төгрөгийн зээлд батлан даалт гаргасан нь хөнгөлөлттэй зээл авсан нийт малчдын 52%-ийг хамарч байна.

ХХААХҮ-ийн сайдын багцад хоршооны гишүүн малчдад олгох хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн татааст 2024 онд 23,2 тэрбум төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 25 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг арилжааны банкнуудад шилжүүлсэн байна. 2025 онд уг зориулалтаар 103,2 тэрбум төгрөг батлагдаж 59,4 тэрбум төгрөгийг хүүгийн татаасыг арилжааны банкнуудад олгосон бол 2026 онд 75,9 тэрбум төгрөг батлагдаж 2026 оны хагас жилийн байдлаар 39,9 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг шилжүүлээд байна. Ингэснээр 2024-өөс 2026 онд нийт 202,4 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн татаасыг улсын төсөвт батлуулж үүнээс 147,4 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг арилжааны банкнуудад шилжүүлсэн гүйцэтгэлтэй байна.

Шинэ хоршооны хөдөлгөөний хүрээнд Зээлийн батлан даалтын сангаас 2026 онд хоршооны гишүүн малчдын зээлийн ашиглалт эргэн төлөлтийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд нийт 7 удаагийн сургалт, уулзалт зохион байгуулж 89 зээлдэгчийн 167,4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэн барагдуулсан. Шинэ хоршоо хөдөлгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, цаашдын бодлого, арга хэмжээг оновчтой төлөвлөх зорилгоор емонголиа цахим системээр дамжуулан хоршооны гишүүн малчдын дунд 14 чиглэлээр судалгаа зохион байгуулсан судалгааг 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд авч нийт 15536 хоршооны гишүүн малчин дээрх судалгаанд хамрагдсан болно. Уг ажлыг улсын хэмжээнд анх удаа зохион байгуулсан бөгөөд 21 аймаг, 330 сум, 5 дүүргийн ЗДТГ, аймгуудын ХХААГ хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран хийсэн.

Судалгааны үр дүнд хоршооны гишүүн малчдад тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, зээлийн санхүүжилтийн зарцуулалтад хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх, орон нутгийн эдийн засаг нийгмийн хөгжилд үзүүлж буй нөлөө хувь нэмрийг тогтоох хоршоонд нэгдсээр бий болсон үр өгөөж малчдын амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлтийг судлах зээлийн эргэн төлөлтөд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, цаашид хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, олон нийтийн санал зөвлөмжийг авсан үр дүнтэй ажил болсон. Судалгааны зарим үр дүнгээс харахад үржлийн мал худалдан бойжуулах

борлуулах чиглэлээр зээл авсан 6851 малчин нийт 373.505 толгой малыг 84,9 тэрбум төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн өрхийн орлого нь 34%-аар өссөн дүн гарсан байна.

Мөн энэ хүрээнд шинэ хоршоо хөдөлгөөний хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 26437 малчин иргэнд зориулсан хоршооны гишүүн малчин цахим үнэмлэхийг емонголиа системд үүсгэн нэвтрүүлээд байна. Шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дүн, үр өгөөжийг малчид болон олон нийтэд хүргэх, хоршооллын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор ХМХ-ээр сурталчилгаа мэдээллийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Бүсийн зөвлөлийн анхдугаар өргөтгөсөн хуралдааны хүрээнд 2025 онд хангай, хойд, говийн бүсүүдэд хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус зөвлөгөөний хүрээ хоршоологчдын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн үзэсгэлэнг худалдааг зохион байгуулсан. Зөвлөгөөний нийт зөвлөгөөнд нийт 17105 хоршооны гишүүн, малчин оролцсон бөгөөд энэ нь хоршооны үйл ажиллагааг сурталчлах, туршлага солилцох, хоршоологчдын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон.

Хоршооны чадавхыг бэхжүүлэх, зөвлөн туслах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх олон улсын сайн туршлагаас суралцах зорилгоор БНХАУ-ын ӨМӨЗО-д зохион байгуулсан хоршооны үйл ажиллагаатай танилцах туршлага судлах сургалтад 7 аймгийн малчин, малчин хоршоологчдыг хамруулаад байна. НҮБ-ын Ерөнхий ансамблийн 78 дугаар чуулганаар 2025 оныг олон улсын хоршооллын жил болгон тэмдэглэх тухай тогтоолыг баталсан билээ. Мөн Монгол Улсын санаачилгаар 2026 оныг Бэлчээр болон нүүдлийн МАА эрхлэгчдийн олон улсын жил болгон зарлах тухай тогтоолыг НҮБ-ын Ерөнхий ансамблийн баталсан баталсан. Эдгээр санаачилга нь үйл ажиллагааны хүрээнд хоршооны хөгжлийг дэмжих хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар Бүгд найрамдах Энэтхэг Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг 2 улсын дипломат харилцаа тогтоосны далан жилийн ойн хүрээнд 2025 оны 3 дугаар сард байгуулж хамтын ажиллагааг идэвхтэй өргөжүүлэн ажиллаж байна аа. Шинэ хоршоо хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд ХААИС-тай хамтран малчдад зориулсан гарын авлага боловсруулж, хэвлэн нийтэлж, малчид болон олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж байна. Мөн ХААИС-ийн МАА бизнесийн сургууль болон эдийн засаг бизнесийн сургуулийн 20 сургагч багштай хамтран 10 аймгийн 1500 хоршоологчийг хамруулсан чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Цаашид анхан шатын хоршоодын үйл ажиллагаа нөөц боломжид тулгуурлан дундын хоршоог хөгжүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Дундын хоршоо нь ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуулалтын үйл ажиллагааг үе шаттай ахиулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээрийг бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн тогтолцоог шилжүүлж хоршоодын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, малчид, үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ ээ. Шинэ хоршоо хөдөлгөөн нь зөвхөн малчин өрхийн эдийн засгийн чадавх орлогыг нэмэгдүүлэх санаачилга бус харин уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшиг, эрсдэлийг хөдөлмөр, хөрөнгө нөөцөө хоршин нэгтгэх замаар хамтын хүчээр даван туулах улмаар үндэсний хэмжээнд сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа билээ. Мөн уламжлалт МАА-н нүүдлийн соёл иргэншлийг үнэт өв, өвөрмөц онцлогийг хадгалан хамгаалж хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгыг давхар агуулж байгаа юм. Анхаарал хандуулсанд

баярлалаа.

Сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ:За баярлалаа. Хэлэлцүүлгээ цаашаа үргэлжлүүлье. Энд чинь өнөөдөр бас идэвхтэй оролцож байгаа өчнөөн олон гишүүд байгаа. Тэд нарыг хүндэтгээд гишүүдээ цаашаагаа хэлэлцүүлгээ цаашаа явуулъя аа. Малчны хамтын ажиллагаа, хоршил, шинэ хоршооны үйл явц гээд Номтойбаяр гишүүний ажлын албаны даргын илтгэсэн илтгэлтэй холбоотойгоор 5 оролцогчоос саналыг нь сонсьё тэгэх үү? Тэгээд цаашаагаа хэлэлцүүлгээ явуулъя. Гараа өргөөд тэндээсээ микрофоноо хэлээд явчихъя 5-ыг авчихъя тэгэх үү? 4 дээр очоод суучих ээлжлээд дараа Т.Аубакир сайдтай холбоотой асуудал дээр нэлээдгүй санал байх шиг байна 4 номерын микрофон.

Н.Баярсайхан хил хязгааргүй алхам ТББ:За баярлалаа. Н.Баярсайхан хил хязгааргүй алхам ТББ. Тэгэхээр зэрэг энэ шинэ хоршоо, шинэ одоо хөдөө гэдэг бодлого бол хэрэгжсэн. Тэгэхээр зэрэг энэ Булган аймгийн зээл олголтоороо өндөр байна гэдэг чинь одоо яг энэ өөдөөс харж байгаа Ж.Бат-Эрдэнэ гишүүн хэдэн онд байна? Мэдэхгүй шинэ хөдөө гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Оролцогч Н.Баярсайхан: Баярлалаа. Н.Баярсайхан, Хил хязгааргүй алхам төрийн бус байгууллага. Энэ шинэ хоршоо, шинэ хөдөө гэдэг бодлого хэрэгжсэн. Булган аймаг зээл олголтоороо өндөр байна гэдэг чинь яг энэ өөдөөс харж байгаа Ж.Бат-Эрдэнэ гишүүн, хэдэн онд мэдэхгүй, шинэ хөдөө гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тэгэхээр тодорхой бодлоготойгоор бэлтгэлээ хангаад иргэдээ мэдлэгжүүлж яваад, малчдаа мэдлэгжүүлээд өөрсдөө өөрсдийнхөө үүсгэл санаачилгаар зохион байгуулалтад орсны үр дүнд бэлэн байсан учраас боломжийг хүртэж чадсан байна. Гэтэл бусад аймаг сумдад ялангуяа говийн бүсэд тэр дундаа уул уурхайн бүсийн малчид нэг дор олуулаа хоршоод зохион байгуулалтад ороод удаан байх боломж байхгүй. Уурхай, цөлжилт, усны хомсдол чинь малчдыг нэг дор удаанаар хоршоод амьдрах боломжийг үгүй хийдэг.

Ийм болохоор бусад аймгийн малчид нэгдүгээрт нь бэлтгэлгүй, мэдлэггүй байлаа. Орон нутгийн удирдлагууд нь ч тэр мэдлэггүй байлаа. Тийм болохоор хүртээмжтэй байж чадахгүй байгаа юм. Илүү авсан нь илүү болж байгаа юм шиг ингэж харагдаж байна.

Тийм болохоор малчны тухай хуулиа дахин шинэчлэн найруулж боловсруулж тодорхой бодлоготойгоор явуулах хэрэгтэй. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого гэдэг юмаа, төрөөс экологийн талаар баримтлах бодлого гэдэг юмаа гаргаж мөн дээр нь ядуурлын талаар барих бодлого гаргаж байж Малчны тухай хууль чинь, шинэ хөдөө, шинэ хоршоо гэдэг юм чинь хэрэгжих гээд байгаа байхгүй. Гэтэл бодлого байхгүйгээр шууд нэг хууль гаргангуутаа хүн бүхэн хариуцах үүрэгтэй, хэрэгжүүлэх үүрэгтэй, хариуцлагын тогтолцоотой болоод ирэнгүүт болохгүй байна.

Тийм учраас Булган аймгийн малчдаас туршлага сургамж нь малчин малчиндаа нөлөөлдөг, сургадаг ийм юмыг бий болгох замаар суурийг нь бэлтгэж байж шинэ хөдөө, шинэ хоршоо бодлого явахаар байна.

Малчны тухай хуулийн шинэ хоршоо, шинэ хөдөө бодлогыг Шадар сайдын түвшинд, хуучин Шадар сайд байхдаа л энийг авч явж байсан, тэгээд Номтойбаяр дээр ирсэн байх. Тэгэхээр юмнуудаа сууриар нь хараач. Газрын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Ашигт малтмалын хууль, Үнэлгээний хууль, Газрын хуулиа уялдаатай хийхгүй бол салбар дундын бодлого байхгүй хууль хэрэгжихгүй байгаатай адилхан. Хэдхэн хоногийн өмнө баталсан хөдөө аж ахуйн тухай бодлого, хууль гарсан. Тэгээд хөдөө аж ахуйн тухай хууль чинь яг л байхгүй. Дахиад хэрэгжихгүй суурийг нь бэлдэхгүйгээр иргэдийг хүчээр зохион байгуулалтад оруулах нь цаасан дээр л хоршоо байна. Амьдрал дээр бол хоршоо байхгүй. Ийм л юм болох гээд байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа, Та маш сайн зөв харж байна. Шинэ хөдөө хөтөлбөр хэрэгжүүлээд явсан. Шинэ хөдөө хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ нэг малчинд туслах биш 1, 2 малчинд туслах биш, нийт та хэд маань хоршоондоо ороод, ногоон тэжээл тарих боломж бололцоо олгоё, трактор тоног төхөөрөмж олгоё гээд нэлээн хэдэн жил хэрэгжүүлчихсэн төслүүдийн ар дээрээс шинэ хоршоо гэнгүүт бэлэн байсан болохоор ийм их боломж бололцоо Булган аймгийн хувьд нээгдсэн гэдгийг хэлье. Баярлалаа. 4 номер уу? 2 номер.

Оролцогч Г.Алтанхуяг: Баярлалаа. Судлаач Алтанхуяг байна. Шинэ хоршоо хөдөлгөөний төсөл нь уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд төсөл боловсруулагдаж байна. Тэгэхээр хуулиа яагаад сурталчлахгүй байгаа юм бэ гэдэг асуудлыг яримаар байна. Хууль чинь малчдын тухай хуультайгаа бас уялдаа холбоотой байгаа юм. Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуультайгаа бас уялдаа холбоотой байгаа. Тэгэхээр чинь хоршоо байгуулаад цаашаа хөгжүүлье. Юунд зориулж хоршоо байгуулаад байгаа юм бэ гэхээр дэлхий нийтийн уур амьсгалын өөрчлөлтийг хамгаалах тухай байгаа. Тэгэхээр энэ дээрээ бид дээр, дооргүй яг энийгээ л ярих хэрэгтэй.

Төсөл гарч болно, журам гарч болно, хөтөлбөр явагдаж болно. Ямар хуультай яаж уялдуулаад бидний зорилго хаашаа яваад байгаа юм бэ гэдэг дээр асуудлыг хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 4 номер.

Оролцогч Б.Юмжирмаа: Монгол Улс даяараа хууль яаж хэрэгждэгийг сонсголоор бид харж байна 937 хууль дээр бас сонсголыг хийх ёстой гэдгийг 1 дүгээрт хэлье. Надаа 70 санал байна. 7-г хэлэхийг хичээе. Хөдөө аж ахуйн сайдын илтгэл үдээс хойш байж байгаад үдээс өмнө явчихсан учраас би саналаа хэлж байгаа гэж хараарай. Монгол Улсад хөдөө аж ахуйн салбар хамгийн чухал салбар, энэ салбар дээрээс улс төржилтөө авахгүй бол, сайдаа маш хурдан сольдог учраас бодлого тогтворгүй явж байгаа гэдгийг бид нар анхаарах хэрэгтэй. Нэмээд боловсролын салбараас улс төржилтийнхөө саврыг татаж өгөхийг бас давхар хэлмээр байна.

Дараагийнх нь би хөдөө аж ахуйн сайдад хандаж юу хэлэх гээд байгаа э гэхээр, төсөл, танилцуулгатай танилцсан улсын аварга малчин гэдэг шалгуур байгаа. Тэрэн дээр бүтээлч малчин гэдэг шагналыг гаргах хэрэгтэй. Бүтээлч малчин гэдэг шагнал Монгол Улсад юуг шийдэх гэхээр бэлчээр олон улсын гэрээ конвенцын өмнө хүлээсэн Монгол Улсын үүргийг, аялал жуулчлалыг, доллароор орлого олох боломжийг, эрүүл мэндийн хувьд эрүүл эко хүнсний зориулалттай сав суулгад малчид сүү цагаан идээгээ боловсруулах боломжуудыг гаргах юм. Ийм шалгуур үзүүлэлттэйгээр бүтээлч малчин гэдгийг хийж байж бэлчээрийн асуудал шийдэгдэнэ шүү. Улсын аварга малчин гэдэг бол тооны араас явж байгаа.

Бид Булган аймаг дээр 2 жилийн хугацаанд хурга бордох төслийг хийгээд бэлчээрийн даацыг хөнгөрүүлэх боломжтой гэдэг туршилтыг хийсэн. Хурга бордоод 20кг хүрсэн ийм туршлага байж байгаа.

Дараагийнх нь сургалт дээр 9 зүйлийг дурдсан байна. 9 зүйл нь дандаа нэг удаагийнх. Тогтмол, тасралтгүй байж дадал хэвшил суудаг юм. Малчин өрхийг бид бизнес эрхлэгч гэдэг талаас нь төлөвшүүлж хандлагыг өөрчлөхгүйгээр 1 удаагийн постын ажил хийгээд өөрчлөлт орохгүй шүү. Манай хийж байгаа сургалтууд бүгдээрээ постынх байгаа. Зүгээр хүмүүс суулгаад, зураг аваад пост биччихдэг, түүгээр яаж чадавхжих юм. Яаж дадал, зан заншил нь суух юм бэ.

Дараагийнх нь сумын Засаг дарга нарыг хоршооны дарга гэдэг хандлага руу төлөвшүүл. Сум, баг, малчдад хүрч үйлчилж байгаа арга хэмжээг сумын дарга, хоршооны даргын үүргийг гүйцэтгэж байж гар үйлдвэрлэл, оёдол, сүү цагаан идээ, ногоо менежментийг хийж өгөхгүй бол ганцхан малчин дээр бүх менежмент, маркетингийг хийе гэж орхичхоод, чадавх гэх юм өөрчлөлтөд хүрэхгүй. Тэгэхээр бодлогын өөрчлөлтүүдийг хийж, харж өгөөч гэж байна.

Дараагийнх нь бодлого энд маш их хэмжээгээр бичигдээд байгаа болохоос биш мэдрэгдэхгүй байгаа гэдэг дээр илүү анхаараач малчдад тулгамдаж байгаа асуудлуудын хэд нь...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа дараагийнх нь 4. Номер.

Оролцогч Ш.Ариунаа: Баярлалаа. Ариунаа, Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо. Саяны танилцуулгатай холбоотойгоор хоршоологчдын хөдөлгөөн бол эв нь олдвол маш зөв хийгээд явчих ажлууд байгаа. Өмнөх хүмүүстэй санал нэг байна. Үүн дээр зарим нэг бодит хүндрэл байгааг 1, 2 гээд хэлчихье.

1 дүгээрт Монгол малчдын өрхийн үйлдвэрлэлийг дэмжье гэж бид нар хэлж байгаа. Монгол гэр, монгол ахуйд тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг гаргаад өгөөч гэж Ц.Идэрбат сайдад тусгайлан хүсэж байна. Албан бичгээр бас явуулья.

Нэг жишээ нь Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэд сарлагийн сүүгээр үйлдвэрлэл цех хийгээд амьдарч байгаа хүн дээр одоо яг энд тавьчихсан байгаа төслүүдээс шалгараад газар дээр нь очиж үзсэн байгаа юм. Тэгээд тэнцээгүй сүүлийн шатандаа яагаад тэнцээгүй вэ ажлын байр цэвэр бохир усны шугамд холбогдоогүй байна гээд. Тэгээд нөхөр нь энийг нь мэдсэн бол голоосоо 2 суваг татчихдаг байж дээ гэж хариулж байсан. Тэгэхээр нөхцөл байдал нэг ийм байна.

2 дугаарт Зээлүүдийг бодитоор малчид авъя гэхээр тариаланч ялгаагүй авъя гэхээр, миний ойлгосноор гаалийн татваруудаас хөнгөлөөд чөлөөлчихдөг төрлийн тоног төхөөрөмжүүдийг оруулж ирж байна.

Авах гэж байгаа хүнд зөвхөн жижиг дунд үйлдвэрийн газрын зөвшөөрөлтэй газруудаас л ав гэнэ. Малчин, тариаланчид очихоор аль хэдийн технологи нь хуучирсан юмнууд байдаг. Буцаад малчин тариаланч хятадын зах зээлээс авч байна. Энэ тойргоо цэгцлээч.

Үүнтэй холбоотойгоор дараагийн шатны ярих юм нь малчин өрхийн аж ахуйг дэмжихийн тулд технологийн боломжуудыг олгох. Бид нар Өвөр Монголыг харж байгаа. Сүүгээ бүгдийг нь өрөм болгож байна. Маш бага цахилгаан хэрэглээд тогоор л болгож байна. Тэгэхээр хөдөө яаж газар плиткийг хэрэглэх вэ гэдэг стандартуудыг Монгол ахуйдаа тохируулаад шинэчлээд өгчхөөч, энэ бол Засгийн газрын өөрийнх нь ажил.

Дараагийнх нь Баасанжаргал гишүүн асууж байсан Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой судалгаа байна уу?. Байдаг. Би индэр дээрээс тухайн олон улсын байгууллагын судалгааны нэрийг хэлэх боломжгүй байна. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын маш олон байгууллагууд Монгол судлаачид, багш нараар маш олон судалгаануудыг хийлгэж байна. Хөрсний элэгдэл, жендерийн асуудал, малчдын асуудал, уур амьсгалын өөрчлөлтийн их хүндрэлтэй үр дүнгүүд гаргаж ирдэг. Судлаачид бидэнтэй ямар гэрээ хийдэг вэ гэхээр өөрсдийх нь зөвшөөрөлгүйгээр гаргаж болохгүй гэдэг. Тийм судалгаанууд байдаг, үүнийг бас та бүхний чихэнд дуулгачихъя. Монгол төр эдгээр мэдээллүүдээ олж аваасай гэж хүсэж байна. Баярлалаа

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ариунаад баярлалаа. Нэг оролцогч авчихъя, 4 номер дээр суугаарай.

Оролцогч М.Бямбаахүү: Баярлалаа. Сонсгол зохион байгуулж байгаа нь сайхан байна, зөв зүйтэй. Гэхдээ Монголын төр засаг томоохон салбар болох мал аж ахуйн салбараа, малчин уламжлалтай, өв соёлтой хүмүүс уул уурхайн дараа орж үнэлэгдэж байгаа нөхцөл байдал гайхмаар. Уул уурхайгаа, жишээлбэл том ордуудаа 1, 1-ээр нь ашиглаад хөгжлийн гарц гаргалгаа болж ашиглах юм бол бодит байдал дээр хөгжил дэвшил болно. Том уурхай ордоор Оюутолгойгоор жишээ авахад, өрөнд орох, эвдэж сүйтгүүлэх, говийн бүсээ өгөх нөхцөл байдал үүсээд байгаа.

Хуулийн сонсгол болж байна. Хуульд биднийг буюу малчид, иргэдээ сонсдог,

мэдээллээр хангаад, эргэж оролцоог нь хангадаг эргэх холбоотой байх юм бол зудын эрсдэл буюу гарч болох эрсдэлээс илүү ангид байж болохоор харагдаж байна. Яг зудын төв бүс буюу Айргийнхаа зүүн талд байсан учраас гарц гаргалгаа яг тухайн үеийн малчин надад бол харагдсан. Надад тэр хэмжээний чадал чансаа байхгүй учраас тодорхой хэмжээний өөрийгөө аврах, өрөөлийг аврах нөхцөл байдал байгаагүй. Тэгэхээр төр маань малчинтайгаа эргэх холбоотой байгаасай гэж бодогдож байна.

Мөн малын түүхий эдийн боловсруулалтын асуудал байгаа. Малчны хөдөлмөр үнэлэмжийг нь шууд баталгаажуулахын тулд дэлхийн зах зээл дээр тухайн ханшаар нь боловсруулдаг болгох хэрэгтэй. Энийг яаж болгох вэ гэхээр жишээлбэл сум, сумд нь лабораторитой болгоод түүнийгээ 1, 2, 3 буюу зэрэглэл, чиглэлээр нь ялгаад гаргаад ирвэл тухайн түүхий эдээ малчин хүн гар дээрээсээ боловсруулчих, ченжийн дамжлагагүйгээр явчих юм бол малчны хөдөлмөр шууд шударга үнэнээр үнэлэгдэх, ядуурлаас гарах боломжтой. Одоо заавал Монголд хүмүүс махаа үнэд оруулж монголдоо үнэтэй өгнө гээд Монгол хүн Монгол хүнээ мөлжиж амьдрахдаа биш, Монгол хүн дэлхийн зах зээл дээрээс ашиг олж цаашдаа хөгжих боломжтой гэдгийг харуулаад явах юм бол илүү үр дүнтэй. Цаг нь ямар хурдан дуусдаг юм. Түрүүчийнхээ ярьсан асуудлын хариултыг авъя гэсэн, одоо хүртэл яам нь ч алга, хариулт өгөх боломж нь ч алга байх шиг байна.

Уул уурхайн яам ирэх үү, энийгээ би бичгээр авъя гэж хэлсэн. Үүн дээр анхаараад бас хариуцлагатай байгаад өгөөсэй, төр малчдаа ирсэн дээр тодорхой хэмжээний асуудлыг хөгжил дэвшил рүү нэг алхам ойртуулаасай гэсэн санаа бодол төрж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Бямбаахүүд баярлалаа. Ажлын албаныханд та бүхний хаяг байгаа. Тэгээд өөрсдөө бас ажлын албаныханд хэн ажиллаж байгаа билээ? Тийм хяналт шалгалтынхан, референтүүд ажиллаж байгаа. Эд нартайгаа холбогдоод анх та бүхэн санал өгсөн шүү дээ тэрнийхээ хэмжээнд ийм саналуудад хариу авъя. Магадгүй одоо үнэхээр саяын тавьсан илтгэлүүдийг хүртэл та бүхэн авч болно. Орон нутагтаа очоод ийм ийм зүйлтэй, ийм мэдээлэлтэй байгаа юм байна. гэсэн байдлаар мэдээллээ хүртэл авах боломж бололцоо нээлттэй байгаа. Тэрийг та бүхэнд хангаж өгье. Ингээд оролцогчдоо сонслоо.

Одоо илтгэлтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. М.Ганхүлэг гишүүн.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Шинэ хоршооны тухай ярьж байна. Сонсгол зохион байгуулах, ажлын хэсгийн гишүүнээр ороод нэг санал дэвшүүлсэн. Малчид, оролцогч нарын яриан дээр гарч байна. Малчны өргөн хүрээтэй сонсгол болгоё гэдэг санал гаргасан. Байнгын хороон дээр ч тэр ажлын хэсэг дээр ч тэр.

Малчны тодорхой бусад малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль

байгаа. Малын генетик нөөцтэй холбогдолтой хууль байгаа. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг шинэ хоршоо хөдөлгөөний гол суурь хууль байгаа. Хуулиудыг цогцоор нь харах шаардлагууд байна гэдгийг саяны илтгэл харуулж байна. Протокол дээр байдаг юм уу? ер нь мал аж ахуйн чиглэлийн ажлууд дээр үргэлжлүүлэн нарийвчилж ярилцах шаардлагатай гэдэг дүгнэлтийг бас оруулах хүсэлтэй байна. Би бас сонсголын гишүүний хувиар илэрхийлье.

Малчны тухай хууль дээр хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй гэдэг ангиллаар зээлүүдийг олгоно гэсэн агуулга байгаа. Гэхдээ агуулгын хүрээнд яг шинэ хоршоо хөдөлгөөний энэхүү хөтөлбөрийг тайлагнаж оруулж болох уу, болохгүй юу, энэнтэйгээ уялдаж байна гэж үзэх үү, үзэхгүй юу гэдэгтэй холбогдолтой эхний асуулт байгаа юм.

2 дахь нь Монгол банкны төлөөлөл хэлэхдээ шинэ хоршоо хөдөлгөөний зээл 2 жил яваад 1 их наяд төгрөг хүрээд болж байгаа юм ярьчихаж байна. Тийм биш шүү 5 жилийн хугацаатай 5 хүртэлх их наяд төгрөгийн санхүүжилт бүхий шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолтой. 2024 оны 4 сарын 24-ний өдөр батлагдсан 166 дугаар тогтоол, миний санаж байгаагаар хүчин төгөлдөр мөрдөгдөөд явж байгаа. Хөтөлбөр эхний үе шат руугаа үндсэндээ ороод явж байгаа.

Цаашлаад дундын хоршоонуудыг бэлдэх үйл ажиллагаан дээрээ сургалт, мэдээлэл, зөвлөгөөнүүдийг авах хоршоодыг дараагийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн олон ажлуудыг орхичихсон байгаа.

1 дүгээрт хоршооны бүтэц зохион байгуулалт шууд удирдлагаар хангахтай холбогдолтой асуудал дээр хөдөө аж ахуйн яам руу шилжинэ гэсэн байгаа. Асуудал яг хэдийгээр шилжих вэ, ямар асуудал болох вэ гэдэг асуултыг асууя.

2 дугаарт нь саяны хэлж байгаа тооцоолол мэдээллээр бол 2026 онд 75,9 тэрбум төгрөгийг төсөвлөөд 39,9 тэрбум төгрөг гарсан байна. Үүний цаана байгаа 30 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох боломжтой юу? Төсөвлөсөн байгаа дээр өмнөх жилүүдэд төсөвлөснийхөө үр дүнд бас хүрээгүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: 1 минут сунгая.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Сүүлийн 30 жилд мал аж ахуйн салбарууд, хөдөө аж ахуйн салбар луугаа хүндээ, малчиндаа хүрсэн ийм тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй.

Шинэ хоршоо хөдөлгөөн алдаа оноотой ч гэсэндээ 100 гаруй малчид нэгдэж нийлэх хандлагыг дэмжсэн. Үүнээс 26 мянган малчид нь 20 гаруй хувийн хүүтэй байсан хүүгээ 6% болгож бууруулаад дээрээс нь зээлийн батлан даалтын давуу талын боломж ашиглаад бусад салбарынханд олдохгүй байсан зээлийг авах боломж бүрдсэн. Ингээд хоршооны гишүүн болсон 70 мянган малчин энийг хүлээж

байгаа. Тэр маргаантай байсан мал үржлийн чиглэлээр зээл олгоно гэсэн байсан заалтыг нь хасчихсан. Одоо зөвхөн трактор, аж ахуйн үйл ажиллагаа авах нөхцөлүүдийг нь бий болгочихсон. Хэрвээ төсөв байгаа энийгээ үргэлжлүүлээд олгоод явах хэрэгтэй. Маш хариуцлагагүй мэдээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. 11 номер.

ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат: Монгол Улсын Засгийн газар бол хөдөө аж ахуйн салбар тэр дотроо газар тариалан мал аж ахуйн салбар луу онцгой анхаарлаа хандуулж байгаа. Тэгээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлэх гээд зорьж байгаа арга хэмжээнд хүртэл Монгол улсын ерөнхий сайд ач холбогдол өгч, очиж оролцож, ажлыг хэрэгжүүлэх тал дээр шат шатны Засаг дарга нарыг шахаж шаардаж ажиллана гэдгээ бас илэрхийлээд явж байна. Тэгэхээр ер нь мал аж ахуйн салбар бол хөдөө аж ахуйн салбарын бодлогын бас их гол цөм явна гэдгийг малчдадаа бас хэлье гэж бодож байна.

М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Манай дээр ер нь хоршоо ярих юм бол урт түүхтэй 2024 оноос хоршооны маш том бололцоонуудыг малчдад олгосон. Үндсэндээ ингээд үзэхээр шинэ болон хуучин гэдэг 2 хоршоотой болчихоод байгаа. Өмнө нь байгуулагдсан хоршоо нь манай жижиг дунд үйлдвэрийн газрын нэг хэлтэс дээр харьяалагдаад, шинэ хоршоо буюу шинээр байгуулагдсан арваад мянган хоршоо Шадар сайдын ажлын албан дээр харьяалагдаад. Тэгээд Засгийн газрын зүгээс шинэ хуучин хоршоо гэж байхгүй. Монгол Улсад нэг л хөдөө аж ахуйн малчдын хоршоо байгаа, энийгээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлж гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ч гэсэн ер нь хоршоог шилжээд ирэх юм бол бид нар яамныхаа бүтэц зохион байгуулалтыг ч гэсэн хоршоотой уялдуулж хийе гэж байгаа. Ер нь урьдчилал болгоод нутагтаа эзэн болъё 100 мянга арьс ширний туршилтууд болгоныг бид нар хоршоо суурьтай явуулна гэсэн бодлоор концепцыг нь боловсруулсан, хэрэгжүүлж эхэлж байгаа. Одоо орон нутгаар явахад яг тэр хоршооныхон бол газар дээрээ нэгдээд л ороод ирэх жишээтэй явж байгаа гэдгийг бас хэлье. Тэгэхээр удахгүй асуудал шийдэгдэнэ.

Шинэ хоршоон дээр зориулагдаж байгаа зээл бол 2026 онд нэг ч төгрөг тавигдаагүй. Тухайн үед олгосон зээлийн тодорхой 12%-ийг төр хариуцаж байгаа. Тэр зээлийн эргэн төлөлт эргүүлээд арилжааны 8, 9 банкнууд руу шилжүүлгийг нь хийгээд тэр нь төсөв дээр тавигдаад л явж байна.

Цаашдаа шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд Монгол Улсад 15100 хоршоо байгуулагдаж 286,9 мянган хүн хоршооны гишүүн болоод ажиллаж байна. Нийт 840 гаруй тэрбум төгрөгийн зээл олгосон. Зээлийн эргэн төлөлт Зээлийн батлан даалтын сангийн өгч байгаа мэдээллээр харьцангуй сайн явж байгаа. Тэгэхээр тухайн үед шинэ хоршоог эсэргүүцээд малчид зээл авч болохгүй шүү гээд л ярьж байсан. Миний хувьд бол тухайн үед юу гэж хэлж байсныг малчид тэнэг хүн биш энэ бололцоог маш зөв ашиглаад өөрсдийнхөө...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. нэмж Шадар сайдын ажлын алба хариулъя. 8 номер.

Шадар сайдын ажлын албаны Шинэ хоршоо хариуцсан шинжээч Б.Болд: Шинэ хоршооны чиг үүрэг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд явж байгаа. Тэгээд сая Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд яриандаа дурдлаа. Манайх шинэ хоршоо хөдөлгөөнийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам руу шилжүүлэхээр холбогдох бичиг баримтын бүрдлийг хангаад Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад явж байна. Ойрын үед асуудал шийдэгдэнэ.

Ер нь 2024-2026 онд 12%-ийн зээлийн хүүгийн татааст улсын төсөвт 202,4 тэрбум төгрөг сууснаас 147,4 тэрбум төгрөгийн татаасыг олгочоод явж байгаа. Зээлийн эргэн төлөлт, чанар нь өндөр түвшинд зээлийн төлөлт бол сайн байгаа мэдээлэл өгөх байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ – Т.Аубакир сайд ирсэн байна. Т.Аубакир сайдын илтгэлийг сонсчихоод нэг мөр дахиад тодруулаад явчих уу? М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Саяын илтгэл дээр 2024 онд 75,9 тэрбум төгрөг төсөвлөсний 39,9 тэрбум нь гарсан байна гэдэг ийм илтгэл гарсан учраас би хэлж байгаа юм. Хэрвээ үлдэгдэл санхүүжилтүүд байгаа бол тодорхой хүсэлтүүдийг нь аваад зээлүүдээ олгоод явах хэрэгтэй. Төсөвлөснөөсөө гүйцэтгэлийн хувьд бага байгаад байна гэдэг асуулт.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам руу шилжиж байгаа юм байна. Илүү уялдаа холбоотой ажиллана гэдэгт найдаж байна. Хөтөлбөр 5 жилийн хугацаанд явж байж үр дүнгээ өгнө. Гол зорилго нь бол тухайн малчин орлого нь үндсэндээ зарлагадаа хүрэхгүй байгаад байгаа учраас хөтөлбөрийн эцсийн үр дүнд 2-3 дахин нэмэгдэх ийм тооцооллын үндсэн дээрээс хөтөлбөр эхэлсэн. Тийм учраас төслийнхөө үр дүнг зайлшгүй үзэж, тодорхой хэмжээнд ажлуудыг нь сайжруулаад үргэлжлүүлээд явах ёстой гэдгийг анхааруулж хэлье.

Хоршиж нэгдсэний олон үр дүнгүүдийн тухай бол бид бүхэн ярьж байгаа. Ингээд 30...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж үгээ хэлье.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Баярлалаа. Өнөөгийн байдлаар зээл авсан малчдын орлого 34%-аар нэмэгдсэн гэдэг ийм тооцооллууд байх шиг байна. Тооцооллыг илүү дэлгэрүүлж асууя? Үндсэндээ малчдын орлогыг нэмэгдүүлэх гэдэг суурь зорилготой. Орлогоо нэмэгдүүлэхэд нь тоног төхөөрөмж тодорхой нөхцөл байдлаар нь хангах ийм л зорилготой байгаа.

Тэгээд бид төрөөс янз бүрийн халамж үйлчилгээ гэхээсээ илүүтэй хөнгөлөлттэй зээлийн боломжийг л нэхэх нь зах зээлийн нийгэмд хамгийн зөв шийдэл болж хувирч байгаа. Тэгэхээр малчдын хувьд ч гэсэн илүү сайжруулах чиглэлийн юмыг анхаарах хэрэгтэй.

3 төрлийн боломж нь бага хүү Зээлийн батлан даалтын сан. Хамгийн гол чухал зүйл нь 5 га газар байгаа, 5 га газрыг хэчнээн хоршоо авсан талаарх мэдээлэл сая дутуу өгөгдлөө. Тэр 5 га газрын талаар мэдээлэл өгөөч? Газар олголттой холбоотой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Малчдын орлогыг нэмэгдүүлэх үндсэн суурь зорилготой байгаа биз? 5 га газрыг хэрхэн шийдвэрлэсэн юм. Шадар сайдын ажлын алба хариулъя. 5 га газартай холбоотой асуудлууд хэрхэн шийдэгдсэн юм. 4 номер дээр суучих. Өөрийгөө танилцуулаарай.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчдын хоршоонд газар олгосон байдлын талаар мэдээллийг танилцуулъя. 2026 оны 6 сарын 02-ны байдлаар газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн тоогоор нийт 643 хоршоонд газар эзэмшүүлэх шийдвэр гарсан байна. Засаг даргын шийдвэрээр 643 хоршооны 399 нь мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар олгогдсон. 244 нь бол бусад мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой зориулалтаар олгогдсон гэсэн ийм дүн мэдээ байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайдын мэдээллийг сонсчихъё. Г.Тэмүүлэн гишүүн, Г.Ганбаатар гишүүдийн нэрийг сануулчхаарай. Тэгээд араас нь нэг мөр явчихъя. Түрүүн анхнаасаа төлөвлөгөөгөөр нэг мөр явах гэж байсан. Малчны хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал гэсэн сэдвээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулга хийнэ.

ГБХНХ-ын сайд Т.Аубакир: Та бүхэнд энэ. Өдрийн мэндийг хүргэе. 2025 оны жилийн эцсийн байдлаар 313 мянган мал малчин 247,9 мянган малтай өрх байгаа юм. Нийт малтай өрхийн 61,7% нь 200 хүртэл буюу цөөн малтай өрх байна. Манай улсын нийт ажиллагсдын 23%-ийг малчид эзэлж байгаа. Нийт малчдын 25 орчим хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж байгаа нь тэдний дийлэнх нь нийгмийн хамгааллын баталгаа хангагдаагүй хөдөлмөр эрхэлж байгааг харуулж байгаа юм. Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлт болон шилжилт хөдөлгөөн нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан малчдын залгамж холбоо алдагдаж тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд эрсдэл учруулах тал ажиглагдаж байна.

Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах бодлого арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

1 дүгээрт цөөн малтай болон малгүй иргэдийг дэмжих зорилгоор малжуулах арга хэмжээг хэрэгжүүлж 8 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгож байна.

2 дугаарт байгалийн гамшиг болон эрсдэлт нөхцөлд бэлэн байдлыг хангах мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг нэмэгдүүлэх ур чадварыг эзэмшүүлэх, дээшлүүлэх сургалтад малчдыг хамруулах.

3 дугаарт орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч болон борлуулалт, худалдааны сувагтай холбох замаар малчин өрхийн үйлдвэрлэл орлогыг нэмэгдүүлэхийг дэмждэг. Мөн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эрчимжсэн мал аж ахуйн туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж малчдыг оролцуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

4 дүгээрт туслах малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд мал бүхий ажил олгогч болон туслах малчнаар ажиллах иргэнийг зуучлах хөдөлмөрийн гэрээ байгуулах замаар туслах малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд 2024 онд мал худалдан авахад зориулж 3319 малчинд 26,4 тэрбум төгрөг, 2025 онд 891 малчинд 7 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан.

Түүнчлэн мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалтад 2025 онд 1541 иргэнийг, 2026 онд 704 иргэнийг тус тус хамруулсан байна. 2026 онд 1051 малчинд 8,4 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох, 838 иргэнд мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалтад хамруулах ажлыг зохион байгуулан үргэлжилж байна.

Малчдын нийгэм хамгааллын бодлогын талаар малчдын хөдөлмөр эрхлэлтийн онцлог улирлын чанартай орлого, байгаль цаг уурын эрсдэлийг харгалзан малчдын нийгмийн хамгааллын бодлого хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд нийгмийн даатгалын ерөнхий хуулиар 2024 оноос малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50%-ийг 5 жилийн хугацаанд төрөөс хариуцан төлж байгаа. Үүний үр дүнд 2024 онд 51,5 мянган малчин нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж тэдний шимтгэлийн зардалд улсын төсвөөс 24,4 тэрбум төгрөгийг хариуцан төлсөн байна. Мөн 2025 онд нийгмийн даатгалд сайн дураар 56,5 мянган малчин хамрагдаж 35,5 тэрбум төгрөгийн шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн бол 29,6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хариуцан төлсөн болно.

Түүнчлэн 2017 оноос малчид өндөр насны тэтгэвэрт 5 жилийн өмнө буюу эмэгтэй 50 эрэгтэй 55 насанд тэтгэвэрт гарч байна. Энэ хүрээнд 2024 онд тэтгэврийн даатгалын сангаас 32,3 мянган малчны өндөр насны тэтгэвэрт 237 тэрбум төгрөг, 2025 онд малчнаар тэтгэвэр тогтоолгон авч байгаа 34,5 мянган тэтгэвэр авагч байгаа бөгөөд тэдний тэтгэвэрт 2025 онд 287,8 тэрбум төгрөг

зарцуулсан байна.

Манай улс малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх 2 удаагийн хуулийг хэрэгжүүлсэн. 2012 онд Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд тус хуулийн үйлчлэлд 607,8 мянган иргэн хамрагдаж 37,9 тэрбум төгрөгийг нөхөн төлсөн. Одоогийн байдлаар энэхүү хуулийн үйлчлэлд хамрагдсан 324,1 мянган хүн тэтгэвэр тогтоолгоогүй байгаа бөгөөд эдгээр иргэдийн тэтгэвэрт 1,9 их наяд төгрөгийг зарцуулаад байна.

Цаашид хуулийн үйлчлэлд хамрагдсан иргэд тэтгэвэр тогтоолгосноор энэхүү зардал жил бүр нэмэгдэж байна. Мөн Улсын Их Хурлаас 2017 онд Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг батлан 2020, 2021 онд хэрэгжүүлсэн. Хуулийн үйлчлэлд 34,4 мянган иргэн хамрагдаж 76,4 тэрбум төгрөгийн шимтгэлийг нөхөн төлсөн хэдий ч одоогийн байдлаар хуулийн үйлчлэлд хамрагдсан иргэдээс 24,2 мянган хүн тэтгэврээ тогтоолгож тэдний тэтгэврийн зардалд 290 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх нь зарим иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах хэдий ч шимтгэл төлсөн хугацаа төлсөн шимтгэлийн хэмжээнээс хамаарсан тэтгэвэр тэтгэмж авах агуулга бүхий нийгмийн даатгалын тогтолцоонд шударга бус байдлыг бий болгож байна гэж үздэг.

Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх гэж, 4.3 дахь хэсэгт хуулийн 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна гэж. Мөн хуулийн 16.1 дэх хэсэгт хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө гэж тус тус заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журмын төслийг нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй 1995-2025 онд малчнаар ажиллаж байсан болон ажиллаж байгаа 5 ба түүнээс дээш жил нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн малчин даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 5 хүртэл жилээр нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалтыг тусган боловсруулсан. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 5 хүртэл жилээр тооцон нөхөн төлүүлэхэд 38,2 мянган малчин хамрагдаж тэтгэврийн даатгалын санд 194,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрөх бол хууль хэрэгжих эхний жилд 4,7 мянган малчны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, тэдний тэтгэвэрт 29,9 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоолол гарч байгаа юм.

Энэхүү тэтгэврийн даатгалын сангийн зардлыг жил бүр олгох ба тэтгэвэр авагчийн өсөлттэй уялдан тэтгэврийн даатгалын сангийн зардал эрс нэмэгдэхээр

харагдаж байгаа. Тухайлбал хуулийн хүрээнд 2027 онд 6,8 мянган малчны тэтгэвэрт 42,8 тэрбум төгрөг, 2028 онд 9,2 мянган малчны тэтгэвэрт 68,2 тэрбум төгрөг, 2029 онд 11,9 мянган малчны тэтгэвэрт 98,6 тэрбум төгрөг, 2030 он гэхэд 14800 малчинд 136 тэрбум төгрөг буюу зөвхөн эхний 5 жилийн хугацаанд малчны тэтгэврийн зардалд 375,5 тэрбум төгрөг зарцуулах тооцоолол гарч байна.

Журмын төсөлд Засгийн газрын гишүүдээс 3 удаа санал авсан бөгөөд Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Эдийн засаг хөгжлийн яамнаас төсөвт үзүүлэх нөлөөлөлтэй холбогдуулан дэмжих боломжгүй талаар саналаа ирүүлсэн байдаг. Түүнчлэн нийгмийн даатгалын сангийн 2025-2026 оны Төсвийн тухай хууль, Малчны тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбоотой зардал мөн бас тусаагүй болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд Ганзоригийн Тэмүүлэн, Гомбын Ганбаатар нар нэрээ өгсөн байгаа. Нэмж асуулт асууж, үг хэлэх гишүүд. Нэрсээ өгье. М.Ганхүлэг гишүүнээр тасалъя.

Иргэдээс дахиад нэр. 7 номер тасаллаа. Эхнээсээ 4 номер дээрээс саналаа хэлье.

Хил хязгааргүй алхам ТББ Н.Баярсайхан: Юуны өмнө Т.Аубакир сайдад баярлалаа. Хүрэлцэн ирсэнд. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Уул уурхайн яамны сайдууд бол ирэхгүй юм шиг байна. Тэд нарт бичгээр санал өгье гэж. Т.Аубакир сайд аа уул уурхайн болон зам тээвэр нөлөөллийн бүсэд ойролцоогоор 4 мянга гаруй өвөлжөө, хаваржаа байгаа юм байна. Дунджаар зуугаад мянган малчин байгаа юм байна. Гэхдээ дутуу тоо байна. Нөгөө гэрчилгээгүй тоонд орохгүй учраас дутуу байна. Хамгийн их газар алдаж байгаа нь бол газрын харилцаа геологи зураг зүйн газрын мэдээллээс харахад говийн 4 аймаг хамгийн их газраа алдаж байгаа юм байна. Өвөлжөө, хаваржаа лиценз дотор амьдарч байгаа юм байна. Энд байгаа хүн амын нийгмийн асуудлыг одоо анхаарахын хувьд бол танай яамнаас юу хийх ёстой вэ гэхээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнээс гадна нийгэм соёлын нөлөөллийн үнэлгээний эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Та онцгойлон анхаараач.

Байгаль орчны асуудлаа Байгаль орчны яам хариуцчихаад байгаа. Яг хүнд ямар нөлөө үзүүлэх юм бэ? Хүний эрх, малын эрүүл мэндэд нь цаашлаад нүүдэлчин соёл, хүнсний аюулгүй байдал, үндэсний олон хүчин зүйлд сөрөг нөлөө үзүүлсээр байгаа.

Ингээд уул уурхайг бид нар тэргүүлэх салбар гэж харсан хэрнээсээ мал аж ахуйн салбараа бид нар одоо чухал салбар гээд 2 өдөр ярилаа. Та мэдсэн байх. Танайхан бас хэлэх байх. Тэгэхээр яг нүүдлийн соёлд түүнийг эрхэлж байгаа, мэдлэг тэлж малчдын нийгмийн асуудлыг уул уурхайн салбараас хамгаалахад, эрсдэлээс урьдчилан сэргийлж, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх асуудлаар та анхаараач ээ. Яг асуудал дээр анхаарахын тухайд 1 дүгээрт Газрын тухай хууль,

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Малчны тухай хуулийг зайлшгүй Ашигт малтмалын тухай хуультай уялдуулах хэрэгтэй. Ингэж байж нөгөө дээлтэй гуталтай жинхэнэ Монгол хүн гэж харагддаг шиг, жинхэнэ Монгол малчин Ерөнхий сайдын хэлдгээр нарлаг Монголын малчид бий болох гээд байна. Тэгэхгүй бол малчид ерөөсөө энд тэндээсээ эрхээ хасуулсаар байгаад мал маллах малчингүй болж байгаа чинь яг энүүнтэй холбоотой юм. Тэгэхээр малчдын нийгмийн хамгааллын асуудал дээр та онцгойлон анхаараач. Танд албан бичиг бас өгье гэж бодож байна. Хүсэлтээ бичгээр өгье. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. дараагийнх 4 номер.

Оролцогч Г.Мөнхбат: Сайн байцгаана уу? Оройн мэндийг хүргэе. Архангай аймгийн Ихтамир сумаас хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч Г.Мөнхбат. Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас асуух асуулт байна. Сонсгол бол үнэхээрийн цагаа олсон байна. Малчны тухай хуулийн 4.2.9 дээр өндөр насны тэтгэвэр тогтоосон малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх хууль батлагдсан. Түрүүн төрийн нарийн бичгийн дарга болохоор хууль цаашид явах боломжгүй гэж хэлсэн байсан. Сайд маань 2 дугаар сард “Сүбээдэй” сайтад ярилцлага өгөхдөө хууль маань одоо 1 дүгээр улиралдаа багтаад хэрэгжүүлээд явна гэж хэлсэн байсан. Энийг хэрэгжилт нь яагаад зөрөөд, зөвхөн худлаа мэдээлэл явж байгаа юм бэ гэж хэлэхээр байна.

Малчид бол дан ганц мал малладаггүй, тухайн байгаа орчиндоо байгаль, ан амьтан, бэлчээрийг хамгаалж байдаг нүүдэлчин өв соёлоо тээж яваа малчид. Ийм учраас одоо 50%-ийг нь төрөөс нийгмийн даатгалын санг төлж байна гэж би ойлгож байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. дараагийнх нь 4 номер.

Оролцогч Ч.Саранмандах: Сайн байцгаана уу? Ч.Саранмандах. Хил хязгааргүй алхам төрийн бус байгууллагын зохицуулагч байна. Би 3 санал хэлмээр байна.

1 дүгээрт нь сошиалаар хүмүүсээ харахаар нийгмийн даатгалын шимтгэл, ипотек тэгээд хуульд тусгасан хамаг хүнд таалагдах, тэр хэллэгүүдийг оруулсан байгаа. Тэр заалтуудыг малчид хүсээд оруулаагүй. Тэгээд хуульд тусгаад оруулчихсан байгаа зүйлийг чинь л хэрэгжилт нь ямархуу байна вэ гэдгийг өөд өөдөөсөө хараад сууж байгаа нөхдүүдээс л хангаад өгөөч л гэж хэлж байгаа юм. Тэгэхээр малчид нийгмийн даатгалыг тэглээд өгөөч, нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөөд өгөөч, тэтгэврийг тэглээд өгөөч гэж хүссэндээ тэгээгүй. Хуулийн заалтад хамаг л таалагдах юмнуудыг оруулчихсан болохоор тэрний хэрэгжилт ямархуу байна вэ гэдгийг шалгаж байгаа шүү.

2 дугаарт нь нэг ийм жишээнүүд их гарч байна. Тэр нь замын хөдөлгөөний

дүрмийн 26.4, 5, 6, 7 гээд заалтууд байгаа. Заалтууд болохоороо манай малчин нүүдэллээд бэлчээрлээд явж байдаг. Тэгэнгүүт энэ заалтууд болохоороо тийшээгээ малаа тууж болохгүй шүү гэдэг. Тэгээд яг бодит байдал дээр мал зам хөндлөн гараад явангуут машин хүрч ирээд мөргөнө. Шүүх дээр очоод жишээ нь болохоороо малчин хохирол барагдуулах болоод явчихдаг. Тэгэнгүүт нөгөө малыг нь үнэлж байгаа үнэлгээ нь яаж үнэлээд байгаа юм нь байхгүй. Энийг нийгмийн хамгаалал эд нарт нь ерөөсөө огт дурдсангүй. Өчигдрөөс хойш, өглөөнөөс хойш сонсоод байна. Малын үнэлгээ гэдэг юм ерөөсөө байхгүй байна. Тэр тэмээ зах зээлийн үнэ 3 сая гэж байгаа. Машинтай мөргөлдөө машины эвдрэл 6 сая, тэгэнгүүт малчин 3 сая төгрөгийн төлбөр ноогдуулах болж байгаа юм. Хоёулаа дундаа тохиролцоод малчин нэмэлтээр 3 сая төгрөгийн хохирол төлөх болж байгаа юм. Зөвхөн зах зээлийн үнээр байгаа тэмээг харьцуулж байгаа юм. Тэр тэмээний 10 жилийн өгөх үр өгөөжийг яагаад тооцохгүй байгаа юм бэ? Энэнээс л эхэлмээр байгаад байгаа юм.

Хуулиудыг хооронд нь нийцэхгүй байна гээд зөндөө олон хүмүүс хэллээ. Хамгийн гол нь практик дээр би малчин хүн малчныхаа тухай хуулийг бариад очлоо. Малчины тухай хуулийн 7.3-ыг би барьж очоод миний өвөлжөөний газар надад хориглоно, энэ дээр давхцуулж ямар нэгэн лиценз олгохгүй гэдэг ямар нэгэн байдлаар ашиглуулах зөвшөөрөл олгохгүй гээд очдог. Тэгэнгүүт Ашигт малтмалын тухай хуулиар уучлаарай наадах чинь манай хуультай хамаагүй манайх хуулиа дагана гэдэг. Тэгэнгүүт яам, яамдууд, салбар салбарууд хоорондоо түлхчихдэг. Голд нь иргэн хаягдчихдаг, малчин хаягдчихдаг. Тэгэнгүүт малчин тухай...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: өөрөө хэн билээ.

Оролцогч Ч.Саранмандах: Саранмандах

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ч.Саранмандах буруу явчих шиг болох юм наадах чинь, бид ерөөсөө Нийгмийн даатгалын шимтгэл төлүүлэх гээгүй малчид төлүүлэх гээгүй та бүхэн л төлж өгөх гээд байна шүү дээ гэсэн нэг юм явчих юм. Уг нь бол хууль санаачилж байгаа явцад бид нар нэлээн судалгаа хийж байж гаргаж ирсэн асуудал шүү. Түүнээс биш энийг дараагийн асуудал дээр бодолцохгүй бол болохгүй байна. Ийм юм ярьж болохгүй байх. Дараагийнх нь 3 номерын микрофон, 2 номерын микрофон.

Оролцогч Г.Алтанхуяг: Судлаач Алтанхуяг. Малчны тухай хуулийн 6.2-т заасан боловсролын асуудлуудаас л ярина.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Илтгэлтэйгээ холбоотой асуулт асуух юм уу? саналуудаа хэлбэл их зүйтэй байх.

Оролцогч Г.Алтанхуяг: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам өнөөдөр насан туршийн боловсролыг хариуцаж байгаа юу, хариуцахгүй байгаа юу? хариуцахгүй бол ямар яам нь хариуцаж байгаа юм бэ? Хуучин чадамжид суурилсан

сургалтын үйл ажиллагааг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам аваад явж байсан. Одоо Боловсролын яам руу орчихсон ч юм шиг, ороогүй ч юм шиг энэ асуудлууд нь шийдэгдэхгүй байгаад байгаа юм.

Малчны тухай хуулийн 6.2. болохоороо их, дээд сургууль, коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгаа юм. Их дээд сургууль гэдэг нь болохоор бакалавр ба түүнээс дээшээ байхгүй, Коллеж гэдэг нь болохоороо чинь нөгөө нэг мэргэжлийн сургалтын чиглэлээр техникийн сургалтын чиглэлээр тусгай зөвшөөрлүүд нь олгогддог ийм юунууд гараад явж байгаа юм л даа. Тэгэхээр энийг хооронд нь ялгах хэрэгтэй. Боловсролын асуудлууд дээр ийм санал байгаа 2, 3 жилээр 1,5 жилээр тусгай зөвшөөрөл олгогддог энэ дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсролын яам өөр ямар яамтай харилцаж байдаг юм энэ тусгай зөвшөөрлийн шаардлагыг бууруулмаар байна. Бууруулах хэрэгтэй байгаа юм. Дахиад дээр нь боловсролын тэтгэлэг гээд олгогддог. Тэр тэтгэлгийг нэмэгдүүлээд хувьсах зардлыг жоохон нэмэгдүүлэх ийм боломжууд байгаа юу? Яг энэ малчидтай холбоотой шүү. Малчны мэдлэгтэй холбоотой асуудлуудыг багшлах боловсон хүчний эрх, зөвшөөрлийн асуудлууд энд нэг ийм юм байгаа юм.

Хууль дээр уламжлалт мэдлэг гэгчихсэн байгаа. Уламжлалт мэдлэгийг олгодог хүмүүст ямар нэгэн их дээд сургуулийн дипломтой хүмүүс байхгүй, энэ хүмүүс нь малчид өөрсдөө байна. Тэгэхээр энэ дээр яг тусгай зохицуулалт хийгээд оруулж өгөх ийм зөвлөмжүүд дээр би санал оруулмаар байна.

Төрийн өмчийн мэргэжлийн 7.5 дээр байгаа тэр насан туршийн боловсрол гэдгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцаж байгаа шууд сумын Засаг даргатайгаа 7.5-раа шууд харилцаад тэр боловсролыг олгоод явуулах боломжтой. Манай байгууллага 2019 оноос хойшоо чадамжид суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулсаар өнөөдөр ирсэн байгаа юм. Яг одоо Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2025 онд гаргасан тэр журам яг тэр чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр байгаад байна. Тэрэнтэй чиглүүлээд гарсан хөтөлбөр байна. Одоо яг би тэрнийгээр манай сургалтын төв чадамжид суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа малчдын боловсрол бол уламжлалт мэдлэг олгох тухай гэдгийг л дахин дахин хэлье. Энийг яг хуулийн зорилго дээрээ байхгүй Уламжлалт мэдлэг. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: дараагийнх нь 3 номер.

Оролцогч Р.Мөнхтөр: Би Сүхбаатар аймгийн Халзан сумаас ирсэн малчин Р.Мөнхтөр гэдэг хүн байна. Сонсголд оролцож байгаа та бүхэндээ өдрийн мэндийг дэвшүүлье. Малчны тухай хууль санаачилсан, санаачлан батлуулсан Тэмүүлэн гишүүн болон сонсгол зохион байгуулж байгаа Улсын Их Хурлын гишүүд Та бүхэндээ талархал илэрхийлье.

Малчны тухай хуульд заасан малчнаа чадавхжуулах чадвартай малчин бэлтгэх талаар орсон заалт нь үнэхээрийн ус агаар мэт хэрэгтэй заалт гэж боддог.

Чадвартай малчин, чадавхжуулсан малчин бэлтгэх юм бол Монголын мал аж ахуйн салбар чинь амиа даагаад явчихна гэж боддог.

Аймаг, сум, багууд малчдаа чадавхжуулах талаар үнэхээрийн муу ажиллаж байна Хуучин, шинэ хоршоо гэж юу яриад байна вэ. Хоршоогоо хуучнаар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр нь байлгаж байвал хэрэгтэй юм биш үү?

Малчин бид Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг бол ухаантнууд гэж боддог. Та нар маань алдаатай хууль алдаа гаргавал Монголын ард түмэн хохирно. Харин малчин би алдаа гаргавал миний эхнэр, хүүхдүүд, би өөрөө хохирно гэж боддог.

Ер нь Монгол хүн нэг л ажлыг гарцаагүй сайн хийх юм бол Монгол орон хөгжихөд их хялбар амар болно гэж боддог.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 4 номер

Оролцогч М.Батболд: Би Дорноговь аймгийн Эрдэнэ сумаас ирсэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас юм асууя. Малчны тухай хууль батлагдаад 2 жил болоод яагаад батлагдсангүй вэ? Та батлахад нь цуг баталсан хүн тэгээд дундаас нь яагаад няцав. Хэдэн гишүүн батлав. Хэд нь одоо энд сууж байна вэ? малчдад хэрэгтэй зүйл, Малчид бид нар бол жирийн 4 улиралд гадаа гандаж хөдөө хөхөрч явдаг, оройн бор хоногтоо гэртээ ирдэг, малчид ер нь их хөдөлмөрч, хөдөө аж ахуй том салбарт их ажил хийж байна. Эрүүл мэндээрээ их хохирч байгаа.

Тэгээд би буцаад очиход малчид маань асууна, хууль хэзээ хэрэгжих вэ? Энийг ямар хүн хариулах вэ? Би очоод юу хэлэх вэ? Одоо энэ оны ар дээр хэрэгжих үү? Би ер нь энд суусан гэдгээрээ орон нутагтаа очиж юу хэлэх юм бэ? Эндээс сайн шийдвэр гарахгүй байна. Энийг хурал тарахаас өмнө нэг хүнээс шийдвэр аваад, багцаа аваад явмаар байна. Оны наана уу, цаана уу, хэрэгжих үү хэрэгжихгүй юу гэдгээ бас нэг хариулт тавиад явахгүй бол тэнд бас олон хүн хүлээж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Та бүхэн маань бас нэг зүйлийг анхаараарай. Хяналтын сонсгол бодит байдлыг үзэх, харах, сонсох, мэдээлэл авах, тэгээд мэдээж сонсголоос зохих байгууллагад чиглэл өгөх юм шүү дээ. Түүнээс биш эндээс нэг асуудлыг за тийм шийдлээ гээд цохидог ч байдаг юм уу, ийм шийдэл бас гарахгүй. Энийг бол бид нар цааш Засгийн газар болоод бусад байгууллагад шийдвэрлэх эрх бүхий байгууллагад чиглэл өгөх юм энийг бас харахгүй манай оролцогчид маань шууд шийдвэр сонсоод явчих гэсэн ийм бодолтой байх шиг байна. 4 номер.

Оролцогч М.Сосоржав: Архангай аймаг, Жаргалант сумын малчин Сосоржав гэдэг хүн байна. Миний гол зорьж ирж Та бүгдийн сонсголд оролцох санал шалтгаан бол нийгмийн даатгалын нөхөн тооцохыг төр засаг минь нэг хэрэгжүүлж өгөөч нэг удаа гэж л хүсэлттэй ирсэн юм. Хууль тэгээд ерөнхийдөө

хэзээ хэрэгжих юм. Энэ хуулийн талаар яамдууд бас нэг сайн ажиллаж өгөөч. Энэ 375 тэрбум төгрөг гээд байна. Би болохоор сая буруу ойлгоогүй бол нийгмийн даатгалыг нөгөө 50% нь төр 50%-г нь төлж байгаа гэж байгаа. Тэгэхээр их хэмжээний мөнгө ингэж байгаа юм чинь малчид нөгөө 50% гэдэг чинь 61,8 гээд 180 мянган төгрөг төлж байгаа. Тэгэхээр 375 тэрбум төгрөг ингээд орж байхад түүнээс 60%-ийг нь малчид төлөхөд тодорхой хэмжээний нийгмийн даатгалын санд орж байгаа гэж би ойлгож байгаа. Тэгэхээр малчдыг та бүгд минь, төр засаг минь ерөнхийдөө дорд үзээд байна уу? гэж би өнөөдрийн юмнуудаас харж сууна. Яагаад ингээд дорд үзээд байна гэхээр өнөөдрийн бид хэдийн байж байгаа Хаа байгаа 540км газар яваад ирсэн хүн энд сууж болж байхад, энд Улаанбаатарт байгаа хүн энд суух боломжгүй. Ингээд л янз бүрийн ажилтай гээд явж байх гэдэг чинь бол бас бид хэдийг хүндлэхгүй байгаагийн шинж юм уу л гэж би ойлгож байна.

Сангийн яам болохоор малчдын нийгмийн даатгалын нөхөн төлөх талаар Санхүүжилт босгох гэж хайж үзсэн үү гэж асуумаар байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: баярлалаа. 4 номер.

Оролцогч Ц.Бийбат: Нийгмийн даатгалын нөхөн тооцох талаар асуулт асууя. Булган аймгийн Рашаант сумаас оролцож байгаа малчин Бийбат гэж хүн байна. Т.Аубакир сайдад энд ирээд мэдээлэл өгсөнд баярлалаа. Хууль 2026 оны 1 сарын 1-нээс хэрэгжихгүй 2 жил гаран болоод хуулийн сонсгол явж байгаа. Хууль гарахад малчин түмэндээ төр анхаарал хандуулж гараа сунгаж сэтгэл гаргаж байгаа юм байна гэж хүлээж авсан. Тэгээд явцын дунд болон саяын 2 хоногийн мэдээлэл дээр зарим нь сайдаас хамаараад байгаа юм шиг янз бүрийн л юм байна. Хувь хүнээс хамаараад байгаа ч юм шиг. Тэгэхээр малчин түмэн, одоо Монгол мал аж ахуйн орон шүү дээ.

Тэгэхээр иймхэн юман дээр хамгийн том уул уурхай ашиглаж байгаа орон шүү дээ. Төр яагаад нэг ийм юман дээр жижигхэн шийдвэр байхгүй. 5 жилийн юмыг л 375,5 тэрбум гээд байна шүү дээ. Тэгэхээр иймхэн жижигхэн юман дээр гол салбар, ер нь ямарваа нэгэн орон оршин тогтнохдоо гол салбаруудаа бодлогоороо хүүгийнхээ татаасаар л авч явдаг шүү дээ. Тэгээд ийм жижигхэн юман дээр сайдууд нь солигдоод, бултаад ирэхгүй байгаа ч юм шиг шийдвэрээ гаргаж чадахгүй байгаа ч юм шиг. Бид чинь тусгаар улс шүү дээ, 60 хэдэн сая малтай, өв соёлоо тээгээд явж байгаа. Иймхэн юман дээр шийдвэр гаргах, мэдэхгүй бол их гайхаад олохгүй байна. Нэг ийм саналаа хэлчихье, бараг би таныг хийчих байх гэж найдаж байна.

Яамдуудын тоо нь малчин хүний тоо, малчин өрхийн тоо 2 зөрөөтэй гараад байна. 180 ч юм шиг 230 ч юм шиг, нэмэгдээд 300 хэд бол худлаа. Би нэг юм хэлье Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зөвхөн малчин өөр хөдөлмөр эрхлэх нь хориотой байдаг юм. Өнөөдөр малчдын тоо буурчихсан. Яагаад вэ гэвэл Гашуун сухайт, Тавантолгой, Сүхбаатарын Бичигтийн боомтоор бүх малчид жолооч, туслах гээд ажил хийгээд авгай нөхөр нь зөрөөд явж байгаа. Ажил хийгээд л нийгмийн даатгал төлчихсөн бол малчин устана шүү дээ. Яагаад тоо хэвээрээ байгаад байгаа юм.

Манайх нүсэр бүтэцтэй яам, бүх яам нь нэг их олон агентлагтай, дотроо аймагтаа газартай, сумдаа мэргэжилтэнтэй нүсэр бүтэц яагаад ийм үхээнц байдаг юм? Яагаад ийм амьгүй байдаг юм. Тэгээд ийм байхаар чинь Монгол орны тусгаар тогтнол үгүй болно. Газар сайгүй хужаа нар ерөөсөө газар ухаад байна. Үгүй энэ чинь хуульгүй Монголд л ингэж байгаа байхгүй юу. Ийм дорой байхад чинь гаднынхан л баярлана. Өнөөдрийг...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Оролцогчид үг хэлж дууссан уу? Сүүлийнх үү? 4 номер.

Оролцогч Ц.Ундармаа: Одоо бол хамгийн сүүлийн асуулт байх. Хамгийн сүүлийн санал хэлэх боломж байх гэж бодоод ирээд суучихлаа. Монгол орны 133 сумд малаа адгуулан маллаж суугаа нийт малчдынхаа өмнөөс хуулийг санаачилж байгаа Г.Тэмүүлэн гишүүндээ болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат гишүүндээ хэдэн үгийг дайя. Энэхүү хуульдаа тусгаад өгөөрэй.

Уул уурхайн лиценз болон хайгуулын лиценз зэргийг ирэх 2026 оны 5 сарын 22-ны өдөр Аж үйлдвэр эрдэс баялгийн яаманд шилжсэн орон нутгийн иргэд газар нутагтаа мэдэлгүй болсон. Уул уурхай явуулдаг жижиг ч байсан том ч байсан бүгдийг нь Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлдэг байх журамд нь буцаагаад шилжүүлээд, оруулаад өгөөрэй гэж хүсэж байна.

2 дугаарт нь Бэлчээрийг хамгаалах заалтыг хуульд тусгаад өгөөрэй гэж хүсэх байна.

Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх сонсголд миний бие 2 өдөр суулаа. Маш хангалтгүй гэж дүгнэж байна. Биелэгдэх, биелэгдэхгүй зүйлүүдийг сонгуулийн шоу болгоод ашиглачихсан юм болов уу гэж миний хувьд дүгнэж байна. Наадмаар хандивлагч, сонгуулиар дэмжих саналынхаа тоог авах гэж малчдыг ер нь ашигладаг юм байна гэсэн бодол энэ хугацаанд төрлөө. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Манай оролцогчид үг хэлж дууслаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж үг хэлнэ. Ирцийн дарааллаар гарсан байна. М.Ганхүлэг гишүүн.

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Сонсгол зохион байгуулсан бас гол шалтгаануудын нэг нь малчдын нийгмийн даатгалын нөхөн төлөлттэй холбогдолтой асуудал. Тэгээд нүүр тулаад орж ирээд тодорхой саналуудыг сонсож байгаа Т.Аубакир сайдад талархал илэрхийлье.

Асуултаа хууль батлагдахад та ямар санал өгсөн бэ гэдгээс эхэлье. Надад жоохон эгдүүцэл төрөөд байгаа асуудал нь би бол хуулийг дэмжсэн гишүүн биш шинээр сонгогдсон гишүүн, тухайн үедээ ийм нөхцөл байдал төсөвт дарамт бий болно, ийм нөхцөл байдал болно гэдгийг мэдсээр байж та хэд маань яах гэж дэмжиж сонгуулийн үеэр ч тэр, дараа дараагийн, хүмүүст ийм боломж бий болгож

харуулаад, өнөөдөр энийгээ хэрэгжүүлэхгүй түвшинд аваачиж байгаа юм бэ гэдэг зарчмын асуултыг түрүүлээд асууя.

Сонсголоос гарах тодорхой үр дүнгүүдийн зайлшгүй нэг хариулт заавал өгөх ёстой. Нийгмийн даатгалын нөхөн төлөлтийг малчид өөрсдөө ашиглаж болох юм уу, үгүй юм уу гэдэг дээр үр дүн гаргахгүй юм бол сонсгол үр дүнтэй болох үгүй гэдэг асуудал яригдана. Тийм учраас асуудлыг тойролгүйгээр ялангуяа Сангийн яамныхан энэ дээр өөрсдөө яагаад болохгүй вэ гэдэг тайлбараа өгөөд хагалмаар байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан мэдээжийн хэрэг нийгмийн хамгаалал талдаа байгаа гэж бодож байна. Тэгэхээр хамгийн нэн тэргүүнд асуудлаа бид нар эцэслэх ёстой. Энд ирсэн олон малчид үүнийг бас хэлж байна. Боломж олдож байгаа дээр дахиад малчдаас нэлээн гарч ирдэг, малжуулах сантай холбогдолтой асуудалд 5 сая төгрөгийг бид нар 8 сая төгрөг болгосон. 8 сая төгрөг маань бас зах зээлийн ханш олон зүйлээс хамаараад хаанаа ч үгүй байгаа юм. Тэгэхээр яах вэ? Цаашдаа ер нь малжуулах хөтөлбөрийн тухай бид нар өөрсдийн гэсэн концепцыг бий болгох тал дээр надад 2 санал байгаа юм.

Нэг дэх нь тухайн бэлчээрийн даацтай нь уялдуулж тооцдог больё гэдэг.

Хоёр дахь нь өнөөдөр манай малчдаас гарч ирж байгаа маш чухал санал байна. Малчин эмэгтэйчүүдийг хэрвээ дэмжээд ирэх юм бол хөдөө орон нутагт хүйсийн тэнцвэртэй байдал бий болгох тал руугаа их зөв болох юм байна гэдэг ийм чухал саналыг бас хэлж байна.

Өнөөгийн байгаа журамтай холбогдолтой 4 санал хэлж байгаа юм. Хамгийн эхнийх нь бол тэр 5 саяыг 8 сая болгосон ч хүрэхгүй байна гэдэг санал байгаа. 2 дахь нь 200 хүртэлх толгой мал гэдэг дээр. Тэгээд хонин толгойд шилжүүлсэн гэчихээр одоо бас өндөр шалгуур болчихоод байна гэж байгаа юм. 3 дахь нь бол насны хязгаар тавьж байгаа нь тухайн бүс орон нутагтаа авах боломжгүй болгоод байна.

Өчигдөр би Хэнтий аймгийн Баянхутаг сумд очиж ажилласан. Тэнд Гантуяа, Энхбаатар тэргүүтэй малчдын зүгээс эхнэр нөхөр заавал байна гэдэг энэ заалт нь болохгүй байна. Эхнэртэй бол одоо үндсэндээ бид нар зээл хууль гэхгүйгээр бас амьдраад явчих боломж байна. Гэтэл эхнэр нь ч олдохгүй, малжуулах хөтөлбөр нь ч олдохгүй үндсэндээ гарцаагүй байдалд оруулаад байна. Тэгэхээр ийм зохицуулалтуудыг жоохон уян хатан болгож өгөөч... **микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: сунгах уу?

УИХ-ын гишүүн М.Ганхүлэг: Нэг мөсөн асуучихъя.

3 дахь асуулт нь сургалт хөгжлийн чиглэлийн насан туршийн боловсролын чиглэл дээр бид хэд нэг оромдсон юм хийгээд байна. Та бидний тайланд 247,9 мянган малчинтай 61,7% нь 200 хүртэлх цөөн малтай малчин иргэд байна гэж байгаа.

Ингээд бид нар 2025, 2026 онуудад 50, 60 сая төгрөгөөр малчдыг мал маллах, ашиг шим боловсруулах сургалтад хамруулсан гэж байгаа юм. 50 мянган малчдын 838-ийг нь сургасан гээд ийм тайлан гаргаад, тэгээд ядаж нэг хувьдаа ч хүрээгүй. Зууны нэг хувьдаа ч хүрэхгүй ийм хэмжээний сургалтыг зохион байгуулаад ажиллаж байгаагаа, хийсэн гэдэг ийм тайлангаар яваад байхаар болохгүй байна. Тэгээд энийгээ цахим болгох, хүртээмжтэй болгох, зөвхөн 800, 900 хүнд хүргэх гэхээсээ илүүтэй илүү олон хүнд хүргэх чиглэлийн юмыг явуулах. Одоо хаагуур ямар хүмүүст зориулаад сургалт ...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайд хариулъя.

УИХ-ын гишүүн, ГБХНХ-ын сайд Т.Аубакир: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Засгийн газрын хуралдаан дуусчхаад Үндсэн хуулийн цэц дээр бас хуралд сууж байгаад жоохон хоцорч орж ирлээ. Хүлцэл өчье.

М.Ганхүлэг гишүүний асуултад хариулаад зарим бас иргэдээс тавьсан санал дээр хариулаад явах нь зөв байх. Малчны тухай хуулийг 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлалцахад өргөн барьсан гишүүдийн нэг нь би өөрөө. Би бас тойргоос 2 удаа сонгогдсон хүн. Малчин иргэдийн ахуй амьдралыг мэднэ. Би малчин хөдөө орон нутгаас гарсан хүн. Малчдын нийгэм хамгааллыг сайжруулах хүрээнд энэхүү нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөх тухай хууль батлах нь зөв гээд Г.Тэмүүлэн гишүүн бид нар хамт батлуулсан. Ингээд явж байгаад 3 дахь Засгийн газар 2024 оноос хойш байгуулагдсан эхлээд Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар, дараа нь Г.Занданшатарын Засгийн газар, Н.Учралын Засгийн газар.

Би Г.Занданшатарын Засгийн газраас эхлээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаад явж байна. Энэ хугацаанд тухайн үеийн Нийгэм хамгааллын сайд байсан Л.Энх-Амгалан сайд мөн миний бие нийлээд 5 удаа Засгийн газрын гишүүдээс буюу бусад сайд нараас санал авах бичгийг илгээдэг. Бусад сайд нарын зөвшөөрөлгүйгээр төсвийн үр дагавартай буюу төсөв дагуулсан журмыг батлах тийм боломжгүй байдаг. Яагаад гэвэл Сангийн сайд сан мөнгө талаасаа харна. Нөгөө талдаа Хууль зүй, дотоод хэргийн сайд нь хууль, эрх зүйн талаасаа харна. Бусад сайд нараас энэхүү саналыг дэмжих боломжгүй, танай нийгмийн даатгалын сан чинь энийг дийлэхгүй гэсэн хариуг өгдөг. Одоо ингээд ярих юм нэлээн л хөврөх байх.

Өнөөдөр яг нийгэм даатгалын сангаас 530 гаруй мянган иргэн тэтгэвэр авч байгаа. Тэдгээрийн авч байгаа тэтгэврийг 300 гаруй мянган иргэний төлсөн нийгмийн даатгалын шимтгэлээр өгөөд явж байгаа. Нийгмийн даатгалын санд шимтгэл төлөөгүй буюу 50% төлсөн иргэдийн тоон дотор цэргийн албан хаагчид 23 мянган иргэн, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэд, мөн малчдын 50%-ийг төсвөөс төлөөд, татвар төлөгчдийн мөнгөөр төлж байна гэсэн үг. Ингээд малчид маань мөн энэхүү сангаас тэтгэвэр аваад явж байгаа.

Ингээд судлаад үзэхээр бид нар өнөөдрийн байдлаар ажлын хэсгүүд бас

хуралдаж байна. Бид нар нийгмийн даатгалынхаа тогтолцоог өөрчилж гэдэг том хуулиа өргөн барьсан. Ажлын хэсгийг Х.Булгантуяа гишүүн ахлаад өчигдрөөс эхлээд ажиллаад эхэлсэн байгаа. Энэхүү хүрээндээ бид нар малчин мөн түүнтэй адилтгах иргэдийг огт нийгмийн харилцаанд оролцоогүй, нийгмийн даатгал төлөөгүй, шимтгэл төлөөгүй иргэдийнхээ нийгмийн хамгааллын асуудлыг яах вэ гэдэг заалтууд ороод явсан. Магадгүй зарим тохиолдолд малчин биш иргэд суурин газарт ерөөсөө огт нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөггүй дандаа залуу явах юм шиг бодоод яваад байдаг нэг харсан тэтгэврийн нас болчихсон байдаг. Одоо яадаг билээ гээд сандарч байгаа маш олон иргэд бий. Эдгээр иргэддээ бид нар ямар боломжуудыг өгөх вэ гэх...**микрофон хаагдсан.**

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ - Гүйцээн хариулах боломж олгоё. 2 минут.

ГБХНХ-ын сайд Т.Аубакир: Тийм учраас бид нар энийг цогцоор нь авч үзэхгүй бол, ний нуугүй хэлэхэд зарим Улсын Их Хурлын гишүүд бол эсрэг байдаг, над руу ч гэсэн хандаж хэлдэг.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Улаанбаатар хот болон бусад суурин газарт татвар, НДШ-ээ 100 хувь төлөөд, дээрээс нь ипотекийн болон лизингийн зээлтэй хүмүүс, суурин газарт амьдарч байгаа иргэд “Яахаараа бид малчдын НДШ-ийг төлөх ёстой юм бэ?” гэсэн байр суурийг маш хатуу илэрхийлдэг.

Тийм учраас бид малчдыг маш сайн ойлгоно. Малчдын нийгмийн хамгааллын асуудлыг сая манай говийн нэг бүсгүй хэлж байна шүү дээ. Бид нар сая Өмнөговь аймагт Р.Сэддорж гишүүнтэй цуг очоод ажиллаад ирлээ.

Малчин иргэдийн нийгмийн хамгаалал, уул уурхайтай холбоотой суурин газруудын асуудал маш хүнд болсон. Энэ тоосжилт гэдэг сүүлийн үед гарч ирсэн. Энэхүү өвчлөл маань ерөөсөө зөвхөн уурхайчдын асуудал биш болсон. Тухайн суурин газрын асуудал болоод эхэллээ шүү дээ.

Сая бид нар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас мянга гаруй иргэний уушгины тоосжилтыг хэмжих үзлэгийг Өмнөговь аймагт үнэ төлбөргүй зохион байгуулаад ирлээ. Үүнд малчин иргэд мөн хамрагдаж байгаа.

Ийм учраас бид үүнийг цогцоор нь авч үзэхгүй бол болохгүй. Тэр малчин айлын хүүхдийн боловсрол, эхнэр, нөхрийнх нь нийгмийн хамгааллын асуудал, аюулгүй байдал гэдэг зүйлийг цогцоор нь авч үзэхгүй бол ингэж өмлөөд, цөмлөөд явах юм бол болохгүй юм байна.

Тэтгэврээ нэмээч гэсэн шаардлагуудыг маш их тавьдаг. Магадгүй хүнд таалагдах гээд л Засгийн газар жаахан нэмээд, ингээд чимээгүй болчих юм уу? Үгүй бол хоёр дахь замыг нь бид нар сонгосон нь ерөөсөө нийгмийн даатгалын тогтолцоондоо шинэ зүйл хийхгүй бол яг энэ байдлаараа нийгмийн даатгалын сан таван жил ч тэсэхгүй.

Иймд, УИХ-ын гишүүд, улс төрчдөд уриалж байгаа маань ерөөсөө энэ нийгмийн даатгалын тогтолцоо гэдэг зүйл улс төр биш шүү. Энэ бол тухайн иргэний

нийгмийн хамгааллын асуудал. НДШ гэхээр зөвхөн тэтгэвэр бодоод байдаг. Гэтэл НДШ төлж байгаа иргэн маань бусад нийгмийн хамгааллын үйлчилгээгээ авдаг.

Тийм учраас энийг цогцоор нь авч үзэх ажлууд явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ц.Туваан гишүүн асууя.

УИХ-ын гишүүн Ц.Туваан: Энэ маш чухал асуудал. Тэгээд хөдөө орон нутгаар тайлан тавиад явж байхад малчид оролцвол ерөөсөө ярьж байгаа асуудлынх нь хамгийн нэгдүгээрт энэ асуудлыг ярьж байгаа юм.

Тэр нь юу гэхээр НДШ-ийг нөхөн тооцох тухай энэ заалтыг яаж хэрэгжүүлэх вэ? Энийг л гаргуулмаар байна гэж.

Өмнө нь, эргээд санахад манай ахмад малчид бол бүгд мэдэж байгаа. 1990-1995, 1995-2000 оны НДШ-ийг төлснөөр тооцож, 5-6 жилийг нь нөхөн тооцуулснаар 300-400 мянган иргэн маань тэтгэвэртэй болж байсан. Тэр үед бол төрөөс ажиллах нөхцөл, бололцоог нь хангаж өгөөгүй гэдэг үндэслэлээр нөхөн төлүүлээд олон хүн тэтгэвэртэй болсон. Малчдын зарим нь энд орсон. Үүнээс хойших хугацаанд ажиллаж байгаа, шимтгэл төлж байгаа малчдын НДШ-ийн төлөлт хангалтгүй байгаа. Яагаад гэхээр манайхан улирлын чанартай орлого олдог. Дээрээс нь тэр болгон ажлын өдрүүдэд цаг наргүй ажилладаг учраас ажлын өдрүүдэд ирээд сумын нийгмийн даатгалын байцаагч дээр очоод уулзаад, шимтгэлээ төлөх, мэдээлэл авах байдал нэлээн хомс байдаг учраас хүндрэлтэй байгаа юм.

Дараагийнх нь бас төрийн нийгмийн даатгалын бодлого дээр энэ хүмүүсийн талаар сайд нь бас ярьж байна шүү дээ. Ингээд хүмүүсээр нөхөн төлүүлэх биш, шимтгэл төлөгчийг олон болгох ёстой. Энэ шимтгэлээр чинь эргээд ахмадуудын тэтгэврийг тавьж байгаа. Тэгэхээр энэ тэтгэврийн НДШ-ийн төлөлтийг бас идэвхжүүлэх зорилгоор би болон бусад гишүүд санаачлаад төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн даатгал, НДШ-ийг нөхөн тооцох, суутган тооцох тухай хууль батлуулсан.

Би сайдаас болон яамныхнаас энэ хууль батлагдсанаас хойш хуулийн хүрээнд хэдэн хүн яг энэ хуулийн үйлчлэлд хамрагдаад, урамшууллаасаа нөхөн төлөх нөхцөл нь бүрдсэн бэ гэсэн нэг ийм асуулт асууя.

Тэгээд манай малчдын талаар хүмүүс их ярьж байгаа. Тэтгэврийн нас нь 5 насаар доогуур байгаа, 20 жил шимтгэл төлсөн байх ёстой, эрэгтэй 15 жил, эмэгтэй 12 жил 6 сар малчнаар ажилласан байх гэх мэт нөхцөлүүд тавьж байгаа юм. Тэгэхээр бид нар хууль дээрээ “нэг удаа нөхөн төлүүлнэ” гээд заачихсан учраас хууль хэрэгжүүлэх л асуудал ярьж байгаа.

Монгол Улс бол парламентын засаглалтай орон. Хууль нь батлагдсан бол гүйцэтгэх засаглал буюу Засгийн газар энийг хэрэгжүүлэх л ёстой. Тэр бусад сайд нар энэ тэр нь татгалзаад байдаг бол тэрийгээ шууд хэл. Тэгээд энэ Засгийн газар чинь кабинетын зарчмаар ажиллах ёстой. Тэр улсуудад хариуцлага тооцоод... (минут дуусав).

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Т.Аубакир сайд хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Энэхүү хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Л.Энх-Амгалан сайдын хувьд болон миний үед нийт 3 удаа бичиг явуулж, бусад яамдаас санал авсан байдаг. Гэвч Сангийн яамнаас татгалзсан хариу авч байсан.

Үүнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Үндсэн хуулийн цэцэд иргэнээс өргөдөл өгсөн байдаг. Тодруулбал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ хуулийг хэрэгжүүлэхгүй байна гэсэн өргөдөл гаргасан.

Үндсэн хуулийн цэцээс ямар дүгнэлт гарсан бэ гэхээр 2026 оны 1 дүгээр сараас хойш, тухайлбал 3 дугаар сард өгсөн өргөдөлд 4 дүгээр сард хариу ирсэн. Тус хууль 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр дуусгавар болсон хууль учраас маргаан үүсгэх боломжгүй гэсэн хариу ирсэн байдаг.

Миний хувьд малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг малчин иргэдийн өнөөгийн нөхцөл байдал, нийгмийн хамгаалалттай нь уялдуулаад төлөх боломжийг сая Г.Тэмүүлэн гишүүн бид хоёр санал солилцоод явж байна.

Яг энэ төсөв хэлэлцээд, чуулган удахгүй завсарлана. Энэ оны 9 дүгээр сарын 1-нд дараа жилийн улсын төсвийг өргөн барина. Ерөнхий сайд, Сангийн сайд болон бусад холбогдох хүмүүстэй уулзаад ямар боломж байгаа талаар ярилцъя. Энэ хурлын дараа уулзалтуудаа хийе гэж байна. Ийм учраас миний хувьд, энд сууж байгаа бүхий л гишүүд бүгдээрээ хөдөө орон нутгаас сонгогдсон. Намайг ч гэсэн тойрог дээр очиход “Нөхөр чи өөрөө барьж явж батлуулсан хууль чинь хаана байна вэ?” гэж асуудаг.

Кабинет буюу Засгийн газар гэдэг чинь зөвхөн нэг сайдын хэлснээр асуудлыг шийддэггүй. Бусад сайд нар санал өгч, санал нэгдсэний үндсэн дээр шийдвэр гаргадаг. Бусад сайд нар татгалзахаар хэрэгжүүлэх боломжгүй болчихож байгаа юм.

М.Ганхүлэг гишүүний асуусан 5 сая төгрөгийг Малжуулах хөтөлбөрийн хүрээнд нэг малчин өрхөд олгодог байсныг миний үед 8 сая төгрөг болгосон.

Энэ бол хэрэгтэй хүндээ маш хэрэгтэй хөтөлбөр болж байгаа. Нэг иргэнд 8 сая төгрөг өглөө гэхэд нөгөө хүн маань малчнаас 8 сая төгрөгөөр мал худалдаж авдаг. Ингэснээр малчин иргэнээ орлоготой болгоод, өөрөө малтай болж үлддэг. Эргээд зуд, турханд малгүй болсон иргэдийг малжуулахад маш оновчтой хөтөлбөр. Бид нар 2026 онд 800 гаруй малчин өрхөд 7 тэрбум төгрөг зарцуулаад эхэлсэн байгаа. Маш олон иргэн аливаа асуудлыг зөвхөн өөр дээрээ биш аймаг, сум, улсын хэмжээнд аваад үзэхээр маш олон хүнийг хамруулж, амьдрал ахуйтай болгочихсон байдаг байхгүй юу. Тийм учраас бид нар М.Ганхүлэг гишүүний саналыг ойлголоо. 8 сая төгрөг ч гэсэн цаашид нэмэх боломж байна гэж үзэж байгаа.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар малчин иргэд маань эмэгтэй 50, эрэгтэй 55 настайдаа тэтгэвэрт гарч байгаа. Харин бусад иргэд эрэгтэй 60, эмэгтэй 55 настайдаа тэтгэвэрт гарч байгаа. Тийм учраас бид нар эдгээр уян хатан зохицуулалтуудыг дараа дараагийн хуулиуд дээр ярилцаад явах нь зөв байх гэсэн саналтай байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: 14 дүгээр микрофон

Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал: Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх тухай хуулийн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 361 дүгээр тогтоолоор төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөх журмыг баталсан.

Энэ журмын хүрээнд ХХААХҮЯ болон тухайн үеийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтраад холбогдох цахим системийг бий болгосон. Бид нар хамтраад сурталчилгаануудаа хийж, аймаг, орон нутгаар нэлээн явсан.

Яг манайд байгаа мэдээллээр бол энэ урамшууллыг ашиглаад малчдын зүгээс нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураар төлсөн тохиолдол одоогоор гараагүй байгаа. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ц.Туваан гишүүн тодруулья.

УИХ-ын гишүүн Ц.Туваан: Энэ их хариуцлагагүй л юм байгаа юм. Энэ яам, агентлагууд чинь хуулийг биелүүлэх, сурталчлах ёстой. Та хэд хар даа. Манай малчид бүгдээрээ мэдэж байгаа. Ноосны, арьс ширний, сүүний урамшуулал авч байгаа малчдын тухайд бол тэр урамшууллаасаа нийгмийн даатгалаа больё, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлчих бүрэн боломж байгаа.

Энийг чинь хооронд нь холбож өгөхөд л болно шүү дээ. Нэг малчин өөрөө хүсэлт гаргаад л болно.

Тэгэхээр энэ дээр хуулийн дагуу “ийм хууль батлагдсан шүү, энийг хэрэглээрэй” гэдэг сурталчилгаа аймаг, сум, анхан шатанд байгаа нийгмийн даатгалын асуудал хариуцсан хүмүүст ерөөсөө очихгүй байна шүү дээ. Энэ бол аягүй дөхөмтэй, аягүй хялбаршуулсан хууль байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийг сурталчлах тал дээр ямар ажиллагаа хийх гэж байна? Энэ дээр сайд нэг хариулт өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайд хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Сум болгон дээр ажиллаж байгаа нийгмийн даатгалын байцаагч нараа бид нар бас идэвхжүүлэн ажиллаж байгаа. Яг энэ малчдын НДШ-ийн төлөлттэй холбоотойгоор бид нар журмаа уян хатан болгоод, ноос, ноолуурын үед буюу малчид орлоготой болдог үед нь НДШ, ЭМД-аа төлөх зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газар дээр журмаа өөрчлөн гаргаж байгаа. Мөн идэш, уушны үед мөнгө орж ирэхээр даатгалын шимтгэлээ төлчихдөг уян хатан зохицуулалт хийж байгаа.

Тийм учраас Ц.Туваан гишүүнтэй санал нэг байна. Зарим нэг зүйл дээр төрийн албан хаагчид, дунд шатанд байдаг хүмүүс ямар нэгэн алдаа гаргаж, цалгардуулаад малчин иргэддээ үзүүлэх үйлчилгээгээ илүү санаачилгатай, чанартай үзүүлэх тал дээр анхаарах шаардлагатай байгаа. Сая өмнөх саруудад

удаа дараа бүх байцаагч нартайгаа онлайн хурал хийж, үүрэгжүүлээд явж байгаа.

Харин малчдыг яг орлоготой болсон үед нь НДШ-ээ төлчихвөл танд ийм давуу талууд бий болно гэдгийг ойлгуулах ёстой. Та харин тавхан хувийг нь төлж байгаа шүү дээ. Төлчихвөл та дараа нь насан туршдаа... (минут дуусав).

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Ганбаатар гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны санал хураалтад гарсан юм байна. Ц.Мөнхбат гишүүн алга байна. О.Алтангэрэл гишүүн асууя.

УИХ-ын гишүүн О.Алтангэрэл: Нэг зүйлийг тодотгож хэлэхгүй бол болохгүй байгаа юм. Манай Т.Аубакир сайдын үгэнд гарч байх шиг байна. Малчдын талаар бас ийм шүүмжлэлтэй байр суурь гардаг гээд.

Үндсэндээ яагаад хөдөө залуу малчин олдохоо больчихсон, малчдын амьдрал ахуй дордчихсон, хүнд байгаад байгаа вэ гэхлээр нийслэл хот болон төв суурин газарт амьдарч байгаа хүмүүсийг хямд мах идүүлэх бодлогын зөрүү ерөөсөө малчдын олох ёстой орлогыг халааснаас нь авчихсан юм. Төр өөрөө нөөцийн мах гэж бэлддэг. Өөр ямар ч салбарт ажилладаг хүний бүтээгдэхүүнийг хямд байлгах гэж төр ингэж хичээдэггүй. Нөөцийн мах гэж олон мянган тонноор нь бэлддэг, үнийг нь хүчээр унагадаг. Энэний чинь зөрүү ерөөсөө дандаа малчдын халааснаас гарсан юм.

Тэр зөрүүн дээр төр нэг тэтгэвэр, нэг НДШ дээр нэг хувь энэ тэр ярьж байгаа юм. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 30 жил малчдын халааснаас төр мөнгө авсан. Дам утгаараа. Ийм учраас ийм бодлого явдаг гэдгийг би нэгдүгээрт хэлчихье.

Тэгээд би их тодорхой асуулт асууя. Тухайлбал, Т.Аубакир сайд та Л.Энх-Амгалан сайдын үеэс аваад бичиг явуулж, бас оролдлого гаргасан юм байна. Энэ журмыг хэрэгжүүлье гээд.

Тэгвэл та яагаад энэ оны 1 дүгээр сард “эхний улиралдаа багтааж журам батлагдана” гэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгдсэн юм? Хэн саад болсон юм? Таны энэ бодлогод яг хэн дээр очоод гацсан юм? Та нэрлээч. Юм чинь эзэнтэй, нэртэй баймаар байна. Бөөрөнхий биш.

Хоёрдугаарт, энэ төсөл дээр жишээлбэл, энэ оны төсөвт тусгасан, тусгаагүй гэдэг асуудлыг танай яамныхан яриад байна. Үгүй ээ, энэ чинь эхлээд малчид мөнгөө төлөхөөр 20-30 тэрбум төгрөгийг нэмэх байх юм биш үү? Энд ямар мөнгө төлөвлөх юм бэ? Гэсэн яг ийм тодорхой асуулт байна.

Гуравдугаарт, та нэг Цэцийн зүйлийг дурдаад байх шиг байна л даа. Энэ чинь журам батлах тухай заалтын үйлчлэл дууссан тухай ярьж байгаагаас биш үндсэн материаллаг хэм хэмжээ болох НДШ-ийг нөхөн төлүүлнэ гэдэг тэр заалт хуульд хүчин төгөлдөр байж байна шүү дээ. Энийг яах юм? Хэрэгжүүлэх юм уу, үгүй юу? Цаашдаа энийг хэрэгжүүлэхээр оролдох юм уу? Эсвэл энийг чинь ер нь чадахгүй гэж байгаа юм уу? Яг ийм тодорхой 3 асуултад хариулт авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайд хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Би төр махны

нөөц бүрдүүлэх нь зөв гэдэг талд байдаг. Яагаад гэвэл махны үнийн өсөлт буюу өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтөд хамгийн түрүүнд өртдөг хүмүүс бол тэтгэвэр авагчид. Сая та бүхэн харлаа, мах 40 мянга хүрэхэд юу болов? 1,7 сая төгрөгийн тэтгэвэртэй хүн эмээ авах уу, махандаа өгөх үү болсон шүү дээ.

Энэ чинь өөрөө манайх шиг ийм жижигхэн зах зээлтэй улс дотор үнийн өсөлтөөс, монополоос сэргийлэх ийм механизм заавал ажиллах ёстой. Би бол энэ дээр тантай санал нийлэхгүй байна.

Энэ 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр байгуулагдсан Засгийн газар дотор та Хууль зүй, дотоод хэргийн сайд байсан. Тухайн үед кабинетын зарчмаар ажилласан байх. Тухайн үед танд Л.Энх-Амгалан сайдаас энэ журмыг батлах саналууд ирсэн л байх. Ёстой та чухам яг ямар хариу өгсөн юм? Би энэ тэрийг айхтар сайн яасангүй. Хамгийн сүүлд миний явуулсан бичиг бол 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр сайд нарт гэж хаягласан бичиг байгаа. Малчны нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөх тухай хуулийн талаар саналаа өгөөч ээ гэсэн. Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас татгалзсан хариу ирсэн. Та өөрөө кабинетад байсан хүн, маш сайн мэдэж байгаа. Үндсэн энэ яамдууд эсрэг санал өгөхөөр журам гаргах ямар ч боломжгүй болчихдог. Тийм учраас энэ дээр саяын 3 яамнаас бол та тодорхой асуулаа. Би тодорхой хариуллаа.

Цэц дээр гарсан асуудал дээр бол ямар үндэслэлээр намайг Цэцэд өгсөн юм бэ гэхээр “Үндсэн хууль зөрчлөө, чи жирийн иргэдийг болохоор 100 хувь НДШ-ээ төл гэххээд, малчин иргэдэд болохоор таныг нэг удаа нөхөн даачихъя гэж байгаа чинь Үндсэн хуулийн тэгш байх эрхийг зөрчсөн байна” гэсэн үндэслэлээр намайг Цэцэд өгсөн.

Харин хугацаа нь хэтэрчихсэн байсан. 3 сар ч шиг санагдаж байна. 4 сарын сүүлээр хариу нь ирсэн. Хугацаа нь дууссан учраас авч хэлэлцэхгүй ээ гэж. Би сайтуудад бол итгэлтэйгээр хэлээд явж байсан. Энэ болчих байх. Яагаад гэвэл би өөрөө итгэлтэй хөөцөлдөөд явж байсан. Яагаад гэвэл эхний ээлжид бол малчид ингээд нөхөн төлөөд, тодорхой хэмжээний хуримтлал ороод ирнэ. Үүгээр нь ингээд явж байтал... Гэхдээ энэ чинь нэг удаа нөхөн төлөөд л хаях биш, тухайн нөхөн төлсөн малчин маань үлдсэн насан туршдаа сангаас тэтгэвэр авах болно шүү дээ. Тийм учраас та нар ингээд энэ нийгмийн даатгалынхаа санг бүр дэндүү сарампай болгож байна даа гэсэн зөвлөмжийг гадна, дотнын эдийн засагч, экспертүүд, ОУВС, Дэлхийн банк энэ тэр өгсөн. Та нар сая тэнд нэг эмэгтэй тодорхой хэллээ шүү дээ. “Бид нар та нараас ямар нийгмийн даатгалын шимтгэлийг минь төлөөд өг гэж гуйсан юм уу?” гэж. Нөгөө олон улсын экспертүүд бол яг тэгж хэлж байгаа юм. Та нар ингээд сонгууль дөхөхөөр л нэг хүнд таалагдах гээд ингээд л юм амлачихъя. Гэтэл нөгөө сан чинь нөгөө талдаа яг сонгодог утгаараа явж чадахгүй байгаагийн чинь нэг нь энэ шүү.

Нөгөө талдаа цэргийн тэтгэврийг бас ярьдаг 23 мянга орчим иргэн гэх зэрэг бид нар эдгээр ерөөсөө зарим эдийн засагч, улс төрчдийн хэлдгээр сангаа сонгодог утгаар нь аваад, битгий улс төржүүлээд байгаач.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: О.Алтангэрэл гишүүн тодруулья.

УИХ-ын гишүүн О.Алтангэрэл: Би ерөөсөө тэр мах, нөөцийн мах бэлдэх нь

зөв, буруу гэж огт яриагүй. Та халиад ингээд өөрийнхөө асуудлыг тэр махны асуудал болгох гэж оролдоод байх шиг байна. Тэр бэлдэнэ л биз, нийслэл нь хийдгээ хийнэ л биз. Ерөөсөө хамаагүй.

Харин таны хувьд бичгээ явуулаад, оролдлого хийсэн юм байна. Энэ чинь бол хариуцсан сайдын хувьд ажлаа хийсэн байна шүү дээ, тэгж харагдаж байна.

Гэтэл яг тодорхой та хэллээ. Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам гээд энэ яамдуудаас тайлбар авах ёстой юм байна. Яагаад энэ дээр татгалзаад төрийн хууль хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ гэж. Энэ дээр бас тайлбар авах ёстой юм байна. Дээрээс нь та энийг яаж хэрэгжүүлэхгүй талаар няцаалт, тайлбар их бодож бэлдэж ирсэн байна. Тэгэхээр юу нь болохгүй, олон нийт юу гэж бодож байгааг таны амнаас сонсохгүй. Төрийн сайд...

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэг минут О.Алтангэрэл гишүүнд сунгаж өгье.

УИХ-ын гишүүн О.Алтангэрэл: Тэгэхээр таныг ажил үүргийнхээ хувьд юу гүйцэтгэж байгаа вэ гэдгийг асууснаас биш хүмүүс юу гэж бодож байгаа талаар таны бодол ямар байгааг ерөөсөө асуугаагүй ээ. Энэ хоёр чинь өөрөө хоорондоо ялгаатай шүү.

Хамгийн гол нь бид нар өнөөдөр ямар асуудал яриад байгаа вэ гэхээр хэн юу гэж бодох, хэн яаж дүгнэхээс үл шалтгаалаад Монгол Улсын хүчин төгөлдөр батлагдчихсан хуулийг яаж хэрэгжүүлэх вэ, өдий болтол яагаад хэрэгжүүлээгүй юм бэ, энэ ямар хариуцлагатай байх вэ гэдэг талаар л бид нар өнөөдөр яриад сууж байгаа.

Ер нь сонсголын зорилго ч ийм байх гэж бодож байгаа. Тийм болохоор нэг зүйлийг би бүр зориуд тодотгож хэлмээр байна. Энэ журам батлахтай холбоотой заалтын үйлчлэх хугацаа дууссан. Журам нэхэхгүй ээ. Журамтай, журамгүй хуулийн харилцаа маань үлдчихсэн шүү. Энийгээ хэрэгжүүлэх ёстой шүү. Энэ дээрээ анхаараарай. Шалтаг, шалтгаан бага бодоорой гэж ингэж л хэлье дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Ц.Мөнхбат гишүүн асууя.

УИХ-ын гишүүн Ц.Мөнхбат: Энэ Малчны тухай хуулийн хамгийн их маргаан дагуулсан асуудал бол энэ НДШ-ийг нэг удаа нөхөн төлүүлэх асуудал л байгаа. Орон нутагт явж байхад, тойргийнхонтойгоо уулзалт хийж байхад хамгийн түрүүлж босоод л нэг хүний гаргаж тавьдаг асуудал.

Яг үнэндээ бид нарыг хуураад, ийм нэг Малчны тухай хуулийн нэрийн доор гоё гоё сайхан заалтууд оруулж ирээд, хэрэгжүүлэх журмыг нь гаргахгүй байсаар байгаад өнөөдрийг хүртэл энэ хууль хүчин төгөлдөр хэрэгжихгүй байна гээд ярьдаг. Өнөөдөр бид нар энд ингээд тойроод сууж байгаа ч гэсэн хамгийн гол фокуслаж байгаа заалтын нэг бол энэ.

Т.Аубакир сайд бол бас зовлонгоо ярьж байна. Тэрийг бол бид нар ойлгож байна. Танхимын зарчмаар Засгийн газар явах ёстой. Засгийн газар энэ дээр бас хариуцлага хүлээх ёстой. Түрүүн тэр М.Ганхүлэг гишүүний хэлсэн шиг анхнаасаа яагаад энийг батлуулахдаа тэр тооцооллыг нь хийдэггүй юм бэ? Эсвэл хийж өгсөөр

байтал тодорхой зорилготойгоор батлаад ингээд явчихсан.

Сонгуульд л ялж байвал дараа нь яадаг ч билээ гэсэн байдалтай ингээд явчихсаны гор өнөөдөр гараад байгаа юм. Тэгээд миний хувьд нэг ийм юм асуух гээд байна.

Журмыг Т.Аубакир сайд оруулаад л байдаг юм байна. Засгийн газар энийг батлах уу, батлахгүй юу? Үүн дээр бид нар Ерөнхий сайдаас, Сангийн сайдаас ингээд цаашлаад асуулгуудыг тавиад явах нь ээ.

Хоёрдугаарт, нийгмийн даатгалын санг сарампай болгочихлоо гээд. Энэ үнэн. Нөгөө сонгуульд л ялж байвал юу хамаагүй хэлж, юу хамаагүй мөрийн хөтөлбөрт тусгасаар байгаад өнөөдөр ийм байдалдаа хүрч байгаа юм. Тэгэхээр энийг бол бид нар засаж, сайжруулж, өөрчлөх ёстой. Энэ дээр Т.Аубакир сайд нэлээн сайн санаачилгатай ажиллах болов уу гэж би бодож байна.

Гуравдугаарт, энэ малчны хүүхдийг үнэ төлбөргүй сургана гээд нэг заалт орчихсон. Тэгэхдээ тодорхой хэдэн мэргэжлүүд тавиад өгчихсөн. Энийг нэг жаахан хүрээ хязгаарыг нь тэлмээр байна. Үүн дээр бид нар мэдээж дараагийн сонсголын үр дүнгээр Малчны тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах асуудлууд яригдах байх. Энэ дээр маш олон талаас нь ярилцах хэрэгтэй юм байна гэж бодоод байгаа.

Дээрээс нь малчны хүүхдүүд сүүлдээ малчин болохоо больж байна. Малчны хүүхдүүд малчин болохоо больчихоор хэн Монголын малыг маллах вэ? Хэн Монголын хүнсний нөөцийг бэлдэх вэ? Хэн Монгол Улсын тусгаар тогтнолын баталгааг хангах вэ? Энэ малчид чинь нэг талаасаа мал маллаад байгаа боловч, нөгөө... (минут дуусав).

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэг минут сунгая.

УИХ-ын гишүүн Ц.Мөнхбат: Нөгөө талдаа малчид чинь Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, тусгаар тогтнолын баталгаа болж, тэр газар нутгаа уул уурхай болон бусад асуудлаас хамгаалж байгаа хүмүүс. Тэгэхээр энэ малчдын хүүхдүүдийг эргээд малчин болоход нь бид нар заавал хөшүүрэг, төрийн дэмжлэг үзүүлэх ёстой. Хот, суурин газрын хүн хэзээ ч малчин болоод очихгүй. Ер нь бол хамгийн ховор тохиолдол. Малчны хүүхдүүд л үргэлжлүүлээд энэ удам угсаагаа залгаж, өвөг дээдсийнхээ мал маллаж байсан арга ухааныг үргэлжлүүлээд явдаг. Тэгэхээр энэ тал дээр манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, дээрээс нь Гэр бүл, нийгмийн хамгааллын яам ийм хөшүүргүүдийг хуульд нэмж оруулах тал дээр бас анхаарах хэрэгтэй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайд хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Г.Тэмүүлэн гишүүн маань ч ороод ирлээ. Бид нар нэгэнт өргөн барьж, батлуулсан хуулийн хэрэгжилтийг ямар байдлаар хангах боломж байна вэ гэдгийг Засгийн газрын түвшинд, зарим гишүүдийн төлөөлөлтэй хамт ярих нь зөв байх. Тийм ээ, Г.Тэмүүлэн гишүүн ээ. Бид нар бас гаргалгаа олох ёстой.

Гэхдээ яг нийгмийн даатгалын сангийн өнөөгийн нөхцөл байдлыг бид нар

хаа хаанаа ойлгохгүй бол 537 мянган иргэн тэтгэвэр авч байгаа юм. Эдгээр иргэдийнхээ тэтгэврийг бид нар яаж өгөх вэ?

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаараа дамжуулаад малчдыг малжуулахаас авхуулаад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж байна. Манай яам бол ерөөсөө хөдөлмөр эрхлэлтийн бодлого руу чиглэж ажилладаг. Энэ сан энгийн нэг жаахан хөрөнгийг л зарцуулдаг юм шүү дээ. Ний нуугүй хэлэхэд, ахмадуудаа яаж хөдөлмөр эрхлүүлэх вэ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй айлын хүмүүсийг ямар байдлаар хөдөлмөр эрхлүүлэх вэ гэдэг асуудал бий. Тэгэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нь өглөөнөөс орой хүртэл асаргаа, сувилгаа, сэргээн засах үйлчилгээг нь үзүүлээд, ард нь аав, ээжийг нь хөдөлмөртэй байлгах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин айлууд байдаг. Тэгээд хүүхдээ гэртээ орхиод явах хэцүү. Мал руугаа явах уу, гэр орноо харах уу гэдэг асуудал үүсдэг. Тийм учраас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хийдэг хамрах ажлын хүрээ маш өргөн.

Энэ дээр Боловсролын яам, Эрүүл мэндийн яамтай хамтраад нэгдсэн бодлогуудыг явуулаад эхэлж байгаа. Тухайн малчин айлын хүүхдийн боловсролын асуудлыг Боловсролын яам нь хариуцна. Эрүүл мэндийн асуудал, жишээлбэл ЭМД-ын асуудал байна. Нийгмийн хамгааллын асуудлыг манай яам хариуцна. Энэ гурван чиглэлийг ямар байдлаар нэгтгэж явах вэ гэдэг дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд гурван сайдын хамтарсан нээлттэй хурлуудыг хийж, бодлогуудаа зангидаад явж байгаа.

Ц.Мөнхбат гишүүнтэй санал нэг байна. Би ч гэсэн хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүний хувьд малчин иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг та нар яах юм бэ гэсэн асуудлууд маш хурцаар тавигддаг. Баруун аймгуудад шүлхий гараад мянга мянгаар нь мал устгаж байгаа. Эргээд л Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тэдгээр малаа устгуулсан иргэдийг малжуулах бодлого хэрэгжүүлээд, ингээд амьдрал буцалж байна шүү дээ.

Ний нуугүй хэлэхэд, энд ингээд боломжтой болчхоод өөрийнхөө батлуулсан хууль дээр Т.Аубакир л эсрэг байгаагүй юм байна гэдгийг сая та бүхэн ойлгож байх шиг байна. Миний хувьд бол хичээгээд явж байгаа. Сая О.Алтангэрэл гишүүнд би яг он, сартайгаа явуулсан албан бичгүүдээ үзүүлээд, сайд нараас санал авъя, малчдын НДШ-ийг нөхөн төлөх тухай хуульд саналаа өгөөч ээ гэсэн. Оны өмнөөс эхлээд явсан бичгүүд байна л даа.

Ийм учраас энэ Засгийн газар кабинетын зарчимтай ажилладаг. Бид нар нийгмийн хамгааллын бодлогыг нь гаргалаа гэхэд УИХ-ын гишүүдийн санаачилсан хуулийн хүрээнд нөгөө талдаа Монгол Улсын төсөв, санхүү хүрэх юм уу, үгүй юү гэдэг дээр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам байр сууриа бариад байж байдаг. Тийм учраас ингэж гацсан тохиолдол бий. Гацсаар байгаад сая 1 дүгээр сарын 1-нд хуулийн үйлчлэх хугацаа дууссан үндэслэлээр бүр ингээд явчих лаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

УИХ-ын гишүүн Г.Ганбаатар: Уг нь анхааралтай сонсож байсан. Нөгөө Төсвийн байнгын хорооны санал хураалтууд давхардаад, ахиад давхар орж асууж байвал уучлаарай.

Нэгдүгээрт, Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдуулан Т.Аубакир сайдын хийсэн мэдээлэлтэй холбоотой хоёр асуулт байгаа.

Ер нь нэг юмыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Шинэ хоршоо ч бай, малчдын нийгмийн даатгалыг нөхөн төлөхтэй холбоотой хуулиуд нь аятайхан гарсан боловч хэрэгжих боломж байхгүй байсан. Үнэндээ эдийн засаг, санхүүгийн ачааллаа дийлэхгүй байгаа. Тэгээд үнэнээ хэлэх хэрэгтэй. Ер нь дандаа худлаа ярьж, хүмүүст таалагдах гэж худлаа ярьж явсаар байж байгаад бид нар ийм байдалд, энэ улс орон ч гэсэн ийм байдалд орчихоод байгаа шүү дээ. Улс төрчдийн хүслээр, сонгуулийн өмнө хийсэн хуулиуд ямар байдгийг зүгээр Малчны тухай хууль дээр арай өөр байсан.

Тэгээд хоёр асуулт байгаа. Хэн гэлээ, нөгөө Н.Номтойбаяр сайдын ажлын албаны нөхөр эргэн төлөлт нь 136.4 тэрбум төгрөг гэж таны мэдээлэлд гарч байна. Энэ чинь үндсэндээ ерөөсөө 15.2 хувь байгаа байхгүй юу. Нийт олгогдсон зээлийн эргэн төлөлт ийм л байгаа юм. Энэ чинь нэг жил нь зээлийнхээ үндсэн төлөлтөөс чөлөөлөгдөж байгаа. Үндсэндээ өдийд төлөгдөөд явж байх ёстой байхгүй юу. Тэгээд яг энэ графикаараа хэд орохоос 15.2 хувийн төлөлттэй байгаа юм бэ гэдэг асуудал байна.

Хоёрдугаарт, түрүүн 5 их наяд гээд, 5 их наядын хөтөлбөр гээд байхгүй шүү дээ. Яах гэж худлаа яриад байгаа юм бэ? Тийм боломж энэ улс орны төсөвт байхгүй.

Үндсэндээ энэ чинь 800-аас 1 их наяд орчим, 894 тэрбум төгрөгийн зээл л гарсан. Тэгээд ахиад олгох зээл 2025, 2026 онд байхгүй. Ингээд битгий худлаа ярьцгаагаад бай. Малчдадаа үнэнийг хэл. Тэгэхлээр 2025, 2026 онд дахиад шинэ зээлийн эх үүсвэр байгаа юм уу? За, тэр хоёр асуултад хариулчхаарай.

Гурав дахь асуулт нь Т.Аубакир сайдтай холбоотой. Та түрүүн энэ малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журмын талаар санал авсан гэсэн. Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, нэг яам нь хэн гэгчхэв, гурван яам санал өгөөгүй гэсэн. Үгүй ээ, Сангийн яамны сайд чинь З.Мэндсайхан, хоёр дахиа сонгогдож байгаа, ХАА-н сайд байсан. Хоёрдугаарт, Эдийн засаг, хөгжлийн яамны сайд чинь Ж.Энхбаяр, хэд ч сонгогдож байгаа юм. Тэгээд тухайн үед дэмжиж байсан улсууд чинь дэмжихээ больчихсон уу?

11 журам батлагдах ёстойгоос дөнгөж хоёр нь батлагдсан. Яг үндсэндээ энэ Малчны тухай хуулийн чинь амин сүнс нь хоёр, гуравхан зүйл байгаа шүү дээ. Уг нь хэрэгжсэн бол зүгээр байсан юм, дажгүй хууль байсан юм. Тэгээд энэ чинь ерөөсөө үндсэндээ хэрэгжихгүй байна. Бид нар ямар сайндаа ажлын хэсэгт нь санал гаргаад, хөдөө орон нутагт явж байгаа улсууд энэ Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэе. Холбогдох байгууллагууд нь ямар байгаа юм?

Өнөөдөр энэ сайд нараа хар. Үндсэндээ Т.Аубакир сайд, Ц.Идэрбат сайд хоёр л сууж байна. Бусад нь 6–7 сайд байхгүй байна шүү дээ. Иймэрхүү маягаар л хандаж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ юугаа... (минут дуусав).

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэг минут сунгая.

УИХ-ын гишүүн Г.Ганбаатар: Үндсэндээ яах вэ, тэр 35,158 малчинд 5

жилийн хугацаанд 375.5 тэрбум төгрөгийг олгоё гэсэн бол олгох л байсан байх. Гэхдээ нэгдүгээрт, хүсэл алга байна. Хоёрдугаарт, энэ журам хэрэгжихгүй байсаар байгаад өнөөдөр бодитой ийм нөхцөл байдалтай тулж байна. Хэрвээ хүсэх юм энэ хуулийг ахиад оруулж ирэх боломжтой шүү дээ.

Түрүүн тэр төрийн нарийн бичгийн дарга хэн гэлээ, УИХ-аас төсөв тавиагүй гэж худлаа ярьж байна лээ шүү. Та нар тийм юм ярьж болохгүй шүү. Хуулиа хэрэгжүүлээгүй сайд нартай л ярих болохоос биш, Нийгмийн даатгалын сангийн 2025, 2026 оны төсвийн тухай хуульд энэ асуудал орж ирээгүй. Хэдүүлээ хүмүүстээ зөв мэдээлэл өгч байх ёстой шүү гэдгийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайд хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Г.Ганбаатар гишүүнтэй санал нэг байна. УИХ-ын гишүүд бол хууль санаачлан батлуулах бүрэн эрхтэй.

Эргээд өнөөдөр манай яамны зүгээс Засгийн газарт нэг санал оруулсан, бас дэмжигдээгүй. Төсөв, мөнгөтэй холбоотой, татвартай холбоотой, нийгмийн хамгаалал, ялангуяа халамжтай холбоотой асуудлыг хувь гишүүд ингээд хууль батлуулахгүй байвал нөгөө нэг яг хүртээмжийн асуудал, үнэн бодитой эдийн засаг, санхүүгийн тооцоолол хийх боломж бүрдэх юм л даа.

Ингээд ярихаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдлаа л гэх байх. Нэг л бид нар тогооноосоо төсөв, мөнгөний зарцуулалт, юмнуудаа нийцүүлээд л явуулах ёстой. Сая Г.Ганбаатар гишүүн бас зах зухыг нь хэлж байна шүү дээ. Бид нар яагаад тооцоололгүйгээр энэ хуулиа өргөн барьчихсан юм бэ гэж. Тийм ээ, бас л энэний зөрүү гарч байгаа юм л даа.

Энэ дотор малчдадаа дургүйлхээд байдаг ч юм уу, ингэж байгаа нэг ч зүйл байхгүй. Ерөнхийлөгчөөс авхуулаад Ерөнхий сайдаас авхуулаад үргэлж л малчин иргэд рүүгээ чиглэсэн төрийн бодлогыг явуулж байдаг.

Харин малчдадаа бас үүгээр дамжуулаад хэлэхэд та бүхэнд төлөх ёстой НДШ-ийн 50 хувийг төлөх боломж байгаа. Бусад иргэдтэй харьцуулахад 5 насны өмнө тэтгэвэрт гарч байна. Бүтэн 5 жил НДШ төлөхгүй явна гэдэг бол маш том хөнгөлөлт.

Бусад салбар, секторт ажилладаг иргэд маань нас нэмэгдээд л 60-тай гардаг байсан бол 62-той гарах байдаг ч юм уу, насжилт өндөрсөж байгаатай холбоотой илүү удаан хөдөлмөр эрхлүүлэх боломжийг бид хайж байгаа юм л даа. Тийм учраас энэ бол зөвхөн нийгмийн даатгал гэхээсээ илүү малчны асуудал.

Манай Г.Тэмүүлэн гишүүний санаачилсан хууль бол маш сайн хууль байсан шүү дээ. Боловсролын салбар дээр малчин өрхийн нэг хүүхдийг Хөдөө аж ахуй, мал аж ахуй, бэлчээрийн менежментийн чиглэлээр үнэ төлбөргүй сургая гэсэн. Энэ маань нөгөө талдаа хуулийн бодлого нь малчин гэсэн мэргэжил, Хөдөө аж ахуйн сургалтын элсэлт маш их багасаж байгаа шүү дээ, үүнийг нөхөх зорилго агуулсан.

Мэдээжийн хэрэг малчин өрх бол хүүхдээ малчин гэхээсээ илүү малын салбар гэхээсээ илүү магадгүй анагаахад сургах хүсэлтэй ч байхыг үгүйсгэхгүй.

Гэхдээ төрийн бодлого нь бол малчдын, мал аж ахуйн салбар ер нь эзгүйдээд байна шүү, энэ рүүгээ хөнгөлөлттэй, үнэ төлбөргүй сургууль явуулъя гэсэн ийм бодлогыг шингээсэн хууль байсан.

Зарим зүйл, заалт нь бас хэрэгжихгүй байгаад харамсалтай байна. Гэхдээ энэ дээр бид нар цаашдаа анхаараад явна. Сая Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлснээр бол бид нар эндээс өнөөдөр ямар нэгэн дүгнэлт гаргах биш, нөхцөл байдал ийм байна шүү гэдгийг Засгийн газарт хүргэх ийм л зорилготой сонсгол болж байгаа. Тийм учраас холоос ирсэн, ойроос ирсэн манай малчин иргэд байж байна, уул уурхайнхан байж байна. Эндээс бид нар ямар нэгэн дүгнэлтэд хүрэх ёстой л доо. Түүнээс ингээд сонгуульд таалагдах гээд л, би тэг гэсэн чинь тэр тэгсэнгүй гэхээсээ илүүтэйгээр энэ дээр бид нар цаашдаа анхаараад ажиллая.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир сайд энэ хуулийг уг нь дэмждэг, дэмжиж байгаа. Тэгээд сайд болсон чинь дэмжихээ больчихлоо. Нөхцөл байдал ийм л байна. Тийм ээ, нөхцөл байдал ийм л байна. Тэмүүлэн гишүүн үг хэлье.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Т.Аубакир сайд орж ирлээ. Би яг танай яамтай хамааралтай нийгмийн хамгаалалттай холбоотой асуудлууд дээр 2–3 асуулт асууна.

Нэгдүгээрт, том зургаар бол үндсэндээ Малчны тухай хууль бол хуулийг хэрэгжүүлдэггүй, хариуцлагагүй төрийн нэг л жишээ байгаад байгаа юм.

Хүнийхээ хөгжилд, хүн рүүгээ хөрөнгө мөнгө харамладаг мөртөө хот дээрээ магадгүй 2–3 их наядаар нь цемент зуурахдаа харамладаггүй. Нэг жил дотор 30 тэрбум төгрөг шийдэж чадахгүй Засгийн газар байна гэдэг бол харамсалтай байгаад байгаа юм. Өнөөдөр бид нар та бүхнээс нэхэж байгаа зүйл бол үндсэндээ энэ хууль дээдлэх зарчим хаана байгаа юм бэ гэдэг асуудал. Хууль дээдлэх зарчим өнөөдөр байна уу? Та нар УИХ буюу төрийн эрх барих дээд байгууллагын гаргасан бодлого, УИХ-ын баталсан хууль, заалтыг шүүх эрх байхгүй.

Үндсэн хуулиар заагдсан эрхээрээ төрийн эрх барих дээд байгууллагын өмнө хуулийн биелэлтийг Засгийн газар улс орон даяар зохион байгуулах үүрэгтэй. Үндсэн хуулийн 38.2.1-д, тэр дундаа Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хуулийг биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна гэж заасан байгаа.

Бид нар энийг л нэхэж байгаа. Тэрнээс бид нар та бүхнийг сонсголдоо авчраад, өнөөдөр та бүхнээс ямар нэг тайлбар, шалтаг сонсохыг хүсэхгүй байгаад байгаа юм. Энэ бол хүндээ чиглэсэн хууль. Та бүхэн улс орныхоо хөгжил рүү чиглэсэн, эдийн засгийнхаа тулгуур салбар дээрээ хэрхэн хандаж байгаагийн бодит илэрхийлэл болчихоод байна. Энэ асуудлаа Засгийн газар дотроо ярь. Хэрэв хүсвэл тэр хуулийн заалт гэдэг асуудлаар шалтаг тавьж байгаа бол нэг хоногийн дотор ч, хоёр хоногийн дотор ч яаралтай горимоор хуулийг өргөн бариад өөрчилж чаддаг. Энэ эрх нь Засгийн газарт байгаа шүү дээ.

Хоёрдугаарт, хөдөө орон нутагт чинь хүн ам зүйн бодлого байхгүй болчихлоо шүү. Хүн ам зүйн бодлогын талаасаа малчдыг төрөөс хэрхэн анхаарах гээд байгаа юм бэ? Наад хөдөө орон нутагт байгаа нийт хүн амын чинь, малчдын чинь, мал аж ахуйн салбарт үйлдвэрлэл эрхлэх гэж байгаа хүмүүсийн чинь дөнгөж 20 хувь нь залуучууд байна. Тэр 20 хувийнх нь залуучуудын 70 хувь нь эрэгтэйчүүд байна.

Хүн ам зүйн бодлого дээрээ яг танай яам ямар ажил хийгээд байгаа юм бэ? Нөгөө “мал дагавал ам тосдоно” гэдэг. Мал маллах, мал дагах хүн чинь байхгүй болчихоод байна шүү дээ. Энэ чинь Монгол Улсын хувьд үндсэндээ гамшиг болж байна.

Энэ улс орон цаашид мал, мах нь байхгүй бол, гурил, будаа нь байхгүй бол улсынхаа аюулгүй байдлын асуудлыг бид нар яах юм бэ гэдэг асуудал байгаад байна. Энэ ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, малчин хүний хөдөлмөрийн үнэлгээг бий болгох асуудлуудыг яах юм бэ? Энэ дээр ямар бодлого баримталж байгаа юм бэ?

Хөдөлмөрийг нь үнэлсэн цагт энэ салбарын хөгжил өөрийн эрхээр яваад байгаа юм. Үндсэндээ энэ хуулиар зааж өгсөн малчны хөгжлийг дэмжих аргачлалыг бий болгох, малчны бүтээмжийг бий болгох, энэ журмыг гаргах асуудлуудыг бид нар хуульчилж оруулж өгсөн байгаад байгаа юм. Тэрнээс 50 хувиар НДШ-ийг нь төрөөс дааж байгаагаа халамжийн бодлого гэж үзээд байж болохгүй шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Үг хэлж, асуулт асуулаа. Т.Аубакир сайд хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир: Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг. Тэгээд миний хувьд сая явуулж байсан бичгүүдээ Л.Энх-Амгалан сайдын үеэс эхлээд авчирсан. 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр явсан байна. Энэ журмыг баталж, саналаа өгөөч ээ гэсэн бичиг. Татгалзсан хариулт ирсэн. Мөн 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр бас бичиг явсан байна. Л.Энх-Амгалан сайдын гарын үсэгтэй “Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг хүргүүллээ. Саналаа яаралтай ирүүлэхийг хүсье” гэсэн бичиг байна. 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр миний гарын үсэгтэй бичиг мөн байна. “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөх тухай журам батлах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг хүргүүллээ. Тогтоолын төсөлтэй танилцаж, саналаа яаралтай ирүүлэхийг хүсье” гэсэн.

Тэгээд кабинетын зарчмаараа л нийгмийн даатгалын сан чинь даахгүй ээ гээд явсан. Өнөөдрийн хэлэлцээд эхэлчихсэн явж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бид нар бас малчин иргэдтэй адилтгах, огт хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй, НДШ-д хамрагдаагүй иргэддээ бас уриалга өгч байгаа л даа. Та төлөөгүй юу? Хоёр жил ингээд та 50 хувийн хөнгөлөлтөө төлчихвөл НДШ төлөгч болчих нь ээ. Энэ маань иргэд анзаарахгүй яваад байдаг байхгүй юу даа.

Манай малчин иргэд маань ч гэсэн тухайн үедээ бас анзаарахгүй л явж байсан. Ингээд тэтгэвэрт гарах дөхөөд ирдэг, “Хүүе, хаая, юу билээ?” гээд л тэгдэг. Эхнэртэйгээ хоёулаа насаараа төлөөгүй л явж байдаг. КОВИД-ын үед бол бас нэг боломж олгож байсан. Үүний хүрээнд харин ч нэлээн хэдэн малчин тэтгэвэртээ гарсан.

Г.Тэмүүлэн нарын гишүүдийн, бидний санаачилсан хууль бол дахиад нэг боломж өгвөл яасан юм бэ гэсэн агуулгатай. Ингээд хууль нь хэдий батлагдсан ч саяын гурван Засгийн газрын үед журам нь батлагдахгүй явсаар байгаад өдий зэрэгтэй очиж байгаа.

Хүн ам зүйн бодлогын хувьд бол өнөөдөр яг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яамнаас нийтдээ УИХ-д таван хууль өргөн барьсан. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлт зэрэг хуулиуд байна. Эдгээр болгон дээрээ бид нар хүн ам зүйн бодлогыг тодорхой хэмжээнд шингээгээд явж байгаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаараа дамжуулаад бид нар залуу малчдын чуулга, уулзалтыг аймгуудад хийдэг. Залуу малчдадаа бид нар мэдээж хэрэг аав, ээжээс нь илүү, удмаараа малчин хүнээс илүү зүйл заана гэж юу байх вэ. Залуу малчдын уулзалт дээр бид нар гэр бүлийн асуудлыг ярьдаг. Би Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас очоод гэр бүлийн асуудлыг ярьдаг. Хөдөө орон нутагт эхнэргүй маш олон залуучууд бий боллоо. Ёстой л нөгөө морь уядаг тулдаа л тэнд тэсээд байж байх шиг байна. Энэ дээр бид нар тусгайлан бодлого авч хэрэгжүүлэх ёстой. Саяын өргөн барьсан хуулиудаараа дамжуулаад бид нар энэ хүн ам зүйн бодлогыг нэг тийш нь болгох ёстой.

Г.Тэмүүлэн гишүүний санаачлан батлуулсан Генетикийн тухай хууль гэх зэрэг ийм бодлогуудыг бид нар нэгтгээд дорвитойхон бодлого авахгүй бол хөдөө орон нутгийн малчдын асуудал бас эмзэг түвшинд байгаа гэдэгтэй санал нэг байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Тэмүүлэн гишүүн тодруулья.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Яамнаас оруулж ирсэн тооцооллоор бол үндсэндээ 38 мянган хүний эрх ашгийг бид нар жилдээ 30 тэрбум төгрөгөөр хэмжиж байгаа юм байна. Энэ асуудал дээр, Т.Аубакир сайд, та танхимынхаа зарчмаар Ерөнхий сайдтайгаа энэ асуудлыг ярь.

Энэ үндсэндээ хууль хэрэгжүүлээгүйнх нь төлөө, бүр санаатайгаар Засгийн газрын хуралдаанд оруулаагүйн төлөө, хугацааг нь өнгөрөөж байхын төлөө Үндсэн хуулийн зөрчил үүссэн асуудал. Энэ асуудал дээр хэрэв та бүхэн энэ намрын чуулган гэхэд асуудлыг шийдэх гарц, гаргалгаа олж орж ирэхгүй бол Үндсэн хуулийн цэц дээр бид нар энэ хариуцлагын асуудлыг ярина. Үндсэн хуулийн зөрчил үүссэн асуудлууд дээр зөрчлийн маргаан үүсгэнэ. Төрийн эрх барих дээд байгууллагын өмнө гүйцэтгэх засаглал ажлаа бүрэн дүүрэн хийж чадаагүйн асуудал. Энийг та бүхэн дотроо ярих ёстой. Тал еэвэнгийн үлгэр шиг ийм тал дутуу байж болохгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Б.Мөнх-Оргил 8 номерын микрофон нэмж хариулья.

Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил: Г.Ганбаатар гишүүний асуултад хариулья. Нийт үндсэн зээлийн төлөлтөөс 136.4 тэрбум төгрөгийг төлсөн. Үндсэн зээлийн төлөлтөөс. 2024 онд анх зээл олгож эхэлснээс хойш, 2024 онд бол малчдаас үндсэн зээлийн төлөлтийг хойшлуулаад зөвхөн хүүг авч байсан. 2025 оноос бол үндсэн зээлийн төлөлт рүү орсон байж байгаа. Нийт 840 хэдэн тэрбумаас 10 хэдэн, 12 хувь нь үндсэн зээлийн төлөлтөөс төлөгдөөд явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ренчинбямбын Сэддорж гишүүн үгээ хэлье.

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: Манай орны 330 суманд яригдаж байгаа зүйл

бол энэ 38 мянган малчны НДШ-ийг нөхөн төлнө гэсэн Малчны тухай хуульд найдсан найдлага байгаа юм. Таны зоригтой манлайлал хэрэгтэй байна. Засгийн газрын зоригтой бас энэ малчдынхаа төлөө анхаарал тавих цаг нь болчихсон байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нийт хүн амын дөрөвний нэг хувь нь бол энэ малчид байгаа байх. Тэгэхээр танай яамны гол зорилтот сегмент чинь малчид юм. Танай яам энийг зоригтой оруулж ирээч ээ, энийг хэрэгжүүлээч ээ. Энэ журам гээд өнгөрсөн юм руу чихээд яах вэ? Та ажлаа аваад удаагүй байх. Тэгэхээр таны манлайлал хэрэгтэй байна. Засгийн газар юу амлаж, юу ярьж сонгогдлоо? Тэгэхээр энд энийгээ хийх хэрэгтэй байна.

190 тэрбум төгрөгийг малчид гаргаад, 1995-аас 2025 оны хоорондох он жилүүдээс 5 жилийг нь малчин өөрөө сонгоод, тэгээд ирэх 5 жил төлөөд эхлэх юм бол 375 тэрбум төгрөгийн ачаалал Нийгмийн даатгалын санд ирэх юм байна. Энэ 375 тэрбум төгрөг бол Монголын энэ ХАА-д зарцуулах ёстой, Монгол төрөөс гаргах ёстой ийм л мөнгө л дөө.

Бүх суманд яригдаад байгаа энэ асуудлыг нэг тийш нь шийдээд цаашаа явах байсан. Энэ Малчны тухай хуулийн нэг ганц найдлага тээсэн заалтаа хэрэгжүүлчих юмсан гэсэн ийм бодолтой байна. Энэ дээр таны манлайлал хэрэгтэй байна. Та зоригтой бай. 33 их наяд төгрөгийн төсөвтэй Монгол Улс 2000 онд 400 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан. Төсөв нэмэгдсэн. Монгол Улс бол баян улс, ядуу улс биш, жижиг улс биш. Бид нар бол мөнгөө юунд зарцуулахаа мэддэггүй, тийм салан палан айл шиг болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ үндсийн үндэс, энэ язгуур үндэс, энэ газар нутгийн тусгаар тогтнолын бүрэн бүтэн байдлыг хамгаалж явж байгаа, бид нарын өвөг дээдсийг үргэлжлүүлж явж байгаа энэ малчдаа бодох цаг нь болсон.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Ямар ч байсан Ц.Идэрбат, Т.Аубакир сайд нар хүрэлцэн ирлээ.

Гишүүдийн хамгийн гол асуудал бол Т.Аубакир сайдын НДШ-тэй холбоотой асуудал байсан. Энд хүрэлцэн ирсэн оролцогчид, малчид, малчдын төлөөлөл, иргэдийн төлөөлөл хамгийн гол энэ асуудлыг сонсохоор ирсэн байгаа. Гишүүд ч бас энэ талаар бүгд хэллээ.

Ер нь УИХ-ын бүрэн эрхийн хамгийн том бүрэн эрх бол Засгийн газрыг байгуулах асуудал шүү дээ. Бид нар Үндсэн хуульдаа зааснаар Ерөнхий сайдыг томилсон. Ерөнхий сайд таныг томилсон, сайд нараа томилсон. Сайд нар УИХ дээр тангараг өргөсөн. Тийм байх, Аубакир сайд, тангараг өргөсөн тээ?

УИХ-аас гаргасан хуулийг хэрэгжүүлнэ гэж тангараг өргөсөн. Чандлан хэрэгжүүлнэ ээ гээд тангараг өргөсөн. Үндсэндээ Засгийн газар УИХ-аас гаргасан энэ хуулийг нэг бүрчлэн биелүүлэх ёстой үүрэгтэй. Хэрвээ дайны үеэр харьцуулах юм бол дээд командлалынхаа тушаалыг биелүүлээгүй командлагч дайны хуулиар шийтгэл хүлээх үүрэгтэй, хуультай шүү дээ. Ингэж л бид нар харах ёстой. Ингэж л зүйрлэх ёстой. УИХ-аас гаргасан хуулийг хэрэгжүүлэхгүй байна гэдгийг л бид нар өнөөдөр нэхэж байгаа шүү дээ.

Үнэхээр боломж, бололцоо байхгүй бол УИХ-д буцаагаад өргөн баригдах

хуулиа өөрчлөөд ороод ир л дээ. Хугацааг нь хойшлуул л даа. Бүхий л арга хэлбэр чинь та бүхэнд байгаа шүү дээ. Хамгийн гол нь УИХ-аас гаргасан хууль, тогтоомж, УИХ-аас явуулсан мөрийн хөтөлбөрийг та бүхэн хэрэгжүүлэх ёстой гэдгийг л бид нар өнөөдөр нэхэж байгаа юм. Энийг л өнөөдөр ард иргэд хараасай гэж хүсэж байгаа юм.

Тэгээд эндээс гарах шийдвэрүүдийг, эндээс гарч байгаа УИХ-ын гишүүдийн саналыг, эндээс гарч байгаа төрийн байгууллага, төрийн эрх бүхий байгууллагын хүмүүсийн гаргасан санал буюу хариултыг бид нар бүгдийг нь багцлаад УИХ-д болоод цаашаагаа Засгийн газарт тодорхой хэмжээний чиглэл өгнө. Ард иргэд энийг бүгдийг нь харж байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд оруулсан хамгийн том зүйл бол хяналтын сонсгол хийх асуудал. Энүүгээр тодорхой асуудлуудыг ард иргэдэд мэдэх эрхийг нээж өгч байгаа, мэдэх эрхийг хангаж өгч байгаа асуудал бол энэ сонсголын хамгийн том ач холбогдол байх ёстой.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу урьдчилан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулж, сонсголын тэмдэглэлд тусгах ёстой.

Ирсэн саналуудыг би та бүхэнд уншиж мэдээлье.

1. Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын малчин Ц.Эрдэнэ-Очир 2026 оны 6 дугаар сарын 19-нд ирүүлсэн байна.

Малчдын ихэнх хувь нь ажилласан жил болон насны болзол хангасан боловч НДШ төлөлтөөс шалтгаалан тэтгэвэрт хамрагдаж чадахгүй байна. Иймд малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөхийг дэмжиж өгнө үү.

2. Завхан аймаг, Тосонцэнгэл сум, 5 дугаар багийн малчин Л.Лхагвасүрэн 2026 оны 6 дугаар сарын 19-нд санал ирүүлсэн байна.

Малчны НДШ-ийг нөхөн төлүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргаж өгнө үү.

Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх Ухааны Академийн Мал эмнэлгийн хүрээлэнгийн шинжлэх ухааны доктор, профессор Я.Ганболд санал ирүүлсэн байна. 6 дугаар сарын 5-нд ирүүлсэн санал байна.

Нэг. Газар эзэмших, газар ашиглах эрхийн талаар: Монгол орны бэлчээрийн эсвэл нүүдлийн мал аж ахуйн онцлогт нийцүүлсэн ямар нэгэн уул уурхайн үйл ажиллагааг эрхлэхээс өмнө малын эрүүл мэнд болон малчны амьжиргаанд нөлөөлөх үнэлгээг заавал хийдэг байх. Ийм утга агуулга бүхий заалт мал аж ахуйн болон уул уурхайн ямар ч хуульд байхгүй бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд мал аж ахуйн, мал эмнэлгийн асуудал ордоггүй нь малчны бэлчээр ашиглах, газар ашиглах үндсэн эрхийг хөндсөөр байгаа. Үүнийг анхаарна уу.

Хоёр. Бэлчээрийн талхагдал, даац, хомсдолын талаар: Багийн хурлаар

хэлэлцэж, бүх малчдад хүрсэн бэлчээрийг жилийн 4 улиралд ээлжлэн ашигладаг уламжлалт буюу Монголын мал аж ахуйн язгуур арга барилыг жил бүр хэлэлцэж, түүнийгээ мөрддөг байх тухай заалт оруулах хэрэгтэй. Энэ ажил Говь-Алтай аймгийн Эрдэнэ зэрэг суманд байгаа нь тод жишээ болно. Энэ асуудлаар багийн дарга нарыг үүрэгжүүлэх ёстой юм. Мөн бэлчээрийг хамгаалах. Харин малчин хүн бэлчээр газраа ашиглах асуудал гэдэг философийг төр засаг ч тэр, малчид ч тэр зөв ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл, эзэмших эрх, ашиглах эрх үүрэг, хамгаалах үүрэг, сэргээх үүрэг гэсэн зарчим үйлчлэх нь зөв. Өнөөдөр зөвхөн ашиглах эрх л үйлчилж байна.

Гурав. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар: Малчдын дасан зохицох үндсэн гол арга нь шинэ нөхцөлд дасан зохицох философийн чадвартай, цөөн тооны мал маллах арга юм. Тиймээс малчны үүрэгт Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малын үүлдэр, угсааг сайжруулах заалтын дагуу айл өрх бүр мэргэжлийн байгууллагатай хамтран төлөвлөгөөтэй ажиллахыг өргөжүүлэх. Малчин айл, хот айл бүр гар тэжээл хийх болон тэжээлийн тариалалт хийх, малаа жил бүр угтуулан тэжээх аянд нэгдэж ажиллах, сум, багийн дарга нар энэ ажилд голлон анхаарах хэрэгтэй байна.

Дөрөв. Орон нутгийн үйлчилгээ: Малчид өөрсдөө малын гаралтай түүхий эдээ бэлтгэж, түүнийгээ боловсруулах, цаашилбал үйлдвэрлэдэг шат дараалсан инновацад шилжих цаг нь болсон. Өөрөөр хэлбэл, малчин, малчдын хоршоо, нөхөрлөл үйлдвэрлэгч байж сая малын түүхий эд хаягдахгүй болно. Тиймээс малчин бүр үйлдвэрлэгч гэдэг ухамсар, сэтгэлгээг суулгах том ажил хүлээгдэж байгаа. Энэ ажилд сумын болон багийн удирдлага өөрсдөө суралцах ёстой. Багийн дарга нарыг улс төржсөн эсвэл ах дүүгийн саналаар сонгодог биш, ажил хийдэг хүнээр сонгох нь зүйтэй.

Тав. Хөдөлмөрийн үнэлэмж: Хөдөөгийн мал аж ахуйд тохирсон малчин хүний хөдөлмөрийн үнэлгээний стандарт, ажиллагааны заавар буюу САЗ, малчин хүний Хөдөлмөрийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүд, малчин хүний бүтээмжийн нотолгоо Монгол Улсад байхгүй. Малчин хүний хөдөлмөрийн хуваарь байхгүй. 1960-аас 1990 онуудад сонгомол утгаар бол байсан. Тэдгээрийг сэргээж, шинэчлэн баталж, одоогийн нөхцөлд нийцүүлэн мөрдүүлэхгүйгээр малчны хөдөлмөрийг үнэлэх боломж байхгүй. Малчны хөгжлийн индексийг монгол ахуйтай холбож, малчны оролцоог тодруулах, залуу халаа бэлтгэх, малчны хөдөлмөрийн үнэлгээ үнэн бодит болж, эергээр мэдрэгдсэн тохиолдолд малчны тоо олширно. Мөн малчдын шавь сургалт, өвлөн уламжлал бий болгосон манлайлагч малчид болон тэднийг дагасан малчдыг төрөөс хамгаалах биш, урамшуулдаг тогтолцоо хэрэгтэй байна.

Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд төгсөөд л ажилладаг гэхээр саад болоод байдаг төрийн албаны шалгалт, цэргийн алба хаасан байх зэрэг саадыг залуучуудын хувьд өөрчлөх хэрэгтэй.

Зургаа. Жендерийн асуудал: хөдөөгийн малчнаар ажиллаж байгаа залуусыг малаас нь салгахгүйгээр цэрэгжүүлэх, сургах хөтөлбөр хэрэгтэй байна. Сумаас өөр аймаг болон аймаг руу шилжих хөдөлгөөнийг хориглох.

Долоо. Хоршооны асуудал: хоршооны бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд оруулах удирдлагын механизмыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн үүрэг болгох, эрх болгож өгөх хэрэгтэй байна. Салбарын бүтэц, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын эрхлэх ажлыг тодорхой болгох хэрэгтэй байна. Төр хувийн хэвшлээ хянах үүрэгтэй юм шиг ажиллаж байна шүү.

Найм. Малчны хөгжлийн сургалт, мэдээллийн талаар: энэ төвийг хувийн хэвшлийн мэргэжилтнүүдэд харьцуулаад, тэднийг дэмжээд явах нь зөв. Хамгийн түрүүнд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Ес. Малын индексжүүлсэн даатгал: индексжүүлсэн даатгал нь зөвхөн

хорогдсон малын тоогоор байдаг тул малчдад ямар ч өгөөж байдаггүй. Харин Малын эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шаардлага, үндэслэлийг 2018-2019 онд Хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар боловсруулсан. Хуулийн төслийн мөн чанар нь малчин малаа даатгалд хамруулна, малын эмч бүх төрлийн үйлчилгээ үзүүлсэн зардлаа энэ сангаас авна. Малчин, малын эмч хоёр маргаангүй болно. Малчдын сан, малын эрүүл мэндийг малын эмч бүрэн хариуцна. Мал эрүүлжинэ.

Арав. Малчдын хөгжлийн сан: энэ санд улс оролцохгүйгээр зөвхөн малчид өөрсдөө зарцуулдаг, бас сангаас хийх ажлыг өөрсдөө хийдэг байх нь зөв гэх мэтчилэн ийм саналуудыг гаргасан байна.

Ингэхээр саналуудыг дүгнэлтэд тусгах болно оо.

Үндсэндээ өнөөдрийн ерөнхий сонсгол өндөрлөж байна.

Эрхэм гишүүд ээ, сонсголд оролцогч төрийн байгууллагын төлөөлөл, малчид, иргэд ээ,

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос зохион байгуулсан “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт ерөнхий сонсголыг 2026 оны 6 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Төрийн ордонд та бид амжилттай зохион байгуулж өндөрлөж байна.

Сонсголын эхний өдөр төрийн байгууллагаас 42, иргэдээс 46, нийт 88 хүн оролцлоо. Байнгын хорооны гишүүдийн ирц 51.7 хувьтай буюу 29 гишүүнээс 15 гишүүнтэй хуралдлаа.

Сонсголын хоёр дахь өдөр буюу 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдөр төрийн байгууллагуудаас 32, иргэдээс 43, нийт 75 хүн оролцлоо. Байнгын хорооны гишүүдийн ирц 65.5 хувьтай буюу 29 гишүүнээс 19 гишүүн оролцлоо.

Хоёр өдрийн сонсголд төрийн байгууллагуудаас давхардсан тоогоор 163 хүн оролцсон байна.

Хяналтын сонсголыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу олон нийтэд нээлттэй зохион байгуулж, Үндэсний олон нийтийн радио, телевиз, Малчин телевизээр шууд дамжуулан, дохионы хэлмэрчтэйгээр хүргэснээр иргэдийн мэдээлэл авах, оролцох эрхийг хангалаа.

Хоёр өдрийн турш УИХ-ын гишүүд, төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнууд, малчид, иргэдийн төлөөлөл оролцож, Малчны тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээний талаар санал, тайлбар сонсож, асуулт, хариулт өрнүүллээ.

Сонсголын үеэр нийт 40 гаруй иргэн биечлэн санал хэлж, малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөнгөлөлттэй зээл, бэлчээр ашиглалт, уул уурхайн нөлөөлөл, гамшгийн эрсдэл, малчдын залгамж халаа, хууль хоорондын уялдаа зэрэг асуудлаар байр сууриа илэрхийллээ.

Тухайлбал, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Батлагдах ёстой хууль, журмууд бүрэн гараагүй байна. Малчдын тэтгэврийн даатгалын нөхөн төлөлт шийдэгдээгүй байна. Уул уурхай, газрын харилцаа, бэлчээрийн асуудал хамгийн ихээр хөндөгдлөө.

Мөн малчдын хөдөлмөрийн үнэлэмж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг батлах шаардлагатай байгаа талаар дурдлаа.

Хоёр өдрийн сонсголын мэдээлэл, Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, төрийн байгууллагын тайлбар, мэдээлэл, малчид болон иргэдийн санал, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Нэг. Малчны тухай хууль батлагдсанаас хойш жил гаруй өнгөрсөн боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хуульд заасан зарим чухал арга хэмжээ, журам, хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй, салбар хоорондын уялдаа холбоо сул, хэрэгжилтийг зохион байгуулах болон хяналт тавих тогтолцоо хангалтгүй байна.

Хоёр. Малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, залгамж халааг бэлтгэх чиглэлээр хуульд заасан зорилтууд бодит үр дүнд хүрээгүй байна. Ялангуяа малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалт, малчны хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгааг онцлон тэмдэглэж байна.

Гурав. Малчдын өмнө тулгамдсан хамгийн том асуудал нь бэлчээр, газрын харилцаа, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл хэвээр байна. Малчдын бэлчээр ашиглах эрх, өвөлжөө, хаваржааны хамгаалалт, усны нөөцийн ашиглалттай холбоотой зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна.

Дөрөв. Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үнэлэмж, малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Малчид хамгийн сахилга баттай зээлдэгчийн нэг атлаа өндөр хүүтэй зээл авч байгаа нь хөнгөлөлттэй санхүүжилт, ипотекийн зээл, даатгалын тогтолцооны хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна.

Тав. Малчны тухай хууль нь зөвхөн нэг салбарын хууль бус, Монгол Улсын үндэс, хүнсний аюулгүй байдал, үндэсний уламжлалт мал аж ахуй, хөдөөгийн хөгжлийн суурь асуудлыг зохицуулсан бодлогын ач холбогдолтой хууль болохыг онцлон тэмдэглэж байна.

Иймд хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжилтийг хангуулах талаар УИХ, Засгийн газар, холбогдох байгууллагууд онцгой анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Сонсголын үеэр гарсан санал, хүсэлт, дүгнэлтийг нэгтгэн боловсруулж, ерөнхий хяналтын сонсголын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар танилцуулан хэлэлцүүлэх болно.

Энэхүү хоёр өдрийн сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд, орон нутгаас хүрэлцэн ирсэн, санал хэлсэн, үзэл бодлоо илэрхийлсэн ард иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, төрийн байгууллагыг төлөөлөн оролцож, тайлбар

Энэхүү хоёр өдрийн сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд, орон нутгаас хүрэлцэн ирсэн, санал хэлсэн, үзэл бодлоо илэрхийлсэн ард иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, төрийн байгууллагыг төлөөлөн оролцож, тайлбар хийж, асуултад хариулсан төрийн албан хаагчид, хоёр өдрийн турш сонсголыг шууд дамжуулсан Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, Малчин телевиз болон бусад хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг хүртээмжтэй байлгах, сонсголд оролцох, ажиллах боломжийг хангаж ажилласан дохионы хэлмэрч, саналаа хэлсэн, хүсэлтээ бичгээр ирүүлсэн орон нутгийн иргэд, ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын хамт олон Та бүхэнд талархал илэрхийлж, цаашдын ажилд өндөр амжилт хүсэн ерөөе.

Ийнхүү хоёр өдөр үргэлжилсэн сонсгол өндөрлөж байна. Та бүхэнд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сонсголын мэдээлэл, сонсголын дагуух ажиллагааг цааш үргэлжлүүлэхээ Та бүхэнд илэрхийлж байна. Ингээд сонсгол хаасныг мэдэгдье.

Баярлалаа.

Тэмдэглэлтэй танилцсан:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

---oOo---